


МОНГОЛ УЛСЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН  
ТҮҮХИЙН ХҮРЭЭЛЭН

С.ЦОЛМОН

# МОНГОЛЫН АЛТАН ОРДОН УЛС

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ:

Доктор, профессор Ч.Дашдаваа  
Академич, доктор, профессор Ж.Болдбаатар  
Доктор, профессор Х.Шагдар



УЛААНБААТАР  
2006

**ШУА-ИЙН ТҮҮХИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВШӨӨРСНӨӨР  
ХЭВЛЭВ**

**МОНГОЛЫН АЛТАН ОРД УЛС  
МОНГОЛЬСКОЕ ЗОЛОТООРДЫНСКОЕ  
ГОСУДАРСТВО  
MONGOLIAN GOLDEN HORDE STATE**

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Э.Жигмэддорж, Ж.Амгалан  
Хавтасны газрын зургийг Б.Батсүрэн, И.Цэрэнням нар үйлдэв.

Хэвлэлийн хуудас: 14.2  
Цаасны хэмжээ: 176 × 250 мм.  
"ADMON" ХХК-д хэвлэв.  
Улаанбаатар хот. 2006 он

## ӨМНӨХ ҮГ

ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс эрхлэн Монголын эзэнт гүрний түүхийг гүнзгийрүүлэн судлах ажлыг ойрхи жилүүдэд явуулсны үр дүнд “Монголын Юань улс” (туурвигч нь Ж.Ганболд, Д.Наран, Т.Мөнхцэцэг, А.Пунсаг), “Монголын Алтан ордон улс” (туурвигч нь С.Цолмон), “Монголын Цагадайн улс” (туурвигч нь Ц.Энхчимэг), “Монголын Эл хаант улс” (туурвигч нь Ц.Ишдорж) хэмээх дөрвөн дэвтэр бүтээлийг уншигч олонд өргөн барьж байна. Эдгээр нь монгол судлаачдын тусгайлан судлан шинжилж нэг сэдэвт зохиолын хэмжээнд туурвисан анхны бүтээлүүд болно.

1206 онд Их Монгол улс байгуулагдсан нь дэлхийн талыг эзэгнэсэн их гүрнийг үүсгэн бүрдүүлэх анхны гараа байсан билээ. Өгэдэй, Гүюг, Мөнх, Хубилай хаан улс орныхоо хаяа, хил хязгаарыг тэлж, Монголын их гүрний бүрэлдэхүүнд Юань улс, Алтан ордон улс, Цагадайн улс, Эл хаант улсыг байгуулжээ. Монголын Юань улс 97 жил, Монголын Алтан ордон улс 250 жил, Монголын Цагадайн улс 149 жил, Монголын Эл хаант улс 88 жил оршин тогтножээ. Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улсууд нь эхэн үедээ холбооны хэлбэртэй байсан бөгөөд цаашдаа хөгжлийн явцад улсуудын холбооны хэлбэрт шилжсэн юм. Монголын эзэнт гүрнийг мөхөх хүртэлх үед түүний бүх нутаг дэвсгэрт Чингис хааны үндэслэсэн Монгол төрийн бодлого тууштай хэрэгжиж байлаа.

Монголын эзэнт гүрний салшгүй бүрэлдэхүүн хэсгийн нэг болох Монголын Алтан ордон улсын түүхийг судлан боловсруулах талаар Монголын тодийгүй гадаадын олон орны эрдэмтэд анхаарал хандуулж, эрдэм судлалын сонирхолтой бүтээлүүдийг туурвисаар иржээ.

1960-аад оны эцсээр хэвлэгдсэн “БНМАУ-ын түүх” гурван боть зохиолд Монголын Алтан ордон улсын түүх тусгагдсан юм. 2003 онд хэвлэгдсэн “Монгол улсын түүх” таван боть зохиолд Алтан ордон улсын түүхийн хэсгийг бага зэрэг дэлгэрүүлсэн авч өмнөх судалгаанаас онцгой ялгагдах зүйлгүй байна.

Монголын Алтан ордон улсын түүхийг нэг сэдэвт зохиолын хэмжээнд тусгайлан туурвисан бүтээл Монгол улсад энэ хир гараагүй

байна. Харин академич Ш.Бира Алтан ордон улсын соёлын тухай өгүүлэл нийтлүүлжээ.

Алтан ордон улсын түүхийн талаар хамгийн их судалгаа явуулсан нь ОХУ болно. Монголчууд Оросын түүхэнд хүчтэй нөлөө үзүүлсэн, эсвэл онцгой нөлөө үзүүлээгүй гэсэн хоёр урсгал чиглэл Оросын түүх бичлэгт бүр XVIII зуунаас үүсч бий болсон ажээ. Монголын нөлөөллийн тухай асуудалд Н.Н.Карамзин, Н.И.Костомаров, Р.И.Леонтович, Н.А.Полеской, Н.Я.Данилевский, К.Н.Леонтьев, М.С.Грушевский нар онцгой ач холбогдол өгч байв. Харин И.Н.Болтин, С.М.Соловьев, В.О.Ключевский нар Оросын түүхэнд монголчуудын гүйцэтгэсэн үүргийг үгүйсгэдэг байна.

Оросын судлаачид Монголын эзэнт гүрний түүхийг судлах талаар XX зуунд ихээхэн хүч чармайлт гаргажээ. Н.Н.Березин, В.В.Григорьев, М.И.Иванин, В.В.Бартольд, В.Я.Владимирцов нарын бүтээлүүд нь түүхэнд Чингис хааны гүйцэтгэсэн үүрэг болон Монголын Эзэнт гүрний түүхийн олон асуудлаар бодитой үнэлэлт өгсөнөөрөө онцлог юм. Ийм байр суурийг Евразийхан хэмээх нэр авсан Оросын судлаачид Н.С.Трубецкой, П.Н.Савицкий, М.М.Шахманов, Г.В.Вернадский, Э.Хардаваа нар үргэлжлүүлсэн бөгөөд Орос улсын хөгжилд Монголын эзэнт гүрний үзүүлсэн дэвшилт нөлөөг онцгойлон тэмдэглэж ирсэн.

Зөвлөлтийн марксист түүхчид Европыг төвчлөх үзэл, Их оросын провинист үзлийн үүднээс Монголын эзэнт гүрний түүхийг судлах болсон бөгөөд Орос орны улс төрийн нэгдэл, эдийн засаг, соёл, хот байгуулалт, худалдаа, зам харилцаа, гар урлалын хөгжилд Алтан ордон улс ямар ч нөлөө үзүүлээгүй, харин монголчууд Орос орныг үгүйрүүлэн хоосруулж, Баруун Европын орнуудаас олон зуун жилээр хоцрогдуулсан хэмээх үзлийг баримтлах болсон билээ. В.Г.Лашуто, М.И.Тихомиров, В.В.Каргалов, Л.В.Черепнин нарын бүтээлүүд үүнд юуны өмнө хамаарагдана.

Гэвч энэ үед түүхэн үнэнийг ямар нэг байдлаар харуулсан бүтээлүүд гарч байсныг үгүйсгэж болохгүй. Алтан ордон улсын түүхийн судалгаанд Б.Д.Греков, А.Ю.Якубовский, А.Н.Насонов нарын бүтээлүүд чухал хувь нэмэр оруулсан юм. Г.А.Феодоров-Давыдов, В.Д.Егоров нар Алтан ордон улсын мөнгөн гүйлгээ, хот байгуулалтын асуудлыг судалсан байна. Шинэ Евразийнхны урсгалыг үндэслэгч Л.Н.Гумилев өөрийн бүтээлдээ Монголын эзэнт гүрний түүхийг бодитойгоор авч үзэж, түүхийг мушгин гуйвуулах явдлыг илчлэн няцаасан билээ.

XX зууны 90-ээд оноос хойшхи үед археологи, зоос судлал, сурвалж бичгийн судалгаа нь Монголын эзэнт гүрний түүхийг бодит байдлаар судлах нөхцлийг бүрдүүлснийг тэмдэглэх ёстой.

Орос орон ардчилалд шилжсэнээс хойшхи жилүүдэд Оросын судлаачид эх орныхоо түүхийн бүхий л үе, түүний дотор Оросын түүхэн дэх Монголын үеийн түүхийг бодитой авч үзэх талаар урагш том алхам хийж байна. Үүнд, юуны өмнө Э.С.Кульпин, В.И.Пантин, В.В.Трепавлов, В.Л.Егоров, Ю.С.Худяков, М.Г.Караморовский, Л.Ф.Недашковский, Ю.В.Кривошеев, Р.П.Храпачевский, Б.Широкорад, Ю.В.Мизун, Ю.Г.Мизун зэрэг олон судлаачдын бүтээлийг дурдаж болно. В.В.Трепавлов Орос оронд Монголын Эзэнт гүрний үзүүлсэн дэвшилт нөлөөг дөрвөн түвшнээр авч үзсэн байна. “История Востока” 6 боть бүтээлд (1996) Монголын эзэнт гүрний түүхийн талаарх судлаачдын янз бүрийн үзэл баримтлалыг харьцуулан авч үзэж, түүний бүрэлдэхүүн улсуудын эдийн засаг, соёлын хөгжил, хот байгуулалт, худалдаа, гар урлалын асуудлыг судлан гаргахад онцгой анхаарал хандуулжээ.

Гэвч XIII зуунд Монголд төр улс байсныг үгүйсгэх, Оросын хөгжилд монголчуудын үзүүлсэн нөлөөг үл хайхрах явдал Оросын зарим судлаачдын дунд одоо хүртэл байсаар байна. Татарстаны судлаачид Алтан ордон улс бол “цэвэр татарын улс” мөн гэж үзэж байна. Хэдийгээр XXI зуун гараад байгаа боловч ОХУ-ын ерөнхий боловсролын болон дээд сургуулийн түүхийн сурах бичгүүд дэх Алтан ордон улсын тухай өгүүлсэн хэсэг нь Зөвлөлт засгийн үеийн түүхчдийн үзэл баримтлалыг үндэс болгосон хэвээр байна.

Дундад Азийн орнуудын судлаачид Монголын эзэнт гүрний түүхийг судлахад бас анхаарал тавьж иржээ. Казахын судлаач А.Ш.Кадырбаев Алтан ордон улс бол Монголын биш харин Тюркийн улс хэмээн батлах оролдлого хийжээ.

Алтан ордон улсын түүхийг судалсан бүтээлүүд Өрнөдийн орнуудад ч нийтлэгджээ. Үүнд, Германы судлаач Б.Шпулериин “Алтан ордны улс” зохиол, В.Хайссигийн удирдлагаар туурвисан “Монголчууд: түүх, соёл” хамтын бүтээл, Израилийн судлаач Рювен Амитай-Прейсс, Англи-Америкийн түүх бичлэгийн төлөөлөгчид болох Ж.Саундерс, Е.Филлипс, Л.Куонтен, Д.Флетчер, Ч.Галперин, Т.Олсен, П.Брент, Ж.Ведерфорд, Д.Морган, С.Эдшед нарын бүтээлүүдийг дурдаж болно.

Ийнхүү Өрнө, Дорнын судлаачид Чингис хаан, Монголын эзэнт гүрэн, түүний бүрэлдэхүүн улсуудын тухай олон арван ном бүтээл, өгүүлэл нийтлүүлсэн байна.

XIII-XIV зууны үеийн дэлхий дахины болон Монголын түүхийг мушгин гуйвуулах хандлага давамгайлж байсан үе хэдийн өнгөрч, дэлхийн болон бүс нутгийн соёл иргэншилд монголчуудын оруулсан хувь нэмрийг улам бүр анхаарах болжээ. Ийм нөхцөлд Монголын эзэнт

гүрний түүх, түүний бүрэлдэхүүн улсуудын түүхийг монгол судлаачдын нүдээр харж, нарийвчлан шинжлэх явдал чухал болж байна.

“Монголын Алтан ордон улс” бүгээлийг профессор С.Цолмон туурвисан болно. Энэхүү бүгээлд Алтан ордон улсын түүхийн зангилаа зарим асуудлыг хөндсөн байна.

Эрхэм уншигч Та энэхүү бүгээлийн талаарх санал бодлоо Түүхийн хүрээлэнгийн нэр дээр ирүүлбэл алдсан, эндсэнээ цэгнэж, судалгаагаа цаашид гүнзгийрүүлэхэд бидэнд ихээхэн тус дэмжлэг болно гэдгийг тэмдэглэсү.

**Редакцийн зөвлөл**

## 1. БАТЫН АЯН ДАЙН

Монголын Эзэнт гүрний түүхээс Батын байлдан дагууллын түүх харьцангуй сайн судлагдсан ажээ. Бат ханы тэргүүлсэн ахмад хөвгүүдийн аян дайны талаар эзлэгдсэн орнуудын түүхчдийн бичсэн олон бүтээл гарчээ. Гэвч энэ талаархи судлаачдын үнэлгээ нэлээд зөрүүтэй ажээ.

Сүбээдэй, Зэв нарын удирдсан цэрэг 1222 онд Гүрж, Азербайжан, Умард Кавказыг дайлан эзлээд Өмнөд Оросын нутагт цөмрөн орж иржээ. Галицын ван Мстислав нүүрлэсэн аюулын эсрэг хамтын хүчээр тэмцэхээр Оросын зарим ванд элч илгээсэн боловч Чернигов, Киевийн вангаас бусад нь дэмжсэнгүй. Монголчуудын довтолгооныг хэрхэн эсэргүүцэх, хүчийг нь яаж сарниулах, өөрсдийн хүчийг хэрхэн оновчтой зохион байгуулах талаар ярилцаж, орос, кибчагийн хамтарсан цэрэг монголчуудын эсрэг байлдахаар тогтжээ. Монголчууд оросын вангуудад элч илгээж кибчагуудад туслахгүй байх, өөрийн нутаг орогнуулахгүй байхыг хүссэн боловч тэд элчийг нь алжээ. Тийнхүү хоёр этгээдийн цэрэг тулалдах нь гарцаагүй болов. Тухайн үед Орос-Кибчагийн хамтарсан хүч 80 000, монголчууд 20 000 цэрэгтэй байсан гэж судлаачид үздэг.

1223 оны 5 дугаар сарын 31-нд Калка гол дээр Зэв, Сүбээдэй, Тогучар нарын цэрэг орос, кибчагийн хамтарсан арми монгол цэрэгтэй шийдвэрлэх тулалдаан хийсний эцэст орос-кибчагийн тал хүнд ялагдал хүлээжээ. Тэр үеийн Оросын сурвалж бичигт орос цэргийн аравны нэг нь л амьд гарч, 6 ван (князь), 70 ноён (боярин) амь үрэгдсэн гэж тэмдэглэжээ.

Калка голын тулалдаанд оросын түүхчид онцгой ач холбогдол өгдөг бөгөөд монголчуудын цэргийн хүчийг сулруулснаар Европ аврагдсан гэж үздэг юм. Калка дахь тулалдаанд бодитой хандсан судлаачид оросын цэрэг ялагдах болсныг хэд хэдэн үндсэн хүчин зүйлээр тайлбарладаг. Юуны түрүүнд монголчууд байлдааны ур чадвар, тактикийн хувьд өрсөлдөгчөөсөө хол тасархай байжээ. Орос цэргүүд байлдааны ур чадвар муу биш байсан ч олноороо дайтах тулалдаанд монголчуудтай адил нэг хүн шиг зохион байгуулалтад орох туршлага дутсан. Мөн

холбоотон болж тулалдсан орос, команчууд хоорондоо уялдаа холбоо муутайн дээр их цэргийг удирдах ерөнхий командлагчийн томилгоон дээр санал нэгдэж чадаагүй нь ялагдах гол шалтгаан болсон гэж судлаачид үзэж байна. Тэгээд ч Оросууд монголчуудын хүчийг дутуу үнэлэхийн зэрэгцээ байлдааныхаа талбарыг ч зөв сонгож чадаагүй ажээ. Тулалдаан болсон газар нь Монголын хөдөлгөөнт морин цэрэгт захиалсан мэт таарч байсан<sup>1</sup> нь ялагдах бас нэг нөхцөл болжээ.

Калка голын тулалдааны дараагаар Зэв, Сүбээдэйн цэрэг Өмнөд Оросын нутгаар дамжин Днепрээс Азовын тэнгисийн эрэг хүртэл урагшлан Крымийн хойгт хүрчээ. Тэд Ази, Европ, Африк гурван тивийн худалдааны зангилаа-Судак хотыг авсан генуечүүдтэй холбоо тогтоосны дараа Ижил мөрөн, Камын Булгаруудын зүг эргэжээ. Энэ нь:

Нэгд, “Зүчийн улс”-ын хилийн аюулгүй байдлыг хангахын тулд түүний хойт, баруун хойд хилийг тойрон тагнаж, дайсныг зайлуулах, хоёрт, Торгон зам дайран өнгөрдөг Булгар хотыг эзлэн авах, гуравт, Кибчагуудыг өмөөрч дайсан болсон Оросын хилийг цэвэрлэх бодлогоос үүджээ<sup>2</sup>.

Булгарыг дайлж, тулалдааны талбараас зугатагсадыг Днепр мөрөн хүртэл монголчууд нэхэн хөөжээ. Гэвч буцахыг тушаасан Чингис хааны зарлигийг элч авчирсан тул Сүбээдэй, Зэв нар нутгийн зүг жолоо залжээ.

Тэр үеэс эхлэн Кибчагийн тал бүхэлдээ, Урал, Ижил болон Дон мөрний сав газар, Каспийн тэнгисийн орчмын тал нутаг, Өмнөд Орос, Умард Кавказ болон Хятадын нутгаас Хар тэнгис хүртлэх уудам газар нутаг Чингис хааны эзэмшилд оржээ. Эцгийн сургаал, эзэнт төрийн бодлогыг Зүчи дагаж, Ази-Европын заагийн уудам нутагт эзэмшлээ тогтоож чадсан боловч нас залуугаар хорвоог орхисноор Оросыг дагуулж, Европ руу нэвтэрч амжаагүй юм.

Тухайн үед монголчууд дэлхийд хамгийн сахилга баттай, дээд зэргээр зохион байгуулагдсан армитай байсан бөгөөд түүнийхээ ачаар Их гүрнийг байгуулж, хэдэн зуун жил ноёрхлоо тогтоож чадсан гэж түүхч, судлаачид үзэж байна.

Чингис хаан өөрийн биеэр үлгэрлэн цэрэг удирдах, байлдах урлагийг хөвгүүддээ заан сургасан ажээ. Чингис хаан өөрөө цэргийн алдарт жанжин байсан төдийгүй нэгэн үеийн нэрт жанждыг хүмүүжүүлэн гаргасан нь дэлхийн цэргийн урлагийн түүхэнд мөнхрөн үлджээ. Жанжин Сүбээдэй, Зэв нар цэрэг удирдах чадвар, стратеги, тактик зохиох аль ч талаараа европын ямар ч жанждаас, тухайлбал Македонийн

<sup>1</sup> Ч.Чойсамба. Бат хааны байлдан дагуулал. УБ., 2003. т. 33.

<sup>2</sup> Х.Шагдар. Монголын аян дайн, цэргийн урлагийн түүх (XIII зуун). Боть. II. УБ., 2000. т. 432

Александр, Юлий Цезариас давуу болохоо харуулж чадсан юм. Тийм туршлагатай жанжид Чингис хааны хөвгүүд, залгамжлагчдыг дайн тулалдааны талбарт ч, төрийг удирдах их хэрэгт ч амьдрал дээр заан сургасан юм. Тиймээс тэд хэний ч байгуулж чадаагүй Эзэнт гүрнийг байгуулж, тодорхой хугацаанд эрхшээлээ тогтоож чадсан юм.

Дэлхийд нэр гарсан жанжин Зэв, Сүбээдэй нар Зүчи болон түүний хүү Бат нартай хамтран өрнө дахины олон орныг Монголын эрхшээлд оруулах их хэргийг нэр төртэй гүйцэлдүүлсэн юм.

Чингис хаан эзлэн авсан нутгаа дөрвөн хөвгүүндээ хувааж өгснөөс ууган хүү Зүчид монгол морины туурай хүрсэн өрнө зүгийн газар нутгийг хувь болгосноор Зүчийн улсын үндэс тавигджээ. Зүчи улсаа зохион байгуулах талаар дорвитой зүйл хийж амжилгүй ертөнцийн мөнх бусыг үзүүлжээ.

Өгэдэй хаан 1235 онд Далан даваанд Их хурилдай зарлан хуралдуулж, олон чухал асуудал хэлэлцжээ. Чингис хааны гэрээсийг хэрэгжүүлж, Зүчидийн Алтан улсыг бүхэлд нь амжилттай байлдан эзэлснийг тэмдэглээд, Өрнө зүгт дайтаж яваа цэргийн хүчийг нэмэгдүүлэх, их цэргийг нэгтгэн захирах үүргийг Бат хаанд ногдуулах шийдвэрийг гаргажээ. Ийм шийдвэр гаргахдаа Зүчийн улсын нутаг дэвсгэр, газар зүйн байршил нь Орос, Европын чиглэлээр аян дайн хийхэд нэн тохиромжтой ар тал, түшиц газар болохыг харгалзсан биз ээ.

Зүчийг таалал төгссөний дараа түүний орыг хэнээр залгамжлуулах асуудал гарахад Чингис хаан ямар ч эргэлзээгүйгээр Батыг нэр заасан нь Зүчийн бусад хөвгүүдээс олон талаараа давуу байснаас тэр буй за.

Их хаан Өгэдэй ч, эзэнт гүрний баруун жигүүрийн хоёр том улсыг захирсан Цагадай, Бат нар ч Орос, Европ руу хийх их аян дайнд нухацтай бэлтгэж, онцгой ач холбогдол өгч байсан нь ажиглагддаг.

“Монголын нууц товчоон”-д тэмдэглэснээр 1232 онд Өгэдэй хаан эхлээд Орос орныг дайлуулахаар Сүбээдэй баатрыг цэргийн хамт илгээжээ. Гэтэл тэндхийн улс иргэдийн эсэргүүцэл үлэмж их, цаашид давшихад хүч дутаж байсан тул Бат, Бүри, Мөнх тэргүүтэй хан хөвгүүдийг нэмэгдэл хүчний хамт илгээсэн ажээ. Энэ аянд мордсон бүх хөвүүд ноёдыг Бат ахлан захиртугай! ...Гол улсаас гарсан цэргийг Гүюг ахалтугай! гэж зарлиг болгожээ. Энэ аянд улс иргэнийг захирсан хан хөвүүд өөрсдийн хөвүүдийн ахмадыг явуултугай! Улсыг эс захирсан хан хөвүүд, түмэн, мянган, зуун, аравны ноёд хэн боловч мөн өөрийн хөвүүдийн ахмадыг явуултугай! Ханы охид хүргэд мөн түүний адилаар хөвүүдийнхээ ахмадыг явуултугай! гэж зарлиг буулгажээ<sup>1</sup>.

Эзэнт гүрэн даяар их хаанаас авахуулаад энгийн иргэн хүртэл айл

<sup>1</sup> Монголын Нууц Товчоо. § 270

бүрийг хамарсан, тэгш шууд, хатуу шударга ийм дайчилгаа явуулах саналыг Цагадай гаргасан ажээ. Цагадай ийм алхам хийх хэрэгтэйг Өгэдэйд тайлбарлахдаа "... Цэрэг олон бол үзэгдэх сүр хүч их болно. Тэнд дайсны хүн үлэмж, харийн улс олон бий. Тэр хязгаарын улсууд хэцүү. Хилэгнэвэл өөрийн биеийг мэсээр хорлож үхэх улс бий. Хурц мэтэй гэнэ" гэж элч илгээн хэлүүлж байсан ажээ. Өгэдэй хаан ахынхаа үгийг ёсчлон дагаж, Цагадай ахын сэрэмжлүүлэн хэлснээр хөвүүдийн ахмадыг томилж явуулъя хэмээгээд Бат, Бүри, Гүюг, Мөнх нарыг аянд мордуулжээ. Тиймээс ч ахмад хөвгүүдийн аян дайн хэмээн түүхэнд алдаршжээ.

Өрнө зүг хийх аян дайны тэргүүн жанжнаар томилогдох үедээ Бат 27 настай, шилдэг залуу жанжин гэж нэрд гарч байсан цаг ажээ. Бат хаан эцэг, өвгөдийн сургасны дагуу дайсныхаа талаар нарийн мэдээлэл цуглуулж, тэднийг сайн таньж мэдсэний үндсэн дээр байлдах арга тактикаа боловсруулж байсны ачаар монгол цэрэг амжилтад хүрч байв. Байлдан буй нутаг орны байдал, дайсны цэрэг зэвсгийн чадавхи, тэндхийн улс үндэстний онцлогийн тухайд тэрээр маш сайн мэдээлэлтэй байжээ.

Бат ханы захирсан Монголын их цэрэг 1236 оны хаврын эхэн сард Эрчис мөрний эх, Алтайн чанадаас өрнө зүг хөдөлжээ. Туршлагатай жанжин Сүбээдэйг Бат ханы зөвлөхөөр Өгэдэй хаан томилжээ. Сүбээдэй жанжин цэрэг удирдахаас илүүтэй эрх мэдэлдээ эрэмшсэн хан хөвгүүдийн эе эвийг олж, нэгэн удирдлагын дор зохицуулах ихээхэн төвөгтэй үүргийг хүлээсэн юм.

Бат, Сүбээдэй нар их цэргийн аян замын дэг журмыг юуны өмнө чандлан тогтоожээ. Тухайлбал, Гүюг, Хадаан, Мөнх, Бүри нарын хан хөвүүд тус тусын цэргийг засч, түмт бүр бие биеэс нэг өртөө зайд аялах, явах зам, хоноглох газрыг толгойн сэргийлэх ангиуд тогтоох, ачаа хөсгийг тусгай цэрэг томилон хамгаалах, замын хоол хүнсийг ав хоморго хийж сэлбэх, зар холбоог түргэн элчээр барих, заасан газар түмтийн ноёд саадгүй цугларахыг хатуу тушаасан ажээ.

Байлдааны явцыг Бат, Сүбээдэй нар нягт хянаж, хүчийг нь нэмэгдүүлэх, хүнсний хангалтыг хийх зорилтыг цаг тухай бүр шийдвэрлэж байв. Урьдчилан гаргасан байлдааны төлөвлөгөө ёсоор их цэргийн өмнө заншлан тагнах анги дайсны тухай мэдээг цаг алдалгүй хүргэж байв. Сүбээдэй баатар тагнуулын мэдээг бодит байдалтай нягт уялдуулан байлдааны тактикийг цэргийн жанждын хамт тухай бүр боловсруулж байсан нь амжилтад хүрэх нөхцөл болсон юм. Цэргийн тагнуулын сүлжээг гартаа атгаж мэдээллийн мөрөөр оновчтой зөв арга хэмжээ авч чадаж байсанд Сүбээдэй баатрын онцгой чанар оршино. Тэр үеийн

Орос, Дорнод Европын улс, аймгийн дотоод хямрал, гадаад холбоо, цэргийн тоо хэмжээ, зэвсэг техникийн байдлыг тагнуулын мэдээллээс бүрэн сайн мэдэж байжээ. Мөн түүнчлэн Венецийн худалдаачнаар дамжуулан баруун Европын байдлыг тандан мэдэж байв. Тиймээс Сүбээдэй баатрын нүд, чих Ромын Папын дэргэд бий гэх яриа ч гарч байжээ<sup>1</sup>.

Батын удирдсан их цэрэг Монгол нутгаас өрнө зүгт хөдлөхөд Ижил, Урал мөрний хөндийд Алтан ордны улсын цэрэг тосчээ. Батын дүү нар өөр өөрийн дайчилсан цэргийг хариуцан захирч байв. Бат хааны өөрийн нь түмтийг дүү Бэрх нь хариуцан засчээ. Ах Орд нь Сыгнакаас түмэн цэрэг гаргаж, дүү Шейбанд захируулан ирүүлжээ. Дүү Бувал Сибирийн ойн иргэдээ, мөн дүү Тангуд нь Бухар, Кокандаас тус бүр хагас түмэн цэрэг дайчлан иржээ.

Их цэрэг Урал мөрний зүүн эрэгт хүрч ирэхэд Бэрх, Шейбан нар Урал, Ижил мөрний хөвөөнд олон зуун завь онгоц цуглуулан, том том сал бэлтгүүлж, их цэргийг усаар гаргах бэлтгэлийг хангасан байв. Энэ хэрэгт Суздалийн ван Ярослав тус болжээ.

Ярославын тусыг Бат хан үнэлж, тэр цагаас түүнтэй холбоотны ёсоор харилцсан бөгөөд Ярослав ч Батад үнэнч зүтгэхээ андгайлжээ. Тэдний хамтын ажиллагаа олон жил үргэлжилж, Ярослав ван Бат хааны хуурай хүү болтлоо өргөмжлөгдсөн билээ.

Монгол цэрэг хоёр их мөрнийг бүтэн сарын турш ачаа хөсөгтэйгээ гатлажээ. Ижил, Доны сав, үржил шимт тал нутагт монгол цэрэг тархан буудаллаж, холын аяны алжаалаа тайлж, хүн малаа амрааж дараагийн их аяны бэлтгэлээ базаажээ. Ярослав ван дайчин нөхдөө авч Монголын цэргийг дагажээ. Сүбээдэй баатрын хүү Урианхадай, Бужигдай ноёны түмтүүд ирж нийлэв. Хөхөдэй, Сөнөдэйн цэрэг Кибчагийн талд түрүүлж ирээд хүлээж байлаа.

Батын цэргийн тоог судлаачид хол зөрүүтэй янз янзаар бичсэн байна. Жишээ нь, Г.В.Вернадский Бат ханы цэрэг 40 000, зарим нь 100 000 гаруй хүн ирснээс 30 000-35 000 нь цэрэг байсан<sup>2</sup>, Эренжин Хардаваа 1236 онд Орос руу цөмөрсөн Батын цэрэг зуун хорин мянгаас зуун тавин мянган хүнтэй байсан гэжээ<sup>3</sup>. Түүнийхээр бол, их цэргийн гуравны нэг нь монголчууд, үлдэх хэсэг нь эзлэгдсэн орны хүмүүс буюу Цагадай, Батын эзэмшлээс дайчилсан түрэг гарлын хүмүүс байсан байна. Мэдээж, тэднийг монгол дарга, даамал захирч явжээ.

<sup>1</sup> Эренжин Хара-Даван. Чингис-хан как полководец и его наследие. Элиста, 1991. стр. 155

<sup>2</sup> Ю.В.Мизун, Ю.Г.Мизун. Ханы и Князья Золотая Орда и Русские княжества. М., 2005. стр. 87

<sup>3</sup> Эренжин Хара-Даван. Чингис-хан как полководец и его наследие. Элиста, 1991. стр. 157

“Монгол цэргийн түүхийн товчоон”-д 1236 оны хавар Ижил мөрний Булгарын хил дээр Гүюгийн захирсан Монгол улсын гол цэрэг, мөн Мөнхийн захирсан монгол цэрэг, Байдарын захирсан Сартуулын цэрэг, Батын захирсан өрнө дахины цэрэг тус тусын газар орноосоо хүрэлцэн ирэхэд 120 000 цэрэг байсан ба түүнээс 5 түм нь монгол, 7 түм нь түрэг цэрэг байсан<sup>1</sup> гэсэн нь дээрхтэй үндсэндээ таарч байна.

Бат ханы захирсан их цэрэг 1236-1237 онд Кибчагийн тал нутгийг эзлэж, Каспийн тэнгис хийгээд Кавказийн уул нуруунаас өмнөх өргөн уудам газар орныг эрхшээлдээ оруулжээ.

1237 оны намар Их хурилдай хурж Орос орныг дайлах шийдвэр гаргав. Бат-Сүбээдэйн штаб тэр жилийн намар унаа малдаа тарга тэвээрэг авахуулж, цэргээ амраах завсар Оросыг дайлах төлөвлөгөөг нарийвчлан боловсруулжээ. Газар газраас авсан тагнуулын мэдээг нягтлан шалгахад Оросын вангууд өөр хоорондоо холбоо барьж, цэрэг зэвсгээ бэлтгэж эхэлсэн нь тодорхой болсон тул яаравчлах хэрэгтэй болжээ.

Батын их цэрэг 1237-1238 оны өвлийн эхээр Рязанийг чиглэн хөдлөв. Орос орон гол мөрөн, намаг балчиг ихтэй учир морин цэргийн довтолгоонд өвөл цаг хамгийн тохиромжтой гэж Сүбээдэй жанжин үзэж байв. Учир нь монгол хүн, морь хоёр хүйтэнд тэсвэртэйн дээр цэргүүд нь хүйтнээс хамгаалах дулаан нэхий хувцастай байв<sup>2</sup>.

Монгол цэрэг Рязаньд дөхөж очмогц элч илгээж, адуу мал, тариа будаа, алт мөнгө, эд хогшлынхоо аравны нэгийг<sup>3</sup> гаргаж өгөхийг шаардсан боловч Рязаны Георгий тэргүүтэй вангууд хүлээн авсангүй эсэргүүцжээ. 1237 оны сүүлээр Бат хааны их цэрэг Рязань хотыг эзлэн авав. Тулалдаанд Рязаны ван Георгий хүүгийн хамт амь үрэгджээ.

Бат Сүбээдэй нарын цэрэг цааш давшиж, Коломна хотыг гэнэт дайран цохив. Хотыг хамгаалсан оросын цэрэг гэнэтийн дайралтад сэхээ авч чадсангүй. Тэр цэргийг Суздалийн ван Юрий Всеволодовичийн бага хүү Владимир захирч байжээ. Монголын цэрэг тэндээсээ умар зүг давшсаар жижиг хэрмэн хамгаалалт бүхий Москваг тав хоног орчим тулалдсаны эцэст эзлэн авчээ. Жанжин Филипп Пянко тэргүүтэй хот хамгаалалтын цэрэг эрэлхэг тулалдсан ч их цэргийн өмнө хүч мөхөсдсөн юм. Рязанийн залуу ван Роман энэ тулалдаанд амь үрэгджээ.

Ийнхүү Владимир-Суздалийн вант улс руу орох зам нээгджээ. Батын цэрэг 1238 оны 2 дугаар сарын 3-нд Владимир хотод тулж ирлээ. Владимир-Суздалийн их ван Юрий Всеволодович хотын хамгаалалтыг

<sup>1</sup> Монгол цэргийн түүхийн товчоон. Боть I. УБ., 1996. т. 254

<sup>2</sup> Г.В.Вернадский. Монголы и Русь. Москва-Тверь. 2001. стр. 58

<sup>3</sup> Д.Оссон Монголчуудын түүх. УБ.,

дүү Святослав, хүү Мсчислав, цэргийн ноён Петр Ослядюкович нарт даатгаад өөрөө Псков, Их Новгород, Смоленск, Ярославлийн вангуудаас тусламж гуйж цэрэг цуглуулахаар Костров, Угличийн чиглэлд гарсан ажээ. Тэгмэгц Мөнхийн жигүүрийн түмтүүд Тверь, Ярославлийн чиглэлээр яаравчлан давшиж, Смоленск, Их Новгород, Псковаас тусламж ирж болзошгүй замыг таслан хаах, Иванова, Ростов, Костром зэрэг замын дагуух хот тосгодыг эзлэн авахыг Бат хаан зарлиг болгоод, тэндээсээ Владимерын вант улс руу давшжээ. Владимир хоёр хөвгүүнээрээ нийслэл хотоо сахиулаад, өөрөө Ижил мөрний салаа Сить гол руу зайлан явжээ.

1238 оны 2 дугаар сард Батын цэрэг Владимир хотыг дайран орж Их вангийн хүү Владимир Юрьевичийг алж хотыг шатаажээ. Бат хаан тэндээс цэргээ хэдэн тийш явуулж, нэг сарын дотор Иванов, Рязанов, Ярослав, Городец, Москва зэрэг вант улсын нутаг дэвсгэрт байсан олон хот балгасыг эзлүүлээд 1238 оны 3 дугаар сарын 4-нд Сить голын хөвөөнд ирж, Владимерын их ванг гэнэдүүлэн дайрч түүнийг алж, цэргийг нь бутцохижээ. Сить голын тулалдаан Орос орны цаашдын хувь заяанд асар их үүрэг гүйцэтгэсэн юм. Юуны өмнө зүүн хойд Оросын ирээдүй эл голын мөсөн дээр 250 жилийн хугацаатайгаар шийдэгджээ<sup>1</sup>. Улмаар цааш давшиж, Суздаль болон Ростов, Ижил мөрний дээд урсгал, Тверийн вант улс болон Торжок хотыг эзлэн авчээ.

Батын цэрэг Их Новгородын захад 100-150 км дөхөж очоод их намагт тулан буцсан байна. Өмнө зүг эргэн Смоленскийн вант улсыг эзлээд Черниговын вант улсын Козельск хэмээх жижигхэн хотыг дайлжээ. Хотын эргэн тойрон бартаа саад ихтэй, түүхч Жувейнийн бичсэнээр бүдүүн могой шургах аргагүй, битүү ойгоор хүрээлэгдсэн бас тэгээд хана хэрэм сайтай, хаалт боолт ихтэй тул хотыг шууд уулгалан дайрах боломжгүй байжээ. Гурван замын цэрэг нийлж хотыг давхар давхар бүслээд, чулуу шидэгч оньсон зэвсэг олноор зоон тал талаас нь харважээ. Бас хотын тал талаас гурваас дөрвөн тэрэг явж багтахаар зам засч, цайз хэрмийг давж хот руу нэвтрэхийн төлөө зууралдсан ширүүн байлдаан хийв. Козельск хотынхон 42 хоног (зарим судлаач хэдэн долоо хоног)<sup>2</sup> тэсэн эсэргүүцэж, хоёр тал ихээхэн гарз хохирол амсчээ. Бат ханы байлдан дагууллыг судалсан Д.Чойсамба “49 хоног эсэргүүцэж, 4000 цэрэг, түүний дотор түмтийн гурван ноён энэ тулаанд үрэгдсэн” гэжээ<sup>3</sup>.

<sup>1</sup> Д.Чойсамба. Бат хааны Байлдан дагуулал. УБ., 2003. т. 66

<sup>2</sup> Ю.В.Мизун, Ю.Г.Мизун. Ханы и Князья Золотая Орда и Русские княжества. М., 2005. стр.

<sup>3</sup> Д.Чойсамба. Бат хааны Байлдан дагуулал. УБ., 2003. т. 61

Козельскийг эзлэн авмагц хотыг шатааж хүн амыг нь хайр найргүй хяджээ.

Түүний дараа Дон мөрний хөвөөнд хэсэг саатаж цэрэг, агт морьдоо амруулжээ. Энэ үеэр найр цэнгэл болж, Батад захирагдахад дургүй байгаагаа Гүюг илэрхийлжээ. Өгэдэй хаан Гүюгийг монголд дуудан авчирч донгодсон билээ.

Бат аян дайнаа үргэлжлүүлж Чернигов, Переяславлийг 1239 онд эзлэн авч 1240 оны 11 дүгээр сарын сүүлээр Киевийг довтолж, 12 дугаар сарын 6-нд эзлэн авчээ. Түүнийг Орост байх үеэр Черниговын ван Андрей "татаарынхны агт морьдыг нутгаасаа хулгайлан авч өөр газар зарсан хэргээр Батад буруушаагджээ. Хэдийгээр энэ хэрэг нь нотлогдоогүй боловч тэрээр алагдсан хэмээн Пано Карпини тэмдэглэлдээ бичжээ<sup>1</sup>.

Хотын хүн амын нэлээд хувь нь дайнд үрэгджээ. Үлдсэн хүмүүсийн нэг хэсгийг боол болгон худалдахаар ялган авчээ.

Монголын жанжнууд Оросын хязгаарыг орхиж явахдаа Киевийн газар нутгаас хоол хүнсээ залгуулж байхаар шийдвэрлэжээ. Тэд Болоховын газар нутгийн тайж нартай хэлэлцээ хийж тэндэх хот суурин, гацаа тосгодоос монгол цэргийн гурил будааны хэрэгцээг хангуулж байхаар тогтжээ. Галиц-Волыны ван Даниил Романович Польшоос Орост буцаж явахдаа Болоховын тайж нарыг урвагчид хэмээн үзэж дайлжээ. Вангийн цэрэг хотуудыг түймэрдэж хэрэм цайзыг нь нураасан аж. Дайнд Болоховын 6 хот устсан нь монгол цэргийг хүнсээр хангахад муугаар нөлөөлжээ.<sup>2</sup>

Бат гол цэрэгтэйгээ Унгар руу хөдлөхдөө Польш, Чех, Болгарын талаас гарч болзошгүй дайралтаас хамгаалахын тулд Мөнх, Гүюг, Хадаан, Орд, Байдар, Бирюй, Бечак, Сүбээдэй, Бурундай нарыг цэргийнх нь хамт татжээ.

Зүүн Европыг эрхэндээ оруулсны дараа 1241-1242 он гэхэд Батын цэргийн тоо 600 000 хүрсэн гэж Оросын генерал М.И. Иванин<sup>3</sup> өгүүлснийг итгэхэд хэцүү ч Батын цэрэг олон чиглэлээр хуваагдан давшилтаа хийж байсан, эзэлж авсан улс орон, газар нутгаас цэрэг дайчилж гол хүчээ сэлбэж байсан, түүнчлэн олзны олон хүмүүсийг дайчлан зам гүүр засуулж, далан шуудуу бариулж, их цэргийн өмнө жийрэг болгон ашиглаж байсан тухай мэдээ ч түүхийн сурвалжид олонтаа дурдсан байдаг. Энэ дашрамд тэмдэглэхэд, монголын цэрэг

<sup>1</sup> Татаар монголчууд Ази-Европт. УБ., т. 245

<sup>2</sup> Мөн тэнд. т. 245

<sup>3</sup> М.И.Иванин. О военном искусстве и завоеваниях монголо-татар и средне-азиатских народов при Чингис хане и Тамерлане. СпБ., 1875

тоймгүй олон, харгис хэрцгий байснаас л эсрэг тал нь ялагдаж байсан мэтээр өрөөсгөл, өнгөц дүгнэлт хийх хандлага өнгөрсөн түүх бичлэгт давамгайлж байсан юм.

Оросын вангууд хоорондоо нэгдэж чадахгүй болтлоо улс төрийн бутралд автсан байсан нь оросын цэрэг ялагдах нэг гол шалтгаан байжээ. Мөн монголын цэрэг оросын цэрэгтэй тулахаас өмнө олон орны цэргүүдтэй байлдан ялсаар тулалдааны арга туршлага, байлдааны хат суусан байжээ.

Умарт Оросын вант улсуудын цэрэг, зэвсэг, эдийн засгийн чадавхи нь өмнөтийнхөөс илүү учир Бат эхлээд Хойт Оросыг салангид дээр нь түргэвчилсэн давшилтаар сэхээ завдал өгөлгүй цувуулан цохих тактик сонгосон бөгөөд тэр нь ч зөв шийдэл байжээ. Ус мөрөн, намаг балчиг ихтэй энэ их нутгийг газар ус хөлдсөн хойно дайлаар мордсон нь хуурай газар дассан Монголын морьт цэргийн хувьд оновчтой сонголт байсан юм. Солонгосын сэтгүүлч Ким Жон Рэ бичихдээ Монголын "... хөх цэрэг нь тухайн үедээ хамгийн үр ашигтай, өндөр бүтээмжтэй арми байв. Гол зорилго нь цөөн тооны хүчээр их хүчийг ялахад оршино. Үр дүн нь эзлэгдсэн улс ард түмний тоогоор хэмжигдэнэ. Чингис хааны үед Монголын хүн ам дээд тал нь хоёр сая байсан бөгөөд хөх цэргүүд 200 мянга л байв. Тэдний дунд жинхэнэ тал нутгийн монгол цэрэг 100 мянгаас хэтрэхгүй байсан"<sup>1</sup> гэжээ.

Бат хан Оросыг эрхшээлдээ оруулсны дараа Галиц болон Вольний вант улсыг байлдан дагуулж "1241 онд Карпатын нурууг даван Краковыг эзлэн авчээ". 1241 оны хавар Одер мөрнийг гатлаж Болеславыг байлдан эзлэв. Үүний дараа Бат нөгөө замын цэрэгтэй хүч хамсан Легницийг байлджээ. 1241 оны 4 дүгээр сарын 9-нд Польш улсын ван II Хенри Побожный 30 мянган цэргээ 5 замд хувааж байлдан ялагдаж, өөрөө дайны талбарт амь үрэгджээ. Бат хан дайны ялалтаа бүртгэхдээ дайсны баруун чихийг нь огтлуулан авахад 9 уут болсон гэж сурвалжид тэмдэглэсэн байдаг авч үүнийг батлах буюу үгүйсгэх боломжгүй юм.

1241 оны 3 дугаар сард Бат хан их цэргээ 3 замд хувааж, өөрөө Орос нэрт боомтоос, Байдарын захирч байсан цэрэг Пржемисээс (Чехословакаас), Хадаан, Сүбээдэй баатрын захирсан цэрэг Украйны баруун өмнөд хэсэг дэх Мултавскийгээс тус тус Унгарт цөмрөн оржээ. Зам зуурын хот тосгодыг эзлээд Пешт хотод тулж ирэх үед Унгарын эзэн хаан IV Бела монголчуудтай байлдахаар Саюу голын баруун хөвөөнд гарч буудаллаад 1000 цэрэг илгээж, голын хөвөөг сахиулжээ. Тэр үед монгол цэрэг голын зүүн хөвөөнд түр буудаллаад шөнө дөлөөр цэргийн

<sup>1</sup> Ким Жон Рэ. Их шуургангаар өнгөрсөн түүх. УБ., 2000. т. 159

зохион байгуулалтыг шинэчлэн цэргээ хоёр хувааж үүрээр довтолсон ажээ. Нэг замын цэрэг нь Саюу голыг гатлаж, нөгөө замын цэрэг нь гүүрийг эзэлжээ. IV Белагийн дүү Коломан цэрэг авч байлдах гэтэл Унгарын цэрэг буудалласан газраасаа бутран сарниж эхэлсэн байлаа. Монголын цэрэг бүслэлтээ татсанд Унгарын цэрэг гарах замтай болсныг мэдмэгц амь зулбан зугатжээ. Монголын цэрэг 2 өдөр араас нь шаламгайлан нэхэж, Унгарын цэргийг бутниргэсэн байна. IV Бела хурдан морь унасаны ачаар зугатан гарч, Карпатын орчимд байх Тереш хотод хүрч, хүргэн Ворославтайгаа учран аюулаас мултарчээ.

Монголын гурван замын цэрэг 1241 оны зун Дунай мөрний хөвөөнд түр амсхийгээд ус хөлдмөгц Дунай мөрний хөвөөнд орших Стригунов хотыг байлдан эзлэхээр мордов. Дунай мөрөн нь олон зуун жилийн турш хөлддөггүй байснаа тэр өвөл хөлдсөн ажээ.

Бат хан голын мөс хэр зэрэг хөлдсөнийг тандан мэдэхээр адуу малаа энд тэнд тарааж орхисон байна. Монголчууд адуу малаа орхиод сураггүй алга болсонд хотын иргэд гайхаж, голын мөсөн дээгүүр гарч ирэн адуу малыг хураан аваачихыг Бат үзээд цэргээ хөдөлгөн голыг гарч, Стригунов хотыг бүслэн авч байлджээ.

Хотын иргэд бэхлэлт цайзынхаа бат бэхэд найдан монголын цэргийг ойшоохгүй байв. Бат ханы цэрэг хотоос нэлээд хол буудаллаад 30 чөдөр оньс байрлуулан том будуун мод чулууг хот руу тоо томшгүйгээр шидэн оруулжээ. Олзлогдогсдоор элс, шороо зөөлгөн гүн сувгийг бөглүүлж, хэрмийн өөд авиран гарч эзлэн авчээ.

Удалгүй Өгэдэй хаан нас барсан тухай гашуудлын мэдээ ирсэн тул Бат их цэргээ хураан нутгийн зүг жолоо залжээ. Европоос монгол цэрэг гэнэт буцсан шалтгааныг судлаачид янз бүрээр тайлбарладаг. Зарим нь монголын байлдан дагуулагчид Оросын армийн шилдэг цэрэгтэй урт хугацаанд зууралдан байлдсанаас хуч нь суларч Европт удаанаар байлдах боломжгүй болсон гэдэг бол Зүүн Европын орнууд хэдийгээр ялагдсан ч монголын цэрэг армид зохих ёсны хохирол учруулж байсантай холбоотой гэдэг. Г.Стракош-Грассмани "Европын соёл иргэншил нь Германы эзэн хаадын болгоомжит бодлого, тэдний цэрэг зэвсгийн хүчээр аврагдсан" гэж өгүүлснийг нь Б.Шпулер дэмжиж байжээ.

Монголын судлаачид монголын цэрэг европоос буцсан шалтгааныг Их хаан Өгэдэй таалал төгссөнтэй холбон үздэг юм<sup>1</sup>. Г.Вернадский "Өрнө дахин санамсаргүй аврагдах болсон нь алс холын монголд гарсан

<sup>1</sup> Colman S., Enchimg C. Podboj polski przez wojska Bata i t.d. Entwertung Polens durch Ar-

үйл явдлын үр дүн” гэж их хааны таалал төгссөнтэй холбон өгүүлжээ<sup>1</sup>.

Монголын өрнөд фронтыг удирдаж байсан Бат хан цэргээ аван яаравчлан буцсаны гол шалтгаан нь Их хааны орыг хэн залгамжлах вэ гэдэгтэй холбоотой байв. Бат хан үүнд хамгийн их санаа зовж байсан нь Өрнө зүг дайлсан ахмад хөвгүүдийн аян дайны явцад гарсан нэгэн хэрэгтэй салшгүй холбоотой юм.

Бүр 1238 онд Кибчагийн уудам талд Бат ханы их цэрэг түр амсхийх үед энэ хэрэг болсон билээ. Бат хан эр цэрэг, агт морьдынхоо хийморийг сэргээхээр тэр зун (1238 он) их найр наадам үүсгэн байхад Өгэдэйн хүү Гүюг, Цагадайн ач Бүри хоёр Бат ханыг өчүүхэн зүйлээр өөчлөн, доорд муу үгээр доромжлон дайрч, хурим найрыг хаян оджээ. Тус тусын хүчирхэг цэргийг захирсан, нэр нөлөө бүхий хан хөвүүд тийнхүү их аяныг тэргүүлэн яваа Батыг эсэргүүцсэн нь алтан ургийнхны дунд урт удаан үргэлжилсэн эвдрэлийн үүдийг нээсэн хэрэг болсон юм. Хэдийгээр түүний нэр хүндэд халдсан ноцтой хэрэг болсон боловч Бат хүлээцтэй хандаж, яаралтай бичиг шийтгэн түргэн элчийг мордуулж, их хаан Өгэдэйд эл хэргийн тухай сонордуулж, хэрхэхийг асуулгажээ.

Энэ тухай “Монголын нууц товчоо”-нд “...Мөнх тэнгэрийн хүчинд, хаан ахын сууд Мэгэд хотыг эвдэж, Орос улсыг эзэлж, зүг зүгт арван нэгэн харь улсыг оруулж, алтан жолоогоо татаж, салалцах болоход их асар босгож хуримыг хуримлав. Энэ хуриман дээр би бүх хан хөвүүдийн ахмад тул нэг хоёр аяга сархад тэргүүлэн уув. Гэтэл Бүри, Гүюг нар надад муудаж хуримаас гарч одов. Явахдаа Бүрид хэлсэн нь: “Бат бид адил байтал, яагаад түрүүлэн уух билээ? Тэр сацуурхах санаатай сахалт эмгэнийг өсгийгөөр давтаж, өлмийгээр гишгэчих юм сан!” гэжээ. Гүюгийн хэлсэн нь: “Бид хоёр тэр нум сум агссан эмгэдийн эгмийг харвалдъя” гэжээ. Элжгэний хөвүүн Аргасуны хэлсэн нь: “Тэдэнд модон сүүл зүүлгэвэл зохино” гэв: (ууцанд нь сум зооно гэсэн утга биз —*зохиогч*) Бид харь элэгтэй, дайсан улсын дотор явж байгаа учир зүйгээ гаргаж хэлсэн боловч, Бүри, Гүюг хоёр тэгж хэрүүлийн үгийг хэлээд найрамдэлгүй тарав. Одоо яахыг хаан авга мэдтүгэй!”<sup>2</sup> гэсэн байна.

Ийм үгийг сонсоод Өгэдэй хаан маш хилэгнэж, “Энэ түрэмгий гайхал хэний үгэнд орж ах хүнийг ам мэдэн доромжлох болов? Ганц муу өндөг ялзарчээ. Ах хүний өөдөөс эсэргүүцсэн ажээ. Харь хол газар хайгуулд явуулж, арван хурууны нь хумсыг ханзартал уул мэт хотыг эзлүүлэхээр урагш зүтгүүлье! Зах хол газрын захирагч болгож, таван хурууны нь хумсыг тамгартал бат бэх хотыг байлдуулан авируулья. Бузар муу түрэмгий Аргасун хэнийг дуурайж, бидний ургийн хүнд ам

<sup>1</sup> Татаар монголчууд Ази-Европт. УБ., т. 242

<sup>2</sup> Монголын нууц товчоо. §275

гарч доромжлох үг хэлэв? Гүюг, Аргасун хоёрыг хамт илгээе! Зүй нь Аргасуныг албал зохих билээ. Гэтэл та нар алагчлав гэх биз. Бүрийн тухай бол Батад хэлэгтүн. Цагадай ахад хэлж илгээтүгэй. Цагадай ах мэдтүгэй!<sup>1</sup> гэв. Энэ зарлигийг Батад яаралтай довтолгон илгээжээ.

Өгэдэй хаан өөрөө Батыг баруун зүгийн их аяны тэргүүнд тохоон томилсон учир зарлигийн ёсоор бусад хан хөвүүд түүнд захирагдах ёстой байв. Их хааны зарлиг ёсоор Гүюг, Аргасун нар яаралтай хүргэгдэн иржээ. Өгэдэй хаан эхэлж Гүюгтэй уулзсангүй. Түүний цэрэгт явсан хашир ноёд, хан хөвүүдтэй уулзан, юу болсныг бүрэн мэдэж авчээ. Хан хөвүүн Мөнгэй (Мөнх), Алчидай, Хонхордай, Жанги гээд олон итгэлт цэргийн ноёд Гүюгийн тухай их хаанд үнэн мөнөөр илтгэн хэлж, эцэст нь: “Чингис хаан эцгийн чинь зарлиг билээ. Хээрийн үйлийг хээр шийтгэж, гэрийн үйлийг гэрт шийтгэх билээ. Хаан одоо Гүюгт хилэгнэж байна. Энэ бол хээрийн үйл хэрэг мөн. Хаан соёрхвол энэ хэргийг Батад тушааж илгээвэл болох уу?”<sup>2</sup> гэж өчжээ.

Өгэдэй хаан тайвширсан хойноо, “... Алчидай, Хонхордай, Занги нар бургилсан зүрхийг дарах нөхөр болж, уур хилэнг минь амарлиулав” гээд, “...Хээр болсон хэрэг тул үүнийг Бат шийтгэвэл зохино. Гүюг, Аргасун хоёрыг Бат мэдтүгэй. Бүрийг Цагадай ах мэдэж шийтгэтүгэй” гэжээ<sup>3</sup>. Өгэдэй хаан хүү Гүюгээ буруушаан донгодож, “...Аянд явах зуур эрүүл бөгстэй хүнийг үл үлдээсэн гэнэ чи. Цэрэг хүний нүүрийн арьсыг хуулж явсан гэнэ чи. Чиний тэр уур хилэнгээс айж, Орос улс дагаж орсон гэж бодож байна уу? Чи Орос улс иргэнийг ганцаараа дагуулж оруулсан мэт санаж бардам омог гаргаж, ах хүний өөдөөс эсэргүүцэв үү? Чингис хаан эцгийн зарлигт: Олон хүн хүчтэй, Гүн ус аюултай гэж бий бишүү. Сүбээдэй, Бужиг хоёрын далавч дор явж, олон бүгдээр хамсаж, Орос, Кибчагуудыг оруулж авсан байтал, чи анх удаа гэрээс гараад Орос, Кибчагын нэг ч хүнийг олж барьсангүй, адаглавал ишигний шийр ч олж авсангүй байж эрэмгий түрэмгий зан гаргаж, ийм тийм үг хэл болж, ганц биеэ гайхуулж явдаг чинь юу вэ?”<sup>4</sup> гэж зэмлэжээ.

Их хааны зарлигийг Бат хүлээн аваад Гүюг, Аргасун хоёрт хатуу шийтгэл ноогдуулсангүй. Тэр хоёрыг цэрэгтээ эргүүлэн авч, Европын их аянд оролцуулсан билээ. Бат хүлээцтэй, уужуу, ухаалаг хүн байсны нэг нь энэ жишээ юм.

Бат их хааны зарлигаар Бүрийг Цагадай хаанд хүргүүлсэн боловч өвөө нь түүнийг хэрхэн шийтгэсэн нь тодорхойгүй. Батын Европ руу

<sup>1</sup> Монголын нууц товчоо. §277

<sup>2</sup> Монголын нууц товчоо. §277

<sup>3</sup> Монголын нууц товчоо. §277

<sup>4</sup> Монголын нууц товчоо. §277

хийсэн аянд Бүрийн нэр дурдагдахгүй байгаагаас үзэхэд, Цагадай түүнийг буцааж явуулаагүй бололтой. Бүри хожмоо Гүюгийг хаан ширээнд өргөмжлөхөд идэвхтэй оролцсон тухай, Бат, Мөнх хоёрыг заналхийлсний улмаас Сарай хотод хүргэгдэн цаазлагдсан тухай мэдээ бий.

Бат тэр удаа Гүюгийг өршөөсөн шийдвэр гаргахдаа уг асуудлын үр дагаврыг олон талаас нь бодсон биз. Гүюг бол Их хааны угсаа залгамжлах хөвгүүдийн нэг, түүний нөлөө, нэр хүнд багагүйн дээр голын цэргийг захирч явсан гэдгийг нь эрхбиш харгалзан үзсэн болов уу.

Өгэдэй хаан Батад уг хэргийг шийдвэрлэх бүрэн эрх өгснөөр түүний нэр хүндийг өргөж, Батыг хан хөвүүдийн “ахмад”, их цэргийн ерөнхий командлагч гэдгийг дахин нотолсон юм. Батын нэр төр их цэргийн дунд улам өсчээ.

Бат тэр удаа Гүюгийг уучилсан ч тэр хоёрын дунд хэзээ ч эвлэршгүй ан цав үүссэн бөгөөд тэр нь хожмын хэрэг явдлуудаас тодорхой харагдана. Хэрэв Их хаан Өгэдэйн орыг Гүюг залгамжилбал Батад ихээхэн төвөгтэй байдал үүсэх нь тодорхой байсан учир тийнхүү эх нутгийн зүг яаравчлан жолоо залсан ажээ. Түүний дээр монгол цэргүүд олон жил эх нутгаас алс байлдаж ядарч туйлдсан нь ийм шийдвэр гаргахад нөлөөлсөн нь мэдээж хэрэг юм.

## 2. АЛТАН ОРДОН УЛС БАЙГУУЛАГДСАН НЬ

Хүн төрөлхтний түүхэнд Монголын хэмээх нэгэн үе тохиож, тэр нь монголчууд XIII-XIV зууны турш Евразид 200 гаруй жил ноёрхлоо тогтоож, тэдний үлдээсэн өв соёл нь сайн, муу хэмээсэн тодотголтойгоор хэдэн зуунаар үргэлжилсээр эдүгээ хүрчээ.

Судлаачдын үзэж буйгаар 1541 онд бичигдсэн Оросын нэгэн сурвалжид Алтан Орд гэдэг нэр томъёо анх тэмдэглэгдсэн гэж үздэг. Монгол хаад дотор, гадаргүй алт, мөнгө, алтадсан эд зүйлсээр Орд өргөөгөө чимж байснаар тийнхүү Алтан Орд хэмээх нэр томъёо гарсан гэдэг.

Улсын нэрийн тухайд Оросын археологич, Марк Крамаровский Алтан ордон улс гэж түүхэнд хэзээ ч байгаагүй. Оросын он дарааллын бичгүүдэд XVI зуунаас эхлэн Алтан орд, Их Алтан орд гэдэг нэр гарч ирдэг юм. Энэ нь Зүчийн удмынхны захирсан улсын Сыра орд буюу Шар орд гэдгийн орос хуулбар гэжээ<sup>1</sup>.

Зүчи хааныг залгамжилсан хаад нь үндсэндээ гурван том бүлэг буюу Бат, Орда, Шейбаны удмын хаадын захиргаанд хуваагдан 1242-1480 он хүртэл 238 жил оршин тогтножээ.

Бат хаан нь Чингис өвгийн сонголтоор эцгийн хаан ширээг залгаж, Өгэдэй хааны зарлигаар Кибчагийн тал нутаг, Оросыг байлдан эзэлж Дорнод Европт хүрэн, Монголын Эзэнт гүрний хаяаг тэлж, түүхэнд Алтан ордон улс хэмээх хүчирхэг улсыг байгуулсан билээ.

Алтан Ордон улс байгуулагдаж оршин тогтносон үеийг ерөнхийд нь гурав хувааж авч үзэж болох юм. Алтан ордон улс байгуулагдаж төвхнөсөн үе. Энэ үед Бат, Бэрх нарын төр барьсан буюу 1242-1266 оныг хамруулж байна. Өгүүлэн буй үед Алтан ордон улсын хил бүрэлдэн тогтож, удирдлагын тогтвортой систем буй болж, дотоод, гадаад харилцааг хөгжүүлж, хөрш орнуудтай нягт холбоо тогтоох, хот сууринг сэргээх буюу шинээр босгох худалдаа эдийн засаг, алба татварын тогтолцоог оновчтой бүрдүүлэх, өртөө байгуулж, зам харилцааны шинэ сүлжээг

<sup>1</sup> Марк Крамаровский. Великая Орда Златая. Улус Зүчи как цивилизация. Российский исторический иллюстрированный журнал. Родина. 2003. №11. стр. 66-74

буй болгох, өөрөөр хэлбэл аж ахуй, соёл, нийгмийн хөгжил, шашин зан суртахуунаар өөр өөр улсыг төрийн нэгдсэн удирдлагад оруулж, шинэ улсыг төвхнүүлэн хааны засаглалыг бэхжүүлсэн гэж болно.

Тус улсын хөгжил цэцэглэлтийн үе нь 1267-1359 оныг хамарч байна. Энэ үед Алтан ордон улсын эдийн засаг бэхжин, соёл, гадаад харилцааны хүрээ өргөжиж, цэрэг-улс төрийн хүчин чадал өсч Евразийн болон өрнө, дорны улс төрийн харилцааг тодорхойлох гол хүчний нэг болсон гэж үзэж болно.

Алтан ордон улс нь энэ үед өрнө, дорныг улс төр, эдийн засаг, соёлын харилцаагаар холбох гүүр болж чадсан юм.

Гуравдах буюу Алтан ордон улсын улс төрийн хүчний задрал, унаалтын үе нь XIV зууны үеийн 60-аад оноос XV зууны 80-аад он хүртэл үргэлжилжээ.

Алтан ордон улсыг байгуулсан цаг хугацааг 1242-1243 он гэж судлаачдын ихэнх нь үздэг. Түүхч М.А.Усманов: ингэж үзсэн нь оросын он дарааллын бичгийн мэдээг ягштал баримталсан хэрэг бөгөөд бодит байдалтай нийцэхгүй хэмээн шүүмжлэлтэй хандаад Алтан ордон улс байгуулагдан төлөвшил, тогтнолыг олсон үеийг XIII зууны жараад оны сүүл үеэс авч үзэх саналыг дэвшүүлжээ<sup>1</sup>. Хэрэв жараад он гэж үзвэл тус улсыг үндэслэгч Бат хаан холбогдолгүй болж байна. Төлөвшил, тогтнол гэж үзвэл нэг хэрэг, харин үүсгэн байгуулсан тухайд бол яах аргагүй Бат хааны үед холбогдох нь гарцаагүй. 1240-өөд оны сүүл тавиад оны үед холбогдох Орос болон бусад хэлнээ буй сурвалжуудад ч Бат болон Бэрх хаан, түүний улсын түүхэнд холбогдох чамгүй чухал мэдээ бий<sup>2</sup>. Тэгээд ч Бат хаан 1255 онд таалал төгссөнийг ч бодолцох хэрэгтэй.

Бат хааны төр барьсан оныг ихэнхи судлаачид 1242-1255<sup>3</sup>, зарим нь 1226-1255<sup>4</sup> он гэжээ. Судлаач С.Товуудорж Бат хааны төр барьж эхэлсэн хугацааг 1226 он хэмээсэн нь эцгийн ор залгасан үеэс тооцжээ. Энэ ч бас бодууштай.

“Судрын чуулган”-д хижрийн 652 онд Бат таалал төгссөн гэснийг (1254 оны 2 дугаар сарын 21-нээс 1255 оны 2 дугаар сарын 9) бусад түүхэн үйл явдлын баримжаа болон түүхэн сурвалжуудын мэдээг харгалзан үзвэл 1255 он байж болохоор байна.

Бат хаан шинээр байгуулж буй Алтан Ордон улсын төр засаг

<sup>1</sup> М.А.Усманов. Золотая Орда: истоки и наследие-Сокровища Золотой Орды. Milan., Italy, стр. 31

<sup>2</sup> Золотая Орда в источниках. Т.1. Арабские и персидские сочинения. М., 2003; А.Галстян. Армянские источники о монголах.Извлечения из рукописей XIII-XIV вв. Перевод с древнеармянского, предисловие и примечания А.Г.Галстяна. М., 1962

<sup>3</sup> С.Товуудорж. өмнө дурдсан зохиол, т. 202

<sup>4</sup> А.Якубовский. Золотая Орда. М.,1937, стр. 53

захиргааны зохион байгуулалт, санхүү, эдийн засаг, алба татварын тогтолцооны бүхий л эх үүсвэрийг гардан тавилцсан юм. Тэрбээр өөрийн биеэр зовон зүдэн хурааж, тухайн улс орнуудын байршил, тэдний аж ахуйн онцлог, хүмүүсийн зан араншинг гадарлах хүний хувьд засаг захиргааныхаа зохион байгуулалтыг оновчтой хийж чаджээ.

Амьдралын хэв маяг, шашин шүтлэг, соёлын төвшин харилцан адилгүй орнуудыг нэгэн төрийн жолоонд зангидан барих бодлогыг боловсруулахад Бат хаанд сайн зөвлөхүүд чухал байв. Оросын Ярослав ван, түүний хүү Невийн Александр, мөн мусульман хүмүүс хаанд түшиг болж байсан мэдээ бий.

Бат хаан Евразийг холбосон өргөн уудам нутгийнхаа төв дунд буюу Ижил мөрний адагт төвлөн суурьшихаар шийджээ. Энэхүү сонголтыг хийхэд олон хүчин зүйл нөлөөлсөн байна.

*Нэгд*, Дешт-Кибчагийн өргөн уудам нутаг нь түүнийг дагалдан харийн нутагт очсон нүүдэлчдэд аж ахуйгаа эрхлэхэд нь илүү тохиромжтой байсан. Нийслэл Сарай хот барьж төвхнөтөл монголчууд нүүдлийн амьдралын хэлбэрээ хадгалсаар байжээ. Тэр өргөн уудам тал нутагт уугуул Кибчаг болон эзэн монголчууд урт хугацааны турш нүүдлийн маягтай оршин тогтнож байв.

*Хоёрт*, шинэ байгуулсан улсынхаа удирдлагын төв гэдгийг онцгой анхаарч байрлалаа зөв сонгосон нь төвлөрсөн удирдлага явуулахад илүү тохиромжтой байлаа.

Оросын эрдэмтэн Э.С.Кульпин: Бат нийслэлээ байгуулах газрыг хэрхэн сонгосныг мэдэхгүй ч сонгон авсан газар нь хүн ам ихээр нягтарсан үндсэн дүүргүүдээс өмнөд, умардаас тэнцүү зайтай, эзэмшил нутгийнхаа бараг төв дунд нь умард өргөргийн 48, уртрагийн 46 хэмд байсан<sup>1</sup> гэжээ.

*Гуравт*, Худалдааны гол замууд энэ нутгийг дайран өнгөрч байсныг харгалзсан. Алтан ордон улсын хаад нь худалдааны гол замуудын байрлалыг харгалзан улсынхаа төвийг сонгосон нь оновчтой сонголт байсан юм.

Оросын эрдэмтэн Егоров: Европт худалдаачдыг дэмждэг орон Италиас өөр байгаагүй бөгөөд Алтан ордон улсад тогтсон дэг журам нь худалдаа хөгжүүлэхэд бүхий л тааламжтай нөхцлийг дээд зэргээр ханган, эдийн засгийг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулж байв. Ингэснээрээ Алтан ордны хаад газар зүйн ашигтай байрлалынхаа үр шимийг хүртэж өрнө, дорныг холбогчийнхоо үүргийг гүйцэтгэж чадсан<sup>2</sup> гэж үзсэн юм.

<sup>1</sup> Э.С.Кульпин. Цивилизация Золотой Орды-Монгольская Империя и кочевой мир. Улан-Удэ, 2004. стр. 171

<sup>2</sup> В.Л. Егоров. Сарай, Сарайчик, Бахчисарай.... Родина. 1997. №3-4. стр. 72-76

Зарим судлаачид Алтан ордон улсын эрх баригчид бүтээн байгуулахаасаа илүү бэлэн ашиг орлогыг авчирч өгдөг худалдааг хэт шүтсэн<sup>1</sup> нь Эзэнт гүрэн мөхөх шалтгааны нэг болсон гэж үзсэн байна. Эдийн засгийн талаар хүчирхэг орон л өөрийн төрийн хүчирхэг бодлогыг хэрэгжүүлдэг нь эрт ч, өдгөө ч үед тодорхой юм. Тиймээс худалдааг хэт шүтсэн гэдэг зэмлэлийг олон талаас нь авч үзэх хэрэгтэй. Монгол хаадад худалдаа нь зөвхөн ашиг орлогын эх сурвалж байгаагүй юм. Тэд зөвхөн ашиг орлого харсан бол худалдаачдын барааг илүү үнээр авч, тэдэнд итгэл үзүүлэн төрийн албанд томилох хэрэг байгаагүй бүлгээ. Худалдаачид нь худалдааны орлогоос илүү их зүйлийг монгол хаадад авчирч өгч байсан юм. Юуны түрүүн харь орнуудын улс төр, эдийн засгийн байдал, эрх баригчдынх нь хувийн зан чанар болоод худ ургийн холбоо, худалдааны үнэ ханшийн мэдээ, шинэ техник, технологи зэрэг олон зүйлийг өөрөөр хэлбэл, худалдаатай гадаад харилцаа, соёл, шинжлэх ухааны хөгжил нэгэн цогц уялдаатай байдгийг монгол хаад олж харсны учир тэдгээрт онцгой ач холбогдол өгч байв. Иймээс ч дээр дурдсанчлан худалдаа, ялангуяа гадаад худалдааг хөгжүүлэх нөхцлийг дээд зэргээр бүрдүүлсэн юм.

Алтан ордон улсын газар нутгийн гадаад хүрээлэл нь ч мөн тааламжтай байв. Гаднаас заналхийлэх дайсангүй, Эл хааны улстай хиллэж буй нарийхан зурвас газрыг эс тооцвол халдан довтлохыг урин дуудах мэт сул дорой хөршүүдээр хүрээлэгдсэн байсан нь Алтан ордон улс хүчирхэгжин Ази тивийн өрнө талын хамгийн хүчирхэг улс болоход нөлөөлсөн<sup>2</sup> байна.

Алтан ордны газар нутаг нь дорно зүг Эрчис мөрнөөс, өрнө зүг Дунай мөрний доод урсгал, өмнө зүг Дербент (Дагестан) болон Арран (Өмнөд Азербайжан), хойт зүгт Ижилийн Булгар багтаж байв. Эрдэмтдийн тооцоолж байгаагаар дорноос өрнө хүртэл 5600 верст, өмнөөс умар хүртэл 4000 верст хүртэл газар нутгийг эзлэн байгуулагдав. Верст нь 1,1 км бол өрнөөс дорно хүртэл 61600 км, умраас өмнө 44000 км хавтгай дөрвөлжин нутагт Монголын Эзэнт гүрний бүрэлдэхүүний Алтан ордон улс байгуулагдав.

Бат нь эрч хүчтэй, ухаалаг, хүлээцтэй, найрсаг удирдагч хүний бүхий л шинжийг шингээсэн томоохон зохион байгуулагч байв. Тэрбээр алтан ургийнхны дотоодын зөрчил төдийгүй улсынхаа болон хувийн гомдлыг шийдвэрлүүлэхээр очсон олон орны элч төлөөлөгчдийн асуудлыг голчоор нь шийддэг ноён нуруутай, алсын хараатай удирдагч

<sup>1</sup> Э.С.Кульпин. Цивилизация Золотой Орды-Монгольская Империя и кочевого мир. Улан-Удэ, 2004. стр. 183

<sup>2</sup> М.Правдин. Чингис хаан түүний өв. УБ., 2005. т. 271

байсан юм. Тиймдээ ч харийн сурвалжуудад “Сайн хаан” хэмээн тэмдэглэгджээ.

Түүний тухай Монголын эзэнт гүрний түүхч Жувэйни «Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх» зохиолдоо бичсэнээс үзэхүл, Бат хариу боддоггүй өгөөмөр, зүйрлэшгүй уужим сэтгэлтэй хүн байжээ. Газар бүрийн ван, дөрвөн зүг найман зовхисын эзэд, хүн бүр түүнээ бараал-хахаар ирнэ. Тэгэхэд тэр хөгшин, залуу хүмүүс бэлгээ барихаас өмнө санд аваачин, монгол, лал бүгдэд хишиг хайрлан их багыг үл хайхарна. Газар бүрийн худалдаачид түүнээ янз янзын эд юмыг барихад тэр барьсан болгоныг аваад, оронд нь хэд дахин давуу үнэ бүхий зүйлийг хайрлана. Бат Рум, Бага Ази, Сирийн султан нарт илгээлт бичээд тэр талаар зарлиг буулгасан бөгөөд түүнд бараалхсан хүн зорьсноо биелүүлэлгүй буцдаггүй байв<sup>1</sup> гэсэн бол Армяны түүхч Киракос Гандзаки: “Бат хаан руу хаад, хан хөвгүүд, вангууд, худалдаачид, өмгөөлөл хайгсад бүгд л цувж байсан бөгөөд тэрбээр (их хаан) тэдэнд вант улс, эзэмшлийг нь шударгаар буцаан өгч зарлигийн бичгээр хангаж байсан тул хэн ч түүнийг эсэргүүцэж чаддаггүй байсан” гэжээ.<sup>2</sup> Энэ мэтээр Бат хааны өгөөмөр сэтгэлийн тухай өгүүлсэн нь олон буй. Бат хаанд зориулан босгосон хөшөө Туркт бий.<sup>3</sup>

Зүчийн улс нь хоёр том хэсэгт хуваагдаж, ахмад хүү Ордын эзэмшил нь зүүн талыг эзэмшиж Хөх Орд гэж байсан ба хоёрдахь хүү Батын орд нь баруун талыг нь эзлэж Цагаан орд гэж байжээ. Гэвч одоо ч энэ хувиарилалтын талаар эрдэмтдийн санал маргаантай, нэг мөр болоогүй, судалгаа нэхсээр байна<sup>4</sup>.

Бат хаан уламжлал ёсоор улсаа гурав хуваажээ. Улсын төв нь мэдээжээр тус улсын нийслэл байсан Ижил мөрний сав газар байсан бол баруун жигүүр нь Ижил мөрнөөс баруун тийш худалдаа эдийн засгийн гол төвийн нэг, баруун жигүүрийн удирдагчийн өргөө байрлаж байсан Крым төвтэй нутаг байв. Баруун жигүүр нь Дешт-Кибчаг буюу Кибчагийн тал хэмээн алдаршжээ. Оросын бичгийн сурвалжуудад кипчакийг половец хэмээн тэмдэглэсэн байдаг. Газар зүйч Хамдаллах Казвини (1281-1349) Ижил-Дон мөрний уудам тал нутаг өмнө нь Хазарын тал хэмээн нэрлэгддэг байсан бол XIV зууны эхээр аль хэдийн Кибчагийн тал хэмээгдэх болсныг тэмдэглэжээ.

Зүүн жигүүр нь Ижил мөрнөөс дорно зүгт Цагадайн нутагтай

<sup>1</sup> Г.Сүхбаатар. өмнө дурдсан зохиол, т. 104

<sup>2</sup> Гильом де Рубрук. өмнө дурдсан зохиол, т. 97

<sup>3</sup> Равиль Амирхан. Золотая Орда и ее правители. Казань, 2003. стр. 23

<sup>4</sup> Ю.В.Мизун, Ю.Г.Мизун. Ханы и князья Золотая Орда и русские княжества. М., 2005. с. 84-85; М.А.Усманов. Золотая Орда: истоки и наследие-Сокровища Золотой Орды. Milan., Italy. стр. 35.

хил залган оршиж байв. Энэ жигүүрийн эдийн засгийн гол төв, зүүн жигүүрийн тэргүүний өргөө байсан Хорезмын Ургенч байв. Тиймээс Зүчийн улсыг хоёр том жигүүрээр нь арабын сурвалжуудад Хорезм болон Кибчаг хэмээн нэрлэх нь бий<sup>1</sup>.

Алтан ордон улсын газар нутгийн тухай, улс нь 10 тойрогт хуваагдаж, тэдгээр нь Алтан ордон улсад цэрэг-засаг захиргааны нэгж болж байсан сонирхолтой баримтыг Мамлюкийн үеийн хамгийн сүүлчийн их нэвтэрхий толийг зохиогч, дундад зууны Египетийн эрдэмтэн Шихаб ад-Дин Абу-л-Аббас Ахмад ибн Али ал-Калкашанди (1355-1418) тэмдэглэн үлдээжээ. Энэ алдарт толь нь тухайн үеийн улс орны тухай үнэт мэдээлэл өгч байгаагаараа алдартай бөгөөд орнодийн орнуудад их судлагджээ. Оросын эрдэмтэн А.П.Григорьев, О.Б.Фролова нар дээрхи нэвтэрхий толийн Алтан ордон улсын түүхэнд холбогдох хэсгийг хэвлүүлсний<sup>2</sup> дотор засаг захиргаа, засаглалын талаар чухал мэдээллүүд байна. Алтан Ордон улсын засаг захиргааны зохион байгуулалт нь түмэн байсан бөгөөд түмэн нь дотроо Ордын түмэн, Оросын түмэн гэж хуваагдаж байсан гээд нийт улс нь төр-захиргааны 10 тойрог болж байсныг дэлгэрэнгүй тэмдэглэсэн нь тодорхойгүй олон зүйлийг нэхэн мэдэхэд тус болж байна. Тэдгээр 10 тойрогийн тухай товчлон дурдвал:

*Нэгдүгээр тойрог нь:* Хорезмын тойрог. Хорезмын хотууд нь түүний 2 нийслэл Кят болон Ургенч, мөн бага Ургенч (ө.х.Хива), Замахшар, Хазарасп, Дарган, Фарабр. Хорезмтай хиллэж байгаа улсууд нь Мангышлак-Каспийн тэнгисийн зүүн эрэгт байх томоохон хойг, хойгийн нэр нь минг, кышлаг гэсэн 2 түрэг үгнээс бүрдэх ба мянган өвөлжөө гэсэн утгатай. Хойгийн умард талд Каратау (Хар уул), хойт болон өмнөд Актау (Цагаан уул) хэмээх уулын гурван гүвээ сунаж тогтсон гэжээ.

*Хоёрдугаар тойрог нь:* Дешт-Кибчаг. Дешт-Кибчаг буюу Кибчагийн тал хэмээгдэх энэ тойргийн газар нутаг нь нэгдүгээр тойргоос хэмжээгээрээ гуравны нэгээр бага ажээ. Дешт-Кибчагийн газар нутгийн тухай мэдээ ал Умари болон Абу-л-Фида хэмээх хоёр зохиогчийн тэмдэглэлээс эш татсан байдаг. Энэ тойргийн хүн амын ихэнх нь түрэг хүмүүс байжээ. Сарайд ноён Карачеевийн дөрөвний хоёр нь байнгын амьдардаг ба мөн эрх барьж буй хааны хамаатан хүргэчүүл байв.

*Гуравдугаар тойрог нь:* Хазарын улс байв. Дагестан дахь Хазарын эртний нийслэл нь Баланжара байсан гэдгээс өөр тус улсын байрлал, түүхийн талаар тодорхой мэдээлэлгүй.

<sup>1</sup> А.П.Григорьев, О.Б.Фролова. Географическое описание Золотой Орды в энциклопедии ал-Кашканди-Тюркологический сборник 2001. стр. 262

<sup>2</sup> Дурдсан зохиол. стр. 262-302

*Дөрөвдүгээр тойрог нь:* Крым. Ордын хэв шинжит түмэн. Энэ тойргийн тухай нэлээд мэдээ тэмдэглэгдэн үлдсэн нь Алтан ордон улсын гадаад харилцаа, худалдаанд чухал байр суурь эзлэж байсантай холбоотой юм. Энэ түмэн нь XIV зууны тэргүүн хагаст Крымын хойгийн дорнод хагаст байсан.

Тохтамыш хааны 1381 оны зарлигт дурдсанаар Крымийн түмэнд Приазовын умарт хэсгийн газар нутгийн зарим хэсэг хамрагдаж байв. Крымийн хэмээн нэрлэгдэх энэ тойрогт Повольжийн Укек хот бүртгэлтэй байсан гэж Ал Кашканди өгүүлжээ. Энэ талаар судалгаа шаардлагатай.

Арабын зохиогч Крымын хотуудыг дурдахдаа Крым Солхат (хуучин Крым), Судак, Кафа (Феодосия) Ал Кашканд Абу-л Фидагийн тэмдэглэснээр энэ тойрогт Крымын хойгт 40-өөд суурин хамаарч байв. (Кырк-ер цайз бэхлэлт) Хойно Ал Кашканди Кырк-еркийн түмнийг 9 дүгээр тойргийн бүрэлдэхүүнд хамааруулжээ. Хар далайг Крымын далай гэж тэмдэглэсэн нь буй. Ал Кашканди Судак хотын хүн амын тухай, хүн амын угсаатны бүрэлдэхүүний шашин христиан шашны төгсгөлийн тухай буй.

*Тавдугаар тойрог нь:* Азовын хязгаар. Дөрөв дүгээр тойргийн газар нутгийн дөрөвний нэг орчимтой тэнцэх хэмжээний нутагтай. Эмхэтгэгч зөвхөн Абу-л Фидагийн мэдээг үндэс болгожээ. Уг тойрогт Азов, Керчь хоёр хотыг тодорхойлон оруулсан байдаг боловч судалгаанд Керчь хотын тухай мэдээ төдийлөн байхгүй.

*Зургадугаар тойрог нь:* Черкесия буюу Черкес, 5-р тойргоос 2 дахин бага газар нутгийг эзэлдэг. Хот болон хүн амын тухай мэдээ хомс

*Долдугаар тойрог нь:* Булгар. Газар нутгийн хувьд 4, 2-р тойргийг нийлүүлсэнтэй тэнцэх газар нутагтай. Ал Кашканди Серб Болгар улсыг Алтан ордноос тусгаарладаг хоёр хотын тухай өгүүлсэн байна. Акча-Керман (Аккерман одоогийн Днестровскийн Белгород) XIV зуунд Алтан ордны далайн томоохон боомт болж байсан ба хүн ам нь мусульмануудын холимог болон буруу номтон (шүтлэггүй) хүмүүс байв.

Энэ хотыг XIV зууны 60-аад оны үеэс Ордынхон орхисон. Хоёрдахь нь Крымийн хойгийн баруун урд байсан Грекийн хот улсын суурин дээр байгуулагдсан Сары Керман нь XV зууны эхэнд бүрэн унасан байна.

*Наймдугаар тойрог:* Улакийн улс буюу Валахия. Одоогийн Румыний Валахийн вант улс. 1324 оны үед жинхэнэ бие даасан улс болжээ. Гэвч зохиогч энд Румыний тухай бус Болгарын тухай, түүний түүхэн нийслэл Тырновагийн тухай болон оршин суугч “бургалуудын”

тухай бичжээ. Мөн Дунайн доод урсгалын баруун эрэгт байрладаг Исакча хотын тухай өгүүлдэг.

*Есдүгээр тойрог нь:* Ас буюу Алан. Крымын хойгийн ордын түмэн Ас болон Аланууд нь өнөөгийн Осетинчүүдийн дээд өвөг Монголын байлдан дагууллын дараа өөртөө засах орон нутгийн удирдлагаа хадгалж үлджээ. Тэдний удирдагч нь түмний ноёны зиндааны хан өргөмжлөгдөнө. Тэд уулынхаа бэхлэлтэд хаалттай амьдралаар Узбек хааны хаанчлалыг дуусах хүртэл байсан бололтой

*Аравдугаар тойрог нь:* Орос орон. Алтан Ордны мусульман тойргуудаас умар зүг байрласан байдаг. Тэр үед өмнө зүгт орших Хар тэнгист байх арлууд Оросуудад харьяалагдаж байв (Энэ нь ямар арлууд байв гэвэл Арабууд арал хойг хоёрыг нарийн сайн ялгадаггүй бололтой. Хар тэнгисийн умарт эргийн арал гэдэг нь далай руу түрэн орсон хуурай газруудыг хэлсэн байж болох юм). Улсын хил нь өрнөддөө франкуудын орон буюу Баруун Европтой хиллэж байсан гээд зүүн зүгтээ Орос нь Булгарын тойрогтой өөрөөр хэлбэл Повольжтой зүүн хойд хэсгээрээ Холманы нутагтай тус тус хиллэнэ.

Дээрхи чухал баримтад зөвхөн газар нутаг бус гадаад харилцаа, худалдаа, түүний үнэ ханшийн тухай ч чухал мэдээ байгаа нь Алтан ордон улсын түүхийг улам гүнзгийрүүлэн судлахад чухал сурвалж болж байгаа юм. Уг толь бичгийн сурвалж нь тухайн үед Алтан ордон улсын нутгаар аялан явсан жуулчдын тэмдэглэл болон Мамлюкийн улс нь Алтан ордон улстай цэрэг-улс төрийн холбоотон байж, хаад эрх баригчид нь бичиг захидлаар харилцдаг байсны хувьд тус улсын тухай мэдээлэл сайтай байсан нь энэхүү баялаг мэдээллийг агуулсан нэвтэрхий толь бичих боломжийг олгожээ.

Энд нэг сонирхол татаж буй зүйл бол Алтан ордон улсын цэрэг-засаг захиргааны тогтолцоо нь аравтын систем, татварын хэмжээ ч аравны нэг хувь байсан бол мөн нийт улсаа 10 тойрогт хуваасан байна.

Эрдэмтэн А.П.Григорьев, О.Б.Фролова нар зарим газар, гол мөрний нэр андуурсан байгааг тэмдэглэсэн нь мөн бусад мэдээллийг ашиглахдаа давхар нягтлахыг анхааруулсан хэрэг юм. Эргэлзээтэй, цаашид нягтлахаар зүйл ч байгаа юм. Тухайлбал, зарим судлаачид Орост монголын шууд захиргаа байгаагүй гэдэг. Үнэхээр ч Оросын вангуудаар дамжуулан захирч байсан. Тэгтэл дээрхи хуваарилалтад Оросыг 10-р тойрог гээд төр засаглалын шууд захиргаанд оруулсан байна. Тэгэхээр дээрхи хуваарилалт нь түүхэн газар зүйн онцлог, аж ахуй, угсаатан хүн амын байршлаар нь хуваасан бололтой. Харин Ордын түмэн, Оросын түмэн гэж заагтай тэмдэглэсэн нь тус тойрогууд нь засаглалын ялгаатай байсныг өгүүлж байгаа болов уу.

Бат хаан биеийн эрүүл мэндийн байдлаас хүү Сартагтаа улсаа удирдах эрхийг нь олгуулахаар Мөнх хаан руу илгээжээ.

Сартагийг Мөнх хааны ордонд байхад 1256 оны орчим Бат хаан таалал төгсчээ. Сартах нутаг буцах замдаа 1257 оны орчим мөн нас барсан гэдэг. Түүний таалал төгссөнийг зарим сурвалжид авга ах Бэрхтэй нь холбон үздэг. Түүнийг хорлосон гэж зарим түүхэнд бичдэг. Гэвч залуу хааны үхлийн үнэн шалтгааныг тодруулах боломж хомс.

Мөнххаан Сартагийн хатад, ах дүү нарын сэтгэлийг тайтгаруулахаар өөрийн элчийг илгээсэн бөгөөд Сартагийн хүү Улагчинийг өсч, эцгийнхээ хаан ширээг залгамжлах хүртэл улсын хэргийг мэдэж явуулахыг Батын их хатан Борогчинд зарлиг буулгажээ. Гэвч ингэх тавилан байсангүй. Улагчин тэр жилээ талийгаач болжээ<sup>1</sup>. Үүгээр Батын удмаас Алтан Ордны хаан ширээг залгах явдал завсарлаж, хаан эзнээр түүний дүү Бэрх өргөмжлөгджээ.

Бэрх бол Батын дүү, Зүчийн 3 дугаар хүү бөгөөд ахынхаа нэгэн адил Алтан ордон улсын түүхэнд онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. Тэрбээр 1257-1266 онд Алтан ордон улсын төрийг барьж байв.

Бэрх болон түүний залгамжлагчдын үед Алтан ордон улсын хил нь Саяны-Алтайгаас Тэнгэр уул, Сырдарья мөрний сав газар Хорезмыг хамраад Каспийн тэнгисийн умард удам тал, Кавказын ихэнх хэсэг Ираны Азербайжан, Крым, Хар тэнгисийн умар талаас өмнө зүг доод Дунай хүрч, Өрнө зүгт өмнөд Оросын хэсэг, Булгарын хаант улсын нутаг, Уралыг даваад баруун болон өмнөд Сибирь, улмаар Саяны нуруутай залгаж байсан байна. Түүхч М.Г.Сафаргалиевийн “Алтан ордны уналт” хэмээх зохиол болон Зөвлөлтийн түүхийн нэвтэрхий тольд Зүчийн улсын хойд хилийг хойд мөсөн далай хүрч байсан гэжээ<sup>2</sup>.

Бэрх нь хүчирхэг хаан төдийгүй чадамгай жанжин байлаа. Тэрбээр Их хаан Мөнхийг хаан ширээнд өргөмжлөхөд онцгой гавьяа байгуулсан тул хүндтэй нэгэн байв. Бэрхийг хаан өргөмжилсөн оныг Якубовский 1257 онд, А.Насонов оросын он дараалсан түүхийн материалыг үндэслэн 1258 он гэж дурдсан байна.

Бэрх хаан 1257 онд зарлиг буулгаж бүх нийтийн хүн амын тооллого хийлгэж байснаас үзэхэд 1257 он гэхэд хаан болсон байв. Бэрхийн хаанчлалын арван жилд (1257-1266) Алтан ордон улсад нэлээд шинэчлэл өөрчлөлтүүд хийгджээ. 1257 онд улсын дотоодод бүх нийтийн хүн амын тооллого хийлгэж, үүнээс өмнө тооллогод хамрагдаж байгаагүй

<sup>1</sup> Рашид-ад-Дин. Судрын чуулган. Боть II. УБ., 2002. т. 90

<sup>2</sup> Советская Историческая энциклопедия. Т. 5. М., 1964. стр. 702; М.Г.Сафаргалиев. Распад Золотой Орды. -Саранск, 1960.

Новгородынхныг тоолж, зохих хэмжээний татвар оногдуулсан ба Бат хааны буй болгосон баскак-даргачийн системийг устгаж Оросын вангуудаар өөрсдөөр нь татварыг нь хураалгаж Ордод хүргүүлдэг болов. Батын үндэслэн байгуулсан Сарайтай өрсөлдөх хоёр дахь том хот шинэ Сарай буюу Сарай-Бэрх баригдаж, Монгол, Түрэг, Орос болон бусад олон үндэстэн холилдон суусан олон улсын худалдаа цэцэглэн хөгжсөн шинэ төв болжээ. Мөн нийслэл Сарайдаа үнэн алдартны шашны төлөөлөгчийн газрыг байгуулахыг зөвшөөрсөн ба лалын шашны олон хийд байгуулжээ. Түүхэнд түүнийг лалын шашныг талархан үзэгч гэх буюу лалын шашинтан хэмээн тэмдэглэжээ.

Бэрхийн үед Оросын баруун нутгийн ихэнхийг сэргээн тохинуулах ажил хийгджээ. Харин гадаад харилцаанд бэрхшээл үүсч Бэрх, Хүлэг нар хоорондоо тэмцэлдсэн нь улс оронд маш их хохирол учруулсан юм. Бараг ялагдаж байсан Бэрх хүчээ сэлбэн гэнэт довтолсонд бэлтгэлгүй байсан Хүлэг цэргээ татан ухарч, Терек голыг гатлахад гүйцэд хөлдөөгүй голын мөс цөмөрч Хүлэгийн цэргийн олонхи живж, үлдсэн цөөн хэд нь үлэмж ялагдаж хүлээсэн юм. Энэ тулалдааныг түүхэнд Төмөр хаалганы тулалдаан гэж нэрлэжээ. Түүнээс удалгүй 1264 онд Хүлэг нас баржээ. Түүний хаан ширээг хүү Абага нь эзлэж эцгийнхээ өшөөг авахаар Бэрх хаантай удтал тулалдсан боловч амжилт олсонгүй.

Бэрх хааны үеэс Алтан ордон улсын гадаад харилцаа өргөжиж Египет улстай элчин харилцаа тогтов. Бэрхийг түүх домог судар бичигт шударга, ухаантай, хэрсүү гярхай, дэмий цус урсгахаас зайлсхийдэг хүн байсан гэжээ. Тэр үеийн лалын шашинтнуудын тэмдэглэснээр “насрад-дин” (сүсэг бишрэлийг хамгаалагч), “abu-аль-магали” (эрхэм дээд ариун хүслийг тээгч) гэж түүнийг өргөмжилж байжээ.

1265 онд Хүлэгийн ахмад хүү Абага Эл хаант улсын хан ширээнд сууж, эцгийнхээ өшөөг авахаар Гүр (Гүрж улсад буй) голын хөвөөнд буусан мэдээг Бэрх сонсоод их цэргээ авчирч, голын хоёр талаас хагас сарын турш хавчин байлдсан боловч хэн нь ч дийлсэнгүй. Бэрх Тбилиси хүрч голыг гатлан байлдахаар яваад зам зуур хүндээр өвчилж нас барав. Бэрх алтан ургийнхнаас анх исламын шашныг шүтсэн хэмээн түүх сударт тэмдэглэгджээ.

Египетийн султан Байбарс 1264 онд Исламын шашны өвөг Осман халифын гараараа бичсэн коран судар ба түүний хэрэглэж байсан тахилгын тавиур, хивсийг Бэрхэд бэлэглэсэн байна. Мөн араб морь, зэр зэвсэг, хар боол, дууч бүсгүй зэрэг үлэмж бэлэг өгч өөрийн нэрийн дараа Бэрхийн нэрийг бичүүлж баасан гариг бүрт бүх мусульманчуудаараа сүсэглүүлэх болсон билээ. Бэрх хааны лалын шашинтай холбогдсон нь түүний улс төрийн бодлоготой холбоотой байсан бололтой.

Бэрх хааны дүр төрхийн тухай гадны элчийн тэмдэглэлд: Бэрх хаан 56 настай, шингэвтэр сахалтай, том шаравтар царайтай, гэзгээ хоёр чихнийхээ араар тавьж, чихэндээ наймалжин хэлбэрт эрднийн чулуун алтан ээмэг зүүжээ. Тэрбээр торгон дээл өмсч толгойдоо шовгор малгай өмсч, ногоон өнгөтэй булгаар ширэн дээр эрднийн чулуу шигтгэсэн алтан чимэглэлтэй бүс бүслэж, хөлдөө битүү артай улаан арьсан гутал өмссөн байсан тухай тэмдэглэжээ.

Бэрх хааныг нас барсны дараа Алтан Ордны хаан ширээ Батын ач хүү Мөнх-төмөрт шилжив. Мөнх-Төмөр (1266-1282) төр барьж байх үедээ мөнгө санхүү, татварын салбарт олон шинэтгэл хийсний дотор зоос цуглуулах ажилд нэлээд ач холбогдол өгч байсны дээр өөрийн нэртэй зоосыг цуглуулжээ. Оросын үнэн алдартны шашны сүм хийдүүдэд татвараас бүрэн чөлөөлсөн хөнгөлөлтүүдийг олгосон нь ирээдүйн Орос орныг байгуулах хөрс суурийг бүрдүүлэхэд хувь нэмэр болжээ. Монголчууд Евразийн талд очихдоо олон шинэ зүйл авч очсон ажээ.

### 3. МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРЭН БА АЛТАН ОРДОН УЛС

Эв эсийг хичээж, төр улсаа төвшин байлгахыг захиж сургасан эцэг хааныхаа гэрээсийг чанд сахиж, Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний улсууд их гүрнийхээ төвтэй нягт харилцаа холбоотой байж тулгамдсан асуудал, маргааныг хамтын хүчээр нэгэн удирдлагын дор шийдвэрлэн гүйцэтгэхийг эрх барьж буй хаад, ноёд чармайж тэр нь элдэв саад бэрхшээлтэй тулгарсан ч даван туулсаар байсныг түүх сурвалжийн мэдээ баримтууд гэрчилнэ.

Анхны их хаадын үед нягт нэгдмэл байсан Монголын эзэнт гүрэн цагийн эрхшээлээр Цагадай, Эл хаад, Юань болон Алтан ордон улсууд болон хуваагдсан ч нэгдсэн удирдлага зохион байгуулалтаа хэсэг хугацааны турш хадгалж хоорондоо улс төр, эдийн засаг, шашны талаар холбоо харилцаатай явж ирсэн билээ. Чингис хаан аян дайнаар эзэлсэн газар нутгаа дөрвөн хүүдээ хуваан өгснөөр нэгдмэл байсан Их гүрний задралын эхлэлийг тавьсан гэдэг боловч хан хөвгүүд их хааны зарлигт захирагдан өөр өөрийн удирдсан хувь улсаа нэгэн төрийн захиргаанд зангидаж, захирах захирагдах ёсыг хуулийн хүрээнд хатуу мөрдлөг болгож байсан юм. Тэгснээрээ монголын бүрэлдэхүүн улсуудын харилцаа холбоо задрах бие даах явц нь аажим олон жилийн турш үргэлжилсээр зуу гаруй жилийн туршид оршин байж чадсан юм.

Тэрхүү харилцаа ямар зарчмаар хэрхэн хэрэгжиж байсан тухай мэдээ занги ховор ч түүхийн баримтыг шүүрдэн үзвэл хэсэг бусаг бага сага мэдээ бий. Тэр нь Их хуралдай хуралдуулах, хаан өргөмжлөх болон байлдах дайтах, дайны олзыг хуваах зэрэг алтан ургийнхны хамтын хүчээр гүйцэтгэж, нэгдсэн шийдвэр гаргах зүйл дээр илүү тодорхой харагдана. Түүхэн баримтад тулгуурлан тэрхүү захирах захирагдах ёсыг хэрхэн сахин мөрдөж, хэрэгжүүлж байсныг товч боловч тоймлон өгүүлье.

Их Монгол улс болон Монголын эзэнт гүрний төрийн хэргийг Их хурилдайгаар хүлээн зөвшөөрч өргөмжилсөн Их хаан төр барих боловч Их хааныг аян дайнд мордох буюу хаан таалал төгсч дараагийн шинэ хаан өргөмжлөх, өөрөөр хэлбэл, төрийн жолоо эзэнгүйдэх эгзэгтэй

тэр мөчид хэн төрийн хэргийг хамаарч шийдвэр гаргах нь маш чухал байв. Тийм эгзэгтэй цаг үед алтан ургийнхнаар хүлээн зөвшөөрөгдсөн, тэрхүү чухал ажлыг итгэл даан гүйцэтгэж чадах хүний удирдлагаар нэгдсэн зохион байгуулалтад орж дараагийн шинэ хааныг өргөмжлөх хариуцлагатай их хэргийг гүйцэлдүүлж чадаж байсан нь чухамхүү захирах, захирагдахын тодорхой жишээ мөн

Өгүүлэн буй үед Их хурилдай хуралдуулах нь хурдан хугацаанд түргэн шийдвэрлэх асуудал биш бөгөөд тодорхой хугацаа шаардах хэрэг байв. Их хурилдай хуралдуулах эрх бүхий хүн, төрийн сайд бичгийн мэргэдтэй зөвлөж, төрийн бэхи зайрангуудаар жил, сар өдрийн сайныг сонгон тогтоолгосны дараа асар уудам нутагт өөр өөрийн эзэмшилд таран суусан, Их хурилдайд оролцож шийдвэр гаргах эрх бүхий алтан ургийнханд элч илгээж хурилдайн товыг сонсгодог бөгөөд тэдгээр нь хүрэлцэн ирэхэд тодорхой цаг хугацаа шаардагдах нь зүй. Хэрэв тогтсон дэг журам, хууль ёс байгаагүй бол тэр хугацаанд хэн нэгэн этгээд төрийн эргэлт гаргах хангалттай хугацаа гардаг байж.

Он жил улирч Монголын эзэнт гүрний хамарсан газар нутаг, захирсан хүн амын тоо нэмэгдэх тутам их гүрний төр барих их хааныг сонгох, түүнийг хүлээн зөвшөөрөх тал дээр бэрхшээл хуримтлагдсаар байсан ч хаан эцгийн гэрээслэсэн, улсаа удирдах удирдлагын нэгдсэн системийг хэрэгжүүлэхийн төлөө тэмцэж хүчин чармайлт гаргасаар Эзэнт гүрний захиргааг унах хүртэл энэ харилцааг барьж чаджээ. Нэгдсэн захиргаа үйлчилж байсны тодорхой жишээ нь Их хурилдай юм.

Чингис хааныг тэнгэр болоход алтан ургийнхны нийтээр хүлээн зөвшөөрсөн Их ноён Толуй төрийн хэргийг бараг хоёр жил шахам хамаарч Их хурилдайг зарлан хуралдуулж, эцгийн гэрээс ёсоор Өгэдэйг хаан сууринаа залсан билээ. Тэр их хурилдайд Цагадай, Бат тэргүүтэн баруун гарын хөвүүд, Отчигин ноён, Егү, Есүнгэ тэргүүтэн зүүн гарын хөвүүд, Толуй тэргүүтэн голын хөвүүд охид, хүргэд, түмэд, мянгадын ноёд бүгдээр цугларан ирж, Хэрлэний хөдөө аралд гүр даяар хурж, Чингис хааны зарлиг ёсоор Өгэдэй хааныг ширээнд өргөмжилжээ. Перс сурвалжид тэмдэглэснээр зарим нөлөө бүхий төрийн эрх мэдэлтнүүд Толуйд, төрийг захирч буй боломж, мөн алтан ургийнхны дунд олсон нэр хүндээ ашиглан хаан ширээнд суухыг санал болгож байсан ч тэрбээр хаан эцгийн гэрээсийг хөсөрдүүлэлгүй чанд биелүүлсэн юм.

Өгэдэй хааныг таалал төгсөхөд алтан ургийнхан дараагийн хааныг сонгох асуудал дээр санал зөрж нэгдсэн шийдвэр гаргаж чадахгүйд хүрч Өгэдэйн бэлэвсэн хатан Дөргэнэ хэсэг хугацаанд төр хамаарсан билээ. Тэр үед алтан ургийнхныг хэн удирдаж, дараагийн хааныг сонгоход хэний саналыг илүүтэй харгалзаж байсан нь сонирхол татаж байгаа

юм.

Тухайн үед шинэ хаан өргөмжилж чадаагүй шалтгааныг Рашид-ад-Дин “Судрын чуулган”-д тэмдэглэхдээ “Тэрбээр (Бат. С.Ц.) бүх садан төрлүүдээсээ хамгийн ахмад нь байсан болохоор түүний эзгүй байх жойгуур хаан ширээний асуудал шийдэгдээгүй 3 жил болсон...” гэх буюу “Өгэдэй хаан, хаан ширээг ач хөвүүн Ширэмүнээр залгамжлуулахаар гэрээслэсэн боловч, Гүюг ахмад нь учир хаан байх учиртай хэмээн Дөргэнэ хатан, мөн зарим ноёд санал нийлсэнгүй. Түүнийг (Гүюгийг С.Ц.) хаан ширээнд залахын тулд дахин Батад айлтгасан...”<sup>1</sup> гэжээ.

Дээр өгүүлснийг хураангуйлбал, Дөргэнэ хатан хэсэг ноёдын хамт Их хааны гэрээсийг давж ахмад хүү Гүюгийг хаан өргөмжлүүлэхээр Батад удаа дараа элч илгээж санал болгосон байна. Хамгийн гол нь энэ чухал асуудлын эцсийн шийдвэрийг төрийн хэргийг хамаарч буй Дөргэнэ хатан бус Бат хаанаас гаргуулахаар хандаад байгаа нь анхаарал татаж байгаа юм. Батыг эзгүйд асуудлыг шийдсэнгүй гэх буюу дахин дахин элч явуулж зөвшөөрөл хүсч байгаа нь ямар ч байсан Бат энэ асуудлыг шийдвэрлэхэд нөлөө бүхий хүн гэдгийг харуулж байна. Харин эцээ энэ эрх Батад олгогдсон нь тодорхойгүй боловч сурвалж бичгүүдэд дан хөвгүүдийг Бат<sup>2</sup> ахална хэмээн дурдсан байдаг нь зөвхөн өрнө зүгийн байлдааныг удирдахыг заасан бус шийдвэрлэх үед ч үйлчлэх зарлигийн тухай дурдсан байж болохыг үгүйсгэх аргагүй. Эсвэл энэ нь хэн бүхний мэдээж зүйл байсан учир бичиж тэмдэглээгүй байж болох юм. Их хааны гэрээсийг хөсөрдүүлэхээс татгалзан, Дөргэнэ хатны саналыг хоёрдах удаа ч тэрбээр мөн зөвшөөрсөнгүй. Төрийн хэргийг түр хамаарч байсан Дөргэнэ тэргүүтэй нөлөө бүхий хүмүүс удаа дараа зөвшилцөхийг хүсэхэд Бат татгалзаж байсан нь нэгд, хуулиа баримталж уламжлалаа дагасан, хоёрт, Гүюг, Бат нарын харьцаа таагүй байсан нь нөлөөлсөн байж болох юм. Хэрэв голын улсаас бүрэлдэхүүний улсуудтай харилцаа холбоо сул байсан бол хаа холын баруун этгээдэд өрших Кибчагийн тал нутагт байсан Бат руу нэгбиш удаа хандах шаардлага байхгүй байх байсан. Гиймээс алтан ургийнхныг нийтэд нь захирч байх нэгдсэн захиргаа үйлчилж түүнийг нь хэн хүнгүй дагаж мөрдөж байсныг харуулж байна.

Дөргэнэ хатан 5 жил шахам төр хамаарсны эцэст алтан ургийн зарим ноёдын шахалтаар Их хааны гэрээсийг даван, Бат хааны эсэргүүцэнийг үл ойшоон Гүюгийг хаанд өргөмжилжээ. Тэрхүү хууль бус явдал алтан ургийнхны дунд эвдрэлийн үүдийг нээсэн төдийгүй

<sup>1</sup> Рашид-ад-Дин. Судрын чуулган. Боть II. Орос хэлнээс хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо. УБ., 2002. т. 88

<sup>2</sup> Монголын нууц товчоо. §270

Өгэдэйн угсааныхнаас үе залгамжлан хаан суух эрхийг нь Толуйнханд шилжүүлэх шалтгааны нэг болсон юм. Уг шийдвэрийг гаргах хурилдайд Бат бие өвчтэй хэмээн шалтаглан оролцоогүй бөгөөд бүрэлдэхүүний хувьд бүрэн бус байв. Батын онцгой эрх Гүюг хааныг нас барсны дараа шинэ хааныг сонгох шийдвэрийг гаргахад илүү тодорхой харагддаг юм.

Өгэдэй хааны үед ухаантайгаараа гайхагдаж, төрийн ордонд төдийгүй алтан ургийнхны дунд нэр хүндтэй байсан Их ноён Толуйн бэлэвсэн хатан Сорхагтани бэги, Монголын эзэнт гүрний үеийн нэг ухаалаг бүсгүй байсан бөгөөд бүхэл амьдралынхаа туршид хөвүүддээ эрх мэдэл авчрах боломжтой мөчийг хүлээж бэлтгэж байжээ.<sup>1</sup> Түүний 20 жил хүлээсэн шийдвэрлэх цаг мөч нь ирж тэрбээр хэнд хандаж хэний дэмжлэгийг олбол хүсэл нь биелэгдэхийг сайн мэдэж байжээ.

Батын бие чилээрхсэн сургаар Сорхагтани бэги өвчтэй авгыг нь эргүүлэхээр хөвүүн Мөнхийг илгээсэн<sup>2</sup> тухай сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн байдаг. Бат хан "...Хан хөвгүүдийн дотроос Мөнх л хаан хүний билэг төгс юм. Тэр Чингис хааны засаг, зарлиг хоёрыг нүдээрээ үзэж, чихээрээ сонссон хүн. Энэ хүн ертөнцийн сайн мууг үзэж, хамаг хэрэг явдлын ашиг, зовлонг амсан, янз бүрийн оронд олон удаа цэрэг захиран явсан бөгөөд оюун билэг нь олноос хэтийджээ" хэмээн саналаа хэлээд чухам ямар учраас Өгэдэйн хөвгүүдээс хаан суулгахыг зөвшөөрөхгүй байгаагаа "Өгэдэй хааны хөвгүүд нь эцгийнхээ үгийг сөрөн төрийг Ширэмүнд бариулсангүй. Мөн Чингис хааны бүх хүүхдүүдийнхээ дотроос хамгийн хайртай бага охин Чаур сэцнийг эртний хууль заншлаас даван төрлүүдтэйгээ эелдэж зөвлөлгүйгээр амийг нь эрсдүүлсэн. Тиймээс тэдэнд хаан байх заяа алга"<sup>3</sup> гэжээ. Өөрөөр хэлбэл, хаан эцгийнхээ гэрээсийг даван, хууль зөрчиж, ураг дотроо учраа олохгүй байгаа хүмүүс бусдыг яаж хуулиар захирах вэ? гэсэн санал гаргаж Өгэдэйн удмынхныг хаан ширээнд дахин өргөмжлөх боломжгүй гэж үзэн шинэ хаанаар Мөнхийг нэр заан томилсонд түүнийг нь ч алтан ургийн олонхи зөвшөөрчээ. Хэдийгээр маш нухацтай шалтгаан олж алтан ургийнхны олонхийг зөвшөөрүүлж чадсан ч Өгэдэй, Цагадайн удмынхны эсэргүүцэлтэй тулгарсан юм. Тэд Батад удаа дараа элч илгээж "Хааны засаг бидэнд оногдвол зохино. Та яагаад өөр хүнд соёрхов хэмээн гомдоллож байсан ч түүнийг шинэ хааныг сонгох шийдвэр гаргахад нөлөө бүхий байсныг харуулж байна. Эс тэгвээс Батыг ийм шийдвэр гаргах эрх түүнд байхгүй хэмээн нийтээр хүлээн зөвшөөрөхгүй, мөн түүнд хандаж элч илгээх ч шаардлага байхгүй

<sup>1</sup> Жек Ведерфорд. Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Эзэн Чингис хаан. УБ., 2003. т. 192

<sup>2</sup> Рашид-ад-Дин. Судрын чуулган. Боть II. УБ., 2002. т. 145

<sup>3</sup> Рашид-ад-Дин. Мөн тэнд. т. 148

байсан болов уу?

Бат гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэхээр шинэ хааныг өргөмжлөх Их хурилдайг хуралдуулах гэхэд “Чингис хааны нийслэл, уугуул нутаг, өргөө гэр нь Онон, Хэрлэнд байтал бид Кибчагийн талд очих ёсгүй гээд алтан ургийн ноёд зөвшөөрсөнгүй. Чингээд дүү Бэрх болон өөрийн хаан ширээг залгамжлуулсан Сартаг нарт гучин мянган цэрэг өгч Хэрлэнд очиж Мөнхийг хаан ширээнд суулгагтун гэж зарлиг буулгажээ<sup>1</sup>. Бат болон Сорхагтани бэги нар хаан өргөмжлөх ёслолыг уламжлал ёсоор Эзэнт Гүрний нийслэл Хархоринд бус Хэрлэнд хийхээр сонгон авсан нь учиртай байв. Хаан ширээ, эрх мэдлийн төлөө өрсөлдөж байсан Гүюгтаны бэлэвсэн хатан Огул Хаймишийн захиргаанд нийслэл Хархорин байснаас тийнхүү Чингис, Өгэдэй хаан нарын хаан өргөмжлөгдсөн Хэрлэнг сонгон авсан байв.

Энд нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд, шинэ хаан сонгох талаар эрчмын маш том эргэлт хийсэн саналыг Бат гаргахад зөвшөөрсөн атлаа Кибчагийн талд Их хурилдай хуралдуулах гэснийг нь хүлээн аваагүй нь алтан ургийнхны дунд нийтээр хүлээн зөвшөөрч дагаж мөрддөг хууль эрх зүйн хэм хэмжээ үйлчилж байсныг маш тодорхой харуулж байгаа юм. Хэдийгээр Их засаг хууль бидний үед уламжлагдаж ирээгүй ч уг хуулинд Их хурилдай хуралдуулах, хаан өргөмжлөх дэг ёсны талаар маш нарийн тодорхой заалтууд байсан нь дээрхи явдлаас тодорхой анзаарагдаж байна.

Батын даалгавраар Мөнхийг (1251-1259) хаан өргөмжлөх төрийн ёслолын ажиллагааг гүйцэтгэн явуулахаар томилогдсон Бэрх ахдаа элч илгээж “Мөнхийг хаан ширээнд өргөмжлөх гэсээр хоёр жил өнгөрлөө. Өгэдэй хаан, Гүюг хаан хоёрын үр сад, мөн Цагадайн хөвүүн Есөнмөнх нар хүрэлцэн ирсэнгүй” хэмээхэд Бат: “Чи түүнийг (Мөнхийг – С.Ц.) хаан ширээнд суулга хэн Ясаас (Их Засгаас) гажваас тэр хүн алдах үхэх”<sup>2</sup> хэмээн Их засаг хуулиас дурдан өгүүлсэнээс уг хууль бүх улсад үйлчилж байсан нь тодорхой харагдана.

Энэхүү хэрэг явдалд түүх сударчид, судлаачид өөрийн үнэлгээ өгсний зарим нь хууль бус төрийн эргэлт гэж үзсэн нь буй.

Ренэ Груссе: Төрийн эргэлт маягтай энэ үйлдлийг харьцангуй малбар гүйцэтгэсэн нь нэг талаар, Мөнхийн гойд хатуу зан төлөв, нөгөө талаар, хууль ёсоор ширээ залгамжлах Өгэдэйнхний хунтайж нар баячир дорой байснаар тайлбарлагдахын дээр бас Чингис хааны гэр бүлийнхний хамгийн ахмад салаа салбарын тэргүүн Бат, хаан төр завсардах үед дарангуйлагчийн үүрэг түр гүйцэтгэж байсантай

<sup>1</sup> Рашид-ад-Дин. Судрын чуулган. Боть II. УБ., 2002. т. 145-146

<sup>2</sup> Рашид-ад-Дин. Судрын чуулган. Боть II. УБ., 2002. т. 145-146

холбоотой байж болно<sup>1</sup> хэмээжээ.

Мөнх хаан төрийн эрхэнд гараад олон арга хэмжээ авч явуулсны дотор төв болон хувь улсуудын харилцаа холбоо, их гүрний эв нэгдлийг хадгалж байх үүднээс тодорхой арга хэмжээ авав. Хувь улсын тэргүүнүүд ба хувь эзэмшил хүртсэн Чингис хааныхны олон хүн алба татвараас чөлөөлөгдөх эрхтэйгээс гадна тус бүрийн орон нутгийн орлогоос төв засгийн төлөөлөгчидтэй хуваалцах ёстой байв. Мөнх тэдгээр зуршлыг хориглон зогсоожээ. Хэрэв хаан ширээ залгамжлагчид цөм энэ бодлогыг туйлбартай барьж цаашид хэвээр үргэлжлүүлбэл Монгол гүрэн алс Дорнод, Туркестан, Перс Оросын ханлигууд болон бутрахаас зайлсхийж тэр улсыг харьцангуй нэгдэлтэй авч үлдэх нь тодорхой зорилго байлаа.<sup>2</sup>

Мөн 1269 онд Цагадайн улсын эзэмшил нутаг Талас мөрний хөвөөнд болсон монгол ноёдын анхдугаар хурилдайгаар Өгэдэй, Цагадайн угсааныхны хооронд гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхээр Алтан Ордны улсаас Мөнхтөмөр хаан хүрэлцэн иржээ<sup>3</sup>. Таласын чуулганаар Зүчи, Өгэдэй, Цагадайн удмын хан хөвгүүд хуралдан эзэмшил нутгийнхаа хил хязгаарын тухай асуудлыг нарийвчлан ярьж тохиролцожээ. Мөнхтөмөр хааны хувьд Таласын чуулган маш ашигтай байсан бөгөөд хурилдайд хаан биечлэн оролцсноор, Бэрх хааны үеэс дайтаж байсан Хүлэгийн улсын эсрэг хан хөвгүүдийг талдаа татаж цэрэг улс төрийн холбоо байгуулж чаджээ.

Мөн бүрэлдэхүүн улсуудын харилцаа холбоотой байсан нь харь улсыг байлдах буюу дайны олзыг хуваахад тодорхой харагдна

Алтан ордон болон бусад бүрэлдэхүүн улсууд ч Эзэнт гүрний төвтэй нягт холбоотой байж Их хааны захиа зарлигийг цаг тухайд нь биелүүлж байв.

Мөнх хаан, дүү Хүлэгийг лалын шашинт улсуудыг дайлуулахаар мордуулахдаа хан хөвүүн бүр, цэргийнхээ арван бүрээс хоёр хүн түүнд (Хүлэгд – С.Ц.) гаргаж өг, тэдгээр нь Хүлэг хаантай явж түүний туслагч нь болог хэмээн зарлиг буулгажээ.<sup>4</sup>

Мөнх хааны тэрхүү зарлигийг хан хөвүүд тэр даруйд нь ёсчлон биелүүлсэн бөгөөд улс улсаас хан хөвүүд тодорхой тооны цэргээ аван заасан газарт очсон юм. Алтан ордон улсаас Зүчийн ууган хүү Орда ахмад хүү Хүлийг 10 000 цэрэгтэй илгээж байжээ.

<sup>1</sup> Ренз Груссе. Чингис хааныхны монголчууд. УБ., 2004. т. 69

<sup>2</sup> Ренз Груссе. Чингис хааныхны монголчууд. УБ., 2004. т. 7

<sup>3</sup> В.Бартольд Мөнхтөмөр ямар ч ашиггүйгээр хол зам туулан маргаан таслахын төлөө Таласын чуулганд оролцохоор ирээгүй болов уу. Харин өөрийн төлөөний хүнийг явуулсан байх гэжээ.

<sup>4</sup> Рашид-ад-Дин. Судрын чуулган. Боть II. УБ., 2002. т. 89

Ибн Василяь нэрээр алдаршсан арабын түүхчийн тэмдэглэлд: "Татарууд дорно зүгээс мандсан үед Чингис хааны зарлигаар Хан хөвгүүд байлдсан газар бүрээс дайны олзны гуравны нэгийг Их хаанд, мөн гуравны нэгийг нь Бэрхийнхэнд, үлдэх гуравны нэгийг нь өөртөө (ялагч буюу олз хуваагч – С.Ц.) ба цэргүүддээ үлдээхийг тушаажээ.

Чингис хааныг таалал төгссөний дараа Татаруудаас хэн нь ч энэ зарлигийг зөрчөөгүй бөгөөд гагц Хулавун (Хүлэг – С.Ц.) дорно зүгт Эльаджем, Эльиракийг байлдан эзлээд дайны олзноос Бэрхийнхэнд ч, Их хаанд ч, хэнд ч өгсөнгүй өөртөө бүгдийг үлдээж<sup>1</sup> Эзэн хааны зарлигийг зөрчсөн хэмээн зэмлэнгүй өнгө аясаар тэмдэглэжээ. Энд дурдсанаас үзэхэд ямар ч байсан аян дайн хийхдээ улс бүрийн хүчийг дайчилсан шигээ дайныхаа олзноос хувь түгээдэг тогтсон заншил байсан байна. Өөрөөр хэлбэл нийгмийн баялгийг дахин хуваарилах зарчмыг оновчтой зөв хийж байснаар ноёрхлоо урт хугацаанд барьж чаджээ. Харин энд нэг анхаарал татаж буй зүйл бол Алтан ордны хаадад олзны гуравны нэгийг хүртээхээр онцгойлон нэр зааж буй явдал юм. Үүнээс үүдэн өгүүлэхэд Бат болон түүнийг залгамжлагч Алтан ордон улсын хаад нэлээд олон зүйл дээр давуу эрхтэй байсан нь харагддаг.

Чингис хаан болон Өгэдэй хааны олон чухал даалгаврыг нь биелүүлснийх нь төлөө, мөн өрнө зүгт хийсэн аян дайныг амжилттай удирдаж авьяаслаг удирдагч болохоо харуулсных нь төлөө хан хөвгүүдийг ахлаж, алтан ургийнхны дунд маргаантай асуудал гарсан эгзэгтэй мөчид шийдвэр гаргаж байх хариуцлагатай үүргийг Батад оногдуулж үүнийх нь төлөө тэр давуу эрхийг соёрхсон байж болох юм.

Ибн Василь Жемаледдин Абуабдаллах Мухаммед Ибнсалем (1297-1298 оны орчим 93 насандаа таалал төгсчээ) нь Хамат хотын ерөнхий шүүгч байсны хувьд тухайн үеийн хэрэг явдлыг сайн мэдэх байсан бөгөөд хүн хүний ам дамжсан явган яриа сонсон тэмдэглэсэн нь бус харин ч албан баримттай илүүтэй харьцдаг нэгэн байсан болохоор түүний үлдээсэн мэдээллүүд нь харьцангуй бодитой гэж хэлж болно.

Бат хаан алтан ургийнхны эв нэгдэлд ан цав суулгахгүйг чармайж бүх зүйлийг журмаар нь хийхийг хичээдэг байв. Өөртэй нь уулзахаар зорин ирсэн гадаадын элч төлөөлөгчдийг Их хаанд бараалхахыг байнга санал болгож, өөрийн хэмжээнд шийдчихэж болох асуудлыг ч Их хаанд айлтгаж шийдвэрлүүлж байсан нь эв эвлрэх, үл ойлголцол гарахаас сэрэмжилсэн хэрэг юм. Бэрх, хаан өргөмжлөгдөөгүй байхдаа Багдадын халиф Аббастай нөхөрлөж байв. Гэтэл тэр үед Хүлэг халиф руу довтлох гэж буйг мэдээд Бат хаанд гомдоллосонд Бат, Мөнх хаанд айлтган

<sup>1</sup> Золотая Орда в источниках. Т. 1. Арабские и персидские сочинения. Составление, вводная статья и комментарии Р.П.Храпечевского. М., 2003. стр. 49

хүсэлт гаргаснаар халифын эсрэг дайны үйл ажиллагааг түр цуцлуулж байв. Батыг таалал төгссөний дараа Хүлэг, Их хаанаас халифыг довтлох зөвшөөрөл хүсэхэд тэр удаа Мөнх хаан түүний хүсэлтэд хориг тавьсангүй хэмээн мөнөөх Ибн Василь тэмдэглэжээ. Энэ баримт нь Бат, Их хаантай байнгын харилцаатай байж түүний эрх мэдэл, захиргааг дээдлэн хүндэтгэж байсны илрэл юм. Эс тэгвээс Мөнхийг хаан сууринд суулгасан онцгой эрхэндээ эрдэж дураараа шийдвэр гаргаж болох байв.

Улс орныг бүхэлд нь хамарсан томоохон ажил хэргүүдийг Эзэнт гүрний төвийн удирдлагаар бүрэлдэхүүний улсууд хамтран гүйцэтгэдэг байв. Үүний тодорхой нэг жишээ нь Эзэнт гүрнийг хөндлөн гулд холбосон өртөөг хэрхэн нэгэн удирдлагын дор хийж гүйцэтгэснийг бэлхнээ мэдэх билээ. Хан хөвүүд өөрийн улсаас өртөөг угтуулан байгуулж төв буюу нийслэлтэй холбох ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалттайгаар богино хугацаанд хийж гүйцэтгэсэн нь төвийн болон бүрэлдэхүүн улсуудын харилцааны сонгодог жишээ мөн.

Мөн энэ харилцаа гадаад худалдаа болон, алба татварын нэгдсэн тогтолцоон дээр маш тодорхой харагдана.

Судлаачид Хубилай хаан монголын улс төрийн төвийг Хятадад шилжүүлснээр хан хөвгүүдийн хувь улс нь аажмаар биеэ дааж Монголын Эзэнт гүрэн задарсан гэж бичсэн нь олонтой.

Оросын түүхч Г.В.Вернадский Монгол болон Евразийн түүхийг нягт судалсан хүний хувьд Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний улсыг захирч байсан монголын хаад Их хаандаа даган захирагдах харилцаа удтал оршин тогтсоор Хятадад монголчуудын нэгдсэн захиргаа унах хүртэл өөрөөр хэлбэл, 1368 оныг хүртэл Монголын эзэнт гүрний тогтолцооны нэгдэл хадгалагдсаар байсан<sup>1</sup> гэсэн нь зүй ёсоор анхаарал татаж байна.

Мөн Японы түүхч Мияваки Жюнко: Хубилай хааны үед Юан, Зүчийн улс тус тусдаа байсан боловч Монголын Эзэнт гүрнийг залгамжлагчид хоорондоо аюулгүй байдлыг хангах үүднээс харилцаа холбоотой байсаар ирсэн гэжээ<sup>2</sup>.

XIII зууны хоёрдугаар хагаст өмнөд хятадыг байлдан дагуулах Хубилайн цэрэгт орос цэргийн отрядууд татагдан оролцсон юм<sup>3</sup>. Мөн тайван цагт ч Алтан Ордон улсаас Хятад руу олон тооны хүмүүсийг дайчлан аваачиж байсан баримт бий. Монголчууд шаардлагатай үед

<sup>1</sup> Г.В.Вернадский. Чингисийн үеийн монголчууд ба Орос улс. УБ., 2004. т. 21

<sup>2</sup> Мияваки Жюнко. Оросын царь Алтан Ордныг залгамжилсан нь. «Түүхт хүмүүсийн цуврал» 26, «Чингис хаан». Дэд дэвтэр. Гакушюү канкюүшя, 1991. т. 82; Т.Мөнхцэцэгийн орчуулгаар авав.

<sup>3</sup> Г.В.Вернадский. Чингисийн үеийн монголчууд ба Орос улс. УБ., 2004. т. 20

нэгдмэл байдал ноёрхлоо хадгалахын тулд Эзэнт гүрний өнцөг булан бүрээс цэрэг хөдөлгөдөг байв. Тухайлбал, Хубилай хаан мусульман иргэдээс бүрдсэн буучийн ангитай байснаас гадна, Нийслэл (Бээжин) хотоос хойшхи газар нутагт 10 мянган орос цэргийн харуул тавьсан байжээ. Тэдгээр Оросууд байнгын оршин суугчид болж 1339 оныг хүртэл амьдарч байсан хэмээн хятадын албан ёсны түүхэнд тэмдэглэсэн нь буй<sup>1</sup>. Энэ нь бас анхааран үзвэл зохих баримт юм. Учир юу гэвэл хүн амын тоогоор Эзэнт гүрэн дотроо тэргүүн байрт орж байсан Юан улс руу олон хүмүүсийг дайчилгаагаар аваачиж заримаар нь бүр тариа тариулж байсан баримт байна. Тэгэхээр хүн хүч дутсандаа бус хятадыг баримтлан захирах улсынхаа аюулгүй байдалтай холбоотойгоор тийнхүү хүмүүсийг аваачиж амьдрах хугацааных нь амин зуулгад нэмэр болгох зорилгоор тариа тариулж байсан болов уу? Мэдээж тэд цэргийн шилмэл анги нэгтгэл байсан болов уу.

Дайчилгаанд өртөн Хятад руу очиж тэндээ суурьшин суухад хүрсэн хүмүүсээс эргэж Оростоо ирэх боломж бараг байхгүй байсан тухай ч мөн тэмдэглэжээ.

Монголчуудын бүрэлдэхүүн улсууд нь Эзэнт гүрний төв буюу голын улстай харилцаж байсан нь монгол төдийгүй бусад угсаатанд ч бие биеэ таньж мэдэх боломжийг олгосон юм. Монголчуудын дэлхий ертөнцийг таньж мэдсэн мэдлэг нь зөвхөн эзэнт улс дотроо бус хилийн чанадад хүрсэн юм. Монголчуудаар дамжин Оросууд, Хятад орон байдгийг мэдэж, дорныхон өрнөдийн улс орны тухай зөв мэдээлэлтэй болж дараагийн зуунуудад худалдаа, эдийн засгийн харилцаа тасрахгүй явж ирэв.

<sup>1</sup> Жек Ведерфорд. Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Эзэн Чингис хаан. УБ., 2003. т. 268-269

## 4. АЛТАН ОРДОН УЛС БА ОРОСЫН ХАРИЛЦАА

Алтан ордон улс нь тухайн үед монголын төрөөс явуулж байсан улс төр эдийн засгийн бодлогыг эзлэн авсан улс орны онцлогт тохируулан хэрэгжүүлж өрнө зүгийн орнуудад монголын ноёрхлыг тогтоон барьж байсан гол төв юм.

Алтан ордон улс, Оросын харилцаа нь эзэн улс, вассалын харилцаа байв.

Алтан ордон улсын түүхийн нэг чухал хэсэг бол монголчууд Орост хэрхэн ноёрхлоо тогтоож, тэднийг яаж баримтлан захирч, эвдлэн сүйтгэж, бүтээн босгож, Орос орныг өрнөдөөс хэрхэн хамгаалж эцэст нь ноёрхол нь унасан тухай асуудал юм. Энэ талаар зүйрлэшгүй их судалгааны бүтээл гарсан боловч өмнөх үеийн түүх бичлэгт үй олон хүний амь насыг бусниулж, соёлын үнэт зүйлсийг эвдлэн сүйтгэж, Орос орныг олон зуун жилийн хоцрогдолд оруулсан гэж ангич нийгмийн хандлагаар нэг талыг хэт дөвийлгөн тавьж байлаа.

Гэхдээ 1930-аад он хүртлэх Оросын түүх бичлэгт уг үеийн түүхийг эсрэг, сөрөг хоёр хандлагаар бичих, түүхэн хэрэг явдалд бодитоор хандах нааштай эхлэлүүд тавигдсан юм. Тэр үеийн гол төлөөлөгчид нь түүхч Полевой, Костоморов, Бестужев-Рюмин, Ключевский, Платонов нар байж Оросын нэгдсэн улс байгуулагдахад татаруудын гүйцэтгэсэн үүргийг Монголын үед Оросын хүч бэхэжсэн...", "Хаанд албан татвараа цуглуулахад нэгдсэн байдал илүү дөхөмтэй байсан нь Москваг тойрсон улс төрийн нэгдэл буй болгоход хүргэсэн. Татаруудын ачаар хүчирхэгжсэн Москвагийн их ван өөрийн засгийг бэхжүүлж чадсан", "Хэрвээ Оросын вангуудад эрх чөлөө олгож дураар нь тавьсан бол тэд эх орноо хоорондоо тэмцэлдсэн, ямар ч холбоогүй хэсгүүд болгон тараах байв. Хааны засаг тэдэнд нэгдэх шинж тэмдгийг өгсөн", "Татарын түрэмгийлэл нь Оросуудыг анх удаагаа засаглал гэж юу болохтой танилцуулсан бөгөөд, тэрхүү засаглалд орох биш, харин зөвхөн захирагдах ёстой гэдгийг харуулсан. Орос орон улс төрийн талаар нэгдэх анхны оролдлогыг Алтан ордон улсын хаад хийсэн" хэмээн бичиж байв. Гэвч тэдгээр түүхчид нь улс төрийн хэлмэгдлийн

давалгаанд өртсөнөөр судалгаанд бодитой хандах явдал хязгаарлагдан нэг талыг барьсан судалгаа, дүгнэлтүүд зонхилох болов. Хэдийгээр үзэл суртлын хяналт байсан ч Оросын археологич, евразийн түүхчдийн бүтээлүүдэд асуудалд бодитой хандахын чухлыг сануулан тэмдэглэж өөрсдийн зохиол бүтээлд энэ чиглэлийг баримталж байв.

Ерээд оноос хойш ардчилал, нийгмийн өөрчлөлттэй уялдан эрдэмтэн судлаачид судалгааны үр дүн, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх бололцоотой болсноор Алтан ордон улсын түүхэнд холбогдох чухал баримт, судалгаа олноор гарах болов. Тэдгээрийн тэргүүн эгнээнд Л.Гумилев, Б.Широкорад, Егоров, В.В.Кожин, Ю.В.Мизун нарын бүтээл явж байна. Гэвч хойт хөршийн түүхийн сурах бичгүүдэд Алтан ордон улсын түүхийг бодитой өгүүлсэн чухал чухал дорвитой судалгааны үр дүн тусах байтугай наад захын хэн бүхний мэдэх зүйлийг ч өгүүлэхийг хүсээгүй, түүхэн үнэний гэгээ тусаагүй байгаа нь харамсалтай.

Доктор Ч.Дашдаваа ОХУ-ын өнөөгийн сургалтанд хэрэглэж буй түүхийн 15 сурах бичигт Монголын Эзэнт гүрний түүхийг хэрхэн тусгасныг шинжлэн үзээд “Монгол-татарын дарлалын үед оросын улс төр, эдийн засаг, соёлын хөгжилд асар их хохирол учирсан, Орос орон үгүйрэн хоосорсон, хөгжил нь олон зуун жилээр хойшилсон гэх санаа нэвт шингэсэн<sup>1</sup> хуучин үзэл тэдгээр сурах бичигт хэвээр байгааг тэмдэглээд энэ нь Монголын Эзэнт гүрний мөн чанар, Алтан ордон улсын үеийн оросын түүхийн асуудлаар ташаа ойлголт өгөхүйц байна хэмээн дүгнэжээ.

Баг хаан 1242 онд Алтан ордон улсаа байгуулаад Оросын нутагт шууд бус засаглал тогтоож вассал улс болгон Оросын вангуудыг томилдог болов.

Энэ үеийн засаглалын хэлбэрийг “евразийн” түүхч Г.В.Вернадский: Хуулийн хэлээр яривал Монголын ноёрхлын үед Орост Засгийн газар гэхээр юм тусгайлан байсангүй...Бодит амьдрал дээр Алтан Ордны хаад л Оросын дээд захирагч байсан бөгөөд Оросын түүх шашдирт бичсэнээр “хаан” нь байжээ. Хааны зарлиг, гэрэгэ үгүйгээр Оросын нэг ч ван нутаг орноо удирдан тохинуулах эрхгүй байв<sup>2</sup> гэж оновчтой тодорхойлсон юм.

Алтан ордон улсын эрх баригч хаад болон түүний эзэмшилд орсон хэн бүхэн Чингис хааны Их засаг хуулийг мөрдөн дагах ёстой байж

<sup>1</sup> Ч.Дашдаваа. Монголын эзэнт гүрний түүх Оросын сурах бичгүүдэд туссан нь -Их Монгол улс, эзэнт гүрний түүх, соёлын ололтууд. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. Улаанбаатар, 2006.06.23-24

<sup>2</sup> Г.В.Вернадский. Чингисийн үеийн монголчууд ба Орос улс. УБ., 2004. т. 41

түүнийгээ ч хэрэгжүүлж байв. Түүнийг давсан хэн бүхэн хуулийн хатуу цээрлэл хүлээдэг тэр л зарчмаар Алтан ордон улсын хаад улсаа болон вассалаа захирч байв.

Орос дахь Монголын захиргаа нь алба татвараа л цаг хугацаанд нь өгчихвөл дотоод хэрэгт нь оролцоод байхгүй, харьцангуй чөлөөт захиргаа байсан юм. Татварыг замаас нь хувьдаа ашиглах, хугацаанд нь өгөхгүй байх, өв залгамжлал дээр маргасан үедээ Оросын вангууд Алтан ордон улсын захиргаанд ханддаг байв. Итгэлийг тэсрүүлэх, татвараа өгөхгүй байх, элчийг нь хороох зэрэгт маш хатуу цээрлэл үзүүлдэг байсан нь засаглалын нөлөөг сулруулахгүй байх, улс орны дотоодод эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлсэн хэрэг байв.

Бат хаан баскак-даргач нарыг вант улсуудад томилон суулгаж алба татвар хураалгахаас гадна Оросын вангуудын үйл ажиллагаанд хяналт тавиулж байв. Хот хотуудад суух баскак- даргач нарыг Их баскак ахлах бөгөөд тэр нь Владимирын вант улсад төвлөрөн сууж байлаа. Баскак-даргач нарын тогтолцоо нь бүх эзэнт гүрний хэмжээнд үйлчилж байсан бөгөөд тэднийг Монголын Эзэнт гүрний их хаанаас томилдог гэсэн мэдээ байдаг ба Өгэдэй хаан баскак нарыг томилж байсан баримт бий.

Оросын вангууд, вант улсаа захирахын тулд Алтан ордны хаанд бараалхаж улс захирах эрхээ албан ёсоор баталгаажуулан зарлиг авах ёстой байв.

Тэр үед Оросын вангуудад өрнө зүгээс Ромын Пап тэргүүтэй загалмайтны шахалтыг хүлээн авч монголын эсрэг хүч хавсран тэмцэх, эсвэл дорно зүгээс тулгаж буй Монголын захиргааг хүлээн зөвшөөрч Алтан ордны зарлигийг дагахыг аль нэгийг нь сонгох түүхэн шаардлага тулгарч, улс төрийн эгзэгтэй нөхцөл байдал үүсээд байсан юм.

Оросын вангуудаас анх түрүү 1242-1243 оны заагт Ярослав II Всеволодович Алтан ордонд Оросын вангуудыг тэргүүлэн захирах эрх авчээ.

Ярослав вангийн дараа Углицийн Владимир Константинович, Ростовын Борис Василькович, Белозерскийн Глеб Василькович, Василий Всеволодович нар ирж Бат хаанд хүчээ өгөхөөр тангараглан зарлиг авчээ.

Новгородын Ярослав ван монголчуудын захиргааг хүлээн зөвшөөрч тэдний дэмжлэгээр өрнөдийн аюулыг няцаах замыг сонгон авсан юм. Өөрөөр хэлбэл Оросуудыг монголчуудын эсрэг турхирч өөрсдийгөө аврах, хүний гараар могой бариулах Папын төлөвлөгөөг няцаасан юм. Хэрэв Ярослав ван болон түүний хүү Александр нар Оросын ирээдүйг зөв олж харж ухаалаг шийдвэр гаргаагүй бол Орос орон хоёр их хүчний тулалдааны талбар болох байв.

Оросын баруун хэсэгт орших Галицийн Данила, Черниговийн Михайл болон Андрей Ярославич нар Алтан ордны эсрэг өрнөдийг дэмжих бодлого барьж байв. үүнийхээ төлөө Данила ван Ромын Папаас вангийн титэм гардаж, Францын Лион хотод болсон католик шашны анхны чуулганд Черниговын Михаил оролцож байв. Невский Александрын дүү Данила вантай ургийн холбоо тогтоосноор уг эвсэлд нэгджээ.

Монголын дарлалд орсноор европын хөгжлөөс тусгаарлагдаж Орос орон хоцрогдох шалтгаан болсон гэж Оросын түүхчид халагладаг. Гэтэл Орос орон өрнөдийн нөлөөнд орсон бол үнэн алдартны шашин нь хүссэн хүсээгүй устаж, үндэсний соёлд нь нөлөөлөхийн зэрэгцээ газар нутагт нь түрэн орж ирэхийг хүсч байсан загалмайтны эзэмшилд орж, ирээдүйн Орос улс байгуулагдах эсэх нь эргэлзээтэй болох байв. Монголыг бараадах шийдвэрт хүрэхэд Ярославт мөн дотоодын улс төрийн байдал ч нөлөөлжээ. Ярославын эцэг нь Владимир-Суздалийн их ван Юрий Всеволодовичийн төрсөн ах бөгөөд хэдэн жилийн өмнө учир битүүлгээр нас баржээ. Дүү Юрий нь их вангийн суудлыг эзлэхийн тулд түүнийг нууцаар хороосон гэдэг нотолгоогүй яриа бий. Хоёр жилийн урьд их ван Юрий Рязанд цэрэглэхээр шийдэхэд залуу ван Ярослав эрс эсэргүүцсэнээс болж эв эвдэрчээ. Ярослав оросууд өөр хоорондоо дэмий дайтаж цус асгаруулахгүйг хичээж хориглосон нь үр дүнд хүрсэнгүй. Рязаний ван Георгий Ингаваревич ч Ярославыг найрсгаар угтсангүй. Хоёр ванг эвлэрүүлэх гэсэн Ярославын оролдлого талаар болж тэд дайтдагаараа дайтжээ. Урам нь хугарсан Ярослав хэний нь ч талд оролгүй өмнө зүг дайжин оджээ.

Киевийн ван Михаилтай нэг хэсэг шадарлан нөхөрлөж, Кибчагуудтай хэл амаа олох, эвтэй найртай байхал нь тусалж байв. Ярослав энэ хугацаанд шалмаг зоригт эрсийг өөртөө элсүүлж, хүч хуримтлуулж байсан бөгөөд тэрбээр Владимир-Суздалийн вант улсыг гартаа авахыг хүсч байв. Чухам энэ үед монголчууд орж ирсэнд Ярослав нэгэнт оросын вангуудтай хэл амаа ололцохгүй тэднээс дэмжлэг олохгүй байсан учир зориг гарган монголчуудтай холбоо тогтоожээ.

Бат хаан түүнийг сайшаан дэмжиж Хархорум руу илгээжээ. Харамсалтай нь Батын үйл ажиллагааг дэмжиж байсан Ярослав Хархорумд учир битүүлгээр нас барсан юм. Түүний үхлийн шалтгааны талаар судлаачид янз бүрийн таамаг гаргаж зарим нь католик шашныхан Оросыг монголоос салгах зорилгоор Папын элч Плано Карпини хор найруулсан гэж үзсэн бол нөгөө хэсэг нь Бат Гүюгийн зөрчилтэй холбон тайлбарлаж байна. Ярослав ван аль алинд нь халгаатай байр суурьтай байжээ.

Алтан ордныг дэмжсэн нь Папын захиргаанаас дорно зүгт хэрэгжүүлэх бодлогод саад болсон бол, Бат хаанд үнэнч зүтгэхээр андгайлж зарлиг авсан нь Гүюг хаанаас Батыг дайлах гэсэн хожмын төлөвлөгөөнд төвөг учруулж болох учир энэ хоёр хүчний аль алин нь нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй.

Хэдийгээр эцэг нь Монголд очиж учир битүүлгээр нас барсан ч Невийн Александр эцгийн бодлогыг өөрчилсөнгүй, харин Бат хааны хүү Сартагтай анд бололцож Батын хуурай хүү гэгдэх болов. Олон жижиг вант улсуудад хуваагдан дотоодын зөрчилд идэгдсэн Орос орныг өөрийн талд үнэнч зүтгэх, нэр хүндтэй аль нэг ванг бусдынх нь дээр тавьж ерөнхийлөн захирагч болгох Алтан ордон улсын бодлого зөв байсан нь хожмын олон үйл явдлуудаас харагдсан байна.

Бат хаан ч Гүюг хааны зүгээс ирж болзошгүй аюулаас сэрэмжлэн найдвартай ар талтай байх үүднээс Ярослав болон хүү Александрыг нь тууштай дэмжиж, тэдний харьяат Хойт Оросын нутгийн ард иргэдээс хорь шахам жил алба татвар аваагүй билээ.

Тухайн үед Литовтай тэмцэлдэж хүч нь суларсны дээр, Монголчуудын аян дайны дараачаар оросын ванлигууд эсэргүүцэх чадваргүй болсныг тооцоолсон Герман, Шведүүд Орост довтлохоор шургуу бэлтгэж байв.

Шведүүд Ладог нуур болон Нева мөрний дагуух газар нутгийг авахаар санаархаж байв. Шведийн Вангийн хүргэн Биргерийн удирдсан цэрэг 1240 оны 7 дугаар сард Нева мөрний хөвөөнд тулж иржээ. Александр эхлээд Шведүүдийг Нева мөрөн дээр, дараа нь Германиудыг Чүд нуурын мөсөн дээр бутцохиж Новогородыг аварсан юм. Энэ тулалдаанд Александрыг дэмжин Бат хааны жанжин Неврюй цэргээ удирдан оролцож гавьяа байгуулжээ<sup>1</sup>.

Өрнөдийн талыг баримталж байсан Черниговын ван Михаил цаашид явцгүйг ойлгож Бат хаанд хүчээ өгөхөөр 1246 онд Алтан ордонд иржээ. Тэр үед Михаил цаазаар авагдсан бөгөөд түүний үхлийн шалтгааныг судлаачид янз бүрээр тайлбарлажээ. 1239 онд монголын элчийг хороосон, хайгуулын ангийг устгасан, Чингис хааны хөрөгт мөргөхөөс татгалзсан шалтгаанаар хороосон гэж Л.Гумилев үзжээ. Монголын элчийг хороож монголчуудын эсрэг тэмцэж байсан ял нь тодорхой байсан ч хүчээ өгөхөөр ирснийг нь үнэлсэн боловч түүнийг Лионы чуулганд оролцсон эсэх тухай асуудал гарахад “оролцоогүй” гээд хүлээсэнгүй. Хэрэв үнэн бол хоёр галын дундуур ор гэхэд татгалзсан учир худал хэлсэн хэмээн цаазаар авчээ. Монголын эрх баригчдын

<sup>1</sup> Я.Ганбаатар. Их нүүдлийн түүх. УБ., 2001. т. 114-115

баримталж байсан нийтлэг зарчим нь дайсан ч байсан үнэнч байвал түүнийг үнэлдэг билээ. Тиймээс үнэнээ хүлээхгүй хуурамч хүнтэй цаашид хамтран ажиллах боломжгүй хэмээн үзэж цаазаар авчээ<sup>1</sup>.

Алтан ордон улс, Орос хоёрын харилцаа Бат хааны үед харьцангуй тайван байжээ. Оросын хаад Бат хаанд үнэнчээр зүтгэхээ илэрхийлж өөрийн улсыг захирах эрхийн зарлигийг авч байсан бол Бат хаан ч Оросын ноёдтой холбоо тогтоон Орос оронд заналхийж байсан аюулыг зайлуулахад цэргийн хүчээр дэмжлэг үзүүлж тэднийг өөртөө татах бодлогыг тууштай явуулж байв. Хуурай хүү гэгдэх болсон Невийн Александрын эзэмшил хойд Оросын нутгаас хэсэг хугацаанд татвар авахгүй байсан нь өмнөд Оросын хүн амыг олноороо хойд хэсэг рүү ялангуяа дөт байсан Москва орчмын газарт нүүн суурьших болгосон нь хүн амын нягтралыг нэмэгдүүлж хожим Оросын улс төрийн төв Киевээс Москва руу шилжихэд шууд бусаар нөлөөлсөн хүчин зүйлийн нэг болов. Монголчуудыг эзлэн авахад Москва хэний ч мэдэхгүй шахам жижиг хот байсан бөгөөд монгол хаадын төрийн бодлого, түүнийг дэмжсэн оросын хаадын үйл ажиллагаагаар Москвагийн үүрэг ач холбогдол, аажмаар өсөв.

Энэ тухай Японы монголч эрдэмтэн Мияваки Жюнко 1237 онд монгол цэрэг оросын хотуудыг довтлоход Москва нэр нь мэдэгдэхгүй шахам газар байв. Гэтэл Алтан ордны эзэмшилд орж, татвар хураах зэргээр хөгжиж, 1399 онд 17 түмэнтэй том вант улс, Балтын тэнгисийн эрэг дагуу их хот болон хөгжсөн Литвийг эсэргүүцэх хэмжээнд хүрсэн гэж дүгнэсэн<sup>2</sup> нь үнэн юм.

Бат хааны үед төрийн засаг захиргаа, алба татварын тогтолцооны үндэс суурь бүрэн тавигдсан бол, Бэрх хааны үеэс улс орны дотоодод захирах захирагдах ёсыг бэхжүүлэхэд гол анхаарлаа хандуулав.

Бэрх хаан 1257 онд Алтан ордны харьяат бүх улсаас татварыг адил тэгш хураах зарлиг гаргаж Хойт Оросын нутагт хүн амын тооллого хийж татвар оногдуулах шийдвэр гаргасан нь эсэргүүцэлтэй тулгарсан боловч Невийн Александр уг асуудлыг дотооддоо зохицуулжээ. Үүнтэй холбогдуулан татвар хураах талаар Александрын гаргасан саналыг Бэрх хаан зөвшөөрч зарлиг гаргаснаар Орос дахь баскак-даргачийн тогтолцоог үгүй болгож “Ордынский выход” буюу оросын вангууд өөрсдөө татвараа хурааж Алтан ордонд тушаах, үүнд нь Владимирын ван хяналт тавих болсон байна.

Бэрх хаан засаг захиргаа, алба татварын тогтолцоог нэлээд

<sup>1</sup> Ж.Бор. Монгол хийгээд Евразийн дипломатын шаштир. УБ., 2004. т. 228

<sup>2</sup> Мияваки Жюнко. Оросын царь Алтан Ордныг залгамжилсан нь, «Түүхт хүмүүсийн цуврал 26, Чингис хаан», дэд дэвтэр. Гакүшюү кэнкюүшя, 1991. т. 130

чангатган, Оростой харилцах харилцааг өргөтгөв. 1261 онд Сарайд үнэн алдартны төлөөний газрыг байгуулж түүгээр дамжуулан Оросын Византи болон өрнөдтэй харилцах харилцаанд хяналт тавив.

Татвар хураахын зэрэгцээ орос вангуудын үйл ажиллагааг давхар хянаж байсан баскак-даргачийн тогтолцоог үгүй болгосон Бэрх хааны бодлого нь Орос дахь хяналтыг сулруулж, аажмаар Оросын вангууд хүчээ нэгтгэж, өөрийг нь унагах хүчин бүрэлдэх үүдийг нээжээ. Энэ нь мөнгөний хүүдий гэж нэрлэгдэх болсон Иван Калитагийн үеэс нэлээд тодорхой болсон юм.

Бэрхийг Батын хааны хүү Мөнхтөмөр залгамжлав. Түүний төр барьсан нь 1266-1280 он байлаа. Тэрбээр Египетийн мамлюктай эвслийн холбоогоо бэхжүүлж, Хубилайн шахалтаар Эл хаадынхтай энх амгалан байдлыг сахиж байжээ. Мөнхтөмөр хаан худалдаа эдийн засгийг дэмжих талаар хэл хэдэн дорвитой арга хэмжээ авсан ба өөрийн нэр, тамга бүхий мөнгөн зоосыг цутгуулж байв. Мөн гадаад худалдааг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулсан гадаадын худалдаачид, вангуудад хөнгөлөлтийн зарлиг олгосны дээр Оросын үнэн алдартны сүм хийдийг алба татвараас чөлөөлсөн хэд хэдэн зарлиг гаргаж байв.

Мөнхтөмөрийг 1280 онд нас барахад залгамжилсан Тодмөнхийн тухай мэдээ хомс. Арабын зохиолч Рукн-ад-дин Бейбарсийн бичиж үлдээснээр. “Тэрбээр Египеттэй үргэлжлэн харьцаж, үнэт бэлэг зүйлсийг өөртөө төдийгүй томоохон эрхтэн дархтанууддаа ч авдаг байсан. Бэлгийн дотор, лалын шашины сүм барих материал ч ирж байсан аж. Чулуучид ирж Султаны нэрийг сүмийн хананд сийлдэг байсан” гэх зэргээр бичсэн байна. Үүнээс үзэхэд Тодмөнх нь хаан ширээнд суумагцаа өмнөх хаадын уламжлалт бодлогыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ лалын шашиныг дэмжиж байжээ. Гэхдээ хоёр Сарай хотыг эс оруулбал, Алтан ордон улсад лалын шашин нэвтрэх үйл явц эхэн үедээ байсан гэж болно.

1287-1290 онд төр барьсан Тулабугийн үед Алтан ордон улсын эрх баригчдын хооронд зөрчил гарах болсон бөгөөд энэ бүхний ард Ногай байсан юм. Ногайн гарал үүсэл тийм ч тодорхой бус. Египетийн сурвалж бичгүүдэд түүнийг Татарын хүү гэдэг. Тэр нь Зүчийн гуч юм. Рашид-ад-дин ч Ногайн эцгийг Татар гэдэг. Гэхдээ өвөг эцгийг нь Буфла гэсэн байдаг. Ногай Буфлагийн татвар эмээс төрсөн учир хаан ширээнд суух эрхгүй байсан гэдэг. Түүний эзэмшил нутаг нь Дешт-и-кипчакийн баруун хэсэг буюу Дон мөрнөөс Днеприйн хоорондох газрыг багтааж байлаа<sup>1</sup>. Тэмцэл хагаралдааны дүнд Тулабуги алагдаж Тохта (1290-1312)

<sup>1</sup> С.Лочин, Алтан ордны хаад, УБ., 2000, т. 79-81.

ан ширээнд суусан боловч Ногай улс төрийн амьдралд нөлөө бүхий байв. Тохта түүнийг уг дуугүй дагаж байсан юм. Гэвч удалгүй Тохта түүнийг эсэргүүцэн тэмцэж 1300 онд Ногай алагдав.

Зөвхөн үүний дараа л Тохта Алтан ордон улсын бүрэн эрхт эзэн нь болов. Тохта лалын шашинтан байгаагүй, харин бөө мөргөлийг шүтдэг тэдний ч лалын шашинтангуудыг ивээн тэтгэсэн бодлого барьж байв. Тэрбээр мөн Ираны Эл хаант улстай харилцаагаа зохицуулахыг хичээж, нэгэн үе харилцаа сайжирч, хаалттай байсан Кавказын зам нээгдэв.

Тохта хааныг түүний ач Узбек залгамжлав. Тэрбээр Алтан ордон улсын хаан ширээнд 30 насандаа, томоохон ноёдын нэг Кутлуг-Төмөрийн дэмжлэгтэйгээр 1312 онд сууж 1342 он хүртэл 30-аад жил төр барьсан юм. Түүнд өрсөлдөгч дайснууд олон байсан ч тэрбээр хатуу чанга бодлого, чиг шугамыг барьж чаджээ. Узбек хааны үед Алтан ордон улс цэцэглэн хөгжив.

Гадаад бодлогын хувьд Узбек урьдын чиг шугамыг үргэлжлүүлсэн бөгөөд Алтан ордон улс нь Египетийн мамлюктай худалдаа, соёл, дипломатын өргөн харилцаатай байсан юм. Узбек хаан лалын шашныг дэмжих бодлогыг тууштай баримталж, маш богино хугацаанд лалын шашныг тус улсад дэлгэрүүлэхийг зорьсон юм.

Тэрбээр өөрөө лалын шашинд орсон ч улс төр, худалдааны сонирхолын үүднээс загалмайн улсуудтай найрсаг харилцааг хэвээр барьж байв. Узбекиг хүү Тинибег нь залгамжилсан боловч удалгүй дүү Жанибекдээ хаан ширээгээ булаалгажээ.

Узбек хааны үйл ажиллагааны нэг гол хэсэг нь Оросын олон жижиг вангуудтай харилцах, тэдний хоорондын маргааныг таслан шийдвэрлэх явдал байв. Алтан ордон улсын хаад Оросын вангуудын маргааныг хэрхэн таслаж байсныг нэгэн жишээнээс харж болно.

Узбекиг дөнгөж хаан ширээнд суух үед Тверийн Михайл, Москвагийн Георгий нар их вангийн суудал булаалдаж (авга ах, ач хүү хоёр) зарга шүүлгэхээр хаанд бараалхжээ. Михайл авга ах нь түрүүлж ордонд ирсэн бөгөөд Узбек хаан түүнийг явуулалгүй дэргэдээ 2 жил байлгасан юм. Михайлийн эзгүй байсан 2 жилийн хугацаанд Георгий Новгородынхныг өөрийн талд оруулж авчээ. Удсан ч үгүй Георгийг Узбек хаан дуудуулах үедээ Узбек хаан Михайлд их вангийн эрх олгосон зарлиг буулгаж монгол цэргээр хамгаалуулан Орос руу явуулсан аж. Михайлаас урвасан Новгородчууд Михайл болон монголын цэрэгтэй байлджээ. Мэдээж Новгородчууд ялагдаж Михайлийн тулгасан олон болзлыг хүлээн авсан байжээ. Георгий Алтан ордонд дуудагдан ирээд 3 жил болсон гэдэг. Тэгээд Узбек хаан өөрийн охин дүү Кончакийг Георгийд гэргий болгон өгч буцаасан байна. Георгий буцаж ирээд

Михайлтай байлдаж, Георгий ялагдснаар Кончак хатан болон Георгийн дүү зэрэг хүмүүсийг нь Михаил олзолж авчээ. Георгий Новгород руу очин хүчээ сэлбээд дахин Михайлтай байлдах гэтэл Михаил: “Хоёул хамтдаа Орд руу очье. Хаан чи бид хоёрыг шүүн үзэг. Түүний хэлсэн нь миний хувьд хууль гэсэн үг. Хатан, дүү чинь болон Новгородын олзлогсодыг буцааж өгье” гэжээ Тэр үед Кончак хатан гэнэт нас барсан нь байдлыг хүндрүүлжээ. Георгий Узбек хаан руу явсан боловч Михаил очсонгүй, 12 настай хүүгээ явуулжээ. Мэдээж Кончакийн үхлээс шалтгаалсан биз. Түүнийг удаж удаж очиход нь Узбек хаан зургаа, долоо хоног юу ч хэлэлгүй байснаа Георгий Михайл хоёрын хэн нь буруутайг шүү гэж тушаасан байна. Шүүгээд, татвар авах гэсэн элч рүү зэвсэг гаргасан, Георгийн хатан Кончакт хор өгч алсан гэдэг ял тулгаж Михайлийг цаазлах шийдвэр гаргажээ. Георгий их вангийн итгэмжлэл жуухыг авч буцжээ. Гэтэл алагдсан Михаилийн хүү Дмитрий, Георгийг Узбек хаан дээр очиж Владимирийн ван болох зарлиг авсныг сонсоод Георгий Алтан Орд руу явлаа. Жилийн дараа Дмитрий Узбек хаан дээр очиж тэнд байсан Георгийг эцгийнхээ өшөөг авч байна гээд хааны нүдэн дээр цавчин алжээ.

Узбек хаан юу ч хэлэлгүй дуугүй л байсаар байв. Өөрийн хүргэн байсан хүнийг нүдэн дээр нь алахад зүгээр өнгөрөөхгүй байх гэж хүмүүс бодож байв. Хаан Дмитрийн хийсэн хэргийг мартчихсан юм шиг дуугүй байсаар 10 сар болов. Дмитрийн хүү Александр нь Узбек хааны татвар хураагчдын хамт Орос руугаа буцав. Узбек хаан гэнэт 10 сарын дараа 1326 оны 9 дүгээр сарын 25-нд Дмитрийг цаазалав. Түүний дараа түүний хүү Александрийг 1327 онд Оросын их ван болгов.

Узбек хааны үед Алтан ордон улс хөгжлийнхөө өндөр төвшинд хүрсэн ч тус улсын улс төрийн болон нийгмийн хөгжилд сөрөг өөрчлөлт оров. Тэрбээр лалын шашинд орсноор төрийн байгуулагуудад лалын шашинтан түшмэлүүд нэмэгдэж, Сарай хотод их хөрөнгө зарж лалын тансаг сүмүүдийг олноор барьж босгохыг зорьсноор ихээхэн зардал шаардагдаж анх удаа Оросын вангуудад зарлигийн бичгийг их мөнгөөр өгөх болов. Энэ нь төр ёсыг гажуудуулсан төдийгүй мөнгөтэй хүний гарт улс төрийн мэдэл төвлөрч хожим Алтан ордон улсыг түлхэн унагах бодит шалтгааны нэг болов. Эрх мэдэл олж авахын хойноос улайран хөөцөлдөж тэр их мөнгө нь ард түмний нуруун дээр хүнд дарамт болж эсэргүүцэл, бослого хөдөлгөөн гарахад хүргэв. Түүний тодорхой жишээ нь Иван Калитагийн үйл ажиллагаа юм. Тэрбээр мөнгөний хүүдий, мөлжигч, шунахай гэж ард олноос хоч хүртсэн хүн байв. Иван Калита Орос орноо мөнгөөр ч болов нэгтгэнэ хэмээн хэд хэдэн вант улсыг захирах зарлигийг мөнгөөр худалдан авчээ. Хохирлоо нөхөхийн

тулд Новгород болон эрхшээлдээ оруулсан газруудын ард иргэдээс татварын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэн нь эсэргүүцэлтэй тулгарч байсан баримт оросын түүхэнд үлджээ. Энэ нь оросын вангуудад үлгэр дууриал болж дараа дараагийн вангууд мөн өрсөлдөж худалдан авсаар зарлигийн үнэлэмж буурсан авч татварын хэмжээ хасагдсангүй.

Алба татварын энэ хэмжээ Алтан ордон улсыг унах хүртэл хэвээр үргэлжилжээ.

Монголчууд хүнд хүчир дарамт учруулж, Орос орныг үгүйрүүлэн хоосруулж байсан гэдэг яриа нь татвар хураалтаас л үүдэн гарсан бололтой.

Узбек хааныг Жанибек залгамжилж 1342-1357 онд 5 жил төр барив. Тэрбээр хүчирхэг Алтан Ордны сүүлчийн хаан болов. Түүний хаанчлалын үед дотоодын самуун эхэлж түүний үр дагавараар улсын дотоодод задрал эхлэв.

Үүний хамт 1346-1347 онд Алтан ордон улсад тахал гарч Азийн худалдааны гол замын дагуу түймэр мэт тархаж олон сая хүний аминд хүрчээ. Крымээс тахал Румд ирж олон зуун мянган хүний амийг авсан бөгөөд 85000 хүн тахалд өртсөн мэдээ буй<sup>1</sup>. 1348 онд тахал Египет, Сирид хүрч, Европын болон Оросын вант улсуудад ч тархжээ.

Тухайн үед тахал нь Өмнөд Италийн хүн амын ихэнх, Германы 1/4, Английн 60 хувийг үхэлд хүргэж, Герман Шведээр дамжин Новгород, Полов, Москвад орж ирэв. Маш олон хүн үхсэн боловч Москвагийн вант улс удалгүй хүн амаа тооны хувьд төдийгүй чанарын талаар ч сэргээн нөхөв. Ухаалаг, ажилч хэсэг нь үлдэв. Тийм учраас Жанибекийн хаанчлал Москвад чухал нөлөө үзүүлэв хэмээн Л.Н.Гумилев бичжээ.<sup>2</sup>

Жанибек Оростой тогтоосон харилцааг хэвээр байлгахад багагүй анхаарч байжээ. Алтан ордны дотоодын хямрал нь Оросын вангуудын хүчирхэгжиж бие даах хандлагыг нэмэгдүүлэв. Жанибекийн амьд сэрүүн үед эх Тайдула хатан улс орныг жолоодох хэрэгт их үүрэг гүйцэтгэж байв. Жанибек 1357 онд ордны хуйвалдаанаар амь үрэгдэж хүү Бердибек нь залгамжлав. Бердибек (1357-1359), хоёр жил төр барьсан. Энэ үе бол Алтан ордон улс үймээн самуунд идэгдсэн он жилүүд байв.

Алтан ордны түүхийн маргаантай асуудлын нэг нь яах аргагүй Куликовын тулалдаан юм. Тулалдаан болсон газар, оролцсон цэргийн тоо, уг тулалдаан болсон шалтгаан, үр дүнгийн талаар өнөө ч судлаачид маргасаар байна. Москвагийн Дмитрий вантай тулалдсан Мамай гэж хэн байв? Тэрбээр Алтан ордны хаан байсан уу? Тийм их цэргийн хүчийг Мамай хэрхэн гаргаж чадав?

<sup>1</sup> А.Якубовский, "Золотая орда" т. 70

<sup>2</sup> Л.Н.Гумилев, "От руси до России" с. 152

Жанибек, Бердибек хааны нас барсны дараа Алтан ордон улсад үргэлжилсэн самуун эхэлжээ. Оросын түүхчид энэ үеийг онцгойлон "Их үймээн"-ий үе хэмээн нэрлэсэн нь санамсаргүй хэрэг бус. Зарим түүхчид Бердибекийн дараа Зүчийн удмынхнаас хаан ширээг эзлэхээр нэр хүндтэй хүн байсангүйн дээр өөр өөрийн талын хүнийг гаргахын төлөө хэсэг бүлгүүд хоорондоо тэмцэлдэх болсон нь Алтан ордон улсын хүчирхэг байдлыг сулруулав. Үүний үр дүнд 1360-1380 оны хорь шахам жилийн хугацаанд 14 хаан солигдсон нь үнэхээр улс төрийн байдал самуурсныг гэрчилж байгаа юм. Алтан ордон аажмаар задарч олон хэсгүүдэд хуваагдаж байв. Тэр үед талийгч Бердибек хааны хүргэн түмтийн ноён Мамай нэлээд нөлөө бүхий байсан боловч алтан ургийн хүн биш учир хаан ширээнд суух боломжгүй байв. Тиймээс өөрийн хүслийг хэрэгжүүлэхийн тулд алтан ургийн Абдуллахыг дэмжин хаан ширээнд өргөмжлүүлэв. Хаан нь Абдуллах болсон ч эрх мэдэл нь Мамайд байсан нь хожмын олон хэрэг явдлуудаас тодорхой харагддаг юм.

Москвагийн ван Дмитрий Сарайд ирж хаан Мюридээс зарлиг авахад түүнийг Владимирын вангаар томилжээ. Яг тэр үед Мамай Абдуллах хааны нэрийн өмнөөс Дмитрийд мөн өөр зарлиг илгээжээ. Үүнийг Мюрид хаан мэдмэгц Суздалийн Дмитрийг Владимирын вангаар томилжээ. Энэ явдал нь улсын доторх захирах захирагдах ёс алдагдсаныг гэрчилж байгаа юм. Ард түмэн энэхүү самуунтай байдлаас үүдэн чухам хэн нь хаан хэн нь ноён, хэн нь бүгдийг захирсан шийдвэр гаргах ёстойг ч мэдэхээ больжээ.

Энэ байдал нь улс төрийн самууралд хүргэсэн гол шалтгаан болжээ. Алтан ордны энэхүү замбараагүй байдал нь Оросын вангуудад боломж олгож хэсэг хэсгээр довтлох болжээ. 1370 онд ван Дмитрий Константинович Булгар хотыг довтлоход хотын оршин суугчид асар их хэмжээний эд хөрөнгөөр бэлэг өгч золио өгөв.

1374 онд Новгородчууд Мамайн элчийг алсан ба хамгаалалтын 500 шахам цэргийг нь хөнөөжээ. 1376 онд Москвагийн их ван дахин Булгарт очиж Казанийг бүслэн авчээ. Хотоо хамгаалж чадахгүй болсны төлөө мөн 5000 рубль төлөхөд хүрчээ.

Энэ бүх байдал нь хэрэг дээрээ Алтан ордны бараг хагасыг захирч байсан Мамайг хариу арга хэмжээ авахад хүргэжээ.

1377 онд Арабшахын удирдсан цэрэг Москваг дайлахаар морджээ. Гэвч Москвагийн цэргүүд тулалдахаас зайлсхийж зугтжээ. Арабшах доод Новгород хүрээд түүнийг шатаажээ. Алтан ордны цэргүүдийг явсны дараа оросын вангууд Мордвад довтолж их хохирол учруулжээ. Үүнийх нь төлөө Москвагийн ван Дмитрийгээс өшөө авахаар Мамай

өөрийн цэргийн жанжин Бегичийг илгээсэн ба 1378 онд Рязаны нутаг Вожа голын эрэг дээр түүний отряд ялагдсан байна.

Вожа гол дээр ялагдсны дараа Мамай черкес, армян, геноуя болон бусад олзлогдогсод болон хөлсний цэргүүдээс голлон бүрдсэн хүчирхэг том армийг бүрдүүлэхээр шийджээ. Түүний зэрэгцээгээр Мамай Литовын ван Ягайлотой холбоо тогтоож хамтдаа Москваг довтлохоор болов. Энэ бүхэн нь эцсийн дүндээ түүхэнд “Куликовын” гэж нэрлэгдэх болсон тулалдаан гарахад хүргэжээ. Гэвч холбоотон Ягайло нь армиа авч тогтсон хугацаанд болзсон газраа очиж чадсангүй.

1380 оны 9 дүгээр сарын 8-ны үд дунд буюу 12 цагт Куликовын их тулалдаан эхэлсэн гэж түүхэнд тэмдэглэдэг. Тулалдааны эхэн үед Алтан ордны талд давуу байдал байжээ. Оросын цэргийг Дон мөрнөөс таслах боломж ордынхонд байсан боловч Мамай боломжийг ашиглаж чадсангүй эцэст нь ялагджээ.

Оросууд ялалт байгуулж тулалдааныг удирдсан Москвагийн Дмитрий түүхэнд Доны Дмитрий хэмээн алдаршив. Энэхүү тулалдааныг оросууд “Ордын ууцыг хугалсан” хэмээн нэрлэж бүх сурах бичигтээ ч тийнхүү тэмдэглэж энэ тулалдааны ач холбогдлыг өндөрт өргөдөг. Гэвч сүүлийн үеийн судлаачид уг тулалдааны судалгааг эргэн харж бодитой хандах эрэлхийлэл хийж байна. Тэдгээр судлаачдаас цэргийн түүхч А.Б.Широкорадыг онцлон дурдаж болно.

Тэрбээр уг тулалдааны тухай судлахдаа юун түрүү “Ууцаа хугалуулсан” гэдэг үг нь их эргэлзээтэй байна. Тэгвэл ууцаа хугалуулсан хэн бүхэн, амьтан ч хэдэн цагаас илүү удаан амьдарч чадахгүй үхдэг билээ. Гэтэл ууцаа хугалуулсан Ордод, Орос хэрхэн дахин 100 жил алба төлсөн байдаг билээ?<sup>1</sup> гээд уг тулалдааны маргаантай асуудлуудыг хөндөн тавьжээ. Мамайн цэргийн тоо хэд байв? Тулалдаан болсон газар хаана байсан хийгээд тулалдааны зорилго юу байв гэдэгт гол анхаарлаа хандуулжээ.

Куликовын тулалдаанд оролцсон цэргийн тоог судлаачид янз бүрээр бичсэн байдаг. Дмитрий вангийн удирдлагад Оросын 23 ван цэргээ аван оролцсон бол Мамайн цэрэг монгол цэргээс гадна эрээвэр хураавар бүрэлдэхүүнтэй байв.

Б.Рыбаков, Мамай 300 000 цэрэгтэй<sup>2</sup> гэсэн бол М.Н.Тихомиров 100-150 000, Р.Г.Скрынников, В.А.Кучкин нар 40-60 000 байсан гэжээ. Тооны хувьд маш зөрүүтэй байна. Тэгвэл Мамай 300 000 хүнтэй байсан гэж үзвэл тэр их хүчийг хаанаас олсон болж таарах вэ? гэдэг асуулт

<sup>1</sup> А.Б.Широкорад. Русь и Орда. М., 2004. стр. 154

<sup>2</sup> Куликовская битва в истории и культуре нашей родины (материалы юбилейной научной конференции). М., Издательство Московского университета, 1983. стр. 52-53

аяндаа гарна. Орос болон баруун европыг дайлж байсан цэргийн хүч ид төвлөрсөн Бат хааны үед ч, ид хүчирхэгжиж байсан Алтан ордон улсыг бүхэлд нь захирч байсан Бэрх, Узбек хааны үед ч тийм их цэргийн хүчийг гаргаж байгаагүй, тэгэхээр энэ тоо эргэлзээтэй юм. Харин нөгөө 2 саналын тухайд бол байж болох тоо учир цаашдын судалгаа шаардлагатай юм. Мамай бол өмнөх нэр дурдсан хаад шиг Алтан ордны бүх нутгийг захирч байгаагүй, зөвхөн хэсгийг нь л захирч байсан бөгөөд тэр үед Алтан ордон улсын ихэнх хэсэг нь хаан Тохтамышийн мэдэлд байсан юм. Тэгээд ч Тохтамыш бол Чингисийн удам, жинхэнэ хаан байсан бол Мамай бол түмний ноён байв.

Тулалдаан болсон газрын тухайд судлаачдын санал мөн л маргаантай байна. XIX зууны эхээр баян газрын эзэн, язгууртан, декабрист С.Д.Нечаев “Вестник Европы” сэтгүүлийн 1821 оны дугаарт анх Куликовын тал Непрядва Дон, Мечей голын хооронд байна хэмээн бичихдээ газрын нэр, мөн газар хагалах үед олдсон олдворуудыг үндэслэжээ. Дон, Непрядва голын бэлчир дэх Монастырщина тосгоны Улаан толгод хэмээх газар Куликовын тулалдааны дурсгалын цогцолборыг ч байгуулжээ.

Гэвч дээрхи алдарт өгүүлэл нь Куликовын тулалдаантай холбоотойгоор маш олон дахин хэвлэгдсэн боловч түүний баримт үндэс болгосон олдворуудын талаар ямар нэгэн тайлбар, судалгаа огт гарсангүй.

Цэргийн түүхч Широкоград нэрт археологич А.К.Станюковичид хандаж С.Д.Нечаевын олдворт анализ хийж өгөхийг хүсчээ. Найман олдвороос зөвхөн хоёрыг нь бараг хүчээр Куликовын тулалдаанд холбогдуулж болох дүгнэлт гарсан нь асуудлыг улам цаашид нягтлах шаардлага ургуулжээ.

Непрядва голын зүүн, нөгөө хэсэг нь баруун хэмээн зарим нь бүр өөр газар хэмээн өнөө ч мэтгэлцсээр байгаа ба А.Б.Широкоград чин үнэнээр хэлбэл Куликовын тулалдаан хаана болсныг хэн ч мэдэхгүй<sup>1</sup> байна гэжээ

Мөн тэрхүү тулалдаанаар Донын Дмитрий гэж алдаршсан Дмитрийн уг тулалдаанд гүйцэтгэсэн үүрэг ч эргэлзээтэй аж. Куликовын тулалдааны талаар асар их судалгааны материал гарсан ч тэдгээр нь гуравхан эх сурвалжид тулгуурладаг бөгөөд түүний нэг болох “Мамайн тулалдааны түүх”-энд: Уг тулалдаанд Дмитрий биш харин түүний үеэл В.А.Серпуховский гол үүрэгтэй байсан хэмээжээ. Хамгийн гол нь дээр өгүүлсэн 3 сурвалжид бүгдэд нь Дмитрий цэрэг захирахаас татгалзсан

<sup>1</sup> А.Б.Широкоград. Русь и Орда. М., 2004. стр. 160

гээд тулалдааны өмнө Дмитрий вангийн өмсгөлөө өөрийн хайртай М.А.Бренк ноёд өмсгөн, морио улаан тугийн хамт өгсөн гэжээ.

Оросын тулалдааны түүхэнд нэг ч ван тийм зүйл хийгээгүй бөгөөд ялангуяа IX-XV зуунд вангууд нэр төрөө маш эрхэмлэж байсан бөгөөд оросын дайчид ван, ноёнгүйгээр тулалдаанд огт ордоггүй байсан аж. Тийм жишээ баруун Европт ч байхгүй<sup>1</sup>. Казанийн Багшийн Их сургуулийн профессор И.А.Гафаров: Дмитрий хэнтэй вангийн өмсгөлөө солив? Тэр хүн нь Михайл Андреевич Бренк тухайн үеийнхнийх нь өгүүлснээр Дмитрий түүнд хайртай байсан бөгөөд харин өөрийгөө аюулд учруулахгүйн тулд, ердөө л түүнийг үхэл рүү илгээсэн аж. Дмитрий түүнд хувцсаа өмсгөхдөө өөрийгөө зуурдын үхэл, шившигтэйгээр олзлогдохоос аврахыг зорьсон бөгөөд, хэрэв татарууд Их ванг өмсгөлөөр нь таних аваас түүнийг барьж авахын төлөө бүхнийг хийх байсан<sup>2</sup> гэжээ. 1380 оноос хойно, өмнөх аль ч тулалдаанд аль аль тал нь жирийн цэргүүдийг алдаг бол ван ноёдыг нь олзлохыг хичээдэг. Энэ нь нэр төрийн болоод их хэмжээний мөнгө, олз олох боломж байдгаас анхаарлын төвд байдаг юм

Мөн тулалдааны хохирлын талаар ч мөн өнөө хүртэл тодорхойгүй байсаар байгаа юм. Тулалдаанд Оросын 12 ван, 483 ноёд алуулсан гэдэг. Гэтэл дээрх 3 сурвалжид татарын цэргийн олзлогсдын тухай нэг ч дурддаггүй нь судлаачдын гайхлыг төрүүлдэг бөгөөд, энэ асуудлыг XIX-XX зууны түүхчид ч чимээгүй тойрон өнгөрчээ. Тийм том тулалдаан олзлогдогсодгүй байна гэж үгүйн дээр, мөн олзлогдогсод байсан аваас он дарааллын бичгүүдэд бахархан тэмдэглэх ёстой гэж Широкопад гайхан бичжээ.

Мамайн дайн хийсэн шалтгаан нь Москвагийн их ван Дмитрийг залхаан цээрлүүлж олон жил татвар авах, оросын ноёдыг хөнөөж тэдний оронд хааны баскакуудыг тавих зорилгод байжээ. Хэрвээ тэрбээр Алтан ордны хаан болохыг хүссэнсэн бол Москва руу биш Тохтамыш руу довтолж эрх мэдлээ олж авах байсан болов уу? хэмээгээд Их ван Дмитрий Иванович алба татвар төлөхгүй байсан нь хүчирхэгжсэндээ бус харин Ордын доторх самуунтай, үл ойлгогдох байдлаас болж Мамай, Тохтамыш хоёрын хэнд нь татвар төлөх нь тодорхойгүй өөрөөр хэлбэл Ордын дотоод улс төрийн байдал тогтворгүй байж хэн нь тухайн үеийн улс төрд зонхилох үүрэг гүйцэтгэж байсан нь тодорхойгүй байсантай холбоотой. Тэгэхээр Мамай харин ч Тохтамыштай тэмцэх хүч олж авахын тулд Москваг довтолсон байж болох юм. Яагаад гэвэл олзны эд агуурс, мөнгөөр шинэ цэрэг нэмэн элсүүлэхийн дээр хоол хүнс хувцас

<sup>1</sup> А.Б.Широкопад. Русь и Орда. М., 2004. стр. 160

<sup>2</sup> И.А.Гафаров. От истоков к истине. Казань. Дом печати. 2002. стр. 11

хэрэглэл, зэр зэвсгийн нөхөн хангалт хийхийг санаархан довтолсон байж болох юм гэсэн оросын эрдэмтэн А.Б.Широкоадын<sup>1</sup> саналыг анхаарч үзэх нь зүйтэй мэт.

Харин Мамай дахин довтолохоор цэргээ бэлтгэж байсан боловч Тохтамыш Мамай руу довтолж Калка гол дээр тулалдан түүний хүчийг бүрмөсөн сөнөөсөн ба Мамайн шадар түшмэлүүд түүнээс урваж Тохтомыш хааны талд орсон учир цөөн цэргийн хамт өөрийн эзэмшил Крымын Кафа хотод буцаж ирэхэд нь түүнээс хөнгөлөлтийн зарлиг гардан авч байсан гегуячууд Маймааг хороожээ.

Мамайн ялагдлын хувьд бол уг тулалдаанд монгол цэргүүд бус олзны буюу хөлсний цэрэг голлож байсан, мөн тооны хувьд ч тийм олон байгаагүйн дээр Тохтамыш хаантай хагаралтай, түүний зүгээс дэмжлэг олоогүйтэй холбоотой. Оросын хувьд бол энэ тулалдаан ач холбогдолтой байсан бөгөөд хүчээ нэгтгэвэл амжилтад хүрч болох итгэлийг олж авсанд оршино.

Куликовын тулалдааны дараа нэгдсэн удирдлагагүй, задарч бутарсан Алтан ордон улсыг Тохтамыш хаан Их Орд нэртэйгээр дахин нэгтгэж чаджээ. Гэвч Оросын вангууд ялалтандаа урамшин Доны Дмитрийг тойрон нэгдэж улмаар Москвагийн нэгдсэн улс байгуулагдаж эхлэв. Тэр үеийн улс төрийн байдал ч таатай нөхцөл байдлыг буй болгожээ. Гол өрсөлдөгч, байнгын аюул занал учруулагч Мамай алагдаж, Владимирын эрх баригчид Москвагийн захиргааг хүлээн зөвшөөрч, Херш Литовын улс дотооддоо зөрчилд автагдсан нь оросууд нэгдэхэд таатай боломж бүрдүүлжээ.

Тэр үед Тохтамыш хаан Мамайг ялж Алтан ордны бүрэн эрхт эзэн болсноо элч илгээж мэдэгдсэн нь Москвагийн эрх баригчдаас ямар нэгэн хариу өгөхийг шаардсан хэрэг болов.

Гэвч тулалдааны шарх нь аниагүй, хүн хүчний их хохирол амссан Москвад эрх захиргаагаа сэргээсэн Тохтамыш хааныг эсэргүүцэх боломжгүй байсан. Тиймээс Москвагийн эрх баригчдаас урьдын адил Алтан ордонтой харилцаагаа сэргээх зорилгоор үлэмжхэн бэлгийн хамт элч нараа илгээжээ. Тохтамыш хан ч хариу элч илгээсэн боловч зорилгоо биелүүлэлгүй Доод Новгородоос элч нь гэнэт буцсаны дараа Тохтамыш Москва руу цэрэглэх болсон нь зүгээр нэг үл итгэлцэх явдал гарсан бус харин нэлээд ноцтой хэрэг болсон бололтой.

Тохтамышийн хувьд Алтан Ордны урьдах хаадуудаас өөр бодлого баримтлах болсон нь Москвагийн бие даах бодлого нэгэнт илэрхий болсонтой холбоотой байв.

<sup>1</sup> А.Б.Широкоад. Русь и Орда. Москва. Вече. 2004. стр. 156

Куликовын тулалдаан болсон эсэх талаар Новгородын эх сурвалжуудад Москвачуудын зохиосон адал явдал гэж тэмдэглэсэн байдаг бол Псковын сурвалжуудад бүр ийм үйл явдал болсон эсэхэд эргэлзсэн байр сууринаас хандсан байдаг.

Оросын судлаачид Куликовын тулалдаан болсон газар оронд төмөрлөг биет хайгчаар зэр зэвсгийн зүйл хайгаад олоогүй бөгөөд нийт 260 мянган га талбайг нэгжсэн ажээ. Куликовын тал нь нэлэнхүйдээ намгархаг газар юм. Тиймээс Орос болон Алтан ордон улсад хэрэглэж байсан морин цэргийн байлдах аргад тус газар нэн зохимжгүй байгааг ч онцложээ.

Куликовын тулалдаанд хоёр талаас хэдий хэрийн цэрэг оролцсон тухай тоо баримт бий. Тухайлбал, Оросын талаас 1.4 сая, 4 зуун мянга мөн 250 мянган цэрэг Куликовт цугларсан гэж үздэг. Энэ нь асар их хэтрүүлэгтэй тоо бөлгөө. Тэр үеийн цэргийн хувцас хэрэглэл, хөө хуяг, зэр зэвсэг маш үнэтэй байсан тул жирийн тариачид худалдан авч чаддаггүй байжээ. Ганц жишээ өгүүлэхэд нэг хөө хуягт 600 метр урт нарийн цувисан төмөр ордог бөгөөд ганц хуяг хийхэд 2 жил зарцуулдаг байна. Тэгвэл нэг иж нум сум хийхэд 3 жилийг зарцуулдаг аж. Тиймээс оросын судлаачдын үзэхээр Куликовт бараг мэргэшсэн цэргийнхэн буюу дээд тал нь 30-аад мянган хүн Оросын талаас оролцсон гэж дүгнэжээ.

Хэрэв үнэхээр ийм тулалдаан байсан бол хаана, хэзээ болсон талаар Оросын судлаачид дараах таамаглалыг дэвшүүлсэн байна. Үүнд нэгд, Рязаниас 30-35 км зайтай байдаг Рязска, Дон мөрний нөгөө эргийн Непрядва гол, эсвэл бүр Москвагийн төвд Китай-хотхоны орчимд болсон байх гэж үзэцгээж байна. Энэ тухай ОХУ-ын төв телевиз ОРТ сувгаар 2002 оны XII сарын 7-нд тусгай нэвтрүүлэг хүртэл хийсэн юм.

Хаана ч бай ийм тулалдаан болж оросууд ялж гарсан нь үнэн бол тэр нь Алтан ордон улс зохих хэмжээгээр сулрах, оросууд нэгдэл нягтралынхаа төлөө санаа тавихад хүргэсэн нь дамжиггүй.

## 5. АЛТАН ОРДОН УЛС БА ЭЛ ХААНТ УЛСЫН ХАРИЛЦАА

Алтан ордон улсын байршил нь лалын шашинтан Ойрхи дорнод, Арабын орнуудтай харилцах боломжийг олгосон юм.

Алтан ордон улсын гадаад харилцаа нь Монголын эзэнт гүрний төв болон өрнө дахины орнуудын тухайн үеийн улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан нэлээд өвөрмөц онцлогтой байсан бөгөөд Бат хааны үед төвөөс явуулж буй гадаад бодлогын жанжин шугам алдагдалгүй явж ирсэн бол түүнийг залгамжилсан хаадын үеэс зарчмын алдаа гаргаж харь гүрний нөлөөнд автан алтан ургийнхан хоорондоо дайтаж цус урсгасан гашуун сургамж буй билээ. Тиймээс Бат хааны гадаад бодлогодоо баримталж байсан гол зарчмууд хийгээд түүнийгээ хэрхэн чадварлаг хэрэгжүүлсэн, түүний үр дүнд Алтан ордон улс хэрхэн өрнө дорныг соёл шинжлэх ухааны түмэн шижмээр холбож чадсаныг түүхэн сурвалжуудад тодорхой өгүүлжээ.

Тухайн үед шинэхэн байгуулагдсан Монголын эзэнт гүрний зүгээс нөлөөний хүрээгээ тэлж шинэ шинэ газар орныг эзлэн авч байсан бол түүний эсрэг Ромын Пап ламаар тэргүүлүүлсэн хүчин, Монголын их хаадыг өөрийн шашинд оруулах, католик шашны нөлөөг Дорнод Европын орнууд болон Орост дэлгэрүүлж, улмаар сүсэгтэн олныхоо хүчээр дорноос ирэх аюулыг хазаарлан тогтоохоор оролдож бусдын нутаг дээр үйл хэргийг өрнүүлэхийг зорьж байв.

Улс төрийн хоёр том хүчин хэн нь хэнийгээ эрхшээлдээ оруулах, нэгэнт бүрэлдсэн улс төрийн нөхцөл байдлаас яавал хохирол багатай гарах ухаан бодлыг уралдуулж байв. Эл хоёр сөргөлдөөний гол талбар нь яах аргагүй Алтан ордон улс байсан бөгөөд идэвхитэй, зөв гадаад бодлого хэрэгжүүлэх зүй ёсны шаардлага Батад тулгарчээ. Юуны өмнө өрсөлдөгч этгээдийнхээ байдлыг тандан мэдэх өөрөөр хэлбэл, өрнөдийн орнуудын улс төр, гадаад бодлого, монголчуудын эсрэг эвсэл холбоо байгуулагдаж буй эсэх болон хоорондынх нь зөрчил тэмцэл зэргийг нэгд нэгэнгүй мэдэж, хэр зөв бодлого явуулахаас түүний гадаад бодлогын амжилт шалтгаалах байв.

Бат хаан энэ нэр хүндтэй үүргийг гүйцэтгэхдээ хэд хэдэн зүйлийг

онцгойлон үзэж төрийн болон гадаад бодлогодоо баримталж байсан нь түүний үйл ажиллагаанаас тодорхой харагдана. Үүнд, нэгд: **Төрийн нээлттэй бодлого** явуулж Монгол төрийн аюулгүй байдалд харшлаагүй нөхцөлд аль ч орны төрийн түшээ, эрдэмтэн мэргэдийг төрийн албанд томилж хийж чадах ажилд нь хүчин зүтгүүлж, алдар гавьяаг нь хөхүүлж байсан нь монгол төрийн хүчирхэг байхын нэг үндэс болов. Олон орны элч төлөөлөгчдийг хүндэтгэлтэй хүлээн авч, хүсэл саналыг нь сонсож, өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх боломжтойг нэн даруй шийдэж, боломжгүйг нь Их хаанд бараалхахыг санал болгож өртөө унаа, дагалдах хүмүүсийг гаргаж өгч байснаар Алтан ордон улс олон орны элч төлөөлөгчийн дуртайяа зорин очих газар, гадаад харилцаа улам өргөжин дэвжихийн үндэс болов. Өрнө болон ойрхи дорнодоос Монгол нутгийг зорьсон элч нарын ихэнх нь Алтан ордны нийслэл Сарай хотод ирж, Бат хааны ордонд бараалхдаг болсон нь Батын баримталсан төрийг удирдах нээлттэй зарчим зөв байсны илрэл юм. Мөн шашны төлөөлөгчдийг адил хүндэтгэн үзэж, өөрийн орны дотоодод аль ч шашныг дэлгэрүүлэхийг хориглоогүйн дээр сүм дуганаа чөлөөтэй барихыг зөвшөөрснөөр нийт улсын дотоодод зөрчил хямрал үүсэхээс сэргийлж чадав

**Хоёрт: Мэдээллийн найдвартай сүлжээ** буй болгож чадсан нь цаг хугацаа хожихын дээр тухайн үеийн цагийн байдлыг зөв тооцоолж, төрийн оновчтой зөв бодлого шийдвэр гаргаж хэрэгжүүлэхэд тус болов. Мэдээлэл олж авахын тулд гадны элч төлөөлөгчдийг хүлээн авахын зэрэгцээ өөрийн элч төлөөлөгчдийг хөрш улсуудад илгээж байсан ба элчийг сонгохдоо ажил хэргийн чадварыг нь харгалзахаас бус угсаа гарвал, огтхон ч хамаагүй байжээ. Бат хаан аливаа асуудалд нухацтай хүлээцтэй ханддаг байжээ. Бат, Унгарын Бела ванд довтлохын өмнө удаа дараа элч илгээж байсан боловч тодорхой хариу өгөхгүй байсаар илгээсэн элчийн тоо 30-д хүрч байсан баримт үлдсэн байна<sup>1</sup>. Элч нарын нэг нь монгол хэлийг гаргууд сайн сурсан англи хүн байжээ. Тэр элч Бела вангаас “Мөнх тэнгэрийн хүчин дор энэ дэлхийн бүх орныг эзлэн захирсан Монголын их эзэн хааны захиргааг хүлээн зөвшөөрч дагаар орохыг шуудхан шаарджээ. Ван болон зөвлөхүүдийг хааны шаардлага ёсоор дагаар монголчуудад бэлэг сэлт барьж илгээхийг элч ятгаад тусыг эс олжээ<sup>2</sup>.”

Өрнө болон ойрхи дорнодоос Монгол улсыг зорьсон төрийн элч, шашны төлөөлөгчид, худалдаачдыг Бат хаан хүндэтгэн дайлж элч

<sup>1</sup> Монголын түүхийн сурвалж судлал: өнөөгийн байдал, судалгааны асуудлууд УБ., 2004. т. 31.

<sup>2</sup> Михаэл Правдин. Чингис хаан түүний өв. УБ., 2005. т. 174.

нарыг дахин ирэх урам төрүүлэхэд анхаарч байв. Алтан Ордны нутгаар дайран өнгөрч Бат хаанд бараалхсан элч нар өөрийн улс орныхоо тухай болон ирсэн зорилго, замд дайран өнгөрсөн улсуудын тухай мэдээлэл өгдөг байсан нь гадаад бодлогодоо зөв чиг баримжаа олоход чухал төдийгүй Алтан ордон улсын гадаад харилцааны хөгжилд тодорхой нөлөө үзүүлжээ.

**Гуравт: Зам харилцааны аюулгүй байдлыг-г чухалд үзэж байв.** Өгэдэй хааны зарлигаар зохион байгуулалт, хүнсний хангамж, улсын хамгаалалттай өртөөг байгуулахад Алтан ордон улс тодорхой хувь нэмрээ оруулсан юм. 30 км тутам өртөө байгуулж, цэргийн хамгаалалтад оруулж худалдаачдын амь нас, эд хөрөнгийг хамгаалсан төдийгүй замын хажуугаар мод тариулж ая тухыг нь хангаснаар өртөөгөөр зөрчигчдын тоо эрс нэмэгдэв. Өртөөний найдвартай, аюулгүй байдлыг хангахад онцлон анхаарсаны үр дүнд өртөөгөөр өрнө, дорны төр, шашин, худалдааны элч төлөөлөгчид нааш цааш чөлөөтэй зорчих боломжийг нэмэгдүүлсний дээр найдвартай үнэн зөв мэдээлэл олж авах үүдийг нээжээ. Алтан ордон улс болон Туркестан Персийг дайрч тив дамнасан хоёр ч худалдааны зам Дорнод Азийг өрнийн орнуудтай холбож Хар тэнгисийн эрэг дэх Венец, Генуя хотод хүрдэг байжээ. Франческо Балдуччи Пеголотт гэгч 1340 онд бичсэн номдоо: “Танагаас Сарай хот орох зам Катай хүрэх бусад замаас арай л найдвар муутай санагдаж болно. Гэхдээ замын энэ хэсэгт багтаа 60 орчим хүнтэй байхад нутагтаа байгаа мэт аюулгүй явж чадна. Харин Танагаас Катай орох зам бол өдөр шөнө ялгалгүй ямар ч аюулгүй Тэнд хаа сайгүй л татаруудын тогтоосон энхийн журам буюу пакс татарика ноёрхож байдаг”<sup>1</sup> хэмээн өгүүлжээ.

Өртөөгөөр зорчиж буй элч нарын зэрэг дэв, ажил хэргийн шаардлагаас хурдан, удаан зорчих нь хамаарч байв. Плано Карпини Францын Лион хотоос 1245 оны 4 дүгээр сарын 16-нд гарч Монголын Эзэнт гүрний баруун хязгаар Ижил мөрний адагт орших Батын өргөөнд (1246 оны 4 сарын 4) очиход бараг нэг жил явсан атлаа Батынхаас Гүюгийн ордон хүртэл (1246 оны 4 сарын 8-наас 1246 оны 6 сарын 16) бараг 2 дахин их замыг хоёрхон сарын хугацаанд туулсан бөгөөд тэрбээр өртөөний гайхамшигийг магтан бичсэн бол Мөнх хааны үед ирсэн В.Рубрук морьтой боловч ачаа ачсан үхэр тэрэгнийхээ аясаар өртөөгөөр нэлээд зовон зүдэн аялсан тухайгаа тэмдэглэсэн байдаг.

**Дөрөвт: Найдвартай холбоотон-той байх.** Оросын вангууд өрнө зүгээс заналхийлэх Тевтоний загалмайтнуудын дайралтыг няцаан барьж байхын тулд Бат хаанаас тусламж хүсэхэд түүнд цэрэг зэвсгийн тусламж

<sup>1</sup> Михаэл Правдин. Чингис хаан түүний өв. УБ., 2005. т. 239.

үзүүлж чадах томоохон улс төрийн хүчин, найдвартай холбоотон чухал байсан учраас уриалгахан хүлээн авчээ. Өөрийн үнэн алдартны шашныг хамгаалах, түүндээ монголчуудаас дэмжлэг олохыг хүссэн Невийн Александртай Бат хаан холбоо тогтоосон нь түүний өрнө зүгт явуулах бодлогод нааштай боломж олгосон юм. Бат хаан элч төлөөлөгч нартай уулзахдаа тухайн элчийн нутаг орны тухай мэдээлэлтэй байдаг төдийгүй түүнийгээ магадлах, одоогийн байдал нь ямар байгааг сайтар тандан мэддэг байжээ. В.Рубруккийн тэмдэглэлд Бат хаан таны (Францын хаан – С.Ц.) нутгаасаа цэрэглэн гарсныг мэдэх тул хэнтэй байлдаж байгааг асуув гэх буюу Бат хаан Лион хотноо хурсан Папын ертөнц дахины чуулганаас монголчуудын эсрэг загалмайтны дайн зарласан пап ламын бодлогыг сэргүүлж загалмайтнуудын гэнэтийн довтолгооноос баруун хилээ аюулгүй болгох зорилгоо шийдвэрлэлээ. Михайл ван Папын зохион байгуулсан Лионы чуулганд оролцоод, түүнийгээ мэдэгдэхийг хүсээгүй учир Унгарт хэсэг хугацаагаар сууж байгаад буцаж иржээ. Тэрбээр уг явдлыг Бат хаан мэдээгүй гэж бодож байсан бололтой. Гэвч Бат хаан Европынхны талаар сайн мэдээлэлтэй байсан тул түүнийг ирмэгц Сарай хотноо дууджээ. Хэдийгээр Бат хаан түүнд өөрийгөө цагаатгах боломж өгсөн ч тэрбээр худал хэлсний учир цаазаар авагджээ.

Европынхон монголчуудын тухай төдийлөн тодорхой мэдээлэлгүй байхад харин монголчууд тэдний хаад ноёдын гэр бүлийн харилцааны хүртэл нарийн ширийн зүйлийг хэдийн мэдсэн байдаг байв.

**Тав:** Эдийн засгийн хүчирхэг байдал. Их гүрний нутгаар хэрэн явж гадаад худалдааг идэвхитэй хөгжүүлж буй худалдаачдад хааны сангаас хөнгөлттэй нөхцлөөр зээл олгох, барааг нь урамшуулалтай үнээр худалдан авах, зарим үед өртөөгөөр хөнгөлттэй явах боломж олгох зэргээр гадаад худалдааг хөхүүлэн дэмжсэнээр дэлхийн чөлөөт худалдааны бүс бий болох үндсийг тавьжээ.

Тухайн үед өрнө дахинд худалдаагаар тэргүүлж байсан Венец, Генуя хоёр хот Алтан Ордонтой хийх худалдааны төлөө өрсөлдөж аажмаар Хар тэнгист Генуя ноёрхох болов. Хуучин дан Венецийн зах зээл байсан Византи бүхэлдээ Генуягийн мэдэлд оржээ. Крымд Генуягийн харьяаны хот суурингууд Алтан Ордны улстай хийх худалдаанд зонхилох болов. Тэр үед Бага Азийн умар эргийн усан боомтууд Төв Азийн худалдааны голлох хэсгийг хангаж байв<sup>1</sup>. Торгоны замыг их хаад ивээлдээ авснаар худалдааны хэмжээ, далайц өмнөх үеэс эрс нэмэгдэв.

Тийнхүү XIII зуунд дэлхийн эдийн засаг, чөлөөт худалдааны бүс

<sup>1</sup> Михаэл Правдин, Чингис хаан түүний өв, УБ., 2005. т. 235

бодитойгоор бүрэлдэн тогтсон юм<sup>1</sup>.

**Зургаа: Шашны эрх чөлөө.** Бат хаан өөрийн улсын дотор шашны зөрчил тэмцэл гаргуулахгүй байх үүднээс хүн амаа шашнаар ялгаварлан гадуурхахгүй бодлого барьж тухайн шүтэж буй шашнаар нь дамжуулан захирч байв. Оросын үнэн алдартны, лалын, несторианы, бөөгийн шашинтнууд Алтан ордон улсад зэрэгцэн амьдарч өөрийн сүм дуганыг байгуулж, зарим хөнгөлөлтийг ч хүртдэг байжээ. Алтан ордны хаадаас Оросын үнэн алдартны хамба лам нарт алба татвар, цэргийн албанаас чөлөөлөгдөх, өртөөгөөр хөнгөлөлттэй зорчих эрхийн зарлиг олгож байв.

Бат хаан дээрхи зарчмуудыг мөрдөж чадсанаар өөрийн улсын эв нэгдэл, аюулгүй байдлыг хангаж Монголын эзэнт гүрний төрийн бодлогыг баруун жигүүрт хэрэгжүүлж чадав.

Чингис хааны байгуулж түүний үр ач нарын залган хөгжүүлсэн Их Монгол улсын төрийн бодлого нь монголчуудын олон зуун жилийн төрийн уламжлал дээр дэлхийн олон улс орны эрдэмтэн мэргэд, төрийн түшээдийн оюун ухааны тусламжтайгаар боловсрогдон хөгжиж олон зуун жилийн амьдралаар шалгагдан төрийн удирдлагын шигшмэл цогц болжээ.

Бат хааныг нас барсны дараа хаан ширээг Бэрх залгамжлав. Энэ үед Хубилай, Аригбөхийн хаан ширээний төлөөх тэмцэл хүчтэй өрнөж, үүнд эзэнт гүрний бүрэлдэхүүн улсууд хамрагдав. Энэ үеэс Алтан ордон улсын гадаад бодлогод ихээхэн өөрчлөлт гарчээ.

Алтан Ордон улсын гадаад бодлогын чухал хэсэг нь Эл хаант улстай Азербайджаны асуудлаар маргаж, заримдаа сөргөлдөх хандлагыг үүсгэж байв. Энэ нь бүр Хүлэгийн үеэс эхэлсэн юм. Хүлэгийг Иран руу мордоход алтан ургийн ноёдоос төлөөллийн шинжтэй хэсэг хүмүүсийг сонгож дагалдуулан явуулжээ. Үүнд, Бат хааны зүгээс Балакан, Сүнжак, Татар ба Кули нэртэй ноёдыг хүч зузаалан өгсөн байна. Хүлэг хаан Багдадыг эзэлсэний дараа 1265 онд Балакан ноёныг урваж хараал хийсэн гэдэг шалтгаар баривчлан авч Сүнжактай хамт Бэрхэд хүргүүлжээ. Бэрх хаан энэ хэргийг нягтлан шалгаад Балаканыг хараал хийсэн гэдэгт итгэсэн тул Хүлэг тийш буцаан явуулж “Тэр буруутан нь мөн. Чи л түүнийг мэдэж байгаа шүү дээ” гэж хэлүүлжээ. Энэ ёсоор Балаканыг Хүлэг хаан буруутган яллаж цаазалсан аж<sup>2</sup>. Үүний дараа Татар ба Кули нар Эл хаант улсад албан хааж байхдаа учир битүүлгээр таалал төгссөнийг Алтан Ордон улсын эрх баригчид ихэд сэжиглэн хорлосон байж магадгүй хэмээн харджээ. Юутай ч энэхүү явдлаас болж

<sup>1</sup> Михаэл Правдин. Чингис хаан түүний өв. УБ., 2005. т. 243

<sup>2</sup> Рашид-ад-Дин. Судрын чуулган. II боть. Орос хэлнээс орчуулсан Ц.Сүрэнхорлоо. т. 90

Бэрх, Хүлэгийн хооронд эв эвдэрсэн<sup>1</sup> хэмээн Рашид-ад-Дин үзжээ.

Татар ба Күли нарыг нас барсаны дараа захирсан цэргүүд нь сарнин дутаасныг Эл хаант улсын цэргүүд нэхэн мөшгөсөн нь хямралыг улам даамжруулсан байна. Энэ үеэс хоёр улсын харилцаа ихэд хурцдаж Хүлэг “Тэр хэдийгээр ах минь боловч даруу зан ичимхий байх ёсноос холдож, надад хандахдаа заналхийлж албадаж байдаг учир би түүнийг үл тоомсорлох боллоо” гэж байхад Бэрх “Тэрбээр (Хүлэг – С.Ц.) лалын сүсэгтний бүх хотыг нурааж эвдсэн, лалын хануудын бүх орон байшинг хөнтөрч хаясан, төрөл садантайгаа ярилцалгүйгээр Халифыг устгасан, нөхөд ба дайснаа ялгахдаа больсон билээ. Хэрэв мөнх тэнгэр тусалбал би түүнээс гэмгүй хүмүүсийн цусны өсийг авна” хэмээн тангараглаад Татарын төрлийн Ногайг 30000 цэргийн хамт Хүлэгийн эсрэг хөдөлгөв<sup>2</sup>. Хүлэг хаан ч мөн Ширэмүн хэмээх ноёноор удирдуулсан цэргийг эсрэг нь хөдөлгөж Ногайн цэргийг Дербент хүртэл цохин ухраасан боловч Хүлэгийн залгамжлагч Абагагийн удирдсан цэрэг Бэрхийн гол хүчинд цохигдон ухрах замд нь Терек голын мөс цөмөрч олон цэрэг нь живсний улмаас ялагдал хүлээснийг өмнө өгүүлсэн билээ. Ийнхүү хан хөвүүний удирдсан гол хүчний цэрэг нь бутцохигдсон тул Хүлэг хаан Тебризд буцжээ. Азербайджанд Хүлэгийн ирж төвхнөснийг Зүчийн гэр бүлийнхэн тэндхийн засгийн эрхийг хууль бусаар булаан авсан хэрэг хэмээн үзсэн<sup>3</sup>, Хүлэг Кавказын уулсын өмнөд нутгийг эзлэн авсанаас үүдэн Бэрх түүнтэй зөрчилдөх болсон<sup>4</sup> зэрэг нь энэ тулалдааны шалтгаан хэмээн судлаачид үзэж байна. Бидний үзэхээр энэ нь Бэрхийн хувьд нэгдүгээрт, эзэнт гүрний хан хөвүүдийн ахчлах ёсноос үүдэлтэй их хааны дараах байр суурины төлөөх далд өрсөлдөөн, хоёрдугаарт, Зүчийн удмынхны татвар татаж байсан Хойд Ираны нутаг дэвсгэрт Хүлэг ноёрхлоо тогтоосон, гуравдугаарт, Бэрх нь лалын шашныг өмгөөлөн хамгаалагчийн хувьд лалын ертөнцөд христийн шашны эрхийг хамгаалагч Хүлэгтэй зөрчилдөх нь зайлшгүй байсан, дөрөвдүгээрт, тус бүс нутгийн эдийн засаг, аж ахуйн ач холбогдол нь Алтан ордон улсын хувьд чухал байсан зэрэг шалтгааны улмаас Азербайджаны явдлаар шалтаглан далд сөргөлдөөн нь мөргөлдөөнд шилжсэн хэмээн үзэж байна.

Терек голын тулалдааны дараа жил буюу 1663 онд Ногай Дербент рүү дахин довтлохоор зэхэж байна гэсэн цуурхлыг шалгахгаар Хүлэг

<sup>1</sup> Рашид-ад-Дин. Судрын чуулган. II боть. Орос хэлнээс орчуулсан Ц.Сүрэнхорлоо. т. 90

<sup>2</sup> Рашид-ад-Дин. Судрын чуулган. III боть. Орос хэлнээс орчуулсан Ц.Сүрэнхорлоо. т. 55.

<sup>3</sup> Груссе Р. Чингис хааныхны монголчууд. Франц хэлнээс орчуулсан Л.Бат-Очир. УБ., 2004. т. 158

<sup>4</sup> Рювен Амитай-Прейсс. Монголчууд ба Мамлюкууд. Англи хэлнээс орчуулсан С.Оюунсүрэн. УБ., 2006. т. 78

хаан Тебризийн шейх Шерифийг Ногайн хүрээнд туршуулаар зарсанд тэрбээр Хүлэг хаанд хүчин туслахаар Хубилай хааны 30000 цэрэг ирж яваа гэх зэргээр Ногайг сүрдүүлсэн гэдэг<sup>1</sup>. Юутай ч энэ удаагийн тулалдаан Алтан Ордон улс, Эл хаадын улсын хооронд өрнөсөн Азербайджаны асуудлыг нэг тийш болгож чадаагүй юм.

Харин Абагыг хаан ширээнд суух хүртэл дахин том хэмжээний дайн байлдаан хоёр улсын хооронд үүссэнгүй. Энэ нь Хүлэг хаан өөрийн улсын дотоод байдлыг тохинуулахад гол анхаарлаа төвлөрүүлсэнтэй холбоотой. Тэгвэл Бэрхийн зүгээс 1261 онд Михаил Палеологийн Константинополд дахин байгуулсан Византи улстай харилцаагаа зузаатгах, улмаар тэдний хяналтанд буй Боспорын хоолойгоор дамжуулан мамлюкуудтай улс төр, эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэхэд гадаад бодлогын гол анхаарлаа төвлөрүүлэх болсонтой Эл хаант улс, Алтан ордон улсын түр хугацааны тайван байдлыг холбон тайлбарлах нь зүйтэй болов уу.

Гэтэл 1265 оны 2-р сард Хүлэг хаан Мерагу хотын хавьд таалал төгсөв. Хүлэгийн ахмад хөвүүн Абага мөн онд хаан ширээг залгамжилжээ. Энэ үеийг Бэрх хаан ашиглан 1265 онд Ногайн удирдсан цэргийг илгээсэн ч Абагагийн цэрэгт ялагдсан аж. Иймд Бэрх өөрийн биеэр цэрэг авч Дербентийг даван Кура гол хүрсэн боловч 1266 онд гэнэт нас баржээ. Үүний үр дүнд Абага хаан Кура голын хойд эргээс Курдаманы тал хүртэлх багахан нутгийг өөрийн болгож шуудуу татсан байна<sup>2</sup>.

Бэрхийн гэрээслэсэн ёсоор Бат ханы ач хүү Мөнхтөмөр Алтан Ордон улсын хаан ширээнд 1266 онд суув. Тэрээр Абага хаантай хэд хэдэн удаа тулалдсан боловч хоёр тал үр дүнд хүрсэнгүй. Рашид-ад-дины мэдээлснээр Абагагийн шахалтаар Мөнхтөмөр эвийн гэрээ байгуулж энэ нь 1288 оныг хүртэл үргэлжилсэн аж<sup>3</sup>. Гэвч энэхүү гэрээ нь Мөнхтөмөрийн хувьд цаг зуурын л үзэгдэл байсан учир Мисирийн Байбарстай Эл хаадын эсрэг холбоолох тухай асуудлаар байнга харилцсаар байв.

Харин 1288 онд Тогтоамышийн удирдсан цэрэг Эл хаант улсад Дербентийн чиглэлээр дайрсан боловч амжилт олоогүй байна. Ийнхүү Хүлэг, Бэрхийн үеэс эхэлсэн ширүүн өрсөлдөөн сунжран хоёр талд тодорхой ашиг хонжоо авчирсангүйгээр нам жим болов.

Алтан ордон улс нь Египедийн мамлюкуудын улстай сайн харилцаатай байж, гол нь Эл хаант улсын эсрэг холбоотон болж тэмцэх

<sup>1</sup> Рашид-ад-Дин. Судрын чуулган. III боть. Орос хэлнээс орчуулсан Ц.Сүрэнхорлоо. т. 57

<sup>2</sup> Мөн тэнд. т. 65

<sup>3</sup> Мөн тэнд. т. 91

зорилготой байв.

Алтан ордон улс, Египетийн Мамлюкийн улс нь улс төр, эдийн засгийн зузаан харьцаатай байсан бөгөөд Мамлюкийнхны хувьд өөрийн хамгийн аюултай өрсөлдөгч Эл хаант улсын эсрэг Алтан ордон улстай холбоотны харилцаа тогтооход чиглэгдэж байв. Харин Алтан ордон улсын хувьд Эл хаант улсаас маргаантай газар нутгаа булааж авах хүсэл эрмэлзлийн үндсэн дээр Мамлюктай холбоотон болох нь ашигтай байв. Ийнхүү Алтан ордон улс, Мамлюкийн улс нь холбоотны харилцаан дээр үндэслэн Эл хаант улстай сөргөлдөж байсан хэдий ч Эл хаант улсын эсрэг байгуулагдсан энэхүү холбоотнуудын ач холбогдлыг хэтрүүлэн үнэлж боломгүй бөгөөд газар нутгийн алслагдмал байдлаас шалтгаалан ялангуяа цэргийн салбарын хамтын ажиллагаа нь тийм ч хангалттай биш байсныг тэмдэглэх хэрэгтэй. Харин эдийн засгийн болон соёлын харилцаа нь чамгүй өндөр түвшинд хөгжиж байв. Гэвч Алтан ордон улс, Мамлюкийн харилцааны талаар Оросын эрдэмтэн Салих Закиров<sup>1</sup>, Монголын судлаач Ж.Бор<sup>2</sup> нарын судалгаанд дэлгэрэнгүйгээр авч үзсэн тул энд давтахаас зайлсхийв.

<sup>1</sup> Салих Закиров. Алтан Ордоны улсаас Египедтэй барьж байсан дипломат харилцаа. Орос хэлнээс орчуулсан С.Оюунсүрэн. УБ., 2004.

<sup>2</sup> Ж.Бор. Монголын хийгээд Евразийн дипломат шастир. Боть II. УБ., 2004.

## 6. МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН

Алтан Ордон улсын эдийн засаг, аж ахуйг судалсан нь харьцангуй бага бөгөөд өмнөх түүх бичлэгт ихэвчлэн сөрөг үнэлгээ давамгайлж байв.

Монголчууд эзлэн авсан газар орноо эвдлэн сүйтгэхээс өөр юу ч хийгээгүй, тэд хүн төрөлхтөнд сайн сайхан зүйл огт үлдээгээгүй мэтээр бичдэг байсан уламжлал нэгэнт үеэ өнгөрөөж, сүүлийн үеийн судалгаанд бодит хандлага буй болсноор асуудлыг хоёр талтай авч үзэх боломжийг нэмэгдүүлэв. Оросын эрдэмтэд монгол хаад эзлэн түрэмгийлсэн газар орноо, эвдэн сүйтгэсэн хот тосгоноо сэргээн босгох талаар анхаарч тодорхой арга хэмжээг авч, худалдаа, гар урлал хөгжүүлж түүнээсээ ашиг олоход анхаарч ирснийг баримтаар нотлон бичих боллоо. Монгол хаадаас хэрэгжүүлж байсан бодлого, түүхэн сурвалж хэрэглэгдэхүүний мэдээ баримт болон археологийн малтлагаар олдож буй эд өлгийн зүйлс ч тухайн цаг үед аж ахуй, эдийн засаг хөгжиж байсныг нотолж байна.

Нийгэм эдийн засгийн хөгжлөөр харилцан адилгүй нүүдэл, суурьшмал ард түмнүүдийг Монгол хаад нэгтгэн Алтан ордон улсыг байгуулан нэгэн төрийн жолоонд захирахад түмэн бэрхшээл учирсан нь мэдээж.

Хөдөөгийн хүн амын хэрэгцээг хотууд хангаж чадахаа больсон төдийгүй хөдөөгийн аж ахуйтнууд нь хотын хүнсний хэрэгцээг хангахад бэрхшээлтэй болсон байв.

Тиймээс юуны өмнө дайнд сүйдсэн аж ахуйг богино хугацаанд сэргээн хэвийн голдиролд нь оруулахын тулд тухайн газар орны онцлогт тохирсон төрийн зөв бодлого боловсруулах явдал чухал байв. Тийм бодлогыг боловсруулахад монгол төрийн мэргэн сайд түшмэдээс гадна нутаг нутгийн эрх баригчдын хүчийг ашиглахад эдийн засгийн урамшуулал ч хэрэгтэй байв.

Монголчуудын дайнд Оросын гар урлал аж үйлдвэр илүүтэй өртжээ. Тэд хөдөө аж ахуйг төдийлөн хөндөөгүйн учир нь тэд үр тариаг нь хүнс болон малын тэжээлдээ хэрэглэдэгтэй холбоотой. Цэргийн болон засаг захиргааны хэрэгцээнд зориулан улаан буудай, овъёос тарихыг Өмнөд Оросоос шаардаж байсан мэдээ бий. Орос бол

монголчуудад татвар төлдгөөрөө үнэтэй байсан ба татвар төлөгчдийн гол цөм нь тариачид байсан учраас хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэмжээг бууруулах сонирхол монголчуудад байгаагүй юм. Тиймээс Бат хаан өөрийн улсын бүрэлдэхүүнд багтаж буй ард түмний эрхэлдэг аж ахуйн онцлогийг харгалзсан төрийн уян хатан бодлого хэрэгжүүлснээр тус улсын нийгэм эдийн засгийн үндэс, бааз суурийг богино хугацааны дотор сэргээн цаашид хөгжих нөхцлийг бүрдүүлж чаджээ. Эдийн засаг, санхүүгийн хүчин чадал өндөртэй улс л төрийн хүчирхэг, далайцтай бодлого явуулдаг учир монгол хаад богино хугацаанд зохих арга хэмжээг авч чадсанаараа байдал аажмаар сайжирч эхлэв.

Алтан ордон улсын аж ахуй нь эзлэгдсэн орнуудын байгаль цаг уур, ард түмний эрхлэж буй аж ахуйн онцлогоос хамаарч мал аж ахуй, газар тариалан, загас, ан агнуур, зөгий үржүүлэх зэрэг баялаг олон төрөлтэй байжээ.

Алтан ордон улсын эрх баригчдад бусад хувь улсуудад тохиолдсон шиг бэрхшээл учирсангүй. Учир юун гэвэл Цагадай болон Юань улсад нүүдэллэн очсон язгууртан эрх баригчид уугуул нутгийн иргэдийн эрхлэж буй аж ахуйн хэв маягийг өөрчлөх хүртэл маргаан өрнөж газар тариалангийн талбайг малын бэлчээр болгох санал ч гарч байсан бол Алтан ордныхны эзлэн авч төвлөн суусан Кибчагийн уудам тал нутаг нь мал аж ахуй эрхлэхэд маш тохиромжтой нутаг байсан юм. Тиймээс ч Алтан ордны эрх баригчид болон тус нутагт нүүдэллэн очсон монголчууд нүүдэл амьдралаа удаан хугацааны туршид хадгалж чадсан юм.

Монголын ямар овог, аймаг Алтан ордон улсад нүүдэллэн очсон тухай тодорхой мэдээ үгүй ч гадаадын элч жуулчдын тэмдэглэлд моал, татар нэрээр олон монголчууд байсан тухай бичсэн байдаг. Рашид-ад-Дины тэмдэглэснээр, Батад харьяалуулсан 4000 монголчуудыг эс тооцвол, түүний цэргийн бусад бүрэлдэхүүн нь кипчак, булгар, огуз зэрэг түрэг угсааныхан байжээ<sup>1</sup>. Тэдгээр монголчууд нь Зүчи болон түүний үе залгамжлагчид, үр хүүхдүүд, харьяат иргэн, дайтан очсон цэргийнхэн, арын албыг залгуулж асан хүмүүсээс бүрдэж байсан нь ойлгомжтой.

Тэгэхдээ монголчууд олон зууны турш уламжлан ирсэн мал аж ахуй эрхлэх сонгодог арга ажиллагааг нутгийн иргэдэд хүргэж очсон төдийгүй нутгийн уугуул нүүдэлчдийн мал аж ахуй эрхлэх аргын ололтуудыг ч өвлөн авчээ.

Японы эрдэмтэн Исоно Фүжико: Нүүдэлчдийн хүрээ нь үйлдвэрлэлийн нэгж биш, хэрэглээний нэгж байсан гэсэн сонирхолтой

<sup>1</sup> Рашид-ад-Дин. Судрын чуулган. Боть II. УБ., 2002.

дүгнэлт хийжээ. Тэгэхдээ Бат хааны хүрээгээр жишээ авсан байна. Бат хааны хүрээ нутагладаг газрын эргэн тойронд нэг өдрийн газарт 30 хүн байрлаж, хааны хэрэгцээний айргийг нийлүүлэхийн тулд хүн бүр гүү сааж, өдөр бүр айргаа хүргэдэг байжээ<sup>1</sup> гэсэн байна. Дээрх эрдэмтэн суурин газрын хүн учраас мал аж ахуйн онцлогийг гүйцэд таньж мэдэхэд бэрхшээлтэй байсны дээр хэрэглээг нь илүүтэй харсан бололтой. Хэдийгээр хааны хэрэгцээг хангах нь тэргүүн эгнээнд тавигдаж байгаа боловч түүнийг нь гүйцэтгэхийн тулд хаадын уудаг хар сүүг нарийн технологээр хийж буй үйлдвэрлэл давхар явагдаж байгаа юм.

Тухайн үеийн аж ахуйн зонхилох хувийг мал аж ахуй эзлэж байв. Эзлэгдсэн орны түүх сударч нар мөн тус нутгаар дайран өнгөрсөн албаны элч төлөөлөгчдийн тэмдэглэлд мал аж ахуйн тухай өгүүлсэн нь цөөнгүй төдийгүй малын тоо толгой олон байсан нь харийнхны анхаарлыг зүй ёсоор татаж энд тэндгүй багшран байх малын талаар олон хүн онцлон тэмдэглэжээ. Тэдгээр мэдээллээс тухайн үеийн мал аж ахуйн хөгжлийг төсөөлж болно.

Монголчууд тэр үеийн зонхилох соёлуудын үр шимийг хүртэж, тэдний эд барааг эдэлж хэрэглэж сурсан ч төрлөх ард түмнийхээ дадал заншлыг хадгалж, өвөг дээдэс нь ямар байв тэр л нүүдэлчдийн толгойлогчид хэвээр үлджээ. Арал тэнгисээс Карпатын уулс хүртлэх өргөн уудам нутагт адуу мал тавтай идээшилж, айл аймаг нь тоо томшгүй мал сүрэгтэйгээ хөндлөн гулд нүүдэллэн амьдарч байлаа<sup>2</sup>.

Гийом де Рубрук “Би бас үй олон үхэр, хонь, адуун сүрэг хараад ихэд бишрэн гайхав. Харин түүнийг малласан хүн тун цөөн харагдав<sup>3</sup> гэсэн бол Алтан ордон улсыг зорин ирсэн египетийн султаны элч нар Крымээс Бэрхийн өргөө хүрэх замд “чачир майхан хонь, адуун сүргээр дүүрсэн тал нутгаар 20 өдөр аялсан тухайгаа тэмдэглэсэн байдаг. Гэр байшингууд\* египедийн элч нарын гайхлыг төрүүлж байжээ<sup>4</sup>.

Хот суурин үгүй атлаа мал сүргээр дүүрэн уудам тал, бэлчээр нутаг нэг газраас нөгөөд хялбархан зөөж босгох ярайсан олон майхан, тэргэн дээрхи өвөрмөц маягийн сууцууд байсан тухай тэдгээр элч нар тэмдэглэлдээ олонтой дурджээ. Ийнхүү аялан яваа хүмүүсийн анхаарлыг татахаар олон мал сүрэг багширч байсан нь мал аж ахуйн хөгжил ямар байсныг гэрчилнэ. Дээрхи мэдээллүүдэд тэмээний тухай дурдаагүй ч таван хошуу мал байсан нь ойлгогдож байна. Учир

<sup>1</sup> Исоно Фүжико. Хүрээг дахин нягтлах нь. «Монгору кэнкю». №19. Ард шөтэн. Оосака.

<sup>2</sup> Михаэл Правдин. Чингис хаан түүний өв. УБ., 2005. т. 271

<sup>3</sup> Мөн тэнд. т. 119

\* Гэг тэрэг

<sup>4</sup> Салих Захиров. Алтан Ордны улсаас Египедтэй барьж байсан дипломат харилцаа. УБ., 2004. т. 45

юун гэвэл, тэмээн сүргийг тусгайлан хариулж худалдаа, аян жин тээх тээврийн гол хэрэгсэл болгож байснаас адуу, тэмээний арилжааны өртөг өндөр байжээ.

Монголчууд таван хошуу малаас адуу, үхрийг мөн онцгой анхааран тоо толгойг нь нэмэгдүүлэхийг анхаарч байсан нь аж ахуйн зориулалттай нь холбоотой юм. Адуу, үхэр нь газар тариаланд зүтгэх хүч болохын зэрэгцээ мөн уналга хөсөгт өргөн ашиглагдаж байв. Оросын түүхчид ван ноёд, ялангуяа Москвагийн их вангууд малыг, түүний дотор агт морьдоо арчлан өсгөхийг хичээж байсан тухай тэмдэглэсэн нь буй. Их вангийн засаг захиргааны нэг чухал түшмэл нь агтач буюу агтны даамал байжээ. Москвагийн их вангуудын гэрээслэлүүдэд азарга, гүү, унаа морьдын талаар цөөнгүй дурдагдсан байдаг<sup>1</sup> гэдэг нь адуун сүргийн цэрэг стратегийн ач холбогдлыг нь илүүтэй анхаарч үхэр болон бусад малын аж ахуйн ач холбогдлыг нь дутуу үнэлсэн нь суурин орны түүхчийн үзэл бодол болов уу. Оросын тариачдын эдийн засгийн чадамжаас хамаарч үхэр, адууг аж ахуйдаа хэрэглэх нь хязгаарлагдмал байж харин цөөн тооны язгууртан баян чинээлэг хүмүүс адуу, үхрийг голлон үржүүлж байснаас тийнхүү дүгнэхэд хүрсэн байж ч болох юм. Адуу, үхэр нь газар тариаланд зүтгэх хүч болохоос гадна цэргийн болон хүнсний чухал хэрэглээ байсан нь мэдээж.

Монголчууд Дунай мөрөн, Днепр, Дон, Ижил, Урал мөрний савыг хамарсан уудам тал нутгийг уугуул нутгийн малчидтай хуваан эзэмшиж байв. Уг тал нутаг нь гол мөрний сав газар тул ус ургамал нь жигдэрсэн малын маш тохиромжтой бэлчээр байжээ. Монгол уламжлалаараа малын бэлчээрийг нарийн хуваарилаж улирлын байдалд зохицуулан ашиглаж байсан нь түүх сударт тэмдэглэгдэн үлджээ. Монголчуудын отгийн дарга бүр захирсан отгийнхоо хүн амын олон цөөнийг харгалзан бэлчээр нутгаа хувиарлан өгдөг ба тэд өвөл, зун, хавар, намар мал сүргээ хаана бэлчээрлүүлэх ёстой болон нутгийнхаа хил хязгаарыг, сайн мэддэг байжээ. Тэд малаа адуулан 8 дугаар сараас сэрүү ормогц аажмаар уруудан нүүдэллэсээр өвөл нь арай дулаан цаг агаартай өмнө зүгийн нутаг тэнгист хүрч очдог ба нэгдүгээр сараас 8 дугаар сар хүртэл аажмаар голоо өгсөн явсаар зунд нь сэрүүвтэр цаг ууртай умар зүг очиж нутагладаг байв. Тэд өвөлдөө бэлчээрийн сайныг дагаж цастай газраар нутагладаг байсан ба цасаар ундаа хийдэг байсан нь уугуул нутагтаа байсантай адил байжээ.

Бүри нэгэн удаа согтуу байхдаа “Би Бат шиг Чингис хааны удмын хүн бишсэн билүү? Яагаад би Бат шиг Этил (Ижил – С.Ц.) мөрний эрэгт

<sup>1</sup> Г.В.Вернадский. Чингисийн үеийн монголчууд ба Орос улс. УБ., 2004. т. 39

мал сүргээ хариулж болдоггүй билээ” гэж хэлэн, Мөнх хааны үед дахин агсам тавьж Бат, Мөнх хоёрыг заналхийлсний улмаас цаазаар авагджээ<sup>1</sup> гэж тэмдэглэсэн байдаг. Аль ч үед үржил шимтэй малын сайн бэлчээр чухал байж түүний төлөө тэмцэл байнга өрнөж байсан нь үүнээс ч тодорхой харагдана. Гэхдээ Бүрийг бэлчээрийн төлөө бус улс төрийн шалтгаанаар цаазалсан нь ойлгомжтой. В.Рубрукийн тэмдэглэлд малын бэлчээрийг усжуулж байсан чухал мэдээ бий. “Мөнөөх их уулсын нэгэн салбар уулыг давж, өрнө этгээдээс өндөр уулсаар хүрээлэгдсэн, дорно этгээдээ эргэн тойрон 25 өдөрчийн газар явж ямар нэгэн тэнгис буюу нууртай сайхан хөндийд орж ирэв. Уулаас эх аван мөнөөх нуурт цутгах хамаг голын усаар энэ хөндийг сайхан усжуулжээ... Дээрх хөндийд урьд цагт олон хот суурин байсан боловч хамгийн сайхан бэлчээр бүхий газар тул татарууд тэнд мал сүргээ хариулах гэж түүний ихэнхийг эвдлэн сүйтгэжээ<sup>2</sup> гэжээ.

Монголд ч мөн бэлчээрийг усжуулах ажил өргөн далайцтай хийгдэж байв. Өгэдэй хааны хийж гүйцэтгэсэн 4 их үйлсийн дотор бэлчээрийг усжуулсан тухай дурдсан байдаг нь уг ажил төрийн бодлогын хэмжээнд байсныг харуулна. Алтан ордон улсын хувьд зөвхөн бэлчээрийг төдийгүй газар тариаланг усжуулах, хотод хиймэл нуур, цөөрөм байгуулах ажлыг маш зохион байгуулалттай хийж үүнд өндөр ач холбогдол өгч байв. Татарууд мал сүргээ хариулах гэж тэнд байсан хотуудын ихэнхийг эвдлэн сүйтгэсэн тухай дээр өгүүлсэн нь илтэд ташаа дүгнэлт юм.

Тухайн үеийн хот суурин хэмээх нь өнөөгийнх шиг хүн ам шигүү суусан хотуудын адил бус байсныг бас бодолцох хэрэгтэй. Монголын байлдан дагууллаас зугтсан тариачид монголчуудын хүрээгүй умар зүгт очиж байв. Тиймээс Владимирийн вант улс Костром, Галич хотын хүн ам эрс нэмэгдэв хэмээн Ренэ Груссе тэмдэглэсэн байдаг<sup>3</sup>. Магадгүй монголчуудын дайны сүр дуулианаас дайжсан нэг хэсэг байхад цэргийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлт зэрэг аргаар бэлчээрт тохиромжтой нутгийг зориуд чөлөөлсөн байхыг нь ч үгүйсгэхгүй юм. Алтан ордон улс нь Монголын эзэнт гүрэн дотроо газар нутаг, хүн амаар Юаны дараа орж байсныг өмнө дурдсан билээ. Мал аж ахуйн зэрэгцээ газар тариаланг ч мөн эрхэлж байв. Кибчагийн тал нутагт мал аж ахуйг зонхилон эрхэлж байсан бол Орос болон Крым, дундад азийн гол мөрний сав газруудаар газар тариаланг голчлон эрхэлж байсан нь жуулчдын тэмдэглэл, тэднээс авч байсан алба татвар, археологийн малтлагаар олдсон шавар сав

<sup>1</sup> Д.Цахилгаан. Бат хаан. УБ., 2003. т. 71-72

<sup>2</sup> Гийом де Рубрук Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988. т. 145

<sup>3</sup> Г.В.Вернадский. Чингисийн үеийн монголчууд ба Орос улс УБ., 2004. т. 38

суулга, үр тарианы үлдцүүд үүнийг гэрчилж байна.

Тариачдыг “сабанчи” буюу модон анжистан гэж нэрлэх ба тэднийг газар болон эд хөрөнгөөр хангагчдыг “уртакчи” (уртак - тэн хагас тэг дундуур нь) гэж нэрлэж байв. Энэ хоёр давхарга Алтан ордон улсын хүн амыг талх, үр тариагаар хангахад гол үүрэг гүйцэтгэж байв. Булгар ба Мордаваас ирэх тариа, будааг хамгийн дөт зам болох Ижил мөрнөөр тээвэрлэж Алтан ордон улсын монголчуудад хүрч ирдэг байв. Нутгийн уугуул иргэд уламжлалт газар тариалангаа эрхлэж улаан буудай, арвай, овъёос, вандуй, шар будаа зэрэг 20 гаруй төрлийн ургамал, тариа тарьж байв. Мөн зөгий үржүүлэх ажил нэлээд дэлгэрлийг олж хүнсэндээ зөгийн бал өргөн хэрэглэж байсан мэдээ бий. Алтан ордноос татсан цэргийг Умард орост байлдуулахаар илгээхэд Булгараас ирсэн цэргүүд хамгийн өлчир байсныг Оросын он дарааллын бичигт онцлон дурдаад, учир нь тэд хүнсэндээ зөгийн бал их хэрэглэдэг учир даарахыг мэддэггүй гэжээ. Хэдийгээр тариалангийн газрын зарим хэсэг нь дайны хөлд сүйдсэн ч аж ахуйг нь маш хурдан сэргээх боломжтой байсан бололтой. Учир нь үр тариа, жимс жимсгэнэ, гурил будаагаар хангах ажил төдий л дутагдсан тухай тэмдэглэсэн зүйл хараахан үгүйн дээр худалдааны захууд дээр газар тариалангийн бүтээгдэхүүний худалдаа нэлээд хөлтэй байжээ. Дайнд сүйдсэн аж ахуйг сэргээх хугацаанд хүнсний нэлээд хэсгийг нь холоос тээвэрлэн авчирч хангалт хийж байсан нь ойлгомжтой.

Алтан ордон улсын газар тариалангийн ажлыг хэрхэн зохион байгуулдаг байсныг Иософат Барбаро тэмдэглэн үлдээжээ. Түүний өгүүлэхээр, хоёрдугаар сарын сүүлчээр Ордны бүх нутгаар зар тарааж гурван сарын төдөнд тариалалтанд гарах тул тариалалтад оролцох хүмүүс бүх зүйлээ бэлтгэн тийм газар очоорой хэмээн нийтэд чанга дуугаар зар тараадаг. Тийн тариа тарих хүмүүс хэрэгтэй зүйлээ бэлдэж газар хагалах ажлын малаа аван, эхнэр хүүхдээ тэргэнд суулган зарласан өдөр товлосон газар очиж тариалалт хийдэг. Тариалалтаа дуусгаад хэсэг хэсгээрээ нийлж найр наадам хийн амарч цэнгэдэг уламжлалтай байв. Намар ургац хураах болоход тариа тарьсан хүн ургац худалдан авах хүнтэйгээ хамт очин газар дээрээ наймаа хийдэг уламжлалтай байсан ажээ<sup>1</sup>. Улс орны эдийн засгийн орлогын нэлээд хувийг тариалан бүрдүүлэхийн зэрэгцээ засаг захиргаа, цэргийн хүнсний хангалтад чухал үүрэгтэй байв. Тэр үед газар боловсруулахдаа 3 төрлийн анжис хэрэглэж байв. Энэ нь хүнд буюу төмөр анжис, төмөр хошуутай модон анжис, хөнгөн модон анжис. Хүнд анжисыг 3 морь чирэх ба маш ховор

<sup>1</sup> С.Лочин. Алтан Ордны хаад. УБ., 2000. т. 108

хэрэглэдэг, харин ганц морь хөллөдөг модон анжисыг умар зүгийн ойн бүсүүдэд хамгийн өргөн ашиглаж байжээ. Газар тариаланд төмөр анжис өргөн хэрэглэснээр хөдөлмөрийн бүтээмж хүнсний хангалт нэмэгдсэн гэж хэлж болно.

Оросын алба гувчуурын ихэнхийг чухамхүү хөдөөгийн оршин суугчид л төлж байсан болохоор монголчууд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бууруулах сонирхолгүй байсан хэмээн Г.В.Вернадский тэмдэглэсэн буй. Монголын төрөөс удаан хугацаанд оршин тогтнож, ахиу алба татвар авахын тулд эрхшээлдээ оруулсан улс орны эдийн засгийг богино хугацаанд сэргээх, элдэв хөнгөлөлт үзүүлэх замаар аж ахуй эрхлэх боломжийг нь нэмэгдүүлэх бодлого барьж байжээ. Түүнээс бус зөвхөн алж хядах, утга учиргүй боолчлох нь монголчуудын эцсийн зорилго бус байсан юм. Эзэнгүй баялаг нутаг, эд баялгийн үйлдвэрлэлгүй бол монголын ноёрхол учир утгагүй нь ойлгомжтой. Баян тансаг сайхан амьдрахын тулд тухайн улс орны ард түмэнд аж ахуй эрхлэх өргөн боломж олгож, тэр чинээгээрээ татвар авахад монголчуудын ноёрхлын гол зорилго, утга учир оршиж байв.

Мөнхтөмөр хаан сүм хийдүүдийг алба татвараас чөлөөлсөн ярлык-жуух олгосон<sup>1</sup> нь сүм хийдүүдийн тариачдад аж ахуйгаа чөлөөтэй эрхлэх боломж өгч тэр нь сүм хийдүүд баяжин хүчирхэгжих чухал хөрс суурь болов.

Загасны аж ахуй хүнсний хангалтад чухал үүрэгтэй төдийгүй ашиг орлогын эх үүсвэр байсан байна. Монголчууд ан агнуур, загасны аж ахуйд саад хориг тавиагүй бөгөөд тэдгээр нь монголчуудад их хэмжээний татвар орлогын үндэс болсон гэж Оросын түүхчид бичиж байна.

Мөн монголчууд Кибчагийн талд очсон хойноо ч уламжлалт загасны аж ахуйг эрхэлсэн хэвээр байв. Монголчууд нутагтаа загасны аж ахуйг эрхэлж байсныг сурвалж бичгийн мэдээ, археологийн олдворууд гэрчилдэг юм. Монгол нутгийн томоохон гол мөрний хөндийгөөс нэвт нүхэлсэн буюу тойруулан ховил гаргасан загасны торны ачаа, загас агнах ясан жад зэрэг олдворууд олддог нь нүүдэлчид загасыг хүнсэндээ хэрэглэж байсныг харуулж байна<sup>2</sup>. Загасыг худалдааны ашиг олох зорилгоор барихаас гадна тус улсын хүнсний хангалтын чухал эх булаг байсныг жуулчид тэмдэглэжээ. Днепр, Дон, Ижил зэрэг мөрнүүд загасаар үлэмж элбэг ажээ<sup>3</sup>. Худалдааны том том

<sup>1</sup> А.П.Григорьев. Сборник ханских ярлыков русским митрополитом. СПб., 2004

<sup>2</sup> Ч.Ерөөл-Эрдэнэ, Г.Рэгзэн. Загас агнуурын холбогдолтой нэгэн олдворын тухай. // Археологийн судлал. УБ., 2000. т. 28-33

<sup>3</sup> Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988. т. 63

зах зээлүүд дээр ялангуяа өрнө зүгийн Солдайя зэрэг хотын зах дээр давсалж хатаасан загас их гүйлгээтэй байсан тухай мэдээ бий. Далайн загаснаас илүүтэйгээр гол мөрний давслан хатаасан загас, тэр дундаа хулд, мөрөг зэрэг загас өрнийн орнуудад ихээхэн эрэлт хэрэгцээтэй байсныг тэмдэглэжээ. Хатаасан загасыг ялангуяа шар айргийн эх орон болох Бохеми, Генуя, Венец, Польш, Герман зэрэг орнууд илүүтэй авч байсан бололтой. Худалдаанаас олсон орлогоороо нэхмэлийн техник хэрэгсэл, цэмбэ зэрэг өргөн хэрэглээний зүйлсээ авдаг байжээ.

Тухайн үед давс олзворлох, боловсруулах нь ашигтай бөгөөд орлого ихтэй аж ахуйн салбар байв.

Кибчагийн тал нутгийн умраар орших том нуурууд нь давс ихтэй. Учир нь нуурт цутгасан гол горхины ус нууранд ормогц мөс мэт хатуу давс болж түүнээс нь давс олборлон боловсруулж худалдаачид ашиг олж байсан тухай сонирхолтой мэдээ бий.

Бат хаан Сартах нар давсны худалдаанаас их орлого олдог байжээ. Оросын худалдаачид тэндээс давс их худалдаж авдаг байсан ба нэг тэрэг давсанд хагас иперперийн<sup>1</sup> үнэ бүхий хоёр боодол хөвөн бөс, цаасан нэхмэл өгдөг байжээ. Бас давс авах хөлөг онгоцнууд ч тэнгисээр их ирдэг байсан ба тэд ачсан давсныхаа хэмжээгээр гааль төлдөг байв.<sup>2</sup>

Тухайлбал, "...Нэг тэнгисээс нөгөө тэнгисийг холбосон татаалаар хиллэсэн мужийн хязгаарт хүрч түүнийг давахад тэндэхийн давст нуураас давс аваад буцаж байгаа хүмүүсээс гааль авч байхаар нутаг заагдсан, харваас уяман өвчтэй мэт доорд үзэгдсэн хүмүүсийн сууринд хүрч ирэв"<sup>3</sup> хэмээн В.Рубрук тэмдэглэсэн нь бий. Үүнээс үзэхэд давсны гааль хураах зориулалтаар тосгон суурингуудыг байгуулсан нь давсны эрэлт хэрэгцээ их байж хүнсний худалдаа арилжааны өргөн хэрэглээний чухал бараа байсан нь үүнээс харагдна. Дундад зууны үед онцгой худалдаанд давс, төмөр орж байсан тухай өөр бусад орны түүх сурвалжуудад ч цохон тэмдэглэсэн нь буй.

Монголчууд хэдийгээр харийн нутагт очсон ч өөрсдийн амьдралын хэв маяг, аж ахуйгаа хэвээр хадгалахыг чармайж байсан юм.

Ан агнуур монголчууд болон уугуул нутгийн иргэдийн амьдралд чухал үүрэгтэй байв. Ан ав нь хоол хүнсээ бэлтгэхээс гадна армийн шинэ залуу үеийг сургах цэргийн сургууль болдог байв. Худалдааны чухал эд болох үнэт үслэг, гоёл чимэглэл, эмчилгээний түүхий эд

<sup>1</sup> Иперпери гэдэг нь мөнгөний нэгж. Судлаачид Иперпери гэдэг нь бизанци гэж дорно дахины алтан зоостой адил. Ханш нь тогтворгүй. В.В.Бартольд Марко Пологийн номд бичсэн тайлбартаа бизан гэдэг нь Юпя, Марко Поло нарын үзэж байгаагаар арабын динар бололтой гэжээ.

<sup>2</sup> Гийом де Рубрук Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988. т. 104

<sup>3</sup> Мөн тэнд. т. 122

авах, мөн дээдэс язгууртнууд зугаагаа гаргах зорилгоор ан хийж байв. Шувуучилж байсан мэдээ түүх сурвалжид цөөнгүй бий. Анч шувууд харцага, шонхор, голлон хэрэглэж байсан мэдээ бий. Монголчууд эрт үеэс нохой, шувууг анд хэрэглэж байсан тухай Монголын нууц товчоо зэрэг сурвалж бичиг, гадны элч жуулчдын тэмдэглэлд олонтой дурдсанаас гадна монгол хаад нохой, шувуугаар ав хомрого хийж буйг хятад, персийн миниатюр зургууд дээр тодорхой дүрсэлсэн нь бий. Шонхор шувуудыг Монгол хаадаас Мисирин хаанд дипломат бэлгийн эд зүйлсийн хамт бэлэглэж байв.

Харцага, шонхор, бүргэд зэрэг өдрийн махчин шувууны язгуурт багтах, хурдан шаламгай хөдөлгөөнтэй, хурц хараатай, задгай газар өндөрлөг дээрээс харж идшээ хайдаг онцлогтой, хүчирхэг шаламгай шувуудыг тэжээн дасгаж, ан гөрөөс барихад сурган ашиглаж байв. Чингэхдээ, тэдгээр шувуудын байгалаас заяасан онцгой шинж, хүч чадалд нь тохируулан тухайлбал, бүргэдээр үнэг, чоно, хярс, туулай зэрэг хөхтөн амьтдыг бариулдаг бол харцага шонхроор голдуу хур, сойр, нугас, галуу мэтийн жигүүртэн шувуудыг авлаж ахуй амьдралдаа өргөн хэрэглэсээр иржээ<sup>1</sup>. Шонхор шувууд төрөлхийн анч, хэнээс ч, юунаас ч зүрхшээдэггүй, аймшиггүй зоригтой бөгөөд өөрөөсөө хэд дахин хүнд олзыг дийлэх чадвартай<sup>2</sup>. Тухайлбал анд сайн сургасан идлэг шонхор хар сүүлт зээрийг хүртэл барьж чаддаг хэмээнэ<sup>3</sup>.

Нохой бол нүүдэлчдийн амьдралд чухал үүрэгтэй байсан бөгөөд өнөө ч аж ахуйн ач холбогдлоо алдаагүй байсаар байна. Анч сайн нохдыг зориуд сурган ан хийлгэхээс гадна хоточ ноход мал хариулах, өртөө улаанд хэрэглэх зэргээр өргөн ашиглаж байв. Монголчууд шувуучлахдаа сурамгай бөгөөд шувууны хүзүүнд, цээжин биеийн дунд хирд суран оосор зүүж баруун гар дээрээ суулган явах ба анд тавихдаа өндөр хөөргөхгүйн тулд зүүн гараараа оосроос нь чангаан анд чиглүүлнэ. Тийнхүү тэд хоол хүнснийхээ ихэнхийг ан хийж олж авна<sup>4</sup> гэх буюу Батын нэгэн хөвүүн олон шонхортой байсан төдийгүй шонхор сургагч нартай байсан мэдээ бий.

Ан агнуураар хоол хүнснээс гадна худалдаа арилжааны болон хаад язгууртнуудын хувцас өмсгөл, зүүсгэлийн гол хэрэглээ болох үнэт үслэгийн зүйлс, хүдрийн заар, баавгайн доньд, үе мөчний өвчнийг анагаах эмчилгээний түүхий эдийг олж авч байв.

<sup>1</sup> У.Эрдэнэбат. Монголчуудын «шувуулахуй» агнуурын уламжлалын асуудалд. //Түүхийн судлал. Т. XXXII. Fasc. 13. т. 149

<sup>2</sup> В.Г.Бабенко, А.А.Кузнецов. Птицы Красной книги СССР. М., 1986. стр. 72

<sup>3</sup> У.Эрдэнэбат. Монголчуудын «шувуулахуй» агнуурын уламжлалын асуудалд. //Түүхийн судлал. Т. XXXII. Fasc.13. т. 150

<sup>4</sup> Гийом де Рубрук Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988. т. 113

Байгалийн баялаг ашигт малтмал олзворлох анхны оролдлогууд хийгдэж байжээ. "...би Мөнх хааны ордонд очтолоо юу ч олж мэдэж чадсангүй. Харин Мөнх хаан өөрөө тэднийг Батын соёрхлоор Талас хотоос дорно зүг сарын газар Болат хэмээх нэгэн хотод татан авчирсныг олж мэдэв. Тэд, тэр газар алт малтах, зэвсэг үйлдэх зэргийг хийж буй аж гэж" В.Рубрук тэмдэглэсэн нь монголчууд алт болон байгалийн ашигт малтмалыг олзворлохдоо олзны хүмүүсийг ашиглаж байсныг гэрчилж байна.

Алтан ордон улсын нийслэл болон бусад хотуудын туурийг малтсан малтлагаар хаад язгууртнуудын эдлэж хэрэглэж байсан эд зүйлс, хувцас хунар, морины тоног хэрэгсэл, илд, дуулга мэт цэргийн зэвсэг, хатдын гоёл чимэглэл алт, алтадсан зүйлс үлэмж олдсон үзвэл, бас алба татвараар хураасан болон байгалаас олзворлосон алт, эрднийн чулуугаар эдлэл хэрэглэл хийж байсан нь ойлгомжтой.

Мөн төмөрлөг боловсруулах талаар монголчууд маш их дадлага туршлагатай байсан ба тэдний хуягийг хэр баргийн сум нэвтлэж чадахгүй, тиймээс тэдний төмөрлөг боловсруулалтын арга технологийг сайтар судлан мэдэхийг Плано Карпини анхааруулан тэмдэглэж байв.

Тухайн үед Алтан ордны монголчууд төмрийн хүдэр боловсруулахад ихээхэн анхаарч энэ ажлыг багагүй хэмжээнд эрхлэж байсныг оросын түүхчид тэмдэглэжээ. Тэгэхдээ тэр үеийн үндсэн арга болох зөвхөн газрын гадаргуу дээрх төмрийн хүдрийг олборлох явдал давамгайлж байв<sup>1</sup>.

Аж ахуй, эдийн засгийг богино хугацаанд эрчимтэй сэргээн, хөгжүүлэх Монгол төрийн зөв бодлогын үрээр эдийн засаг, худалдааны өсөлттэй уялдан хэн юу чадахаа хийж амьдрал ахуйгаа залгуулах, амьдралаа дээшлүүлэхийн төлөө зүтгэх болсноор аж ахуй нэлээд сэргэн хөгжиж ирэв. Гэвч энэ өсөлт хөгжилтөд саад болох зүйл мундсангүй. Эхний үед алба татвар хураагч баскакууд үнэнч шударга ажиллаж алба татварын хэмжээ ч аж ахуй хөгжүүлэхэд дарамт учруулахгүй боломжийн байжээ. Энэ тухай алба татварын хэсэгт дэлгэрэнгүй өгүүлсэн учир давталгүй орхиё. Аажмаар татвар хураагчид хээл хахуульд автаж мусульмануудтай хуйвалдах болсон хийгээд цаг бусын гувчуур татвар авах, татварын хэмжээг нэмэгдүүлэх болсон нь аж ахуйн хөгжилд саад учруулах болов. Түүний дээр алтан ургийн ноёд эрх мэдэл, хаан ширээний төлөө хоорондоо дайтах болсон нь ч бодит бэрхшээл учруулсан нь дамжиггүй.

Ийнхүү Алтан ордон улсын эрх баригч хаад нийгмийн хөгжил, зан

<sup>1</sup> Г.В.Вернадский. Чингисийн үеийн монголчууд ба Орос улс. УБ., 2004. т. 38

заншлаар харилцан адилгүй олон угсаатныг нэгэн төрийн жолоонд зангидан барьж нийгмийн үйлдвэрлэл явуулах таатай боломж олгосноор тухайн үед аж ахуй, эдийн засгийн хөгжилд ахиц гарч Алтан ордны улсын хэвлийд хожмын хүчирхэг улсууд бүрэлдэн буй болсон юм.

Монголчууд тархай бутархай байсан тэдгээр улсуудад төрийн нэгдсэн удирдлага, бодлогоор аж ахуй эдийн засгийг хөтлөн явуулж болдогийн сонгодог жишгийг мэдүүлж өгсөн юм. Алтан Ордны дараа байгуулагдсан Оросын, Крымийн, Казаны хаант улсууд нь Монгол төрийн аж ахуй хөтлөлтийн сонгодог загварыг тэр чигээр нь хуулбарлан авч цаашид хөгжүүлсэн юм.

## 7. ӨРТӨӨ ЗАМ

Улс орны хөгжлийн гол гогцооны нэг нь зам харилцаа билээ. Кибчагийн удам тал нутагт хөндлөн гулд сүлжсэн усан болон хуурай замууд нь өрнө, дорныг холбож байв.

Өрнө зүг Батын их цэрэг дайтах зам нь өндөр өндөр уулс, өргөн их мөрөн голууд, намаг шалбааг зэрэг бартаа ихтэй байсан бөгөөд олзны болон өөрийн цэргийн хүчээр зам засуулж, гүүр тавиулж явсан нь Алтан ордны улсын дэд бүтцийн асуудлыг давхар шийдсэн хэрэг байв.

Алтан ордны улс байгуулагдсанаар худалдааны хуучин замуудыг гол суурь болгон тэдгээр замуудыг зохион байгуулалттай сүлжээнд оруулж, өртөө байгуулжээ. Тэгснээрээ өрнө, дорныг улс төр, эдийн засаг, гадаад харилцаа, соёлын түмэн шижмээр жинхэнэ ёсоор холбож өгөв.

XIII зуунд Монголын эзэнт гүрэн хүчирхэгжихэд нөлөөлсөн гол хүчин зүйлсийн нэг нь өртөө байв. Монголчуудын байгуулсан өртөө нь ямар зохион байгуулалттай, ямар үүрэг гүйцэтгэж байсныг өрнө, дорны олон түүхч, тухайн үед өртөөгөөр зорчиж байсан элч төлөөлөгчид зохиол бүтээл, аян замын тэмдэглэлдээ тодорхой бичиж үлдээжээ.

Монголчууд чухал бөгөөд нүсэр ажлыг хэрхэн гүйцэлдүүлж төрийн удирдлагынхаа гол хөшүүрэг болгож чадав гэдэг нь сонирхолтой юм.

Далан давааны Их хурилдайгаар 1235 онд олон чухал асуудал хэлэлцүүлсний нэг нь Их Монгол улсын зам харилцааны тухай байв. Энэхүү чухал ажлыг олон талаас нь нухацтай авч хэлэлцээд Өгэдэй хаан өртөө байгуулах зарлиг буулгаж, түүнийг түргэн шуурхай хэрэгжүүлэх маш оновчтой саналыг Цагадай гаргажээ.

Цагадай “Би эндээс угтуулан өртөө замыг байгуулсугай. Бас эндээс Батад элч илгээе. Бат угтуулан өртөө зам байгуулж холботугай”<sup>1</sup> хэмээжээ.

Өртөө байгуулах ажлыг зохион байгуулахаар улс улсаас төлөөний хүмүүс томилон гаргажээ. Их хаанаас - Күридай бичээч, Цагадайгаас - Имхолчин Тайчудай, Батаас Сүкү-Мулчитай, Толуй хаанаас Сорхагтани

бэгийн тушаалаар Элжигдэй нар томилогджээ. Тэдгээр ноёд бүх орон мужуудаар явж өртөөнүүдийг байгуулжээ<sup>1</sup>. Өртөө байгуулах нь зохион байгуулалт, хөрөнгө чинээ, цаг хугацаа шаардсан нүсэр ажил байсан нь ойлгомжтой.

Өртөө зам тавьж дуусгах хугацааг нутаг нутгийн ноёд тэргүүлэгчид нь өөрсдөө мэдэж тогтоон явуулмой<sup>2</sup> гэсний дагуу Бат тэргүүтэй Алтан Ордны ноёд өөрийн улсын нутаг дэвсгэрийг Их Монгол улсын нийслэлтэй холбох хэд хэдэн гол маршрутын дагуу өртөөг байгуулжээ.

Монголын Эзэнт гүрний төрийн хэрэг пирамидийн дээд оргилоос суурь руу, сууриас дээд оргилд хурдан хугацаанд хүрч уг шийдвэр ажил хэрэг болж амьдралд хурдан хэрэгжих үндэс болж байв.

Их хааны зарлиг ёсоор бүх улсын зүг зүгийн мянгатаас замчин улаачныг гаргуулж суурилах газрыг тогтоон, өртөө замыг тавиулаад Арачиан, Тогучар хоёроор захируулж, замын нэгэн суурь өртөөнд 20 улаачин суулгах болов. Улааны морь, шүүсний хонь, саалийн гүү, хөллөх үхэр, ачих тэрэг зэргийг тогтоосон хэмжээгээр бэлтгэ хэмээн тунхаглав<sup>3</sup>.

Өртөө нь юуны өмнө Монголын их хаан, төрөөс явуулах бодлогыг хэрэгжүүлэх гол хэрэгсэл болов. Монгол хаадын зарлигийг хэрэгжүүлэх бүрэн эрх үүрэг бүхий алт, мөнгө, хүрэл гэрэгэтэй элч нар, төрийн сайд, түшмэд, цэргийн жанжид өртөөгөөр ээлж хүлээхгүй довтолгон төрийн хэргийг цаг мөчтэй уралдан хэрэгжүүлж байхад, Монгол хаадтай холбоо тогтоох, тэдний гадаад, бодлого, ая занг мэдэх, цэрэг зэвсгийн хүчин чадлыг тандах, энэ оронд ямар замаар хүрч болох зэрэг олон зүйлийн ээдрээт асуудалд хариу олохыг зорьж харийн элч төлөөлөгчид, худалдаачид, шашны санваартан зэрэг есөн зүйлийн хүмүүс цувж байлаа.

Өртөө нь өргөн удам нутагт мэдээллийг харьцангуй хурдан түгээх, хариу мэдээллийг богино хугацаанд авах боломжийг нээж өгснөөрөө тухайн үедээ дэлхийн хэмжээний их улсын удирдлага мэдээлэл, холбооны системийн хамгийн боловсронгуй хэрэгсэл болж байв. Тиймээс зарим судлаач, өртөөг өнөөгийн интернетийн үүрэг гүйцэтгэж байсан гэж үздэг<sup>4</sup>.

БНСУ-ын нэрт сэтгүүлч Ким Жон Ре: “Мэдээлийн технологийг

<sup>1</sup> Rashiduddin Fazlullah. Jami'u't- Tawarikh. Compendium of Chronicles. A History of the Mongols. Translated and Annotated by W.M.Thackston, Part Two. Harvard University. 1999. pp. 328-329

<sup>2</sup> Пэн Дая, Сюй Тин Хар татаарын хэргийн товч -Ж.Баясах. Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг. УБ., 2005. т. 255

<sup>3</sup> МНТ §279, 280

<sup>4</sup> Ж.Болдбаатар. Дэлхийн болон бүс нутгийн түүхэнд монголчуудын гүйцэтгэсэн үүрэг. УБ., 2003

хүн төрлөхтний түүхэнд гарсан 3 том хувьсгалын нэг гээд Интернетийн үндсэн загвар бүр XIII зууны Евразийн тал нутгийн нүүдэлчдийн их гүрэнд үүссэн нь бодит юм. Чингисийн Их гүрэнд өргөн уудам евразийг нэгэн нетворкийн сүлжээнд холбож байсан харилцаа холбооны арга зарчим байсан ба энэ нь өртөө юм”<sup>1</sup> гэжээ.

Байгуулагдсан даруйхандаа буюу Өгэдэй хааны хаанчлалын үед өртөөний эмх журам, үйл ажиллагаа эмх цэгцэнд орж, төлөвшиж эхэлжээ.

Өртөөгөөр зорчигчдын тоо жилээс жилд нэмэгдэж, элдэв төрлийн хөнгөлөлт эдлэх, зорчигч олширсноор өртөөний ачаалал ихэсч, үйл ажиллагаа нь доголдоход хүрчээ. Тиймээс 1251 онд Мөнх хаан өртөөгөөр зорчиж буй ноёдод үзүүлэх үйлчилгээнд хязгаарлалт тогтоож, 1280 онд Хубилай хаан өртөөний хуулийг шинэчилж түүнийг цэгцлэх яаралтай арга хэмжээ авсан нь Алтан ордон улсад ч хамаатай байв.

Харамсалтай нь монголчуудын өртөө замын чиглэл маршрут, өртөөний хууль дүрэм, хангамжийн тухай цогц бүрэн төсөөлөл өгөхүйц мэдээ баримт монгол түүхийн сурвалжуудад үгүй байна.

Харин тухайн үед өртөөгөөр зорчиж явсан гадны элч жуулчид, харь улсын түүхчдийн тэмдэглэлд хэсэг бусаг мэдээ үлджээ. Энэ нь нэгд, өртөө нь хөдөлгөөнт чанартай сүлжээ байсан, хоёрт, өртөө зам нь цэргийн болон төрийн удирдлагын нууцтай холбоотой мэдээ дамжуулах систем байсантай ч холбоотой.

Дээр дурдсан элч жуулчдын тэмдэглэл дэх хэсэг бусаг мэдээний ихэнх нь Алтан ордны улсын өртөөний маршрут, хангалт, үйлчилгээний тухай хөндсөн байдаг нь өнөөгийн судалгаанд дөхөм үзүүлж байна.

Өрнө зүгээс Эзэнт гүрний нийслэлийг зорьсон хэн бүхэн Бат болон Алтан ордны хаадад бараалхан өртөө хэрэглэж Хархорумын зүг одоохдоо аян замын тэмдэглэл бичиж үлдээсэн байдаг нь уг маршрутыг сэргээн мэдэхэд чухал сурвалж болдог юм.<sup>2</sup>

Францисканы сүмийн гэлэн, Гийом де Рубрук Эзэнт гүрний эзэмшил нутгаар дамжин, Мөнх хаанд бараалхахдаа өртөө замын дараах маршрутаар аялжээ. Үүнд, Ижил мөрний хөвөөнд орших одоогийн Актюбинск хотоос гарч Кибчагийн талаар аялсаар Каратау уулын бэл хүрч өнөөгийн Кулан (Луговое хот)-д иржээ. Тэрбээр цааш Тэнгэр уулын нурууг даган Капчагайн дүүрэг орчмоор Или голыг гатлаж, Эквиус хотод (энэ хот эдүгээ Чингелди дүүргийн Кировский орчимд, Коксу голын хавьцаа байдаг) очжээ. Тэндээс барагцаалбал Копальскийн шар замын чиглэлээр Лепсийн дүүрэг рүү явжээ. Замдаа

<sup>1</sup> Ким Жон Ре. Их шуурганаар сийлэгдсэн түүх. УБ., 2000

<sup>2</sup> Плано Карпини, Вильгельм Рубрук. Дурдсан зохиол. УБ., 1988

Каялык (Талды-Курган мужид буй Койлык туурь) гэдэг том хотод түр саатаад цааш Зүүнгарын хаалгаар гарч, тэндээс Алтайн нурууг давж явсаар Их хааны өргөөнд хүрсэн байна<sup>1</sup>.

Өртөөгөөр зорчигчдын ажил хэрэг, элчийн зэрэг дэвээс хамаарч алт, мөнгө, хүрэл гэрэгэ олгож байсан бөгөөд түүнээс хамаарч өртөөний үйлчилгээ ч ялгаатай байв. Ийнхүү Гэрэгэ нь хийсэн материал, хэлбэр дүрсээрээ ч ялгаатай бөгөөд олгосон дугаартай байжээ<sup>2</sup>.

Плано Карпини өөрийн аян замын тэмдэглэл - "Монголчуудын түүх" зохиолдоо өртөөний маршрутыг бичсэн нь дундад зууны монголчуудын гайхамшигт зохион байгуулалттай сүлжээ замын тухай ерөнхий боловч сэргээн мэдэх боломжийг олгож байгаа юм.

Ромын Пап IV Иннокентийн элч Плано Карпини асар уудам нутгийг өртөөгөөр маш богино хугацаанд туулж Гүюгийг Их хаанд өргөмжлөх ёслолд оролцож байв. Тэрбээр 1245 оны 4 дүгээр сарын 16-нд Францын Лион хотоос гарч 1246 оны 4 дүгээр сарын 4-нд Ижил мөрний адагт орших Бат хааны өргөөнд ирэхдээ бараг нэг жил явсан атлаа Батынхаас Гүюг хааны ордон хүртэл (1246 оны 4 дүгээр сарын 8-наас 1246 оны 6 дугаар сарын 16) хүртэл өмнөхөөс бараг хоёр дахин их замыг хоёрхон сарын хугацаанд туулснаас үзэхэд өртөө нь ямар гайхамшигтай зүйл байсныг мэдэж болно.

Гэтэл Мөнх хаан төр барьж байх үед Монголд ирсэн Вильгельм Рубрук яг тэр өртөөгөөр явахдаа их бэрхшээлтэйгээр маш удаан явсан тухай тэмдэглэсэн байдаг. Энэ нь П.Карпинигаас цаг хугацааны хувьд арай хожуу явсны дээр, Дөргэнэ хатны үед өртөөний дэг журам алдагдаж дараачийн хаад нь журамлан сэргээж байх үед тохиосон бололтой.

Өртөө хэрэглэсэн бүхэн их хурдтай явах боломжгүйг В.Рубрукийн тэмдэглэл харуулж байна. Тиймээс ямар хэргээр, ямар уналга хэрэглэж байгаагаас хамаарч өртөөгөөр зорчих хугацаа, хурд харилцан адилгүй байв.

Өртөөнд хурд хүч сайтай, агт морьд хэрэглэхээс гадна ачаа бараа ихтэй хүмүүс морин болон үхэр тэрэг, заримдаа илжиг, мөн бүхээгтэй тэрэг ч хөлөглөж байжээ.

В.Рубрук: "нутгийн даамал ноён биднийг үхэр тэргээр явахад таван өдөрчийн газар хүргүүлэхээр 2 замчин өгч.... тэд биднийг ачаа тээшээ тээх үхэр тэрэг, ачилганы морьдын алиныг нь ч авч болно гэсэн. Константинополийн худалдаачид үхэр тэрэг юмуу Оросуудын арьс үс тээвэрлэхдээ хэрэглэдэг бүхээгтэй тэрэг ч худалдан авч болно

<sup>1</sup> Алишер Акишев. Скифээс улбаалсан их торгон зам. УБ., 2001. т. 40-42

<sup>2</sup> Yang Hye-Suk. The Foreign Policy of the Great Mongol Empire and the Paiza-International Scientific conference. 2005.

хэмээн зөвлөсөн юм. Бүхээгтэй тэргэнд юмаа аччихаад өдөр бүр буулгах явдалгүй гэснээр бид үхэр тэрэгний аясаар, мориор гэлдрүүлэн их удаан явсан гэжээ<sup>1</sup>.

Ибн-Батутын тэмдэглэснээр “Сарай Батаас Ургенч хот хүртэл 40 хоног явах хэрэгтэй. Хэрэв Хаанбалгас (Бээжин) хүртэл дөрвөн дугуйтай тэргээр явбал 9 сар болно”<sup>2</sup> гэснээс үзвэл уналга ачилганы бүхий л төрлийг ашиглаж байсан байна.

Өртөөгөөр зорчигчдын аюулгүй байдлыг сайтар хангасан байсан нь олон элч төлөөлөгчдийн тэмдэглэлд үлджээ.

Узбек хааны үед ирсэн XV зууны Арабын түүхч Ибн Арабшагын өгүүлснээр худалдаачны анги Хорезмаас гараад их тэргэнд сууж зам турш ямар ч аюул бартаа, яриа шуугиангүйгээр гурван сарын дотор Крымд амар тайван хүрч чадна. Унаа хөсөгтөө тэжээл бордоо авч явсны хэрэггүй, аму хүнс ч дутна гэж айж зовох учиргүй үүнээс гадна замч дагуулсны ч хэрэггүй<sup>3</sup> аж. Венецийн худалдаачин Франческо Балдучи Пеголотт 1340 онд бичсэн “*La prastica della mercatura*” хэмээх номдоо Танагаас Катар орох зам бол өдөр шөнө ялгалгүй ямар ч аюулгүй. Тэнд хаа сайгүй л татаруудын тогтоосон энхийн журам буюу “*Pax Tatarica*” ноёрхож байдаг гэж тэмдэглэжээ.

Мэдээлэл дамжуулах маршрут нь уян хатан байв. Өртөө нь цаг үеийн байдлаас тухайлбал, үер ус, дайн байлдаан зэрэг замд саад тодгор гарсан үед маршрутаа өөрчлөх боломжтой систем байсан байна. Тухайн байдлаас шалтгаалан өртөөний зам хааяа түр өөрчлөгддөг байв. Олон мянган өртөө энд тэндгүй тархсан байх тул мэдээ хүргэх замаа хамгийн дөтөөр сонгох боломж бүрдүүлжээ. Өөрөөр хэлбэл, маневрлах чадвар сайтай мэдээллийн сүлжээ байжээ.

Өртөөний хангалт, түүний үйлчилгээнд тавих хяналтын талаар тодорхой мэдээ байхгүй ч элч нарын тэмдэглэлд дурдсанаас үзвэл ард иргэдээс авах татварын тодорхой хувиар санхүүждэг байжээ.

Мөнх хааныг төр барьж байх үед Хархорумд ирсэн Монголын эзэнт гүрний түүхч Жүвейнийн тэмдэглэснээр: Өртөө бүхнийг жилд 1 удаа байцаана. Дутагдаж гачигдсаныг нь тариачнаар нөхүүлнэ. Цэргийн алба өртөөний бэлтгэмж жич тэдгээрийг бэлтгэхэд хэрэглэх мал унаа өвс бордоог хүртэл тэднээр гаргуулах, нэг өртөөний хангамжийг хоёр түмт хариуцах журамтай байжээ. Тэр зардлыг өрх болгонд татвар болгон оногдуулдаг ба элч зарлага нь унаа унаш олох гэж нааш цааш

<sup>1</sup> Плано Карпини, Вильгельм Рубрук. Дурдсан зохиол. УБ., 1988. т. 55

<sup>2</sup> D.Morgan. Ibn Batuta and Mongols.

<sup>3</sup> Золотая Орда в источниках. Том первый. Арабские персидские сочинения. Тизенгаузен. М., 2003.

хөөцөлдөх хэрэггүй болов<sup>1</sup> гэж тэмдэглэснээс өртөөний хангалтын ерөнхий зарчмыг тоймлож болно.

Өртөөгөөр зорчигсодын хангамжийн тухайд: бидний 4 хүнд 4 хоног тутам 1 хонь гаргаж өгөхийг тушаасан гэх буюу 8 хүний 15 хоногийн хүнсэнд бодож нэг ямаа, нэг тулам үнээний сүү, 3 хүний 6 хоногийн хүнсэнд ганц туранхай хонь, жаахан шар будаа өгсөн тухай элч нар тэмдэглэсэн байна. Дээр дурдсанаас үзвэл, хоол хүнсний хангалт нь нутаг орны онцлог, байгаль цаг уур, улирлын байдлаас шалтгаалан янз бүр байсан бололтой.

Өртөөний хангалтын тухай, ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэхийг нарийн шалгадаг байсан тухай мөн тэдгээр элч нар тэмдэглэсэн байна.

“Монголын нууц товчоон”-д “охор шидэмс дутуулбал өрөөлөөр хагас алдалтан болтугай. Халбага хигээс дутуулбал хамар хагас алдалтан болтугай” гэж дурджээ. Хариуцлагагүй хандсан этгээдэд хатуу шийтгэл оноохыг заасан нь аливаа албан тушаалтанд тавих хяналт чанга байсныг гэрчилнэ.

Мөн өртөөний ажлыг онцгойлон үзэж байсны нэг баримт нь өртөөнүүдэд албан татварын хөнгөлөлт үзүүлж байсан явдал юм.

Өртөө байгуулж, замуудыг хяналтад авснаар төрийн засаглал шуурхай хэрэгжих боломжийг буй болгосон төдийгүй худалдаачдыг дээрмийн халдлагаас хамгаалж аюулгүй байдал, тав тухаар хангасан нь гадаад худалдаа, гадаад харилцаа хөгжихөд нөлөөлсөн гол хүчин зүйлийн нэг болов.

Өртөөг тус улсын доторхи бусад замтай холбосноор замын нэгдсэн сүлжээ болж Алтан ордон болон Монголын эзэнт гүрний төрийн бодлого их гүрний баруун хязгаарт саадгүй хэрэгжих боломжийг бүрдүүлэв.

Монголчууд хэрэгцээт зүйлсээ Эзэнт гүрний аль ч хязгаараас хэчнээн хол ч хамаагүй нэн түргэн зөөдөг бөгөөд хүн ард, бараа таваарыг олон тоогоор, их хэмжээгээр, асар хурдан нүүлгэн шилжүүлж байсан нь урьд өмнө огт гарч байгаагүй үзэгдэл байв<sup>2</sup>.

Ерөөс хурд гэдэг бол XIII зууны амьдралын хэв маягийг тодорхойлж, нүүдэлчдийн хөдөлгөөнт амьдралын хөдөлгөгч гол хүч болж байсан гэж болно. Өөрөөр хэлбэл, өртөө буюу монгол морины хурдаар төр засаглал удирдлагаа гүйцэтгэж, өртөөний хурдаар мэдээллийг олж авах буюу түгээж, өртөөний хурдаар шинэ шинэ газар орон, хүн ардыг танин мэдэж, соёлын охь дээжийг мэдэрч байжээ.

<sup>1</sup> Ata-Malik-Juwaini World Conqueror. pp. 52-53

<sup>2</sup> Жек Ведерфорд. Дурдсан зохиол. т. 160

Тийнхүү төрийн хамгаалалт, хангалттай өртөөний сүлжээгээр Монголын эзэнт гүрэн холбогдсноор төв засаглалыг хэрэгжүүлэх, мэдээлэл, гадаад харилцаа, худалдааг хөгжүүлэх гол хэрэгсэл нь өртөө болсон төдийгүй өрнө дорны ард түмэн бие биенээ танин мэдэх, соёл шинжлэх ухааны ололт амжилт харилцан нэвтрэх гүүр болсон юм.

Чухамхүү морин өртөө байгуулсанаар монголчууд 200 гаруй жил Евразид ноёрхлоо тогтоож чадсан төдийгүй дэлхийн улс төр, нийгэм эдийн засгийн хөгжлийг урагш ахиулахад чухал түлхэц болов.

## 8. ХУДАЛДАА

Улсын сан хөмрөгийг бүрдүүлэх гол хүчин зүйлийн нэг нь худалдаа байв. Шинэ байгуулагдсан Алтан ордон улсын эдийн засгийг хөгжүүлэх гол хөшүүрэг болох худалдааг дэмжиж богино хугацаанд сэргээн хөгжүүлсэн нь улс төрийн ч, эдийн засгийн ч онцгой ач холбогдолтой байв. Тиймээс Монголын эзэнт гүрний төрөөс хэрэгжүүлж буй олон улсын худалдааг хөхүүлэн дэмжиж, хөгжүүлэх бодлогыг шинээр байгуулсан өөрийн улсын эдийн засгийн хөрс сууринд хэрхэн суулгах талаар Алтан ордон улсыг үндэслэгч Бат хаан эртнээс бодож төлөвлөж явсан гэж хэлж болно. Юуны өмнө эзлэгдсэн орнуудын худалдаа эдийн засгийн хуучин системтэй танилцаж түүн дээр нь үндэслэж шинээр санхүү, урамшууллын системийг нэмэн хэрэгжүүлэх нь цаг хожсон төдийгүй тухайн улс орнуудын онцлогийг харгалзсан хамгийн зөв шийдэл байв.

Бат хаан өрнө зүг дайлах их цэргийг удирдаж явахдаа дайлсан улс орныхоо байдлыг нүдээр үзэж, өөрийн биеэр танилцсан нь хожим төр засгийн бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд дөхөмтэй болсон юм. Эзэнт улсынхаа байршлын давуу талыг ашиглан өрнө дорныг холбосон худалдаа, эдийн засгийн чухал бүс болгоход хэрэгцээтэй бүх зүйлийг хийхээр төлөвлөж байв. Монгол хаад мэдээллийн үнэ цэнийг үнэлж мэддэг байсанд тэдний давуу тал оршино. Бат худалдааг богино хугацаанд сэргээхийн тулд газар газрын худалдаачидтай уулзаж худалдааны замын маршрутыг мэдэх, шинээр худалдаалах газруудтай холбоо тогтоох ямар боломж байгааг дайны дундуур ч анхаарч судлаж явжээ.

Тэрбээр явсан газар бүртээ худалдаачдтай уулзан тэдний санал бодлыг зүгээр нэг сонсоод өнгөрсөнгүй хамтран ажиллахыг санал болгож байсан нь үр дүнтэй зөв шийдэл байж түүнийгээ ажил хэрэг болгож чадсан юм.

Бат хаан Москваг эзэлсний дараа тэнд суудаг гадаадын худалдаачдыг олж цуглуулахыг цэргүүддээ даалгажээ. Вена, Любек, Брюгге, Гамбург, Дортмунд, Мелебах зэрэг тэр үеийн Германы харьяанд байсан Европын хотуудаас ирсэн худалдаачид бэлэг сэлт барьсаар Батын

өмнө сөгдөв. Бат хаан тэднээс хаагуур яаж явдаг, хаанаас ямар бараа авч хааш нь зардгийг асууж мэдэв. Тэдний ярианаас усан зам их чухал болохыг тусган авав. Тэдгээр худалдаачид Смоленск хотоор дамжин Днепр мөрнөөр Хар далай орж Болгар, Араб хүрдэг; Двина, Кам, Ижил мөрнөөр Оросын хойт, урд хязгаарт очдог тухай маш дэлгэрэнгүй тайлбарлаж өгчээ.

Бат хаан тэдэнд би Оросын эзэн болно. Та нар надад үнэнч зүтгэж, олон газрын сайн бараа зөөж байсугай! хэмээн зарлиг буулгаад, дүү Шейбанд Москва, Коломна, Подольск, Клин зэрэг ойр хавийн суурин тосгоныг тохинуулан засаг захиргаа, алба татварыг эмхэлж цэгцлэх үүрэг өгсөн тухай сонирхолтой мэдээ байдаг<sup>1</sup>. Энэ жишээнээс харахад их цаг хугацаа зарцуулж хийх зүйлийг богино хугацаанд хэрхэн хийж амжуулж байсныг харуулж байна. Тухайн үед монгол төрийн бодлогод цаг хугацаа, хурдны тухай ойлголт чухал байв. Тиймээс юуны өмнө худалдааны замын маршрутыг зөв гаргаж хуучин байсан худалдааны том хотуудыг хурдан сэргээх, шаардлагатай газруудад шинээр хот суурин босгох, худалдаалахаар сонирхож буй этгээдэд хот суурин барьж байгуулах зөвшөөрөл олгох, өртөөний ажлыг эрчимжүүлж, үйлчилгээг нь хурдан шуурхай болгох, хуурай замын зэрэгцээ Дон, Днепр, Ижил мөрөн цаашлаад Хар далайгаар дамжин усан замаар гадаад худалдааг өргөжүүлэх бодлого боловсруулж түүнийгээ хэрэгжүүлэхээр шийдвэртэй арга хэмжээнүүдийг авч явуулав.

Алтан ордон улсын газар зүйн байршил нь Монголын Эзэнт Гүрний баруун хязгаар, өрнө дорныг холбох төв болж байсныхаа хувьд дэлхийн худалдааны чухал боомтын нэг газрын дундад тэнгис болон арабын улсуудтай, мөн Хүлэг болон Цагадайн улстай, Итали, Византи, Герман, Богеми, Балтийн тэнгисийн зэрэг өрнө зүгийн орнууд, мөн Скандинавийн орнуудтай ч худалдаалах боломжтой байснаараа улсаа хөгжүүлэхэд олон талаар давуу байв. Юуны өмнө худалдааны зам маршрутыг сэргээх, шинэчлэн тогтоох, усан замын худалдааг онцгойлон үзэхээр болов.

Дунай мөрөн болон Газрын Дундад тэнгисээс Монголын эзэнт гүрний төв хүртлэх Евразийн тал хээрийн бүсийн зам хэмээгддэг дорно өрнийг холбосон хоёр их замыг Алтан ордон улсын хаад эрхшээлдээ барьж худалдааг ивээн тэтгэхийн хамт худалдаанд өөрсдийн хяналтыг тогтоож байв<sup>2</sup>. Тэр замаар тэмээн жингийн цуваа Хятад, Бага Ази хийгээд Ойрхи Дорнын хамаг л нарийн нандин эд барааг Ижил мөрөн

<sup>1</sup> Д.Цахилгаан. Бат хаан. УБ., 2003. т. 55

<sup>2</sup> Ш.Бира. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. Боть III. УБ., 2001. т. 232

рүү зөөн авчирч байв<sup>1</sup>. Алтан ордон улс нь Монголын эзэнт гүрний нийслэл Хархоринтой өртөөний нэгдсэн системээр холбогдож байсан бөгөөд Хархорин нь Хятадтай өртөөгөөр холбогдсон байсан нь олон улсын гадаад худалдаа, Өрнө дорны бараа таваарын солилцоог жинхэнэ утгаар хөгжүүлэх боломж бүрдүүлжээ. Хархорин-Хятадын хооронд 37 өртөө<sup>2</sup> байж, тэр замаар өдөрт нааш цааш тус бүр 6 шар хөллөсөн 500 том тэрэг ачаа өнгөрдөг байсны<sup>3</sup> дотор Алтан ордон хаад, эрх баригчдын бараа таваар ч явж байсан нь мэдээж билээ. Худалдааны замын зөв маршрут нь худалдааны цар хүрээг тэлэхийн хамт, цаг хугацааг хэмнэж бараа таваарын эргэлтийг нэмэгдүүлэв. Италийн худалдаачид торго дурдан авах гэж Хятад руу биш, харин Алтан ордон улсад ирэхэд л хангалттай болов.

Алтан ордон улсын төв хэсэгт орших Булгар нь маш сайн худалдааны флоттой байсан ба мөн Булгар хотоос 7 километрийн зайд орших Ага-базар гэдэг гадаад худалдааны том захад тэмээн жин, худалдааны хөлөг онгоц тасралтгүй ирдэг байсныг ашиглан түүнд суурилан усан замын худалдааг цааш өргөжүүлэх боломжтой байв. Алтан ордны нутагт байх том гол мөрнүүдийг ашиглан усан замын худалдааг явуулах болов.

Умраас Новгород, Доод Новгородоор дамжин худалдааны баян хотуудын бараа таваар Ижил мөрний усан онгоцны худалдаагаар Алтан ордны нийслэлд ирэх болов. Эхэн үедээ муслим болон, италийн худалдаачдын бүлэглэлд хавчигдаж байсан Орос худалдаачид тодорхой хугацааны дараа өөрөөр хэлбэл Мөнхтөмөр хааны үеэс л худалдааны үйл ажиллагаагаа идэвхижүүлж Ижил мөрний усан онгоцны худалдаанд оролцох болж Тохтамыш хааны үед Ижил болон бусад гол мөрний усан онгоцны худалдаанд өөрсдийн хяналтыг тогтоож чадав. Мөн Европынхон Танаид голоор дарвуулт онгоцоор ирж оросын загасчидтай худалдаа хийх болсон байна.

Түүний зэрэгцээ Хар тэнгист Италийн худалдааны 2 том бүлэг Алтан ордны улстай худалдаалахаар хоорондоо өрсөлдөж байсан нь усан замын худалдааг өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлэв. Тэдний хүчийг далай тэнгисийн худалдаанд ашиглахаар шийджээ.

Хар тэнгист эхэндээ Венецийн худалдааны газрууд давамгайлах байр суурьтай байсан боловч өрсөлдөөний явцад Генуягийнханы нөлөө, худалдаалах цар хүрээ нь илүү болж хуучин дан Венецийн зах зээл байсан Византи бүхэлдээ Генуягийн мэдэлд оржээ.

Алтан ордны хаад өөрсдийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд

<sup>1</sup> М.Правдин. Чингис хаан түүний өв. УБ., 2005. т. 271

<sup>2</sup> Рашид-ад-Дин. Судрын чуулган. Боть II. УБ., 2002

<sup>3</sup> Д.Майдар. Өмнө дурдсан зохиол. т. 131

өрсөлдөгч хоёр талын аль алиныг нь дэмжжээ. Крымийн хойг дахь хэд хэдэн худалдааны усан боомтыг чөлөөлж тэнд хуваарилан өгсөн бөгөөд консул төлөөлөгчид нь тэнд сууж байв. Тийнхүү тусгаарласан нь тэдгээр атаач жөтөөч худалдаачид бие биетэйгээ Алтан ордны нутагт харгалдан тэмцэлдэхээс болгоомжилсон хэрэг байв. Боомтуудыг өгснөөр өрнөдийг Алтан ордонтой хуурай болон усан замаар холбож чадав.

Венецийн ах дүү худалдаачид Николо, Маффео Поло нар 1260 онд Константинополь хотоос Алтан ордон улс руу усан онгоцоор ирж Алтан Ордны хаан Бэрхэд бараалхаж байсан нь үүний тодорхой баримт мөн.

Хэдийгээр Алтан ордон хаад өрсөлдөгч хоёр бүлгийг адилхан дэмжсэн ч Крымд ч мөн Генуягийн харьяаны хот суурингууд Алтан ордон улстай хийх худалдаанд зонхилох болов. Тэр үед Бага Азийн умар эргийн усан боомтууд Төв Азийн худалдааны голлох хэсгийг хангаж байв<sup>1</sup>.

Бат хаан худалдааны сүлжээ замыг маш богино хугацаанд сэргээн бүрдүүлэх зорилт тавин бие биетэйгээ харилцан уялдаатай, цогц хэд хэдэн чухал асуудлыг шийдвэрлэснээр түүний төр барьж байх хугацаанд хуурай замын тэмээн жингийн цуваа, далайн болон гол мөрний худалдааны гол маршрут нь үндсэндээ төлөвшлөө олж олон улсын худалдаа сэргэж эхэлжээ. Замын оновчтой маршрутыг буй болгохдоо худалдааны замын аюулгүй байдлыг давхар хангаж чадсан байна.

Замын асуудлыг шийдвэрлэсний дараа түүгээр явж худалдаалах худалдаачдын тоог нэмэгдүүлэхийн тулд эдийн засгийн урамшууллын системийг чадварлаг ашиглажээ. Юуны өмнө Монголын Их хаадын хэрэгжүүлж байсан худалдааны урамшууллын системийг Алтан ордон улсад хэрэгжүүлэв.

Их гүрний нутгаар хэрэн явж гадаад худалдааг идэвхитэй хөгжүүлж буй худалдаачдад хааны сангаас хөнгөлттэй нөхцлөөр зээл олгох, барааг нь урамшуулалтай үнээр худалдан авах, зарим үед өртөөгөөр хөнгөлттэй явах боломж олгох зэргээр гадаад худалдааг хөхүүлэн дэмжив.

Мөн Алтан ордон улсын эрх баригчид өөрсдийн нэрийн өмнөөс улсын дотоодод болон харь оронд худалдаачдыг сонгон санхүүжүүлэхдээ эхний үед дадал туршлагатай мусульман худалдаачдыг гол төлөв санхүүжүүлж байсан бол аажмаар хүрээгээ тэлэн Итали, Византи, Оросын худалдаачид, улмаар худалдаа хийхийг хүссэн хэн бүхнийг дэмжин урамшуулж байв.

Монгол хаад худалдаачдад элдэв хөнгөлөлт олгох, тэдний аюулгүй

<sup>1</sup> Мөн тэнд. т. 235

байдлыг хангах үүднээс зарлигийн бичиг олгож байв. Монголын эзэнт гүрний түүхч Жүвейнийн тэмдэглэснээр, Сарай Бат хотод худалдаачид зүг бүрээс элдэв төрлийн бараа авчирч, Их хаан шинэ бараа бүрт өртгөөс хэд дахин давуу үнийг төлж байв. Энэ нь худалдаачдад урам өгч томоохон хөлтэй наймаа хийгч худалдаачид Их хаадын нийслэл, ордонг зорин хаа холоос ирдэг болгов.

Өмнө дурдсан Николо, Маффео Поло нар Константинополь хотоос Алтан ордон улс руу усан онгоцоор ирж Чингис хаанаас тогтоосон худалдааны хэв журмын дагуу тэд элдэв үнэт зүйлс эрднийн чулуу зэрэг эд бараагаа Бэрх ханд бэлэг болгон барьж түүний ордонд нэлээд зочилсны эцэст хаанаас өөрсдийн өгснөөс ч их бэлэг сэлт авч байсныг Марко Поло номдоо тэмдэглэжээ.

Ром, Сири бусад орны султан нарт хөнгөлөлтийн бичиг, гэрэгээ өгч, худалдаа хөгжүүлэхэд хүчин зүтгэсэн хүн бүрт шан харамж хүртээдэг нэн ялангуяа гадаад худалдааг ихэд урамшуулдаг байсан нь дэлхийн чөлөөт худалдааны бүс бий болгоход хүргэсэн юм. Алтан ордон улсын хаадаас худалдаачдад ихээхэн итгэл үзүүлж байсны гэрч нь тэднийг элч төлөөлөгчөөр илгээн төрийн хэрэгт оролцуулж, томоохон албан тушаалд томилдог байсан явдал мөн. Худалдаачид ийнхүү дипломатын үүргийг гүйцэтгэж байв. Тухайн улсаас ирээд буцаж буй худалдаачнаар дипломат илгээмж илгээх, захидал бичиг дамжуулах боломжийг эзэн хаад ашиглаж байв. Бусад оронд ч монгол хаадын тогтоосон жишгийг дагах болов. Египедийн султан Байбарс Алтан ордонд илгээх анхны захидлаа наймаачдаар дамжуулан илгээж байв<sup>1</sup>.

Худалдааны цар хүрээ нэмэгдэх тутам Монгол хаад элдэв янзын хөнгөлөлтүүд, онцгой эрх дарх олгож байв. Учир нь худалдаа нь ердөө л нэг бараа таваар зөөн борлуулж ашиг хонжоо олоход чиглэгдэж байсангүй шинэ мэдлэг, шинэ мэдээлэл, шинэ технологи дэлгэрүүлэхэд тустай байсныг монгол хаад олж харж ач холбогдол өгч байсан юм. Үүнийг ухаараагүй зарим нь монгол хаадыг юмны үнэ цэнэ мэдэхгүй илүү үнээр авдаг, эсвэл зүгээр олсон эд учир үнэ цэнийг мэдэхгүйгээс үрэн таран хийдэг гэх нь бас байсан ч түүнийг нь зөвөөр ойлгосон нь урамшин, харин ч хаадын өргөөг зорин очих нь урьдаас эрс нэмэгджээ. Гадаад худалдааны ач холбогдлыг нэмэгдүүлэхийн тулд худалдаачдын нийгмийн байр суурийг өргөх нь чухал байсан тул хэд хэдэн чухал арга хэмжээ авчээ. Худалдаачдад хаанд бараалхах эрх дарх соёрхол хааны нэрийн өмнөөс хөнгөлөлтийн гэрэгэ олгох, худалдааны төв байгуулах зөвшөөрөл олгох, өртөөгөөр хөнгөлөлттэй зорчих, төрийн албанд

<sup>1</sup> Салих Захиров. Алтан Ордны улсаас Египедтэй барьж байсан дипломат харилцаа. УБ., 2004. т. 42

томилон ажиллуулах, гадаад улсад одох элчин төлөөлөгчийн үүрэг гүйцэтгүүлэх зэрэг дорвитой арга хэмжээ авч явуулав.

1266 оны Каффын хэлэлцээрээр монголын захиргаа Генуячуудад Крым дахь худалдааны томоохон суурин, агуулахуудаа бараа таваар гадагш гаргах боомт болгон ашиглахыг зөвшөөрчээ.

Крымийн Каффа боомтод байсан Генуягийн худалдаачид Мөнхтөмөр хаанаас хөнгөлөлттэй худалдаалах зарлиг авчээ. Мөн Германы худалдаачдад Ригаар саадгүй дамжин Новгородыг дайран Алтан ордод ирж худалдаалах боломжтой замыг нээснийхээ төлөө их ван Ярослав Мөнхтөмөр хаанаас зарлиг авч байв<sup>1</sup>.

Мөнхтөмөр хаан худалдаачдыг зүйл бүрээр дэмжиж байсан нь худалдааны харилцаа холбоог улам өргөжүүлж Өрнө, Дорнын соёлын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж түүний төр барьж байх жилүүдэд тус улсын эдийн засгийн байдал тогтвортой хөгжих хандлагыг нэгэнт олсон байв.

Орос улс Алтан ордон улсын вассал болсноор олон улсын худалдаанд өмнөх үеэс илүү өргөн далайцтай оролцох боломж олжээ.

Узбек хаан Генуя болон Венецийнхэнтэй худалдааны харилцааг сэргээж шинээр хэлэлцээр тогтоосноор Генуягийн элчин төлөөлөгч Антонио Грилло, Николо ди Пагана нар Каффа хотноо хашаа хороо барьж дэлгүүр хоршоо нээх зөвшөөрөл олж 1316 оноос тэнд идэвхитэй үйл ажиллагаагаа дахин сэргээжээ. Узбек хаан 1332 онд мөн Дон мөрний адаг Тана хэмээх газар суурин барихыг Венецийнхэнд бас зөвшөөрчээ<sup>2</sup>.

Эдгээр арга хэмжээ нь тухайн үед худалдаачид нийгэмд доогуур байр суурьтай байсныг эрс өөрчилсөн юм. Язгууртнууд худалдаа наймаанд оролцдоггүй байлаа. Монголчууд, худалдаачдад эрх мэдэл олгож тэднээс дээгүүр байр суурьтай болгосон нь эдийн засгийн асуудалд илүү ач холбогдол өгч байсны гэрч юм. Монголын эзэнт гүрний хэмжээгээр худалдаачдын нийгмийн байдлыг дээшлүүлэхэд анхаарч тодорхой арга хэмжээнүүдийг авч явуулжээ. Хятадад күнзийн эрдэмтэд нийгэмд хамгийн дээд зэрэгт тооцогддог байсан бол тэднийг 9-р зэрэглэлд, худалдаачдыг 2-р зэрэглэлд<sup>3</sup> оруулсан нь угсаа язгуурт хүмүүсийг балмагдуулав. Цогц арга хэмжээ авч явуулснаар худалдаачдын язгуурын гарал нийгмийн байдалд эрс өөрчлөлт оржээ.

Худалдаанд мусульман худалдаачид, армян, гүржийн эрх баригчид нэлээд чухал байр суурийг эзлэж Алтан ордон улсын төр засаг,

<sup>1</sup> Григорьев А.П. Сборник ханских ярлыков русским митрополитом. СПб., 2004. стр. 20-21

<sup>2</sup> Мөн тэнд. тал 163

<sup>3</sup> Ж.Ведерфорд. Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан. УБ., 2003. т. 274

захиргааны албанд зүтгэх болсон орон нутгийн албан тушаалтангуудын ихэнх нь худалдаачдын гэр бүлээс гаралтай байсан нь тухайн үед дээрх арга хэмжээ хэрхэн нөлөөлсөн болон худалдаа ямар чухал үүрэгтэй байсныг гаргажээ.

Гэвч Монголын ноёрхлын үед бий болж байсан шинэ боломжийн давуу талыг ашиглагсадыг уугуул нутгийнхан нь тэр болгон таатайгаар хүлээн авч байсангүй, харилцан адилгүй хандаж байв. Тухайлбал, Грек, Армен, Гүржийн сурвалжтан, газрын эзэд шинээр баяжсан худалдаачдыг хялайж хардаг байсан бол харин Оросын вангууд болон язгууртнууд худалдаанд ихээр татагдан орж тэд бие биеийг дэмжин захиргааны гол албан тушаалд дэвшжээ.

Тэдгээр онцгой эрх дарх, хөнгөлөлтүүдийн хариуд худалдаачид ч хаант төрд зүтгэж гадаад худалдаа, тагнуулын алба, мэдээлэл олж авахад Их хаадад ихээхэн тус дэм болж хааны сан хөмрөгт ихээхэн ашиг орлого, хөрөнгийг оруулдаг байсан юм..

Нэгэн угсаатан үндэстний хувийн эрх ашгаас төрийн хэргийг дээгүүр тавьж байсан учир хэн чадвартай нь хүчээ өгч монголын төр дэлхийн хэмжээний бодлого явуулах чадвартай хүчирхэг төр болж чадсан юм.

Худалдаа зах зээл илүүтэй хөгжсөн, эрэлт хэрэгцээ, хотын хэрэглээ нэгэнт бүрдсэн газарт эдийн засаг, худалдаа арилжааны тааламжтай нөхцөл бололцоог нь бүрдүүлмэгц зах зээлийн жамаар худалдааны ажил эрч хүчээ аван хөгживж байлаа.

Торгоны замыг Их хаад ивээлдээ авснаар Алтан ордны худалдааны хамрах цар хүрээ, хэмжээ далайц нь өмнөх үеэс эрс нэмэгдэж худалдааны шинэ шинэ төвүүд байгуулагдсан төдийгүй ашиг орлогын төлөө цаг мөчтэй уралдан зах зээлийн өрсөлдөөнийг буй болгов.

Худалдаалах зам болон худалдааны эрхийн төлөө олон орны худалдаачид өрсөлдөж байв. Алтан ордон улс байгуулагдсан эхэн үед худалдаанд мусульман худалдаачдын эвсэл холбоо, өрнө зүгт Италийн Венец, Генуягийн худалдаачдын худалдааны замын төлөө, түүнд ноёрхлоо тогтоохын төлөө өрсөлдөөн тэмцэл нь монополь эрхийг буй болгож Орос болон бусад орны худалдаачдад шахалт үзүүлж байв.

Бэрхийн төр барьж байх үед бараа таваар элбэгжин худалдаа хэдийн ахицтай түвшинд хүрсэн боловч оросын худалдаачид олон улсын худалдаанаас таслагдсан байв. Учир нь худалдааны гол гол замуудад төв азиас гаралтай мусульман, араб худалдаачид ноёрхож тухайн үеийн худалдааны хамгийн гүйлгээтэй бараа таваарыг өөрсдийн гарт барьж монополь тогтоосон байв. Гэсэн ч Оросын худалдаачид уйгагүй чармайлт гаргаснаар XIII зууны сүүлч үеэс Ижил мөрний худалдаанд

сая онц эрхээ тогтоож чадсан байна.

Дон мөрний адагт орших Тана хотод худалдааны төвөө байгуулсан италичууд 1342 оноос худалдааны онцгой эрхээр хангагдсан атлаа 1343 онд лалынхантай хэрүүл маргаан үүсгэж харилцан тэмцэлдэж эхэлсэн нь мөн л худалдааны өрсөлдөөн байв. Тиймээс Жанибек хаан Венецийнхэн ба Генуячуудыг Тана хотоос хөөн гаргаж Каффа хотыг 1343, 1345 онуудад хоёр ч удаа эзлэн авч байв<sup>1</sup>.

Төрийн зөв бодлогын үрээр цэцэглэн хөгжсөн худалдааны том төвүүд, хот суурин, боомтууд байгуулагдав. Энд юуны өмнө Алтан ордны хоёр Сарай, Үкек, Тана, Булгар, Крымийн хойгийн өмнөд эрэгт худалдааны боомт хот Каффа, Солдайя байсан бөгөөд энэхүү хот нь өрнө, дорны худалдаанд чухал үүрэгтэй байв. Солдайя хот Синопольтой тэнгис алгасан харалдаа орших учир умрын орнуудад очихоор яваа Түркийн худалдаачид хийгээд Орос болон умрын орнуудаас турк орохоор буцаж яваа худалдаачид цөм дайран өнгөрдөг байжээ..

Алтан ордон улс нь олон улсын худалдааны төв болсныхоо хэрээр худалдаалах эд зүйлийн төрөл нь ч маш баялаг байв.

Алтан ордон улсын худалдааны гол төвийн нэг Булгар нь Скандинавын орнуудтай үслэг эдлэлийн худалдаа хийж байсан бөгөөд эндэхийн үслэг эдлэлүүд бусад газрынхаас илүү дулаан, чанартай гэж үнэлэгддэг байв. Мөн орнуудтай төмөр, төмөрлөгийн худалдаа хийж байсан ба Өрнө зүг Италийн хотуудтай мөн Дундад Ази, Кавказ, Иран, Балтийн тэнгисийн орнуудтай гоёл чимэглэл, цэмбэ, торго, ангийн үс, хүнсний зүйлс худалдаалж байв. Энэтхэг, хятад, араб, иран, худалдаачид газар бүрээс ирж наймаалан дайран өнгөрөх ба булгар худалдаачид ч Скандинав, Балтийн нутаг, Орос, Константинополь, Багдадад явж хоол амтлагч, нэхмэл бөс, даавуу, хятадын шаазан торго зэргийг худалдаалж байв.

Алтан ордон улсын нийслэл Сарайд XIII зууны 60-аад оноос мөхөж байсан Латины эзэнт гүрний төлөөлөгчид үзэгдэх болж, Сарай хотын зах зээл дээр Фландрын нарийн нэхмэл эд борлуулах болсноос гадна Кибчагийн үнэт үс болон амуу тариаг баруун Европт зөөвөрлөх болжээ.

Умраас ирсэн худалдаачид нь үен, хэрэм, бусад амьтны үнэт арьс авчрах ба өмнөдөөс ирсэн худалдаачид нь хөвөн ба мяндсан нэхмэл бараа, торго, анхилам үнэртэн авчрах ажээ. Европынхон Танаид голоор дарвуулт онгоцоор ирж хатааж борцолсон хилэм, мөрөг, хулд зэрэг бусад зүйлийн загасыг их хэмжээгээр худалдан авдаг байв.

<sup>1</sup> Мөн тэнд. т. 164

Тухайн үед дайн байлдаанаар олзлогдож ирсэн буюу цэргийн албыг хүнд бэрх ажлаас чөлөөлөгдсөн Алтан ордны хүн амын нэлээд хувийг эзлэх гар урчууд олон орны урчуудын сонин содон хэв маяг шингээн урласан гоёл чимэглэлийн зүйлс, зэр зэвсэг, сав суулга олноор үйлдэх болсон нь худалдаалах барааны төрөл зүйлийг нэмэгдүүлж байв.

Узбек хааны үед Сарайд оросын худалдаачдын том эзэмшил байгуулагджээ. Тэр үеийн орос худалдаачид Сурож<sup>1</sup> хоттой ашигтай үйл ажиллагаа эрхэлж байв. Сурожтай худалдаа хийж байсан тухай Волынскийн он дарааллын бичигт тодорхой дурджээ.

Сурож хотын орос худалдаачид XIV зуунд Москвагийн худалдаачдын ихэнх хувийг бүрдүүлж байсан юм. Чухам тэр үеэс Оросууд өрнөдийнхөнтэй худалдаагаа өргөжүүлэв. Москва, Тверийнхэн, Новгород, Псков хотынхон Литов, Польш, Богеми, Германтай худалдаалав. Баруунаас Орос руу голлон худалдаалж байсан зүйлсийн дотор ноос, цэмбэний зүйл зонхилох байрыг эзлэж байв. Тиймээс тэдгээр худалдаачдыг цэмбэчид буюу суконниками гэж нэрлэх болов.

Худалдаачид, худалдааны тухай ярихад “агт морьдын худалдаа”-ны тухай өгүүлэхгүй байж үл болно. Арабын жуулчин Ибн-Батута бичихдээ (XIV зуун 30-аад он) Дешт-Кибчаг нь адуугаар алдартай бөгөөд хамгийн сайн морь 50-60 дирхем<sup>2</sup>, В.Рубрук мөн сайн агт 7 алтан зоос хүрдэг байсан гэж бичжээ.

Морьдыг Энэтхэг рүү зөөдөг байсан бөгөөд нэг цуваанд 6000 хүртэл морьд ачсан мэдээ буй. Морьдыг худалдааны пүүсүүдээс илгээхийн хамт хувь худалдаачид ч 100, 200-аар нь морьд авдаг байв. Алтан ордны худалдаачид асар өндөр татвартай гэж тэмдэглэгдсэн энэ худалдааг өргөн хийж байсан нь XV зууны 70-аад он болоход зөвхөн Иранд жилдээ 40000-аад тооны морьд худалдаж байснаас илэрхий<sup>3</sup>.

Тэр үед худалдаалах төрөл зүйлийн дотор боолын худалдаа нэлээд газар авч байв. Дайн байлдаанаар олзолж ирсэн буюу алба татвараа төлөөгүй хүмүүсийг боол болгон худалддаг байжээ. Боолын худалдааг Хар тэнгис, Газар дундын тэнгисийн дорнод хэсгээр дамжуулан хийж байсан бөгөөд гол худалдан авагчид нь арабын улсууд түүний дотор Мисирүүд, европоос Итали түүний дотор Генуячууд байв. Каффын гэрээгээр умар зүгийн ховор ангийн арьс үс наймаалах их зах зээл болсон Кибчагийн хааны нийслэл, Ижил мөрний доод урсгал дахь Сарай хотод Италийн худалдаачид хурч очиж боолын худалдааг эрхлэх

<sup>1</sup> Солдайяа гэдэг нь уг хотын итали нэр, Сурож гэдэг нь тэр үеийн орос нэр нь одоо Судак

<sup>2</sup> 1 дирхем нь Монголын үед алтанд шилжүүлснээр 12.5 карат, мөнгөн динар нь 75 карат байв.

<sup>3</sup> А.Якубовский. Золотая Орда. стр. 117

болов. Монголчууд Кибчагийн тал нутгийг эзлэн авах үедээ олон тооны түрэгүүдийг олзлон авч Сири, Египедээс амьд бараа авахаар ирдэг худалдаачдад худалдаж байжээ. Кибчагийн тал нутгаас худалдан авчирсан түрэгүүд нь шударга, өгөөмөр төдийгүй эрэлхэг, бие бялдар сайтай, үзэмж төгөлдөрөөрөө онцгой ялгарч байжээ. Египедийн дайчдын ихэнх нь мамлюкуудаас (боолууд) бүрдэж байсан бөгөөд тэдний дундаас чадварлаг цэргийн жанжид олноороо тодорсон юм. Тэдний нэг болох 800 дирхемээр худалдагдаж байсан Байбарс хожим Египедийн султанаар тодорч байв<sup>1</sup>. Алтан ордноос худалдааны онцгой эрх авсан Генуячууд тэрхүү онц ашигтай худалдааны замыг гартаа барьж байсан бөгөөд Европт боолуудыг олноор гаргаж байв. Генуячуудын араас европын бусад үндэстний худалдаачид ч цувж, Крым, тухайлбал, Каффа хот боолын худалдааны үндсэн төв нь болжээ. Боолчуудыг үй олноор нь Итали, Францын хотуудад илгээж байсны дотор славянчууд, тухайлбал, оросууд ч байдаг байв. Ордал олзлогдсон олон боол, вангууд худалдагдаж байсан<sup>2</sup>. Сарайд байгуулагдсан үнэн алдартны шашны төлөөлөгчийн газрыг зарим судлаачид олзлогдсон Оросуудын төлөө тэдний эрх ашгийг хамгаалах үүднээс байгуулсан гэж үздэг. Алтан ордны улсаас Юан улс руу олзны оросуудыг илгээж байсан мэдээ бий.

Монголд эзлэгдсэн Төв Ази, Баруун Азийн үндэстнүүдтэй адил орос, кибчаг хүмүүсийг олзлон Монгол, Юань улс руу явуулж, газар тариалан цэргийн албанд зүтгүүлэх нь цөөнгүй байв. Юань төвийн цэрэгт Тангуд цэргийн отряд, Баруун Азийн цэргийн отрядтай зэрэгцэн Асү отряд (Алан отряд) Кибчаг цэргийн отряд, Оросын отряд байжээ. “Юан улсын судар”-аас үзэхэд Төгстөмөрийн үед 10 000 гаруй орос хүнд 6700 акр газар өгч, тариа тариулсан тухай мэдээ бий<sup>3</sup>. Тэдгээр боолууд нь гол төлөв залхаан цээрлүүлэх цэргийн анги нэгтгэлийг бүрдүүлж байдаг ба хүний нутагт буй тийм арми нь эцэг, эх, хамаатан садан, нэг угсаатай гэж хайрлах зүйлгүй бослого тэмцлийг хайр найргүй дардаг байсан учир ялангуяа хүн ам олон Юань зэрэг газар нутагт зориуд аваачин суулгаж байжээ. Тайван цагт хүнсний хангалтыг нь өөрсдөөр нь хийлгэхийн тулд тариа тариулж байсан болов уу.

Алтан ордон улсад орос, кибчагуудыг боол болгон Европын өмнөд хэсгийн улсуудад өргөнөөр худалдаалж байсан ба Хар далайн эргийн хотуудад боолын худалдаа дагнасан захууд хөгжсөн.

Улмаар Кибчагийн тал нутгаас их хэмжээний боол монгол, ислам

<sup>1</sup> Салих Захиров. Алтан Ордны улсаас Египедтэй барьж байсан дипломат харилцаа. УБ., 2004. т. 35-37

<sup>2</sup> Тюркологический сборник 2001. Золотая Орд и ее наследие. М., 2002. стр. 168-169

<sup>3</sup> Монголын Эзэнт улс ба Өрнө дахим. Ред. Сагүчи Тоорү. Хэйбоншя. 1970. т. 126. - Т.Мөнхцэцэг. Япон дахь Монголын түүх бичлэг. УБ., 2006

худалдаачдын гараар дамжин Сири, Баруун хойд Африк, Египетэд руу их хэмжээгээр зарагдаж, Александр хот Газар дундын тэнгисийн бүс нутаг дахь хамгийн том боолын зах болсон байна.

Сонирхолтой нь Италийн хотуудад эмэгтэйчүүд ихээхэн гүйлгээтэй байжээ. Тухайлбал, XIV зуун хүртэл эмэгтэйчүүдийг хоёр дахин илүү тогтоон авч байсан бол XIV зуунаас эхлэн бараг дөрөв дахин олноор худалдан авч ихэвчлэн гэр орны ажилд хэрэглэдэг болсон аж. Боолуудаас 16-30 насныхан онцгой үнэтэй бөгөөд 40-өөс дээш настанг авдаггүй байв. Үндэстний хувьд боолын худалдааны зах зээл дээр оросууд, дараа нь черкис эмэгтэйчүүд үнэ хүрдэг байсныг түүхэнд тэмдэглэжээ<sup>1</sup>.

Мисирийн мамлюкууд хүн хүчнийхээ нөөцийг нөхөн нэмэгдүүлэхийн тулд залуу түрэг боолуудыг олноор худалдан авах болсон нь ихээхэн гүйлгээтэй болоод ашигтай наймаа байсан учир Итали худалдаачид боолуудыг олноор нь худалдан авч байжээ. Шилдэг цэрэг эрсийн эзэмшлийн тал нутгийг хоосолж буй худалдаачдад дургүйцсэн Тохтай хаан Италийн худалдаачдын энэхүү ажиллагааг зогсоохын тулд 1307 онд Сарай дахь Генуячуудын орд харшийг битүүмжилж улмаар Каффа дахь сууринг нь довтлохоор цэрэг илгээжээ. Генуя суурингийнхан хотоо өөрсдөө галдан шатааж усан онгоцоор зугтсан ажээ. 1312 оны 8 дугаар сард Тохтай хааныг нас барах хүртэл байдал ноцтой хэвээр байв<sup>2</sup>.

Өгүүлэн буй үед гадаад дотоодын худалдаа аль аль нь урьд хэзээ ч байгаагүйгээр хөгжин цэцэглэж, хүн зоны танин мэдэхүйн нүдийг нээж ахуй амьдралын бүхий л хэрэгцээг хангаж байсан аж. Худалдаа нь зөвхөн чамин тансаг, гоёл чимэглэлийн зүйлийг худалдаалдаг байсан гэвэл эндүүрэл болно. Худалдаагаар язгууртны хэрэглээний чамин тансаг зүйлээс эхлээд нүүдэлчин, тариачин зэрэг хүн амын өргөн хэрэглээний зүйлсийг бүхэлд нь худалдаалж байв. Хэрвээ тариачид бөс бараа, металл эдлэл, шавар сав суулга авч байсан бол нүүдэлчид тариа будаа, бүдүүн борог эд даавуу, авах жишээтэй. Унгар, Италийн худалдаачид торго дурдан авах гэж Хятад руу биш, харин Алтан ордны улсад ирэхэд л хангалттай байв. Сарай хотын зах дээр Булгараас орж ирсэн ангийн үс Европын болон Скандинав, Оросын худалдаачдын анхаарлыг зүй ёсоор татаж байв. Хорезмийнхан арьс шир, түүнийг элдэж боловсруулах холтос зэргийг Ижил мөрнөөс зөөдөг байв.

Тухайн үед дан ганц гадаад худалдаа ч бус дотоодын худалдаа боломжийн хэмжээнд хөгжиж малчин тариачид өөр өөрсдийн аж ахуйгаас гарах эд зүйлсийг хэрэгцээнийхээ хэрээр арижин авч байв.

<sup>1</sup> М.Д.Полубояринова. Русские люди в Золотой Орде. М., 1978. стр. 39

<sup>2</sup> Рэне Груссе. Чингис хааныхны монголчууд. УБ., 2004. т. 162-163

Ижил мөрний доод сав газраар нүүдэллэн амьдардаг малчид өөрсдийн аж ахуйгаас гарах хүнсний хэрэглээний мах, цагаан идээ, хонины ноос, арьс шир зэргийг авчирч, тариачид нь аму тариа, боловруулалт нь төдий өндөр бус ч хөвөнгийн нэхмэл эд, төмөрлөг эдлэл, хүнсний зүйл хадгалах болон ус зөөх зориулалтын керамик сав суулга зэргийг сольж арилждаг байв.

Худалдааг дагаж соёл, шинжлэх ухааны олон шинэ зүйл өрнө дорнодод харилцан нэвтэрчээ. Европт хятад торгоны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр бас дууриалгаж хийх болсон мэдээ бий. Олон улсын худалдаа хөгжихийн хэрээр хүмүүсийн хэрэглээнд ч өөрчлөлт орж улам бүр шинэ зүйлсийг танин мэдэж хэрэглэхийг эрмэлзэж байв. Тухайн үед хятад сампин, элдэв нарийн амттан, хоол амтлагч халуун ногоо чинжүү, цагаан гаа, шанцай, задь тэргүүтнийг Европт хэрэглэх болсон төдийгүй түүний эх нутаг болох Дорны орныг ч таньж мэдэв. Энэтхэг Мосул даавуу, эрээн бөс, сувд эрднийн чулуу Европт өргөн тархжээ. Иранаас зэр зэвсэг, хивс, арьс ширэн эдлэл ирж байв. Ази урьд өмнө хэзээ ч ийм агуу том, зүйл бүрийн соёлын хослол бүрдсэн баян чинээлэг байсангүй<sup>1</sup>. Византийн Клуассоны паалан Хятадад хүрч хятадын шаазангийн урлагтай нэгдэн шинэ төрөл бий болгоход түлхэц өгчээ. Бат хааны уул уурхайн газарт Трансильваанийн германууд ажиллаж алт олзворлолт нэмэгдэхийн хэрээр худалдан авах чадвар өсч байсан нь худалдаа гүйлгээний цар хүрээг нэмэгдүүлэв. Он жилүүд өнгөрөх тутам харилцаа холбоо өргөсч худалдаа наймааны төрөл зүйл улам нэмэгдэж худалдаачдын тоо өсч байв<sup>2</sup>.

Хаан өргөмжлөх, харь орны элч төлөөлөгчдийг хүлээн авах, үдэх, үндэсний баяр ёслол зэрэгт хэрэглэх архи дарсны том зах зээл, хэрэглээг буй болгосон нь усан үзэм тариалж дарс үйлдвэрлэдэг тариачдад аж ахуйгаа өөд татаж чанартай сайн дарс үйлдвэрлэж ашгаа нэмэгдүүлэхийн төлөөх өрсөлдөөнийг буй болгов.

Зах зээлийн өрсөлдөөнд тэнцэхүйц зүйлийг үйлдэхийн төлөө гар урчууд өөрсдийн ур чадварыг сайжруулах нь зайлшгүй болсноор гар урлалын хөгжил мэдэгдэхүйц дээшилсэнийг археологийн малтлагаар олдож буй эд өлгийн дурсгалууд гэрчилнэ.

Харин худалдаалах зарчим нь том худалдаачид, ноёд язгууртнууд өргөн хэрэглээний барааг бөөнөөр нь авчирч хөрөнгө чинээ, худалдан авах чадвар багатай хүмүүст жижиглэн худалдаалж мөнгөөр буюу хэрэгцээт зүйлсээрээ арилжин авдаг байжээ. Гийом де Рубрук энэ талаар тодорхой жишээ дурдсан байдгийг иш татвал, "Том ноёд нь

<sup>1</sup> М.Правдин. Чингис хааны өв. УБ., 2005. т. 241

<sup>2</sup> М.Правдин. Чингис хааны өв. УБ., 2005. т. 240

өмнөд нутагт байдаг эзэмшил газраасаа өвлийн цагт шар будаа, гурил зөөж авна. Харин ядуучууд нь түүнийг хонь ба арьс хөрсөөр худалдаж авдаг”<sup>1</sup> гэжээ.

Алтан ордны хотуудаар худалдаачид чөлөөт худалдаа эрхэлж байв. Хорезм, Бухарт орчин үеийн банк шиг санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг баян хүмүүс ч байв. Алтан ордноос хойш ч Энэтхэг, Хятадын алслагдсан дүүргээс Алтан ордны зоос олдож байсан нь худалдаа хэр өргөн далайцтай хөгжиж байсныг илтгэнэ.

Алтан ордны нийслэл болон худалдааны гол гол хотуудаар нь Унгар, Итали, Сартуул, Египет, Ирак, Турк, Армян, Крым зэрэг олон орны худалдаачид хөлхөлдсөн үнэхээр “дэлхийн хот”, өрнө дорнын соёлын солилцооны төв болсон байжээ

Монголын Их хаад үнийн ерөнхий түвшинд хяналт тавьж байсан ч тэд зах зээлээс хамаарсан өөрсдийн үнийн жишгийг нэгэнт тогтоосон байв.

Дэлхийн чөлөөт худалдааны зах зээлд борлогдох, хүний эрэлт хэрэгцээг хангах тийм л зүйлүүд худалдааны болон худалдан авагчдын шаардлагад нийцэх учир гар урчуудын ур чадварыг сорих болсон нь ур хийц муутай нь нэгмөсөн зах зээлээс хасагдан, шаардлагад нийцэх бараа таваар нь нийт эзэнт гүрний зах зээлд борлогдох болов.

Худалдаанд нэгдсэн жин хэмжүүрийн систем буй болгох оролдлого хийж, мөнгийг хөрвөх чадвартай болгосноор Алтан ордны зах зээлд, олон орны мөнгө худалдааны эргэлтэд орж байсныг тус улсын нутгаас археологийн судалгаагаар олдож буй олдворууд болон бичгийн сурвалжийн мэдээ гэрчилж байна. Худалдаа хөгжихийн хэрээр худалдааны зам дагуух хотууд маш хурднаар сэргэн хөгжиж худалдааны том төвүүд болохын хирээр алт, мөнгөн зоос цутгаж гүйлгээнд оруулж байв. Зоос цутгаж, дэлддэг төвүүд бий болсон нь их хаадын хяналтад байв.

Зөвхөн Алтан ордон улсын хаадын өөрсдийн цутгуулсан зоос гэхэд л Крым, Булгар, Хорезм, Сарай, Гюлистан, Сыгнак зэрэг хотуудад дэлдсэн 21 хааны нэр бүхий мөн хаадын овгийн тамгатай зоос өнөөгийн судалгаагаар илэрч олдоод байна<sup>2</sup>. Тэдгээр олдсон 47 ширхэг зоосыг мөнгө, зэсээр дэлдсэн байгаа ба нэг ч алтан зоос олдоогүй нь сонирхол татаж байна. Судлаач Б.Нямаагийн цуглуулгад буй зоосноос гадна Алтан ордон улсын Укек хотоос олдсон асар их зоосны цуглуулгад ч нэг ч алтан зоос байхгүй байна. Мөн тэдгээрийн дотор дээрхи хотуудад цутгасан

<sup>1</sup> Гийом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988. т. 112

<sup>2</sup> Б.Нямаа. Монголын Эзэнт Гүрний мөнгө хаадын овгийн тамга УБ., 2005. т. 36-40, 193-210

зоос байхаас гадна Азак, Хорезмд цутгасан зоос ч байна<sup>1</sup>. Алтан ордон улс нь олзны германуудаар алт олзворлуулж байснаараа, орд гэр болон эдлэл хэрэглэл нь алт, мөнгөөр хийсэн байснаараа алдартай байв. Тиймээс алтан зоос байхгүй байгаа нь зоос дэлдүүлэхэд хөрөнгө чинээ хүрээгүйдээ бус тэдгээр нь хаадын зэрэг зиндааг харуулах зэрэглэлтэй өөрөөр хэлбэл, зөвхөн Их хаад л алтан зоос цутгуулдаг байсан болов уу гэтэл зиндаа адил Эл хаан Абака (1265-1282) 2 алтан зоос, Аргун хаан (1284-1291), Гайхату хаан (1291-1295), Байду хаан (1295) Газан хаан (1295-1304), Өлзийт хаан (1304-1316) нар тус тус нэг алтан зоос цутгуулсан байгаа нь тийм бус байсныг харуулж байна. Эсвэл одоогийн судалгаагаар олдоод байгаа нь л тэр байж болох юм.

Монголын нийслэл Хархорин, Маамуу толгойн булшнаас Алтан ордон улсад цутгасан 2 мөнгөн зоос, Алтан ордон нутгаас Мөнх хааны нэртэй зоос олдсон нь худалдаалах цар хүрээ өргөн байсны дээр монгол хаад эх нутагтайгаа холбоотой байсны гэрч юм. Худалдаа нь төв болон бүрэлдэхүүний улсуудын харилцааг илэрхийлж байв.

Алтан ордон улсын зах зээл дээр иперпер, дирхэм, алтан зоос бизанцы, яскот зарим үед цаасан мөнгийг хэрэглэж байсан мэдээ бий. В.Рубрук цаасан мөнгөний тухай өгүүлэхдээ: Мөнх хааны тамга шиг зураас бүхий уртаараа ч өргөнөөрөө ч алга дарам хэмжээтэй хөвөн цаасыг мөнгөний оронд хэрэглэдэг гэжээ<sup>2</sup>. Японы монгол судлаачдын бичсэн Монголын эзэнт улс ба Өрнө дахин хэмээх бүтээлд: Юан улсаас Кибчагийн хаанд бэлэг болгон цаасан мөнгө хүргүүлсэн бөгөөд үүнийг хятадтай хийх худалдаандаа хэрэглэж байсан болов уу<sup>3</sup> гэжээ. Цаасан мөнгө нь авч явахад хялбар алтан баталгаатай учир юуг ч худалдан авч болно гэжээ. Арилжааны хэлбэр байсан ба зарим эд зүйлийг мөнгөөр төлөөлүүлэн наймаалж байв. Орост янз бүрийн үслэг ан, үен, хэрэмний арьс мөнгөний оронд гүйж байжээ<sup>4</sup>.

Олон улсын худалдааг хөгжүүлэхэд дан ганц аюулгүй байдал бус мөн бараа таваарын хангалтыг давхар анхаарсан байв. Эзлэгдсэн орны эдийн засагт худалдааны үзүүлсэн нөлөө харилцан адилгүй. Худалдаанаас авч байсан гааль татвар нь хаадын санд орсон ч эргээд худалдааг тэтгэх, өртөө замын тав тух, аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ худалдаачдад олгох зээл хэлбэрээр санхүүжилт хийгддэг байна.

Монголчуудын эзлэн авч төвлөн суусан нутаг нь байгалийн нөөц баялаг ихтэй, худалдаа арилжаа өндөр хөгжсөн нутаг байсан нь худалдаа,

<sup>1</sup> Л.Ф.Недашковский. Золотоордынский город Укек и его округа. М., 2000.

<sup>2</sup> Гийом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988. т. 180

<sup>3</sup> Монголын Эзэнт улс ба Өрнө дахин. Редактор Сагүчи Тоорү. Хэйбоншя, 1970. т. 276. Т.Мөнхцэцэгийн орчуулгаар авав.

<sup>4</sup> Гийом де Рубрук Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988. т. 181

эдийн засгийг хөгжүүлэхэд чухал бааз суурь болж байв. Монголчуудын эрхшээлд орохын өмнө хэний ч мэдэхгүй байсан улс орнууд худалдаа, эдийн засаг, гадаад худалдаанд идэвхитэй оролцож нийгмийн харилцааны шинэ орчинд дасан зохицож байв. Гэвч худалдааны эдийн засгийн үр шимийг бүгд адил тэнцүү хүртсэнгүй.

Худалдааны зам, олны хөлийн газар ойр байсан хот суурингууд, тэнд амьдардаг гар урчууд худалдаачид худалдаагаар хөлжиж байсан бол алс бөглүү орших тосгоныхон амин зуулгаа залгуулахтай төдий л байсан бололтой. Худалдаанд хүн бүхэн ашиг олж байгаагүй бөгөөд худалдаа арилжаанд хамрагдсан худалдаачдаас Дорно Өрнийг холбохыг өөрсдийн түүхэн хувь заяа гэж үзсэн ойрхи дорныхон л гол ашиг хонжоог олсон билээ.

Үнэхээр зах зээл, эрэлт хэрэгцээ л тухайн үеийн бараа таваарын нийлүүлэлт, худалдан авалт нь тухайн барааны чанарыг тодорхойлж байв.

Эл зөв бодлогын дүнд Алтан ордон улс нь Өрнө, Дорнын худалдааны гол зангилаа төв болсон юм.

Монголын ноёрхлын үед Чингис хааны удмын хан язгууртан нар, орон нутгийн эрх баригчид монголын төрд зүтгэж буй албан хаагчдаас бүрдсэн дээдсийн давхарга бүрдсэн нь тансаг хэрэглээг зүй ёсоор буй болгов.

Энэ нь бичгийн сурвалжуудын мэдээ болон археологийн олдвороор нотлогддог юм. Нэн ялангуяа Сарай ба бусад хотуудыг малтсан археологийн судалгаагаар хот суурин, дотоод гадаад худалдаа, гар үйлдвэрлэл хөгжиж байсны гэрч болох орд харш, байшин барилгын туурь, керамик сав суулганууд, шил вааран эдлэл, гадаад, дотоодоос зөөвөрлөн авчирсан чамин тансаг зүйлс, алт мөнгөн гоёл чимэглэлийн зүйлс, олон орны мөнгө зоос, хүнсний зүйлүүд байсныг илтгэх олон зүйлсийг олжээ<sup>1</sup>.

Худалдаанаас татвар авдаг байсан тухай олонтой тэмдэглэсэн байх боловч ямар хэлбэрээр, хэдий хэмжээний татвар авдаг байсан нь тодорхойгүй юм.

Чухамхүү Алтан ордны үед, түүний худалдааны бодлогын ач үрээр өрнө, дорно, өмнө умрыг холбосон “Торгоны их зам”-ын үйл ажиллагаа бүх талаар өрнөн дэлгэрсэн гэж хэлж болно. Үүнийг батлах баримтыг дурдваас Ижил мөрний дагуух хот суурингаас илэрсэн археологийн материалаар олон орны зоос, барилгын чимэглэл, байшингийн дээврийн пааландсан хэсгүүд, өнгөлсөн гантиг, тоосгоны үлдэгдэл,

<sup>1</sup> Ж.Ж.Саундерс. өмнө дурдсан зохиол, т. 183

Хятадын хоргой торго, мөнгөн эдлэлийн үлдэц, Италийн дархчуудын алтан эдлэл, Ази даяар алдаршсан Венецийн толь, шилэн эдлэл, шүр сувд зэрэг олон зүйлс олдсоор байгаа явдал юм. Оросын археологч Терещенко Сарай хотын туурийг малтаад "...Дөрвөн зүгт 210 сажень<sup>1</sup>, өргөөшөө 5.5 сажень газарт малтлага хийж ихээхэн зүйлийг олов. Үүнд, Өнгөт ба шилэн сав суулга, аяга, бэхийн сав, ширний тасархай, элдсэн шир, зотон (даавуу), торгон эд, шатсан хувцас, хутга, сэлэм, сүх, хайруулын таваг, угаал үйлддэг түмпэн, шилээвэр (дархны шилээгүүр), гал гаргадаг хэт, ширмэн тогоо, зэс аяга, зэс лааны тавиур, нэхмэлийн ясан саваа, хайчны хугархай, түлэгдсэн цаасны үлдэгдэл, хусны холтос, түлэгдсэн хулс, хадаас, дэгээ, хаалганы цуурга, цоож, болон маш олон төрлийн хүнсний зүйл тухайлбал, жигнэсэн талх, арвай, буудай, самар, хушга, бүйлс, үзэм, чавга, дарс хийдэг жимснүүд, цэцэг, чинжүү, вандуй бүр кофе ч байв. Гурван ширхэг чулуун зооринд өнгө бүрийн (хөх, шар, цэнхэр, ногоон, улаан, цагаан) будаг, амгай, хазаар, цулбуур, тах, морины давирхай, зэс хуудсууд, хутга ирлэгч, будаг нухдаг чулуу, зэс утас, зээтүү байв. Эдгээр янз бүрийн зүйлүүд нэг дор байгаагаас харвал энд зах байжээ гэж таамаглаж болно ..." <sup>2</sup> гэж үзжээ.

Зөвхөн Монголын хүчтэй засаглал тогтож, эдийн засгийн чөлөөт бүс бүрэлдэн, замын аюулгүй байдлыг бүрэн хангасны ачаар Алтан ордны гадаад харилцаа урьд байгаагүй эрчимтэй хөгжих болсны дотор бүрэлдэхүүнд байсан улсууд түүний дотроос Оросын эдийн засаг сэргэж худалдаа арилжаа цэцэглэн хөгжиж улмаар Дорно зүгийн олон оронтой харилцах болов. Оросын худалдаачид Алтан ордны дотоодод Ижил мөрний усан замын худалдаанд ноёрхох болсон төдийгүй өрнөдийн Итали, Швед, Герман, Литовтой төдийгүй дорно зүг Монгол, Хятад, Энэтхэг хүртэл худалдаалах болсон нь Оросыг Дорнын ард түмнүүдтэй танилцах үүд хаалгыг нь анхлан нээсэн юм.

Олон улсын худалдаа эрчимжсэний нөлөөгөөр Энэтхэг тоо, лалын одон зурхайн арга барил Өмнөд Азид нэвтэрч, Ойрхи дорнын бичил уран зураг, нэхмэл хатгамлын урлаг, шаазан ваарын урлалд бүхэлд нь Хятадын нөлөө гүнзгий тусчээ. Энэ үеийн ихэнх нээлтүүдийг эрдэмтэд бус эгэл жирийн гар урчууд, ажлын хүмүүс хийж байсан нь энэ үеийн онцлог юм<sup>3</sup>.

Алтан ордны нутагт Итали, Сири, Энэтхэг, Хятад зэрэг өрнө, дорнын олон орны үнэт эдлэл болон өргөн хэрэглээний бараа таваар их хэмжээгээр борлуулагдаж байсан нь археологийн малтлагаар илэрч

<sup>1</sup> Сажень- эртний Оросын уртын хэмжүүр. 1 Сажень нь 32 вершок. Вершок нь 4.4 см.

<sup>2</sup> А.Якубовский. Золотая орда. с. 110

<sup>3</sup> М.Правдин. Чингис хааны өв. УБ., 2005. т. 242

олдож буй олдвороос тодорхой харагддаг бөгөөд тэдгээр нь гадаад худалдааны хамрах цар хүрээ өргөн байсныг харуулж байгаа юм.

Үүний хамт Алтан Ордны эдийн засаг сэргэн хөгжихөд нөлөөлсөн гол хүчин зүйл бол Ази, Европын дайнаар монголчуудын олзолсон хүмүүсээр олборлуулсан алт, эрдэнэс, дайны олз, алба татвараас олсон орлого нь хаад ноёдын болон улсын хэрэгцээг хангахын зэрэгцээ тухайн нутаг орныхоо бүтээн босголт, засаг захиргаа, хүн амын зардал сүйтгэлд шингэж эдийн засгийг сэргээхэд нэмэр болдог байсан байна. Тухайлбал, шинэ шинэ хот сууриныг барьж байгуулах, тус орны улс төр, эдийн засгийн гол гол төвүүдийг холбох өртөө замуудыг барьж байгуулах, тэнд ажиллах хүмүүсийн нийгмийн асуудлыг давхар шийдэх, албаны болон худалдааны хүмүүсийн аюулгүй байдлыг хамгаалах харуул хамгаалалтын зардал зэрэгт эргээд зориулагдаж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Гэвч монголчуудын ноёрхлын сүүл үе буюу XV зуунд Алтан ордон, Эл хаад, Цагадайн улсуудын хоорондын болон дотоодын улс төрийн тогтворгүй байдал нь худалдааны замын тогтвортой байдлыг алдагдуулах болсон нь худалдаалах өөр арга замуудыг хайх болгов.

## 9. АЛБА ТАТВАР

Монголын эзэнт гүрний алба татварын тогтолцоо болон түүнийг хэрхэн бүрдүүлж байсан талаар харьцангуй бага судлагджээ. Ер нь аливаа улсын сан хөмрөгийг бүрдүүлэх гол хэсэг нь татвар юм.

Өмнөх үеийн түүх бичлэгт татварын тогтолцооны тухай бараг судлаагүй атлаа нүүдэлчдээс дарлал мөлжлөгөөс өөр юуг ч өвлөж аваагүй, тэд дааж давшгүй татварын бодлогоор дарамталж, ард түмнийг үгүйрүүлэн хоосруулж, аж ахуйг нь сүйрүүлж, улсын хөгжлийг олон зуун жилээр хойш татсан гэх мэт зүйлийг улиг болтол давтаж, дуу дуугаа авалцан санал нэгтэй бичиж байсан нь ангич хандлагын тусгал байлаа.

Монголын эзэнт гүрний түүхийг судлагчид Их гүрний нийт хүн амын цөөн хувийг монголчууд эзлэдэг байсан тухай ямагт бичдэг. Тэгвэл тэр цөөнх дааж давшгүй татвараар дарамтлах аваас эзлэгдсэн орны ард түмэн эсэргүүцэн босч, монголын ноёрхлыг даруй түлхэн унагах байсан нь ойлгомжтой хэрэг.

XIII зууны Монголын эзэнт гүрэн нь өөр бусад улсуудад эрхшээлээ тогтоож, алба татварын тогтолцоог бүрдүүлэхдээ эзэлж авсан орныхоо онцлогийг нарийн харгалзан үзэж байсан тэр л зарчмыг Алтан ордон улсад хэрэгжүүлжээ.

Алба татварын тухай өгүүлэхдээ алба татварын ямар тогтолцоог монголчууд Алтан ордон улсад тогтоов, тэр нь тухайн ард түмний амьдралд хэрхэн нөлөөлөв гэдэг асуудал чухал байрыг эзлэнэ.

Харамсалтай нь алба татварын тухай тодорхой мэдээ баримт хомс, цэгцтэй судалгаа харьцангуй бага байгаа нь бидний судалгаанд бэрхшээл учруулж байгаа боловч түүх сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн хэсэг бусад мэдээ баримт нь уг асуудлын тоймыг гарган тавих боломж олгож байна.

Алтан ордон улсын эрх баригчид Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний нэг хэсгийн хувьд эзлэн авсан улс орнууддаа Өгэдэй хааны зарлигаар хуульчлан тогтоосон аравны нэг хувийг татварт авах тэр л зарчмыг баримтлаж, алба татварын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлжээ.

Монголын засаг захиргааны нэгж нь аравтын тогтолцоо, татвар хураах хэмэлсэн хэм нь аравны нэг гэдэг зарчим баримтлав.

Оросын хотуудыг байлдахдаа ч монголчууд энэ л шаардлагаа тавьж, байлдалгүйгээр эд хөрөнгийнхөө аравны нэг хувийг өгөөд өөрийн хотоо хэвээр захирах болзлыг Оросын вангуудад тавьж байв.

Монгол цэргийг явж өнгөрөнгүүт тооллогын хүмүүс ирж тухайн бүсийн хүн, малын тоо болон эд хөрөнгийнх нь хэмжээг бүртгэн авч эзэлсэн газар бүрийнхээ тухай маш дэлгэрэнгүй мэдээллийг эргэж явуулдаг байв<sup>1</sup>

Юуны түрүүнд татвар ноогдуулах үндсэн нөхцөл болсон хүн амын тооллогыг Ордын засаг захиргаа нийт улс даяар явуулав.

Алтан ордон улсад монголын хаад бүх нийтийг хамарсан тооллогыг гурван удаа явуулжээ. Эхнийх нь Бат хааны улсаа төвхнүүлж байх үе буюу 1240-өөд оны сүүл, хоёрдахь нь Бэрх хааны үе буюу 1257 он, Мөнхтөмөр хааны үе буюу 1272<sup>2</sup> онд хүн амын тооллогыг явуулжээ. Оросын түүхэнд Алтан ордон улсын хаад 2 удаа бүх нийтийн тооллого явуулсан гээд сүүлийн хоёр тооллогыг нь албан ёсоор дурддаг юм. Бид гурван удаа хэмээн цохож буй нь Бат хаан анх улсаа байгуулаад алба татварын тогтолцоог бүрдүүлэхдээ ямар ч байсан нарийн тодорхой хийж чадаагүй юмаа гэхэд татвар оногдуулах чиг баримжаа авах хэмжээний тооллогыг хийсэн болов уу гэж бодож байна. Дайлах цэрэг явж өнгөрөнгүүт тооллогын хүмүүс ирдэг байсан тухай дээрхи мэдээ ч үүнийг нотлон харуулж байна. Түүнээс хойш бүх нийтийг хамарсан тооллого хийгдээгүй нь татвар хураах тогтолцоонд өөрчлөлт орж, татварыг монгол баскак-даргач нар бус Оросын вангууд өөрсдөө хураах болсонтой холбоотой. Энэ талаар хойно дэлгэрэнгүй өгүүлнэ.

Хүн амын тооллогыг ч тухайн улсын онцлогт нь тохируулж явуулж байсан байна. Тухайлбал, Хятадад хүн амын тооллого хийж татвар оногдуулах нэгжийг өрхийн тэргүүнээр тооцож, нэг өрхөд оноож байсан бол, Алтан ордод тооллогыг өрхийн бүх хүнийг тоолж, хүн нэг бүрээр тооцож татвар оногдуулж байв.

Алтан ордон улсын татварын анхны тогтолцоог эмхлэн бүрдүүлсэн Бат хаан Орос орноос авах алба татварт заагтай хандаж байжээ. Үүний баримт нь Оросын он дарааллын бичгүүдэд тэмдэглэснээр Бэрх хаан суусны дараах жил буюу 1257 онд Алтан ордны хүн амын бүх нийтийн хоёрдахь тооллогыг хийжээ. Уг тооллогоор урьд нь хэзээ ч хамрагдаж байгаагүй Новогородыг тоолох шийдвэр гарч үүнд дургүйцсэн хотынхон бослого гаргасан тухай тэмдэглэснээс мэдэж болно.

Оросын хойт зүгийн ванлигуудаас 20 шахам жилийн хугацаанд татвар аваагүй атлаа өмнөд Оросын ванлигуудаас авч байжээ. Энэ нь

<sup>1</sup> Жек Ведерфорд. Дурдсан зохиол. т. 160

<sup>2</sup> Ю.В.Мизун. Дурдсан зохиол. стр. 305-306

өмнөд нутгаас хойд нутаг руу нүүн шилжигсдийн тоог эрс нэмэгдүүлсэн ба улмаар газар хүрэлцэхгүй болж ой огтлон цэвэрлэж, тэдгээр шилжин ирэгсэдэд газар олгож байсан байна<sup>1</sup>. Татвар авч байгаагүйн баримт нь 1257 оны тооллогоор урьд нь хүн амын тооллого хийж байгаагүй Новгородчуудыг тоолж татвар оноох болсныг эсэргүүцэн бослого гаргаж байсан тухай мэдээ байна.

Бат хааны татварын энэ бодлого нь оросын хүн амын шилжилт хөдөлгөөн, суурьшилд ч нөлөөлж, зарим судлаачдын үздэгээр ирээдүйн Москвагийн вант улсын хүн амыг нэмэгдүүлэхэд чухал түлхэц болжээ.

Харин Хойт Оросын нутгаас татвар аваагүй талаар ямар нэгэн тайлбар, шалтгааныг хэн ч дурдсангүй. Магадгүй Бат хааны өөрийн улс төрийн байр суурьтай холбоотой ч байж болох юм. Гүюг хааны зүгээс ирж болзошгүй аюулаас сэрэмжлэн, Оросын Ярослав ван түүний хүү Александр нартай сайн харилцаатай байж бие биедээ цэрэг, зэвсгийн тусламж үзүүлж байсан билээ.

Бат хааны үед хот, хотод баскак-даргач нарыг томилон суулгаж байсан ба бүх даргач нарын асуудлыг эрхэлсэн Их даргач Владимирийн вант улсад төвлөрөн сууж байв. Баскакууд хэмээх даргач нар нь зөвхөн татвар (дань) авах үүрэгтэй бус бас янз бүрийн алба, тухайлбал цэргийн, өртөөний зэрэг албыг алба гүйцэтгэгчид хэрхэн гүйцэтгэж буй болон орон нутгийн эрх баригч ноёдын үйл ажиллагааг хянах үүргийг давхар гүйцэтгэж байжээ.

Татвар хураагч баскакуудын аюулгүй байдал, эрх мэдлийг Ордын цэргийн анги хангаж байв. Тэрхүү цэргийн ангийн удирдагч нь Ордын захиргаанаас томилогдсон монгол хүн байх ба бүрэлдэхүүнд нь харь орны, мөн орос хүн байхыг ч зөвшөөрч байв. Хааны ордны их баскак Буга татвар хураахдаа өөртөө таалагдсан бүх юмыг авч байсан ба тэр дээрэмчдийн цэргийн бүлэгтэй явдаг байснаас хэн ч эсэргүүцэх боломжгүй байв гэсэн нь дээрхи мэдээг давхар батлаж байна.

Залхаан цээрлүүлэх буюу дарангуй цэргийн бүрэлдэхүүнд ихэвчлэн харь орны хүмүүсийг оруулдаг байсан нь тэдний гүйцэтгэх үүрэгтэй нь холбоотой юм. Тэд хүний нутагт тал тохой татахгүй, хуйвалдахгүй, эсэргүүцэл, хөдөлгөөнийг дарахад сэтгэл хоёрдох, хайрлах садан төрөлгүй учир босогчдод хайр найргүй ханддагтай нь холбоотой байлаа.

Бэрх хааны үеэс Батын тогтоосон алба татварын тогтолцоонд өөрчлөлт оржээ. Бэрх хааны шийдвэрээр 1257 онд Новгородыг тоолж татвар оногдуулах болсныг эсэргүүцэж бослого гарсан тухай өмнө дурдсан. Бослогын эцсийн үр дүн нь юу болохыг сайн мэдэх

<sup>1</sup> Ю.В.Кривошеев. Русь и монголы. СПб., 2003. стр. 182-183

хүний хувьд уг бослогыг Александр Невский өөрөө намжаан даржээ. Александр Невский өөрийн биеэр Ордод очиж, Бэрх хаанд бараалхан татвар хураах талаар санал тавьж тохиролцоонд хүрчээ. Энэ нь Оросын вангууд өөрсдөө алба татвараа хурааж, Алтан ордонд хүргэж өгч байх түүнд нь Александр хяналт тавих санал байжээ. Үүнийг нь Бэрх хаан зөвшөөрсөн байна.

Гэвч Александр энэ ашигтай саналынхаа үр шимийг үзэж чадаагүй бололтой. Учир юу гэвэл хоёрдахь хүн амын тооллогоос хойш Александр 1257, 1292 онд 2 удаа Ордод очсон бөгөөд бослого дарсны дараа санал тавьсан гэж үзвэл 1257 он байж болох боловч тохиролцоонд хүрээд Ордоос буцаж явах замдаа гэнэт нас барсан гэсэн мэдээнээс үзвэл, сүүлийн очилт буюу 1292 он байж болох юм. Гэвч Бэрх хаан 1266 онд нас барсан тул 1257 оноос өөр он байх боломжгүй байна. Мөн 1262 онд Монголын эзэнт гүрний төвд гарсан хямралыг далимдуулан Ростов, Владимир, Суздаль, Переяславль, Ярослав зэрэг вант улсуудад монголын баскакуудыг эсэргүүцсэн бослогууд удаа дараа гарсан тухай мэдээ буй нь тэр хүртэл баскакууд байсныг харуулж байна. Мөн XIV зуунаас баскакын системийг хүчингүй болгосон тэмдэглэл бас байна. Тэгвэл магадгүй Владимерын вант улсад баскакын системийг үгүй болгон туршилт хийгээд дараа нь нийт орон даяар хэрэгжүүлсэн ч байж болох. Энэ өөрчлөлт нь цаг хугацаа шаардсан ажил байсан бололтой.

Баскакын тогтолцоог байхгүй болгосноор Ордоос Орос оронд тавих хяналт суларсан гэж судлаачид үздэг.

Бэрх хаан чухам юуны учир Александртай тохиролцоо хийж ийм шийдвэр гаргасан нь тодорхойгүй боловч олон хотуудад баскакуудыг суулгаж цалин хангамж олгох нь нүсэр дарамттай байсны дээр татвар хураах нь байнгын эсэргүүцэлтэй тулгардаг төвөгтэй ажил учир эсэргүүцэл тэмцлийг намжаах үүднээс чухам тийм тохиролцоонд хүрсэн ч байж болох юм.

Оросын вангууд өөрийн харьяат албатаас татвар хурааж, Алтан ордны нийслэл Сарайд хүргэж өгдөг албатай болжээ.

Түүнийг нь Ордынский выход хэмээн нэрлэдэг байжээ.

Оросын он дарааллын бичгүүдэд Батыг “сайн хаан” хэмээн тэмдэглэдэг бол Бэрхийг таалал төгсөхөд хүнд хэцүү үе дуусгавар боллоо гээд харин Узбек хаан өргөмжлөгдсөн үеэс татвар хураалтын байдалд өөрчлөлт орсон байна.

Монголын баскакууд татвар хурааж байх үед бус харин түүний дараах үеэс татвар хураалтын байдал хүндэрч ирсэн бололтой байна. Оросын вангууд татвараа хураах болсон эхний үед хүн амын тооллого эсэргүүцэл тэмцэлгүй байсан тухай тэмдэглэсэн боловч тэр тааламжтай

үе нь удаан үргэлжилсэнгүй.

Тверь мужаас Ордод төлөх алба гувчуурыг Юрий ван мэдэх болж татварт хураасан эд баялагийг Ордод хүргэж өгөхийн оронд Новгородын худалдаачдаар заруулж завшсан хэрэг гарсан бөгөөд түүнийг нас нөгчсний дараа орыг нь залгамжилсан дүү Иван нь 1331 онд Ордоос зарлиг авахад ахынх нь идэж шамшигдуулсныг нь нөхөн төлөх үүрэг өгөв. Түүний эцсийн үр дагавар нь татвар төлөгчдөд хүндээр тусчээ. Мөн “Мөнгөний хүүдий” хэмээн нэрлэгдэх болсон Иван Калита алт, мөнгөөр Алтан ордон улсын хаадаас вангийн зарлигийг худалдан авахыг анхлан буй болгожээ. Энэ явдал үлэмж газар авсан нь мөнгө ихээр цуглуулсны хүнд ачаа нь эцсийн дүндээ мөн л ард түмэнд оногдож байв. Оросын вангууд хүү нь эцгээсээ улсаа захирах эрхийг өвлөн авах явдал Орос орон Алтан ордон улсын вассал болсон үеэс эцэс болж гагцхүү Алтан ордон улсын хаанд бэлэг сэлт барин очиж өвдөг сөгдөн үнэнч зүтгэхээ андгайлан байж өрсөлдөөний дундаас тэрхүү улсаа захирах эрх олгосон зарлигийг авдаг болов. Хэнд улс захирах вангийн зарлиг өгөх нь тухайн хааны үзэмжээс хамаарах ба тэр нь өөртөө үнэнч зүтгэх эсэх, өгсөн хөрөнгө мөнгөний хэмжээ зэргээс хамааралтай байв.

Тухайн үед Оросууд Алтан ордон улсын хаадаас зарлиг авах гэж өрсөлддөг болжээ.

Зарлиг нь эрх зүйн хувьд ямар байсан бэ? гэвэл түүнийг авснаар нэгд, улсаа захирах, хоёрт, өөрийн эзэмшил нутгийн улсын албатаас алба татвар авч өөрийн биеэр буюу Владимирын вангаар дамжуулан Ордод хүргэх эрх, үүргийг давхар хүлээж байв.

Оросын вангууд зарлиг авахын төлөө ширүүн өрсөлдөж хаанд бэлэг сэлт өгч байсан нь хожим заавал төлөх төлбөр болон хувирсан байна. Алба татвар нь цаг хугацаандаа, тогтоосон хэмжээндээ ирж л байвал ордын хаад санаа амар байж татварт тавих хяналтыг сулруулснаас замаас нь идэж шамшигдуулах ард олноос татварын хэмжээг нэмэгдүүлж авах зэрэг гажуудал буй болсон нь татвар төлөгчдөд дарамт болов. Иван Калитаг мөнгөний хүүдий, мөлжигч, шунахай гэж ард олон зүйл бүрээр нэрлэх болжээ. Үүний гэрч нь тэрбээр эцсийн зорилгоо Орос улсаа мөнгөөр ч болов хамаагүй нэгтгэнэ гэж мэдэгдэж байсан явдал юм. 1332 онд Иван Калита Владимирын болон Ижилийн орчмыг захирах зарлиг, 1335 онд Иван мөн Дмитров Углиц мужийн вангийн эрхийг, дараа нь Галицийн, Белозёрын вангийн эрхийг тус тус худалдан авсан ба эд мөнгөний хохирлоо нөхөхийн тулд Новгород болон эрхшээлдээ оруулсан газруудын ард иргэдээс татварын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэн нь ширүүн эсэргүүцэлтэй тулгарч байсан баримт Оросын

түүхэнд үлджээ. Энэ нь Оросын вангуудад үлгэр дууриал болж дараа дараагийн вангууд мөн өрсөлдөж худалдан авсаар зарлигийн үнэлэмж ч буурахад хүргэжээ. Алба татварын энэхүү тогтолцоо Алтан ордон улсыг унах хүртэл хэвээр үргэлжилжээ.

Харийн ноёрхлоос чөлөөлөгдөхөд Москвагийн ван монголчуудын буй болгосон татварын тогтолцоо, цэргийн албан хаах үүргийг хэвээр нь үлдээснээс<sup>1</sup> үзэхэд уг тогтолцоо нь тухайн оронд зохицож байсан төдийгүй татварын хэмжээ нь ч боломжийн байсан нь ойлгомжтой. Эсэргүүцэл тэмцэл дэгдэж, хүнд хүчир дарамт учруулах болсон нь татвар хураалтын хэмжээ, хураах арга хэлбэрт л хамаг хэргийн учир оршиж байжээ.

Тухайн үед Алтан ордон улсад татвар төлөгчид нь хотын оршин суугч гар урчууд, худалдаачид, хөдөөд тариачид байв.

XIV зууны дунд үеэс өмнөд Орост хөдөөгийн оршин суугчдыг христiane буюу крестьяне хэмээн нэрлэх болсон ба тэдгээр нь хөдөөгийн хүн амын гол цөмийг бүрдүүлж байв. Петр Струвегийн бичсэнээр энэ нэр томъёог сүм хийдийнхэн гаргаж ирсэн байна Христiane гэдэг үгийг газар тариаланч гэсэн утгаар анх хэрэглэсэн баримт нь хамба лам Киприанаас гэгээн Константины сүмд (1391 он) олгосон жуух бичигт байдаг. Сүм хийдийн газар түрээслэгчдийг анхандаа христiane хэмээн нэрлэж байсан ба тэдний хүн амд эзлэх хувь богино хугацаанд өссөнөөр хожим тариалан эрхлэгчдийг нийтэд нь нэрлэх болсон байна. Үүнд, монгол хаадуудаас сүм хийдүүдийг алба татвараас чөлөөлж, бас удаа дараа олгож байсан хөнгөлөлтүүд нь дээр дурдсан христiane-уудын тоо өсч, нийгмийн бүхэл бүтэн давхарга болон өсөж бэхжихэд нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Монголын эрхшээлийн эхэн үед сүм хийдийн тоо 30 байснаа түүхийн харьцангуй богино хугацаанд 150<sup>2</sup> болтлоо өсч, тэдний мэдэлд ажиллах христiane тоо болон газрын хэмжээ нь ч үлэмж нэмэгджээ.

Монголын ноёрхлын өмнө Дорнод Орост жижиг газар эзэмшигчид байсан хэдий ч монголын эрхшээлийн үед тоо нь цөөрч зарим нь вангийн ордныхны бүрэлдэхүүнд орж үлдсэн нь жирийн тариачид болж газар тариалангийн хөгжил буурсан гэж үздэг. Энд нэг зүйлийг анзаарахад нөгөө “Хорогдсон” хэмээх жижиг газар эзэмшигчид нь татварын шинэ тогтолцоонд зохицон, улсын албат болж татвар төлөхөөс зайлсхийж, түүний оронд газартайгаа аль нэг вангийн буюу сүм хийдийн мэдэлд харьяалагдсан байж болох юм. Нөгөө хорогдож доройтсны шалтгаан үүний цаана нуугдаж байж болох аж. Үүнийг

<sup>1</sup> Г.В.Вернадский. Дурдсан зохиол, т. 73

<sup>2</sup> Мөн тэнд.

цаашид нухацтай шинжлэн үзэх нь зүйтэй мэт санагдана.

Сүм хийдийн эзэмшил газраас гадна өөр гурван төрлийн газар дээр тариачид амьдарч байв. Нэгд, Хар газар буюу татварт хамрагддаг улсын газар, хоёрт, ордныхны газар буюу улсын татварт хамрагддаг, гуравт, Алба хашдаг ван ноёд, тайж язгууртнуудын газар эзэмшилд суудаг тариачид<sup>1</sup> гэж байжээ.

Монголын эрхшээлийн үед сүм хийдийн болон бусад газар дээр ажилладаг тариачдын статус нь ялгаатай байжээ. Сүмийн хийдийн тариачид зөвхөн сүмдээ л татвараа өгөхөөс цэргийн алба гэх мэт бусад албанаас чөлөөтэй байв. Нөгөө бусад тариачид нь улсын алба төлж, цэргийн алба хааж байв. Тариачид мөн ургацынхаа аравны нэг хувийг татвар өгнө.

Монголын ноёрхол унасны дараа онцгой эрх, хөнгөлөлт үзэж байсан сүм хийдийнхэн энэ эрхээ баталгаажуулахын тулд Москвагийн их ванд ханджээ. Гэтэл их ван зарим хөнгөлөлт үзүүлсэн боловч анжисны зэрэг зарим татварыг бага хэмжээгээр оногдуулжээ. Цаг хугацаа өнгөрөх тутам Москвагийн их вангийн эрх мэдэл өсч, сүм хийдийн эрх дарх буурч, сүмийн тариачид онцгой ялгагдах зүйлгүй болжээ.

Тухайн улс орнуудын эрхлэх аж ахуйн онцлогийг харгалзан татвар оноож байсан ба шинээр янз бүрийн татваруудыг ч буй болгожээ.

Орос үслэг эдлэлийн, Кавказын улсуудад дарсны, Хятадад цагаан будаа, нүүдэлчдэд малын татварыг тус тус онооно.

Татварыг газраас анжиснаас авч байсан ба түүнээс гадна загас барих, ан агнах, зөгийний үүр тутмаас гааль (пошлина) авч байв. Мөн худалдаанаас гааль (пошлина) авна. Худалдаанаас авч байсан гаалийг тамга гэж нэрлэж байв<sup>2</sup>. Оросын түүхэнд Новгороддыг тоолоод татвар авахаар ирсэн баскакууд нь аравны нэг (десятина) ба тамга гэдэг татвар авахаа мэдэгдсэн байна. Бүтээгдэхүүний аравны нэгийг авах татвар нь бидэнд ойлгомжтой байсан ба харин тамга гэдэг татварыг огт мэдэхгүй байсан гэжээ. Судлаачдын үзэж байгаагаар тамга нь худалдаанаас авах гаалийн татвар байсан бололтой. Үүнийг судлаачид тайлбарлахдаа анх малын худалдаанаас гаралтай байж болох юм гээд агт морь зарахдаа тамгаар нь ялган тэмдэглэж, тэр нь төдий хэмжээний агт зарсан хэмээн баримжаа авдаг байснаас тамга гэдэг татвар үүсч, хожим гар урчууд ч худалдааны пүүсүүд ч өөрийн худалдааны тэмдэг буюу тамгатай байсан нь үүнтэй холбоотой байж болох юм.

Хүн амын тооллогод тулгуурласан татварын тогтолцоо Бат хааны

<sup>1</sup> Ю.В.Кривошеев. Русь и монголы. СПб., 2003. стр. 185.

<sup>2</sup> Дж.Феннел. Кризис средневековой Руси. 1200-1304. М., 1989. стр. 158

үндэслэсэн Алтан ордон улсын засаг захиргааны зохион байгуулалт нь монгол хаадад ихээхэн ашиг өгч байв. Их ван бүр мөнгө төгрөг, алт, мөнгөн эдлэл, арьс үс, мал хунараар алба татвар цуглуулах ёстой байсан бөгөөд ноёд бие биеэ хардаж сэрдэн хов зөөх нь их тул их вангаас юу ч далдалж үл чадна<sup>1</sup> гэснээс татварт авч байсан зүйлүүдийг мэдэж болно.

Татварыг баскакууд буюу даргач, вангийн төлөөний тусгай түшмэлүүд (чиновники-данщики), гаальчид хурааж байжээ. Хотын гар урчууд, худалдаачдаас бүтээгдэхүүний болон орлогын аравны нэг хувиар татвар авна.

Алба татварыг Орон нутгийн мөнгө зоос, эсвэл бүтээгдэхүүнээр хураана. Аж ахуйгаас авах алба татварыг оноохдоо тухайн татвар төлөгчийн эрхэлж буй аж ахуйн онцлогийг харгалзан үздэг бол хүн амын татварыг (подушные подати) өрхийн хүн нэг бүрээр бодож авдаг байв

Алтан ордон улсын эрхшээлд орсон нүүдэлчдээс ямар татвар хэдий хэмжээгээр авч байсан тухай мэдээ баримт хомс боловч Эзэнт гүрний бусад бүрэлдэхүүн улсуудын нэг адил мөн малаар алба татвар авахдаа мөнөөх аравны нэг гэдэг зарчмаа баримталж малаар авч байсан болов уу?

Татвар төлөгч нь олон тооны татварыг санд төлж байв. Хэдийгээр бүрэн бус ч Сарай болон Крымын хант улсын зарлигаас зарим зүйлийг мэдэж болно. Крымын Сагиб гирейн зарлигт 13 төрлийн алба татварын тухай дурдсан боловч нэлээдийг нь ямар татвар байсныг нь болон хэмжээг нь тодруулах боломжгүй байна. Үүнд, 1. Ясак, 2. клан, 3. салыг, 4. кулуш, 5. култыка, 6. бач, 7. худалдааны татвар (харадж, хараджат), 8. тосгоны татвар сала харадж, 9. газрын татвар (ерь-хылясы), 10. подать с трубы (өрхийнтатвар), 11. хүнсний (сусун), 12. фураж - малын тэжээл (гулюфэ), 13. постой<sup>2</sup>

Татвараас монголын буюу оросын вангуудад гавьяа байгуулсан дарханууд чөлөөлөгдөж байсан нь "Тарханные ярлыки" хэмээх жуух олгож байснаас харж болно<sup>3</sup>.

Алтан ордон улсын татварын тогтолцоог аваад үзэхэд эрх баригчдаас гаргасан зарлиг хуулийг хэрэгжүүлэгч орон нутгийн түшмэл, тухайн вассал улсын эрх баригчид нугалан хөсөрдүүлж, хүндрүүлж байснаас бус бүгдийг цөлмөн авах дээрмийн шинжтэй байгаагүй болох нь баримтаар харагдаж байна. Өөрөөр хэлбэл, төгс бус байсан ч тухайн орон нутагт зохицсон байсан нь хожмын үйл явдлаас харагдана. Түүний дээр Алтан

<sup>1</sup> Б.М.Правдин. Дурдсан зохиол. т. 274

<sup>2</sup> М.Худяков. Очерки по истории Казанского ханства. М., 1991. стр. 211-212

<sup>3</sup> А.П.Григорьев. Дурдсан зохиол

ордон улс унасны дараа өв залгамжилсан улсууд, тухайлбал Оросын, Крымийн, Астарханы улсууд ч монголчуудын буй болгосон татварын системийг тэр чигээр нь өвлөн авсан төдийгүй хэмжээг нь нэмж байсан нь боломжийн тогтолцоо байсныг харуулж байна. Мөн Оросын вангууд зарлиг авахаар өрсөлдөхдөө татварын хэмжээг нэмэгдүүлж, илүү татвар олж ирнэ гэх буюу алт, мөнгөөр худалдан авч байсан нь татвараас гадна нөөц боломж их байсныг харуулж байгаа бус уу

Оросын түүхэнд монголчуудын тогтоосон татварын тогтолцоо нь дээрмийн шинжтэй байж, Орос орныг цөлмөн үгүйрүүлсэн гэж үзэх нь асуудалд өрөөсгөл хандсан хэрэг юм.

Харин цаг хугацаа өнгөрөх тутам албан тушаалаа ашиглах, татварыг бөөнөөр нь бэлнээр төлчихөөд жижиглэнгээр ард иргэдэд оноохдоо өсгөөд авчихдаг байсан шунахай авилгач нарын буруутай үйл ажиллагаанаас эсэргүүцэл хөдөлгөөн гарч байв.

Монголын эрх баригчид орон нутгийн удирдлагаас гарч буй мэдээллийг цаг алдалгүй чадварлаг ашиглан, цаг тухайд нь санхүүгийн болон татварын өөрчлөлтийг уян хатан хийж байсан нь тэдний Оросын уудам нутагт удаан хугацаагаар оршин тогтох үндэс болж байв.

## 10. ГАР УРЛАЛ

Монголын ноёрхлын үед нийгмийн янз бүрийн давхаргууд чөлөөт худалдаа, үйлдвэрлэлд оролцож хэн юу чадахаа хийж худалдаа арилжаанд оролцох бололцоо нээгдсэн нь аажмаар эдийг засаг сэргэн хөгжих нөхцлийг бүрдүүлэв. Үүнтэй холбоотойгоор гар урлалын хөгжил эрс дээшлэв.

Тэр үеийн гар урчуудын давхарга нь Дундад Ази, Кавказ, Крым, Орос зэрэг орнуудаас дайн байлдаанаар олзлогдогсод болон сайн дураар ирсэн чөлөөт иргэд, мөн гарын ур дүй сайтайгаараа цэргийн хүнд хүчир албанаас чөлөөлөгдөгсөд, уугуул нутгийн урчууд болон нүүдэллэн ирэгсэдээс бүрдэж байв. Тэдгээрийн дотор монгол гар урчууд ч байв.

Гар урлалын үйлдвэрлэл нь мэргэжлийн болон гэр зуурын гэсэн хоёр түвшинд явагдаж байсан байна. Мөн төрийн хяналт дор мөнгө зоос цуглах, дэлдэх гар урчууд байв. Хуурамч зоос үйлдэж гүйлгээнд гарахаас сэргийлж тэдний ажиллагаанд хатуу хяналт тавьдаг байжээ.

Арьс, шир, үслэг эдлэлийг боловсруулж худалдаанд гаргах болон өөрсдийн хэрэглээний хувцас хэрэглэлийг үйлдэх нь Алтан ордны хэмжээнд нэлээд чухалд орж байв. Учир нь хүн амын нэлээд хувийг уугуул болон нүүдэллэн ирсэн нүүдэлчид эзлэж байсан бөгөөд тэд эрхэлж буй мал аж ахуй болон ан гөрөөнөөс олсон арьс шир, ангийн үсийг боловсруулж байсан учир түүнийг боловсруулах гар урчууд нэлээд хувийг эзлэж байв.

Ангийн үнэт үслэгийг тэр чигээр нь зарж арилжих буюу заримыг нь тодорхой хэмжээний боловсруулалт хийгээд зардаг байж.

Малын болон үнэт ангийн арьс үсээр хувцас хэрэглэл урлаж байв. Үнэг, булган дах, малгай, шилүүс, ирвэс, мануул, туулайн арьсаар хаадын дээл хувцас урлаж, адууны ширээр маш сайхан гутал хийнэ. Эдгээр ажилд мэргэшсэн гар урчууд нэгэнт буй болсон байв.

Монголчууд арьс шир идээлэх, боловсруулах тогтсон технологитой байсан бөгөөд бэлэн болсон бүтээгдэхүүнээ өнгө будганд оруулж цэргийн болон өргөн хэрэглээний эдлэл хэрэглэл, хувцас хунар хийдэг байв. Тухайн үед Монгол нутгаар явсан жуулчдын тэмдэглэлд Бат, Бэрх нарыг улаан хүрэн зогой арьсан гуталтай, эрднийн чулуу шигтгэж алт

мөнгөөр чимэглэсэн алтан бүстэй байсныг тэмдэглэсэн байдаг.

Дээр дурдагдаж буй алтан бүс, улаан хүрэн өнгийн гутал хоёр нь бидний анхаарлыг татсан юм. Учир юу гэвэл Их Монгол улс болон Монголын эзэнт гүрний хаадын оршуулга, эдлэж хэрэглэж байсан зүйл энэ хэр хараахан олдоогүй байгаа. Гэвч ховор боловч монгол нутгаас олдоод байгаа тэр үеийн монгол язгууртнуудын булшнаас дээрхи мэдээнд дурдсантай адил зүйл бодитоороо олдсон явдал юм.

Алтан бүсний тухайд гэхэд л Монгол болон Алтан ордны нутгаас археологийн малтлагаар олдож буй нэлээд хэдэн алтан бүснүүд нь монгол язгууртнууд алтан бүс хэрэглэж байсан бичгийн мэдээг давхар батлахын зэрэгцээ алт мөнгөний дархны ажил нэлээд өндөр төвшинд хүрснийг гэрчилж байгаа юм. Улаанбаатар хотын ойролцоо орших Сонгино хайрхны Дадарт уулын ойролцоогоос археологич Д.Навааны олсон болон Алтан ордон нутгаас олноор олдсон алтан бүс нь үүний нэг нотолгоо юм. Гэхдээ Монгол нутгаас олдсон алтан бүсний хийцээс Алтан ордон улсаас олдсон алтан бүсний хийц илүү чамин байгаа нь гар урлалын хөгжлийн төвшин, олон орны урчуудын оролцоотой холбоотой.

Археологийн судалгаагаар илрүүлсэн Алтан ордны хаад язгууртнуудын алт, мөнгөн гоёл чимэглэлийн зүйлс, үнэт эрднийн чулуун зүүсгэл, сав суулга, алтадсан дуулга, илд зэрэг нь Алтан Ордны гар урчуудын бүтээл төдийгүй харь улсын хаад язгууртнуудаас бэлгэнд ирүүлсэн эд зүйлс ч байв.

Тэдгээр зүйлсийн хийц, урлагийн шийдлийг харахад гар урлал дээд зэргээр хөгжиж байсныг илтгэхээс гадна олон орны соёлын харилцан нөлөөллийг харж болно.

Алтан бүсний тухайд Монгол болон Алтан ордны нутгаас адилхан олдсон бөгөөд харин хийцийн хувьд Алтан ордноос олдсон алтан бүс нь монгол нутгаас олдсон бүснээс ур сайтай, хийцний хувьд чамин байсан нь цаг хугацааны хувьд арай хожуу болохын дээр, гар урлалын хөгжлийн түвшний ахиц, харь улс орны гар урлалын нөлөө туссантай холбоотой юм.

Монгол улсын Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших Цагаан ханангийн агуйн оршуулгаас XIII зууны түүхэнд холбогдох ховор нандин олдворууд олдсон юм. Тэрхүү олдворуудыг хэдий үеийн болохыг нь тогтоолгохоор анх 1999 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнд хандахад доктор А.Очир, Д.Баяр, нарын хамт тэдгээр гайхамшигтай зүйлүүдийг нүдээр үзэх завшаан тохиосон билээ<sup>1</sup>. Урьд өмнө биет

<sup>1</sup> Монголын эзэнт гүрний үед холбогдох нэгэн ховор дурсгал. //Археологийн судлал. Т. XX. fasc. 8. т. 100-119

байдлаар олдож байгаагүй XIII зууны монгол язгууртны хувцас хэрэглэлүүдийн дотор улаан хүрэн өнгийн арьсан гутал<sup>1</sup> байсан юм. Харамсалтай нь ухвар мөчид хүмүүс уг олдворыг шатааснаар гутлын хамрын хэсэг нь гэмтсэн боловч тэр үеийн монгол язгууртнуудын эдлэж байсан гутлын дүр төрхийг бүрэн харж болохоор байсан юм. Тэрхүү гутал нь түрийн өвдгөвчний хэсгээр өндөр бөгөөд персийн миниатюр зургийн дүрслэлтэй хэлбэр хийц нь адил байгаа ба өнгө нь дээр дурдсантай тохирч байгаа нь монгол язгууртнуудын нийтлэг өмсдөг арьсан гутал байсан бололтой.

В.Рубрук, монголчууд адууны ширээр гайхамшигтай сайхан гутал урлана гэж тэмдэглэсэн нь бий. Монголчуудад эртнээс нааш хар модны холтсыг буцалган хувцас хэрэглэл хийх арьс ширийг будаж өнгө оруулдаг уламжлал байсан бөгөөд уусмалын нягтралаас хамаараад шаравтараас, гүн хүрэн улаан хүртлэх өнгө гарган авдаг байв.

Алтан ордны гүүхэнд холбогдох сурвалж хэрэглэгдэхүүнд Хорезмынхан арьс шир элдэж боловсруулах модны холтос зэргийг Ижил мөрнөөс зөөж наймаалдаг байсан тухай мэдээ бий. Магадгүй монголчуудын арьс боловсруулах (идээлэх, элдэх, будах) технологи Алтан ордонд дэлгэрсэн байж ч болох.

Сарайд гадаадын маш олон худалдаачид сууж байсан бөгөөд тэдний худалдаалан авдаг гол зүйл нь европ болон дорно дахины хэрэглэгчдийн анхаарлыг татдаг, голдуу булгар болон умардын орноос ирдэг нэхий, үнэт үслэг, арьс шир байсан тухай Ибн Батута<sup>2</sup>, Омари нар тэмдэглэжээ. Арьс шир, үслэг эдлэлийг элдэх, будахад хэрэглэдэг нэгэн зүйлийн модны хальс зөөж авчирдаг байсан тухай мэдээ бий. Ийм модны хальсаар Хорезмын арьс ширний үйлдвэрлэлийн хэрэгцээг тусгайлан хангаж байсан бөгөөд тэр нь худалдаалах зүйлийн дотор нэлээд чухал байранд орж байснаас үзэхэд арьс шир, үслэг эдлэл боловсруулах урлал нэлээд хөгжиж байсан байна. Боловсруулсан арьс ширэн эдлэл, хэрэглэл, үслэг эдлэлийг авахаар хаа холоос худалдаачид зорин ирдэг байсан ба худалдааны том төвүүдэд түүнийг тусгайлан борлуулах худалдааны төлөөлөгчдийн газрууд байгуулагдсан нь уг ажлын далайцыг харуулна.

Нэхмэлийн гар үйлдвэрлэл байсан нь малын ноос болон Төв Азиас зөөн авчирсан хөвөнг боловсруулан хувцас хэрэглэл хийдэг байв. Ийм төрлийн үйлдвэрлэлийг гол төлөв дундад азиас ирсэн хүмүүс эрхэлж

<sup>1</sup> Монголын эзэнт гүрний үед холбогдох нэгэн ховор дурсгал. // *Studia Archeologica*. T. XX, fasc. 8, т. 100-119

<sup>2</sup> D.O.Morgan. *Ibn Battuta and the Mongols*. *Journal of the Royal Asiatic Society*, Volume 11, Issue 01. April 2001. pp. 1-11

байв.

Сарай Бэрхэд арьс шир, нэхмэлийн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж байв. Дундад Азиас авчирсан хөвөнгөөр хөвөн, даавуу, ноосон нэхмэл эд хийхийн зэрэгцээ өвөрмөц хийц уртай нэхмэл эдлэлийг ихэвчлэн Дундад Ази, Кавказ, Иран, Хятадаас авчирч байсан нь тодорхой.

Нийгмийн хэрэглээгээ дагаад гар урлалын салбарт ч өөрчлөлт гарч гар урчууд нь мэргэшлийн чиглэлээр үйлдвэрлэлээ дагнах болов.

Дээдсийн хувцас хэрэглээний торго дурдан, сайн чанарын цэмбээр хувцас хунар оёж, алт мөнгө, эрдэнэсийн чулуугаар язгууртнуудын эдлэл хэрэглэл титэм, хаан ширээ, тамга, алтан бүс, гоёл чимэглэлийн зүйлс, морины алт мөнгөн тоног хэрэгсэл, орд гэрийн чимэглэл, сав суулга зэрэг үзсэн хүний нүд хужирлах тансаг сайхан зүйлсийг урлаж байсан нь өнөө ч археологийн малтлагаар олдож ур хийцээрээ гайхагдан тухайн үеийнхээ гар урлалын хөгжлийн төвшинг илтгэх үнэт мэдээллийг өгсөөр байна. Хатад бүсгүйчүүдийн гоёл чимэглэл, морь болон тэрэгний тоног төхөөрөмжийг хээ угалз гарган гоёмсогоор урлаж байв. Ялангуяа хатад, эмэгтэйчүүд нь хувцсаа чимэглэх их дуртай байж. Тэд алт мөнгөн оройтой, түүндээ тогосын өд хатган эрдэнэсийн чулуугаар чимж, үнэт торгоор хулдсан малгай өмснө гэж харийн жуулчид тэмдэглэжээ. Хаадын ордон, хаан, хатан, бүсгүйчүүдийн гоёл чимэглэл, морины тоног хэрэглэл, цэргийн жанждын илд дуулга зэрэг олон зүйлсийг алт мөнгөөр маш сайхан урлаж тэр нь хэн хүний хараа булааж дархчуулынх нь ур чадварыг гайхуулж байсан нь дан ганц монгол урчуудын бус олон орны урчуудын хамтын ур шингэсэн бүтээлүүд байв.

Эрэлт хэрэгцээгээ даган нийт эзэнт гүрний торгоны үйлдвэрлэл өсч, торго, торгон эдлэл, бөс барааны худалдаа нэмэгдэн үнэт торго, бөсөөр хувцас хэрэглэл оёдог оёдолчин, урчуудын тоо ч нэмэгджээ. Үүний зэрэгцээгээр эзлэгдсэн орны улс түмний соёлыг огтхон ч үгүйсгэлгүй янз бүрийн шүтлэгт хүндэтгэлтэйгээр хандаж сүм хийд дугана, суврага, ордон, хот тосгодыг барьж босгоход газар газрын гар урчууд хувь нэмрээ оруулж байсан юм.

Худалдаа хөгжихийн хэрээр хотуудад худалдаачид, гар урчууд, дархчууд олноор суурьшин суух болсон нь хотын хүн амын нэлээд хувийг эзлэж хотуудын амьдралыг тэтгэгчид болж байв. Зөвхөн Сарай хот гэхэд л 100 000 шахам хүнтэй гар үйлдвэрлэлийн томоохон төв байсныг бичгийн ба археологийн дурсгалууд нотолж байна.

Гар урчууд нь мэргэшлийн чиглэлээр дагнан хэсэг хэсгээрээ бөөгнөрөн сууж, үйлдвэрлэлүүдийн бичил хорооллыг үүсгэж байсан нь Алтан ордны хотуудын малтлагаас тодорхой харагддаг юм.

Жишээ нь: Сарай Бэрхэд цэргийн зэвсэг болон хөдөлмөрийн багаж үйлддэг төмрийн дархчуул, керамик эдлэл, шавар сав суулга үйлдэгчид, арьс шир боловсруулах, тоосго, барилгын материал, тариалангийн багаж үйлдвэрлэгчид, алт мөнгө гоёл чимэглэлийн урчууд, хүрэл ба зэс эдлэл хийгчид гэх зэргээр хуваагдаж байсан аж<sup>1</sup>. Гар урчуудын хөдөлмөр зохион байгуулалт нь Египет, Иран Турк, Дундад Ази, Гүрж, Армяны гар урчуудын нэгэн адил тусгай нэгдлүүдэд нэгдэж дундад зууны Европын цехүүдийн маягаар ажиллаж байсан аж.

Алтан ордон дахь Монголын анхны суурин нь эсгий туургатан нүүдэлчдийн ахуй амьдрал, аж төрөх ёсонд нийцсэн янз бүрийн ур хийц зориулалт бүхий гэрүүдээс бүрэлдэж байжээ. Түүнийгээ дагаад энгийн гэрт харц ардууд, том тэрэг тавцан дээр байрласан олон баганат гэрт язгууртан дээдсүүд суудаг, тэр нь яваандаа гэр маягийн байшин барилга болон хувирчээ. Плано Карпини, В.Рубрук нарын тэмдэглэлд: "Тэд бургас сүлжин дэвссэн тэргэн дээр гэрээ барьж түүндээ амьдрана. Гэрийн гадна талыг янз бүрийн гоё сайхан хээ угалзаар чимэглэнэ. Орох хаалгандаа мөн үүд хэмээх эсгий зүүж түүнийгээ хээ гарган ширж оёдог байв.

Тэргэн дээр барьсан гэр сууцын зарим нь өргөөшөө 30 фут хүрэх том хэмжээтэй байв. Би нэг удаа нэгэн тийм гэр тэрэгний дугуйн хоорондох зайг хэмжиж үзсэнд 20 фут хүрч байсан ба тэргэн дээр байгаа гэр нь 2 дугуйнаас хааш хааш таваас доошгүй фут илүү гарч байв. Нэг гэр тэргэнд хөллөсөн үхрийг тоолж үзэхэд 22 байсныг тэрэгнийхээ өргөний хэмжээгээр тус бүр 11 үхэртэй, 2 эгнээ болгон хөллөсөн байв. Тэрэгний тэнхлэг нь хөлөг онгоцны шургийн дайтай өргөн бөгөөд тэргэн дээр гэрийн үүдэнд нэг хүн суун хөллөсөн үхрээ тууна. Түүнээс гадна тэд бас цуулсан бургас модоор том авдрын дайтай дөрвөн тал чингэлэг хийж түүнийхээ нэг захаас нөгөө зах хүртэл модон саравч хийж бяцхан орох хаалга гаргана. Тэгээд тэр чингэлэг буюу гэрээ хар өнгийн эсгийгээр бүрж, бороонд нэвтрэхгүйн тулд эсгийдээ өөхөн тос буюу хонины сүү шингээх ба бас л гоё нэхмэл болон үслэг эдээр чимнэ. Тийм хайрцагандаа бүхий л эд агуурс, үнэт зүйлээ хадгалах гол мөрөн гатлахад ч хялбар байхын тулд уг чингэлгээ тэмээнд хөллөсөн өндөр тэргэн дээр хөдөлгөөнгүй баглана. Түүнийг тэрэгнээс хэзээ ч үл буулгана. Тэд нүүж буухдаа гэрээ ямагт урагш харуулж барих бөгөөд хайрцагтай тэргүүдээ гэрийнхээ 2 талаар айл айлын зайтай эгнүүлэн тавина. Эмэгтэйчүүд гэр тэргийг маш гоё сайхан хийдэг байна. Нэг баян монгол хүн дор хаяж 100 буюу 200 тийм чингэлэгт тэрэгтэй байжээ.

<sup>1</sup> А.Якубовский. Столица Золотой Орды-Сарай Берке. Л., 1932, стр. 20

Бат хаан 26 эхнэртэй байсан эхнэр бүр нэг том гэртэй, том гэрийн хойгуур барьсан олон жижиг гэртэй байв. Жижиг гэрүүдэд нь шивэгчин хүүхнүүд суух ба тийм гэр тус бүрд 200 тэрэгтэй байв. Хаа нэгэн газар нүүж буухад авааль эхнэр нь баруун талд буудаллах ба бусад нь дараалан буудалласаар бага эхнэр нь хамгийн зүүн талд буудаллана. Эхнэр бүр хоорондоо айл айлын зайтай бууна. Тийнхүү нэг баян моал (монгол –С.Ц.) хот айл гэдэг нь том хотын дайтай байсан ба харин түүнд эрэгтэй хүн цөөн байдаг байв. Хамгийн чадал муутай эмэгтэй гэхэд л 20 буюу 30 тэрэг эзэгнэнэ. Тэд тэргээ үхэр буюу тэмээнд хойно хойноос нь цувруудан хөллөх ба хамгийн түрүүчийн тэргэнд эмэг эх нь сууж тэргээ туух ба бусад тэрэг нь хойно хойноосоо дараалан цувран явна”<sup>1</sup> гэжээ.

“Бид олон гэр тээсэн Скатайн тэрэг ачаатай тааралдсан бөгөөд түүнийг харахад нүүж яваа том хот урьдаас ирж явах шиг санагдав” гэж Гийом де Рубрук тэмдэглэсэн нь Алтан ордон улсын нэг онцлог байв.

Хотын оршин суугчдын цөм нь монгол иргэд гэхээсээ олзны гар урчууд, худалдаа наймааны хүмүүс, аянчин гийчин, цэргийн албан хаагчид, сүүлдээ лам нар байсан бололтой. Монголчууд гэр сууцаа үндэсний хээ угалз, уран зургаар чимэглэдэг байв. Тэд эсгий ширдэг дээр өнгийн утсаар хээ угалз ан амьтны дүрс, шувуу ургамалыг дүрсэлдэг байв.

Терещенко, Л.Ф.Недашковский, Марк Крамаровский нарын археологийн үе үеийн малтлагаар Алтан ордон улсын нийслэл болон бусад хотуудын хөгжил, гар урлалын хөгжлийг тодорхойлохуйц олон чухал олдвор олж судалгааны эргэлтэд оруулсан нь тус улсын гар урлал, барилгажилт, гадаад харилцаа, худалдааны хөгжлийг тодорхойлоход чухал хувь нэмэр болов. Алтан ордон нь төмөрлөг боловсруулалтаар алдартай байв.

Алт мөнгөөр дээдсийн хэрэглээний зүйлсийг урлахаас гадна төмөр, төмөрлөг боловсруулж цэргийн зэр зэвсэг, хөдөлмөрийн багаж, ахуйн хэрэглээний эд зүйлсийг чанарын өндөр түвшинд хийж байжээ.

Монголчуудын боловсруулсан төмөр хат сайтай байснаараа гадныханд гайхагдаж байсан. Түүгээрээ ч цэргийн зэр зэвсэг нь бусдаас илүү сайн байж амжилтад хүрсэн. Тэгвэл түүнийг бүтээлцэж байсан төмрийн дархчууд ч өөрийн өндөр технологитойгоо Алтан ордонд очиж дэлхийн төмөрлөгийн үйлдвэрлэлд өөрийн хувь нэмрээ оруулсан юм. Төмөрлөгийн үйлдвэрлэл нь Алтан ордон улсын хотын амьдралд хэчнээн чухал үүрэгтэй байсныг Оросын археологчдын малталтаас

<sup>1</sup> Гийом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988. т. 105-107

харж болно.

Сарай- Бэрх хотын малтлагаас төмрийн дархны газар, хутга, болон жижиг оврын зэр зэвсэг үйлдэх газар, тариалангийн багаж хадуур анжис хошуу, хүрэл багаж хийх гар үйлдвэрийн газар бүхлээрээ олджээ.

Терешенкогийн малтлагын үед нэг газраас хүдэр хайлуулах 8 зуух олдов. Түүний нэг зуух нь далан салхивч нүхтэй, төвд нь байх нурсан нэг зуухны эргэн тойронд усан хоолой байжээ. Зуухны дэргэдээс хэдэн жижиг дэн, бутан, тогоо, мөн төмөр, зэс төмөрлөг хайлуулах багаж сав, хэв олноор олджээ. Бусад хүдэр хайлуулах зуухнаас бас төмрийн цутгамал хэсэг хэвийн хэлтэрхий ба төмөрлөг хайлуулах багаж сав илрүүлэв.

Төмөр дөрөө, сумын зэв, сэлэм, төмөр жад дуут сум зэрэг цэргийн зэвсэг, хаалганы төмөр хонх, авдрын хүрэл бариул тоног, тосон дэнгийн суурь, өвлийн улиралд дулааны төхөөрөмжгүй гэрт гар хөлөө бүлээсгэхэд хэрэглэдэг нүүрсний цогоор халдаг хүрэл гиса зэрэг олон зүйл олджээ. Эдгээрт монголын ноёрхлын үеийн нийтлэг бөгөөд онцлог олон зүйл багтаж байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн зохион байгуулалтад оруулсан хөдөлмөрийн хуваарь эндээс харагдана.

Сарай Бэрхэд үйлдвэрлэж байсан зүйлсийн жагсаалтыг А.Ф.Якубовский гаргасны дотор төмөр эдлэл нэлээд хувийг эзлэж байсан нь хүрз, сүх анжисны хошуу, алх, дөрөө, хадуур, тогоо, тах, төмөр цан, хазаарын амгай, цагриг хадаас гогцоо, нугас, янз бүрийн цоож, цүүц, хайч, гинж төрөл бүрийн хүйтэн зэвсэг (жад, сэлэм, илд г.м.) байжээ. Зэсээр аяга таваг, домбо, сав, элдэв гоёл чимэглэл хийдэг байв.<sup>1</sup>

Алтан Ордонд зоосны үйлдвэрлэл нэлээд байр суурьтай байсан нь өөрсдийн хаадын төдийгүй Өгэдэй (1229-1241), Мөнх (1251-1259), Аригбөх (1260-1294) зэрэг Их хаадын зоосыг ч хийж байснаас харагдана.

Мөнхтөмөр (1266-1282), Тодмөнх (1282-1287), Тулабуга (1287-1291) хааны үед зоос цутгалт өндөр хэмжээнд нийт үйлдвэрлэсэн зоосноос мөнгөн зоос 10.6 хувийг эзэлж байв.

Алтан ордон улсад мөнгө цутгаж байсан гол хотууд нь Сарай, Сарай Ал Махрус, Сарай ал Джедид, Гюлистан, Укек, Мохша, Булгар, Барджин, Маджар, Крым, Азак, Тебриз байв.

Татщевийн дүүргийн Полчаниновский тосгоноос 4 верстийн зайтай газраас 1892 онд 1226 мөнгөн зоос бүхий керамик сав олджээ.

Мөн 1990 онд Саратовт Казанийн сүмийн дэргэдээс барилга барих

<sup>1</sup> А.Ф.Якубовский. К вопросу о происхождении ремесленной промышленности в Сарай Бэрке. Исторический журнал. 1944. №1

үед Алтан ордон улсын 200 зэс зоос бүхий шавар домбо, мөн 1847 онд Саратовоос Жанибек, Тогтомыш хааны мөнгөн зоос бүхий клад олдсон нь мөнгө цутгах ажил ямар хэмжээнд байсныг харуулж байна. Нийт 21 клад олдсоны 19 нь Ижил мөрний баруун эргээс, 2 нь зүүн эргээс олдсон нь сонирхол татаж байгаа юм. Дангаараа олдсон мөнгөн олдворын 13 газрын 5 нь Ижил мөрний баруун, 8 нь зүүн эргээс олдсон байгаа нь Укекийн худалдааны дайлайцыг харуулж байна<sup>1</sup>.

Алтан ордны зөвхөн Укек хотоос 11 мөнгөний клад, дангаараа олдсон зоос 1450, мөн тухайн нутагт үйлдвэрлээгүй мөнгөн зоос ч олноор олдсон нь гар урлалын болон худалдааны цар хүрээг харуулж байна.

Зөвхөн Алтан ордон улсын хаадын өөрсдийн үйлдүүлсэн зоос гэхэд л Крым, Булгар, Хорезм, Сарай, Гюлистан, Сыгнак хотуудад хийсэн 21 хааны нэр бүхий мөн хаадын овгийн тамгатай 47 зоос өнөөгийн судалгаагаар илэрч оллоод байна.<sup>2</sup> Тэдгээр нь ихэвчлэн мөнгө, зэсээр дэлдсэн ба нэг ч алтан зоос байгаагүй нь сонирхол татаж байна.

Судлаач Б.Нямаа Монголын зоос судлалын салбарт анхны шан татаж Монголын түүх судалгааны талбарыг өргөтгөн олон шинэ баримтыг судалгааны хамт эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан юм. Түүний судалгаа археологийн олдвороор батлагдсаар байна. Ганц жишээ дурдахад Оросын археологич М.Краморовскийн Алтан ордны нутгаас олсон алтан бүсний зүүлтэд судлаач Б.Нямаагийн олж тогтоосон Алтан ордны хааны тамга байгаа нь уг судалгааны эрдэм шинжилгээний ач холбогдлыг харуулж байгаа юм.

Алтан ордон улсын хот байгуулалт эрчимжсэнтэй холбогдон барилгын материал, вааран дээвэр, тоосго хийдэг гар үйлдвэрлэгчид байв.

Бэрх Сарайгаас пааландсан тоосго ихээр олдсон ба тэдгээр нь номин ногоон, хөх, цагаан гурван өнгө голлож байсан ба бас ховор ч гэсэн шар, алтан шаргал өнгийг хэрэглэдэг байв. Тэдгээрийг ордон, сургууль, бунхан, лалын сүмийн дотор гадна ханыг чимэглэхэд хэрэглэж байсан гэж судлаачид үзсэн. Түүхий болон шатаасан тоосго ихээр олдсон нь тоосгоны үйлдвэрийн хөгжлийг харуулж байна. Тоосгоны үйлдвэрлэл нийслэл Хархоринд ч далайцтай хөгжиж байсан бөгөөд янз бүрийн худалдааны тэмдэгтэй тоосгонууд олноор олдсон нь нэг бус хэд хэдэн үйлдвэр байсныг харуулж байгаа юм. Тэдгээр үйлдвэрт дан ганц олзны хүмүүс бус монгол гар урчууд ч мөн ажиллаж хувь нэмрээ оруулж байсан нь мэдээж.

<sup>1</sup> Л.Ф.Недашковский. Золотоордынский город Укек и его округа. М., 2000. стр. 159-168

<sup>2</sup> Б.Нямаа. Монголын эзэнт гүрний мөнгө, хаадын овгийн тамга. УБ., 2005. т. 36-40, 193-210

Мөн ваар шаазан эдлэлийн үйлдвэр байсан бөгөөд Сарайн археологийн олдворын дотор хамгийн их хувийг вааран сав суулга, барилгын материалууд эзлэж байв. Монголчуудыг ирэхээс бүр өмнө ваар, керамик сав суулганы урлаг нь Ижил мөрний доод сав газар, Кавказад нэгэнт өндөр хөгжсөн, нарийн мэргэжлийн урчууд нь энэ ажилдаа бүр гаршсан байв. Ваар сав үйлдвэрлэлийн хувьд Ургенчийн нөлөө хоёр Сарай хотод илүү байв. Ургенчээс ваар савны бүлэг урчуудыг авчирсан мэдээ буй.

Гар урлал эдийн засагт ихээхэн байр суурьтай болсны улмаас нүүдэлчин шинж чанар нь алгуураар багасах болжээ. Энэ нь газар тариалан эрхлэгчдийн өсөлтөөр биш худалдаачин, гар урчууд зэрэг суурьшмал нийгмийн нөлөө бүхий давхаргын өсөлтөөс шалтгаалан алгуураар багассаар, улмаар энэхүү өөрчлөлтийн явцад илүү дэвшилттэй аж ахуй хожимдоо гарч ирэх болсныг түүхчид бичиж байна.

Гар урлалыг хөгжүүлэх төрийн бодлогоор Монгол хаадын дэмжсэн бодлого нь худалдаа, хот байгуулалт зэрэг нийгмийн бусад салбарын хөгжилтэй нягт уялдан түргэн хурдацтай хөгжиж байв.

Америкийн эрдэмтэн Чарльз Галперин “Монголын ноёрхлын үед гар үйлдвэрлэлийн доройтол байсангүй. Хүн амын бүх давхарга нь хэн чадах нь юу чадахаа хийж байсан бөгөөд гагцхүү ур чадвар л бүхнийг тодорхойлж тухайн үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүхэн цэцэглэн хөгжиж, дэлхийн стандартад нийцээгүй бүхэн мөхсөн юм”<sup>1</sup> гэсэн нь түүхэн үнэн юм.

Монголын хаадууд эзлэн захирсан, байлдан дагуулсан газар орноосоо гар урчууд, дархчуудыг олноор нь нь зөөн аваачиж үйлдвэрлэх хүчин болгож байсан нь нэг талаас хүч хэрэглэн хүний эрх чөлөөнд халдсан хэрэг боловч нөгөө талаас аваад үзвэл тэдгээр худалдаачид нь өрнө дорнын гар урлалын технологи тээн очиж олон улсын арга туршлага нэгдэн нийлж синтез болсноороо дэлхийн гар урлал болон үйлдвэрлэлийн технологийг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулсан юм.

<sup>1</sup> Чарльз Галперин. Россия в составе Монгольской империи- Монголоведные исследования. Выпуск 4. Сборник научных статей. Улан-Удэ, 2003. стр. 81-82

## 11. ХОТ СУУРИНЫ АМЬДРАЛ

Монголчуудын аян дайны хөлд Оросын хотууд олноор сүйрч хожим үед ч хөгжил нь саарч хөгжил олон жилээр хойш татсан гэх буюу нүүдэлчдэд эзлэгдсэн учраас тэдний амьдралын онцлогтой уялдан хотууд төдийлөн хөгжөөгүй гэж Оросын түүх бичлэгт өгүүлэх нь өнөө ч байсаар буй билээ.

Сүүлийн үеийн оросын түүх бичлэгт хот суурины хөгжлийг бодитой үнэлэх хандлага гарч зарим түүхчийн судалгаа болон Алтан ордны нутагт хийсэн археологийн малтлага шинжилгээ, судалгааны ажлын үр дүн эрс өөр дүгнэлт гаргахад хүргэж байна.

Мэдээж хэрэг, асар өргөн далайцтай дайны дундуур цэцэглэн хөгжиж байсан хотууд эвдэрч сүйдсэн нь үнэн боловч бүх хотыг үгүй хийсэн гэх буюу дайн дууссаны дараа ч цөлбөн хоосолсон нь хэдэн арван жилээр хэвээр үргэлжилж, соёлын хоцрогдолд хүргэсэн гэдэг нь түүхэн үнэнд нийцэхгүй юм.

Оросын тархай бутархай хот улсуудыг байлдан дагууллаар зад татаж, хөдөлгөөнт амьдрал, олон улсын харилцаанд татан оруулснаар хожмын Оросын нэгдсэн улс байгуулагдах хөрс суурийг тавьж өгсөн болно.

Монголчууд газар нутаг хүрэлцэхгүйдээ, үй олон хүнийг учир утгагүйгээр хөнөөхийн төлөө дайн хийсэн бус, харин эсэргүүцсэн цөөн хэдийг нь хатуу ширүүнээр дарж цээрлэл болгон, бусдыг нь айлган сүрдүүлэх замаар эвдрэл хохирол багатайгаар эзлэн авах бодлогыг явуулж байсан бөгөөд монголчуудад юу ч үгүй эвдэрч хоосорсон хот суурины балгас, хүн ам нь юүртэл хядагдсан хотуудын туурь бус өөр өөрийн аж ахуйгаас алба татвар төлж байх харьяат албат хэрэгтэй байсан юм.

Худалдаа, гар үйлдвэрийн хөгжлийн дүнд Алтан ордон улсын хотууд цэцэглэн хөгжив. Ялангуяа худалдааны зам дагуу оршиж байсан хотууд дайнд сүйдсэн хэдий ч богино хугацааны дотор сэргээгдэж өмнөхөөс илүү хурдан явцтай хөгжиж байсан бол худалдааны замаас алслагдсан хотууд сэргээн босгогдох нь удаан төдийгүй зарим нь бүр тэр чигээрээ орхигдсон нь дайны хөлд газрын хөрснөөс ор сураггүй арчигдсан гэх

хотуудын тоог нэмж байв.

Монголчуудын элчийг алсан буюу тэднийг улайран эсэргүүцсэн, бослого гаргасан хотууд эвдэгдэж тэдний саналыг хүлээн авсан хотууд нь хөндөгдөөгүй аж. Оросын соёл иргэншлийн төв болсон Киев, Чернигов, Переславль, Рязань, Суздаль, хотууд дайны хөлд бүрмөсөн нуран эвдэрсэн бол Умард Оросын хотууд Смоленск, Новгород, Псков, Галич зэрэг хотууд хэвээр үлдсэн байна<sup>1</sup>.

Гэхдээ Киев зэрэг зарим хотууд монголчуудыг очихоос өмнө дотоодын тэмцлээр сүйрсэн байсныг Л.Н.Гумилев баримтаар гаргасан билээ.

Мөн монголчууд нүүдэлчин учраас суурин амьдралыг төдий л ойшоодоггүй гэх буюу уран дархчууд, мэргэшсэн гар урчуудыг хаандаа хүчин зүтгүүлэхээр авч оддог байсан монголчуудын төрийн бодлого нь байлдан дагуулалтын эхний үед хараахан нурж сүйдээгүй хотуудад ч том дарамт болсон<sup>2</sup>, мөн оросын гар урчууд дархчуудыг тийнхүү монголын хүрээ нутаг даяар тараан цацаж хаяснаар оросын өөрийнх нь туршлага, уламжлалыг барагдуулсан бөгөөд үйлдвэрлэлийнх нь уламжлалыг тасалдуулсан<sup>3</sup> гэж Оросын түүхчид бичдэг.

Бат хаан Алтан ордон улсыг байгуулаад улсаа хөгжүүлэх нэлээд цогц бодлого хэрэгжүүлжээ. Түүний дотор хот байгуулалтын асуудал чухал байр эзлэж байв. Юуны өмнө, дайны хөлд сүйдсэн хотуудыг сэргээн босгох, түүний зэрэгцээ шинээр хот байгуулахад анхаарлаа хандуулж өөрийн улсын нийслэлийг богино хугацаанд барьж босгохоор улс улсаас олзлогдон ирсэн урчуудыг дайчлан цуглуулж уг ажлыг эхлүүлжээ.

“Бат хаан хотын амьдрал, худалдаа наймаа, гар урлалыг хөгжүүлснээр улсын санд арвин их ашиг оруулж, энэ нь улсын хөгжлийг хөтлөх түлхүүр гэдгийг ойлгож шинээр хот байгуулах, хуучин хотуудыг хурдацтай сэргээхэд хүн хүч, хөрөнгийг ихээхэн татан төвлөрүүлж байсан нь бусад хотын хөгжилд дарамт үзүүлсэн гэх зэмлэлийг хүлээх шалтгаан болсон юм.

Гэхдээ монгол хаад хувийн тансаг амьдралаа цогцлоон бүтээхийн тулд бус хаана сэргээн босголтыг богино хугацаанд хийх шаардлагатай байна тэнд хүч хаяж гар урчуудыг үндэс угсаагаар нь ялгаварлахгүйгээр илгээж онцгой авьяастай, ур дүйтэйг нь Их хааны нийслэл Хархорин болон буюу Бат хааны шинээр байгуулсан Сарайд авчирч байв.

<sup>1</sup> Г.В.Вернадский. Чингисийн үеийн Монголчууд ба Орос улс. УБ., 2004. т. 35

<sup>2</sup> Мөн тэнд.

<sup>3</sup> Рыбаков. стр. 525-536- Г.В.Вернадский. Чингисийн үеийн Монголчууд ба Орос улс номоос дам ишлэв. УБ., 2004. т. 36

Оросын археологчдийн малтан шинжилсэн судалгаанаас үзвэл, хот бүхэн гар урчуудын хороололтой байсан нь үүнийг гэрчилнэ.

Алтан ордон улсын ноёрхлын эхэн үед түүний хаад, ноёд хот сууринд байрлах бус харин Ижил мөрний хөндийг өгсөн уруудан нүүж, хотын амьдралаас зайдуу амьдарч байсан бөгөөд хот суурингуудыг Их хааны жанжин сайдууд захирдаг байв.

Бат хааны орд өргөө ч шинэ хот байгуулж бүрэн суурьшин төвхнөглөө энэ уламжлалаа даган Ижил мөрний үржил шимт хөндий, Дешти-Кибчагийн бэлчээр ус сайтай тал нутагт улирлын аясыг даган нүүдэллэдэг байв. Нүүдэлчдийн хотын нэг онцлог нь алсаас харахад нүүгэлтсэн том хот байснаа өглөө харахад юу ч үлдээгүй нүүгээд явчихсан байдаг тухай тэрн үеийн түүхч, элч жуулчид тэмдэглэсэн нь олон буй.

Хааныхаа өвлийн харшаас зуслан руу нүүж яваа ордынхны хамт хааны хатад, төрөл садан, нэгэн овог аймгийнхан, цэрэг хамгаалалтынхан, шадар зөвлөх, түшмэдүүд, худалдаачид, гар урчууд хөгжимчид болон лалын, бурхны, буддын, үнэн алдартны шашны лам хуврагууд, монголчуудын шашныг бишрэн шүтэгчид, тайлгач бөө, хувилгаанууд бас нүүдэллэдэг байжээ<sup>1</sup>.

Сарай<sup>2</sup> хотыг Бат Төв Европоос буцаж ирээд Ижил мөрний цутгалан Ахатуба голын зүүн эрэг дээр байгуулжээ. Алтан ордон улсын хаадын эзэмшил болсон тал хээрийн энэхүү нутаг газар, хот байгуулахад тохиромжтой байв.

Шинээр нийслэл болон худалдааны том төвүүд байгуулагдснаар гар урчууд, худалдаачид, шашны зүтгэлтнүүд нэмэгдэн ирсээр хотын хүн ам бүрэлдэн, хотын хэрэглээг буй болгов.

Алтан ордон улсад нийтдээ 25<sup>3</sup> хот, зарим судлаач 150 хот<sup>4</sup> байсан гэх буюу зарим нь 200 шахам болсон гээд чухам энэ үед Алтан орд хотуудын орон гэгдэх болсон гэжээ. Тэдгээрээс алдартай нь Сарай-аль-Махруса, Сарай-аль-Жадид, Булгар, Джукетау, Азак, Крым, Укек, Мажар, Мукша, Хажитархан, Каффа, Сурож, Хорезм, Солхат, Сарайчик, Ургенч болон бусад хотуудыг нэрлэж болно.

Алтан ордон улсын ноёрхолын үед оросын хотуудын хөгжил саараагүй юм. Дмитрий гэрээслэлдээ ач хүү II Василий ууган хүү III Ивандаа 14 хот өвлүүлэн өгсөн бол бусад 4 хүүдээ 12 хотыг хуваан эзэмшүүлжээ. III Иван ...ууган хүүдээ 66 хот үлдээсэн атлаа дөрвөн

<sup>1</sup> Алишер Алиев. Скифээс улбаалсан их торгон зам. УБ., 2001. т. 42

<sup>2</sup> Перс хэлээр Сарай гэдэг нь «Ордон» гэсэн утгатай үг ажээ.

<sup>3</sup> Д.Цахилгаан. Бат хаан. УБ., 2003. т. 120

<sup>4</sup> Равиль Амирхан. Золотая Орда и ее правители. Казань, 2003

дүүгийнхээ дунд зөвхөн 30 хотыг л үлдээсэн тухай мэдээ байдаг<sup>1</sup>. Үүнээс үзэхэд зөвхөн нэг вангийн гэрээслэлд ийм олон хот байснаас үзэхэд бүх улсын хэмжээнд бол нэлээд том тоо гарах нь ойлгомжтой. Тэгэхээр хотууд сүйрэн унасан гэдэг нь асуудалд яаж хандахаас л хамаарч буй хэрэг болов уу.

Оросын түүхч В.А.Кучкин: XIII зууны эцэс XIV зууны эхэнд Зүүн хойт Орост хотуудын тоо бага зэрэг нэмэгдэж, XIV зууны хоёрдугаар хагасаас эрчимтэй нэмэгдэн тус XIV зууны эцэст 50-иас багагүй буюу өөрөөр хэлбэл монгол татаруудын байлдан дагууллын өмнөх үеэс хоёр хагас дахин нэмэгдсэн<sup>2</sup> гэсэн нь ямар ч байсан монголын ноёрхлын үед оросын хотууд унаж хөгжил нь олон зуунаар хоцорсон гэдэг хуучны дүгнэлтэд бодитой хандах хандлагууд ч байна<sup>3</sup>.

Худалдааны зам дагуу голлон төвлөрч байсан хотууд хурдацтай хөгжиж байхад худалдааны замаас алс байсан хотууд хөгжлөөр бусдаас хоцорсон нь үнэн ажээ.

Нийслэл хотуудын хувьд байдал өөр байв. Алтан ордны улсын түүхэнд Сарай Бат буюу хуучин нийслэл, Сарай Бэрх хэмээх шинэ нийслэл гэсэн хоёр Сарай байсан бөгөөд Узбек хааны үед Алтан ордны нийслэл Сарай Батаас, Сарай Бэрхэд шилжжээ.

Бат хааны байгуулсан Сарай хотын туурь нь одоогийн ОХУ-ын Астрахань хотоос холгүй Селитренный хэмээх газарт байгаа ба Сарай Бэрхийн туурь нь Ижил мөрний Ахатубед буй. Сарай Батыг Ижил мөрний зүүн хөвөөнд байсан хэмээн Рубрук тэмдэглэжээ.

Бат, Бэрх нар нийслэлээ эдгээр газарт сонгон авсан нь бас учиртай. Энэхүү Доод Ижилийн газар нутаг бол нэгд, худалдааны олон замын уулзвар, алдарт торгоны зам дайран өнгөрдөг, хоёрт, монгол нутагтайгаа харьцахад шулуун дөт, гуравт, газар тариалангийн бүсүүдтэй ойрхон учир нүүдлийн ба суурин аж ахуйг хослуулахад дөхөмтэй байсантай холбоотой<sup>4</sup>.

Шинээр барьж байгуулсан хотын барилга байгууламжийн тухай дэлгэрэнгүй өгүүлсэн нь хомс ч бас бага сага мэдээ бий. Хотын хамгийн сүрлэг сайхан байгууламжуудын нэгэнд хааны ордон зүй ёсоор орно. Бат юуны өмнө улс орны нүүр царай болсон хааны өргөө ордонг тансаг сайхан бариулж тэнд Алтан ордны төрийн чухал хэргийг хэлэлцэн шийдэхээс гадна, гадаад дотоодын элч төлөөлөгчид хуран чуулж

<sup>1</sup> Г.В.Вернадский. Мөн зохиол. т. 52

<sup>2</sup> В.А.Кучкин Города Северо-Восточной Руси в XIII-XV веках (Крепость и посад;городское население) История СССР. 1991. №2. Ю.В.Кривошеев. Русь и Монголы. СПб., 2003. стр. 349

<sup>3</sup> Ю.В.Кривошеев. Русь и Монголы.СпБ., 2003. стр. 350

<sup>4</sup> А.Якубовский. Золотая орда. М., 1937. с. 50

дэлхийн хэргийг зөвлөн ярьдаг байжээ.

Б.Ринчен “... Хаадын өргөөг “Шар ордон” хэмээн нэрлэдэг байсан бөгөөд Ижил мөрөнд байсан Бат Сайн ханы өргөөг мөн Шар Ордон гэж байсан учир тэр нэрийг нь Алтан Ордон гэж улсын нэр болгож нэрлэх болсон”<sup>1</sup> гэжээ.

Бат хааны ордныг Рубрук дүрслэхдээ “Тэр өөрөө алтан чимэглэлтэй ор мэт хаан ширээнд суух ба түүнд гурван гишгүүрээр өгсөн хүрнэ. Батын хажууд нэгэн хатагтай сууна. Ах дүү хөвгүүд эрэгтэй эмэгтэйгээрээ мөн л баруун зүүн ялгаран суудаг” гэжээ.

Плано Карпинийн тэмдэглэснээр Батын ордны хаалганы ойролцоо төв дунд зассан ширээн дээр алт, мөнгөн сав суулганд ундаа дүүргэсэн байв гэсэн бол В.Рубрук: Бат хааны ордны асрын хаалганы дэргэдэх вандан дээр чулуун шигтгээтэй, том том алт, мөнгөн хул аяганд айраг хийж тавьсан байсан хэмээн ордны тансаг сайхан болон гадаадын элч төлөөлөгчдийг хүлээн авах онцгой дэг жаягтай байсан тухай тэмдэглэсэн байдаг.

Сарай Бат хотод анхнаас олон шашны сүм хийд, гар урчууд, худалдаачдын хороолол, гадны элч төлөөлөгчдийг хүлээн авдаг ёслолын яам, өртөөний яам зэрэг газрууд байжээ. Гадны элч төлөөлөгчдийг хүлээн авдаг яамны тухай сонирхолтой мэдээг тэр үед Алтан ордонд ирж байсан элч төлөөлөгчид тэмдэглэн үлдээжээ.

Гаднаас ирж буй элч нарыг аль зүгийн ямар улсаас ирснээс нь хамаарч өөр өөр газар хүлээн авдаг дөрвөн яам байсан тухай тэмдэглэсэн байдаг. Гийом де Рубрук: “Батын ордонд элч нарыг огт өөрөөр хүлээн авдаг юм. Түүний ордонд өрнөд талын яам гэж байдаг Тэнд дандаа өрнөдөөс зорьж ирсэн хүмүүсийг хүлээн авдаг. Ертөнцийн бусад зүгээс ирэгсэдийг тухайн зүгт байрлах яам нь хүлээн авдаг. Батын ордонд бие биеэ тэд үл таних бөгөөд өөр газрын элч нарыг тэр тэр улсынх гэж мэдэхгүй. Аль нэг элчийг ордонд дуудахад өөр бусад нь дуудагдахгүй байх нь бий. Ордонд зөвхөн дуудахад нь л очдог юм билээ”<sup>2</sup> гэж тэмдэглэсэн нь бий.

Сарай нь олон замын зангилаа хот байж Их Монгол болон эзэнт гүрний хаадтай уулзахаар өрнө зүгээс зорин яваа бүхний анхлан очдог том хот байжээ. Хүн зон цуглахын хэрээр худалдаа, гар урлал, гадаад харилцаа эрчээ аван хөгжиж байв.

Археологич Терешенко: Узбек хааны төр барьж байх үед Сарай

<sup>1</sup> Б.Ринчен. Дундад эртний Монголын тухай хоёр сонин бичиг. –Шинжлэх Ухаан амьдрал, УБ., 1989. №2, т. 37

<sup>2</sup> Гийом де Рубрук. Монголын эзэнт гүрэнд зорчсон нь. 1253-1255. Франц хэлнээс орчуулсан Т.Төмөрхүлэг. УБ., 2000. т. 95

Бэрх хотод 100 гаруй мянган хүн тогтмол суудаг байсан бололтой гэж үзжээ. Тэгвэл Сарай нь ямар хэмжээний хот байсныг тэр үеийн бусад хотуудтай харьцуулан үзэхэд төвөггүй ойлгогдоно.

XIII зуунд Ром 35 000, XIV зуунд Париж 58 000 хүнтэй, Европын томоохон хотуудын тоонд ордог байсантай жишвэл, Сарай хотын цар хэмжээ тодорхой болно. Байнгын оршин суугчдаас гадна албан хэргээр яваа элч төлөөлөгчид, худалдаачид, шашны санваартнууд гээд явуулын өч төчнөөн хүн хувийн болон албан хэргээр нааш, цааш хөлхөлдөн нийслэл Сарай хотын хүн амын өсөлтийг нэмэгдүүлж байв.

Тухайн үед шинээр баригдсан Алтан ордны нийслэл нь харьцангуй богино хугацаанд өрнө дорны элч, худалдаачид хөлхсөн олон орны шашны төлөөлөгчид, гар урчууд суурьшин суусан улс төр, эдийн засаг, соёлын томоохон төв болов.

Алтан ордон улсын хаадаас хотоо хөгжүүлэхээр төлөвлөгөөтэй, зохион байгуулалттай, далайцтай явуулсан арга хэмжээг дутуу буюу санаатай гүйвуулан үнэлсэн судлаачид ч байна.

Тэд Алтан ордны нийслэл болон хотуудын хурдан өсөлт, хөгжилт нь өөрийн үйлдвэрлэх хүчний хэвийн өсөлтийн үр дүн бус гол төлөв оросын тариачин хүн амаас хүч хэрэглэж булаан авсан эд зүйлс, хөдөлмөрөөр хангагдаж байсан гэх буюу Алтан ордны хотуудын, ялангуяа хоёр Сарайн эд хөрөнгө, баялаг нь бүрэн утгаар нь хэлбэл эзлэгдсэн ард түмнүүдээс түүний дотроос Оросоос системтэй дээрэмдэн авсан зүйл байв<sup>1</sup> гэж бичиж байна.

Сарайд лал, үнэн алдартан, несториан, католик зэрэг шашны их бага төв, хэд хэдэн орны худалдааны төлөөлөгчийн газар байгуулагдсан нь Сарайг олон улсын хэмжээний хот болгосон төдийгүй тухайн бүс нутагт буй болсон цоо шинэ зүйл байв. Олон зүйлд өөрийн гэсэн өвөрмөц өнгө аястай, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх шинэ дэг жаяг, журмуудыг монгол хаад буй болгожээ. Тухайлбал, гадаад харилцаанд элчийг хүлээж авах үдэх, өөрийн элч төлөөлөгчдийг харь оронд илгээх, гадаад харилцааны акт, бичиг баримтуудыг үйлдэх, хэрэгтнийг шийтгэх<sup>2</sup>, хүн амын тооллого явуулж алба татвар оноох нь хүртэл уугуул нутгийнхнаас илүү боловсронгуй, өндөр төвшний байв.

Монголчуудын буй болгосон бүхэн бусдаас илүү гэж хэлж буй нь тэдгээр нь зөвхөн нэг улсын хэмжээний хэрэг бус Чингис хааны үеэс олон улс орныг эзлээд тэдгээр орнуудад байсан дэвшилтэт зүйлийг

<sup>1</sup> Б. Греков и А. Якубовский Золотая Орда (Очерки истории Улуса Джучи в период сложения и расцвета в XIII-XIV вв) Л., 1937. стр. 109

<sup>2</sup> Орос болон Алтан ордны эрхшээлд буй улс орнуудын дотоодод болсон хэрэг явдлыг орос буюу тухайн орны шүүхээр хэргийг шийдэх, харь улстай буюу ордтой холбоотой хэргийг Сарайд шүүж байсан байна.

өвлөн авч сайн мууг нь амьдралаар шалган баталгаажуулж, өөрсдийн туршлагаар буй болгосон бэлэн системийг монголчууд Орос болон Кибчагийн тал нутагт хэрэгжүүлж байгаад хэргийн гол учир оршино.

Сарай болон бусад хотуудад улс орны хөгжлийг тодорхойлогч гол хүчин болсон худалдаа, гар урлал илүүтэй хөгжиж тухайн үеийн үйлдвэрлэлийн болон чанарын стандартыг тогтоож байв.

Америкийн эрдэмтэн Чарльз Галперины тэмдэглэснээр: Алтан ордон улсад гар урлалын уналт байгаагүй бөгөөд олон улсын худалдаа, зах зээлийн эрэлт хэрэгцээ, бараа таваарын хангалт бүхнийг тодорхойлж, дэлхийн стандартад нийцсэн бүхэн худалдаалагдаж, шаардлага хангаагүй нь хаягдан гээгдэж байв гэсэн нь бодит байдлыг маш оновчтой үнэлсэн хэрэг юм<sup>1</sup>. Тиймээс гар урчууд, үйлдвэрлэгчид хийж буй зүйлээ тэр л эрэлт хэрэгцээнд нийцүүлэхийн тулд чанарын өндөр төвшинд үйлдэх болсноор Сарай хотыг гар үйлдвэрлэлийн төв болгов.

Алтан ордны хотуудын туурийг малтсан Оросын археологич Терещенко, Л.Ф Недашковский, М. Крамаровский зэрэг олон эрдэмтдийн судалгааны үр дүнд тус улсын соёлын түүхэнд холбогдох асар үнэт зүйлс олдсон төдийгүй уг хотын дүр төрхийг ерөнхийд нь тоймлон мэдэх боломжтой болсон юм.

Уг малтлагаар хотын хөгжлийг тодорхойлох олон чухал олдвор олдсон нь өдгөө Санктпетрбургийн Их ордон музейд хадгалагдаж байна.

Сарай-Бат нь өрнөдөөс Монголын эзэнт гүрнийг зорьсон хэн бүхэн дайран ирдэг, Эзэнт гүрний төвд хэрхэн хүрэх зам маршрут, Монголын Их хаадтай хэрхэн харилцах тухай бүхий л мэдээллийг авдаг гол газар байжээ.

Сарай-Бат, Сарай-Бэрх нь нийслэл байсныхаа хувьд хүн амын суурьшил, барилга байгууламж, гар үйлдвэрлэлийн бүтээмж, хот зохион байгуулалтынхаа хувьд бусдаас ялгарч байсан тухай тэр үед нүдээр үзсэн олон орны элч жуулчид тэмдэглэн үлдээжээ.

Ираны түүхч Жузжаны "Табакат-и-Насир" зохиолдоо: "Батын байгуулсан хотуудад үй олон мөргөлчдөөр дүүрэн сүм хийд байгуулсан. Түүнийг хаанчилж байсан бүх үед лалын шашинт орнуудын хүн ам дур зоргоор амьдарч байв. Батын захиргаанд орсон Ираны тодорхой хэсэгт тэр өөрийн төлөөний захирагчдыг суулгаж байлаа гэжээ.

Энэ нь лалын шашинтны хувьд онцгойлон анхаарсан бус монголын төрд дайсагнаагүй хэн бүхэн монгол хаадын ивээлд багтаж, шударгаар

<sup>1</sup> Charles J. Halperin. Russia in the Mongol Empire in Comparative Perspective-Harvard Journal of Asiatic Studies. Vol. 43. №1. Cambridge, Massachusetts 02138. 1983. p. 244

зүтгэж гавьяа байгуулсан нь төрийн өндөр албанд томилогддог шударга зарчим үйлчилж байсан юм

Монгол нутаг дахь эрт үеийн хот байгуулалтын уламжлал, уран барилгын нийтлэг шинж нь наран ургах зүгийг бэлэгдсэн, шавар, ваар, чулууг ашиглан барьсаар ирснээр тодорхойлогддог бөгөөд хөгжлийнхөө явцад гудамж талбай засах, цэцэрлэгжүүлэх гоёл чимэглэл тавих, халаалтын систем байгуулах зэрэг хот байгуулалтын нарийн зүйлүүдийг бий болгожээ. Монголчуудаас Оросын хотын хөгжилд шинээр оруулсан зүйл бол халаалтын систем буюу ханз байв. Монгол нутгаас олдсон хотуудын тууриас халаалтын энэхүү ханз бас олддог юм.

Тэр цагийн Азийн барилгын уран хийцийг үндэслэн барилгын материалыг бэлтгэх, барих технологи, арга чадварыг эзэмшсэн нь монголчуудын соёл мэдлэгийн гайхамшиг байжээ. Энэ соёл нь Сарай-Бат хотыг байгуулахад өвлөгджээ.

Харин Сарай-Бэрх хотын өнгө төрх нь хуучин Сарайгаас илүүтэй лалын хотын шинжтэй байв.

Бэрхийн байгуулсан Шинэ Сарай хотын орд харш, сүм дуганыг лалын уран барилгачид гантиг, үнэт чулуугаар өвч бүрж чимэглэсэн төдийгүй усан сан байгуулах зэргээр тухайн үеийн хамгийн баян тансаг орчныг цогцлон бүтээжээ<sup>1</sup>.

Хуучин Сарай нь Узбек хааны (1312-1342) төр барьж байх үед үйлдвэрийн төв болжээ. Хотод 30 гаруй сүм дуган сүндэрлэж, тоосгоны, ваар савны, гантиг боловсруулах гар урлалын бичил хотхон ажиллаж байв. Тэдгээрээс хамгийн том нь хааны ордныхны хэрэгцээт зүйлсийг үйлдвэрлэдэг хааны урчууд хэмээх урлан байжээ<sup>2</sup>.

Сарай Бэрх нь нэг захаас нөгөөг нь хүртэл хагас өдөрчийн газар явдаг, гар урчуудын суурин, олон шашны сүм дуган, худалдааны захуудтай том хот байжээ. Тэрбээр олон угсаатны хот байсан бөгөөд угсаатан бүр өөр өөрийн хороололд суудаг тогтсон уламжлалтай байв. Ирак, Египет, Сири болон бусад газраас ирсэн худалдаачид хөрөнгөө хамгаалсан хэрэм бүхий тусгай хэсэгт амьдарна.

Хуучин Сарай нь уртаараа 39.6 км, өргөнөөрөө 13.2 км, шинэ Сарай нь 52.8 км талбайг хамарсан газар нутагтай том хот байжээ.

Хэмжээ, эзлэх талбай, тооцоотой төлөвлөгдсөн байдал, ус дамжуулах хоолой болон үзэсгэлэнтэй сайхнаараа хоёр нийслэл бусдаас ялгарч байв. Ус дамжуулах сувгийн тухайд уугуул нутгийн хот байгуулалтын нөлөө ч байсан байх. Гэхдээ энэ нь монголчуудын хувьд

<sup>1</sup> М.Правдин. Чингис хаан түүний өв. УБ., 2005

<sup>2</sup> Б.Греков и А.Якубовский Золотая Орда (Очерки истории Улуса Джучи в период сложения и расцвета в XIII-XIV вв) Л., 1937. стр. 109

шинэ зүйл бус бөгөөд монгол нутгаас олдсон хотын тууриудаас усан суваг, усжуулах хоолой байсны ул мөр олноор олддог юм. Тухайлбал, Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт Хар бухын балгас гэж бий. Энэ хот нь 4 хаалгатай, гол гудамжнаасаа салбарласан нарийн гарцуудтай, орон сууцны хороолол бүхий дөрвөлжин хот байжээ. Хотыг цэцэрлэгжүүлэхээр усжуулах суваг татаж байсан ул мөр байдаг<sup>1</sup>.

Сарай-Бэрх хотод эзэн хааны маш том ордон байх бөгөөд дотроо өвлийн сууцтай байв. Түүнчлэн халуун усны газартай, хотын төв дунд Ижил голоос татаж байгуулсан бэсрэг хиймэл нууртай. Нуурын усыг унданд хэрэглэдэггүй ба голоос шавар домбоор авдаг... хэмээн Ал-Омари тодорхой бичжээ.

Сарай Бэрх хотод 1333 оны үед очсон Арабын жуулчин Ибн Батута “Сарай хот тэгш тал газар орших бөгөөд өргөн гудамж, гоёмсог зах зээл, үй түмэн хүн бялхан дүүрсэн гайхамшигт сайхан хот байсан”, “аялан яваа хүн хотыг нь тойроход хагас өдөрчийн газар болох тухай” өгүүлжээ.

Крымд Солхат хот байгуулсны дурсгалд зориулж Узбек хааны нэрийг чулуун дээр сийлсэн сүм эдүгээ хүртэл уламжлан иржээ.

Монгол хаадын орд, гэр тэрэг, тэдний өмсгөл зүүсгэл, дүр төрхийн талаар бичиж тэмдэглэсэн зүйл, эд өлгийн олдвор тун ховор байдаг бол харин Алтан ордон улсын хаадын ялангуяа Бат, Бэрх, Узбек хааны тухай өгүүлсэн зүйл бага сага тэмдэглэгдэн иржээ. В.Рубрук Бат хааны дүр төрхийн тухай тодорхой өгүүлсэн бол 1262 онд Бэрх хаанд бараалхсан Египедийн султаны элч Ал-Муфадодол түүний тухай мөн сонирхолтой тэмдэглэл үлдээжээ.

Түүний бичсэн нь: “Тэд (элч нар) их хаанд бараалхаж бүхий л ёслолыг гүйцэтгэсний дараагаар цагаан эсгийгээр бүрхэж, дотор талыг нь торгоор доторлож, сувд үнэт чулуугаар чимсэн, 500 морьтон өлхөн багтах уужим цэлгэр асарт ороход, гэмтэл авсан хөлөө олбог, дэр тавьсан сандал давуулан унжуулж, хаан суудалдаа тухалсан Бэрхийг харжээ. Түүний хажууд Тогтогай хатан нь зэрэгцжээ. Түүнээс гадна хоёр хатан байв. Хаан, угсаа залгах хүүгүй, түүнийг залгамжлагч нь ахынх нь хүү болох бөгөөд эмир Оглу гэгч болой. Тэр үед Бэрх хаан 56 настай байв<sup>2</sup>.

Оросын археологич Марк Крамаровскийн сүүлийн үеийн судалгаа нь Алтан ордны нийслэл болон бусад хотуудын хөгжил, гар урлалын хөгжлийг тодорхойлохуйц олон чухал олдвор олж судалгааны эргэлтэд оруулсан нь тус улсын гар урлал, барилгажилт, гадаад харилцаа, олон

<sup>1</sup> БНМАУ-ын түүх. I боть. т. 154

<sup>2</sup> Золотая Орда в источниках. Т. 1. Арабские и персидские сочинения. М., 2003. стр. 92-93.

улсын худалдааны хөгжлийг тодорхойлоход чухал хувь нэмэр болов.

Монголын үеийн хот байгуулалтын нэг онцлог нь хамгаалалтын хана хэрэмгүй байсан ба тэр нь хотыг өргөжин тэлэхэд сайн нөлөө үзүүлсэн төдийгүй цэрэг стратегийн ч ач холбогдолтой байв. Өмнө эзлэгдсэн Оросын хотууд галиц хотынхон хамгаалалтын хэрэмыг сэргээн барьсанд хүчээр буцаан нураалгаж байсан билээ.

Тэр үед Оросын хотууд нь тархай бутархай оршиж хоорондоо харилцаа холбоогүй байсны дээр харилцан дайсагналцан тэмцэлдэж байсан нь хот хамгаалалтын хана хэрэмыг зайлшгүй барихад хүргэж байсан бол монголчууд тэрхүү хувь хувиа хоохойлсон хамгаалалтын хэрэмыг зад татаж нэгдмэл бус байсан тэдгээр хотуудыг улс төр, худалдаа, эдийн засаг, хөгжил дэвшлийн түмэн учгаар холбон Орос, Булгар зэрэг олон улсыг амьд хөдөлгөөнт амьдралд хөтөлж оруулсан юм.

Ингэснээр Оросын хотууд татвар, дарамт, хүчирхийлэлд ч өртөх төдийгүй бас хөгжил дэвшилд ч хүрэх үүдийг нээсэн юм. Тэдгээр хотуудад цаг үеэ сайн мэдэрч чадах авьяаслаг удирдагч л хэрэгтэй болсон байжээ.

XIII-XIV зууны үе дэх монгол хотуудыг олон газраас авчирсан олзны цэрэг, боолууд (өр төлбөрөө төлж чадаагүй буюу харь орноос олзлогдсон байв) гар урчуудын хүчээр бариулж байсан тул хотууд нь дорно, өрнийн уран барилгын шийдэл туссан, газар газрын уран барилгын нийлмэл шинж төрхтэй байсан байна<sup>1</sup>.

Нийслэлийн зэрэгцээ Алтан ордон улсад олон том хотууд байсан нь тус улсын эдийн засагт шийдвэрлэх нөлөөтэй байв. Тэдгээр хотуудын нэлээд нь Ижил мөрний Булгарт байжээ.

Алтан ордны эрхшээлд орсон Булгар нь тухайн үедээ том улс байсан бөгөөд Ока мөрнөөс Урал хүртэл өргөн уудам нутаг, Вятка, Кам, Яик (Урал), Ижил мөрний үржил шимтэй сав газрыг хамарч байснаараа газар тариалан ч, мал аж ахуй ч хөгжихөд таатай нөхцөл бүхий учраас тус улсын эдийн засаг хүчирхэг байхын үндэс болжээ.

Булгарын газар нутаг нь орчин үеийн Татарстан, Чуваш, Марий Эл, Удмурутийн хэсэг, Мордов, Башкир түүнчлэн Самар, Саратов, Волгоград, Астрахань, Пермь, Пензень, Нижегород, Ульяновскийн нутаг багтаж байснаас хэр том улс байсныг харж болно.

Булгар нь Ази Европыг холбосон худалдааны зам дээр байснаас худалдаа эрчимтэй хөгжиж Итали болон Оростой худалдаалахын зэрэгцээ Скандинавийн орнуудтай үнэт үслэг, түүгээр хийсэн хувцас

<sup>1</sup> Ж.Болдбаатар, Ц.Батбаяр, З.Баасанжав нар. Монгол улсын түүх. УБ., 1999. т. 239

хэрэглэл, төмөр худалдаалж байв.

Тус улсын нийслэл Булгар хотоос 7 км-ын зайд Ижил мөрний хөвөөн дээр Ага-базар гэдэг гадаад худалдааны том төв байсан ба энд худалдаалахаар тэмээн жин, худалдааны хөлөг онгоцууд ирдэг байсан гэнэ. Мөн энэ захад энэтхэг, хятад, перс, араб зэрэг орноос худалдаачид олноор ирдэг байсан ба булгар худалдаачид ч Багдад, Орос, Константинополь, Скандинав болон Балтийн тэнгисийн орнуудад очиж худалдаалж байв.

Худалдаа хөгжихийн хэрээр хотууд маш эрчимтэй хөгжиж байсан бөгөөд Булгарт монголчуудын довтолгооны өмнө бэхлэлт хэрэм бүхий 200 орчим хот байсан тухай тэмдэглэжээ. Ижилийн Булгарын хоёрдах нийслэл нь Биляр хот байв. Тус хот нь 70 000 хүнтэй 7 сая кв.метр нутагтай байв. Тухайн үед 30 000 хүнтэй хот томоохонд ордог байсан бол Биляр хоёр дахин их хүн амтай байсан нь хэр зэрэг том хот байсныг харуулна.

Булгар нь монголчуудыг ирэхээс өмнө нийслэл хот байсныхаа хувьд худалдаа, гар урлал, соёлын томоохон төв байжээ. Тус хот нь дайны хөлд нэлээд сүйдсэн боловч маш богино хугацаанд сэргээгдэн үйл ажиллагаа нь хэвийн амьдралд орсон байна. Монголчуудтай, уугуул нутгийн эрх баригчид найрамдлын гэрээ тогтоож хүчин зүтгэхээ андгайлахад тэдгээр ноёдын эрх мэдлийг сэргээжээ. Хаин тодорхой хэмжээний алба татвар төлөх болов. Ингэснээр Булгарын хотууд дахин сэргэж Алтан ордны улсын худалдаа, гар урлал, соёлын төвийн нэг болов.

Ижилийн Булгарыг Доод Повольжтой холбож байсан Укек хот нь Зүчийн улсын хөгжлийн гол судас болж худалдааны гол том төвүүдийн нэг байв<sup>1</sup>.

Оросын академич И.И.Лелехин болон И.П.Фальк нар 1769 онд уг хотын туурийг судлаад зоос, керамик болон төмөр эдлэлүүд, тоосгон байгууламжууд, 400 сажень урттай хотын шороон далан зэргийг илрүүлэн олжээ.

Укек хот нь Саратовоос доош 8 верст буюу 8.8 км-ийн газар байжээ.

Булгар нь зоос үйлдвэрлэлийн томоохон төв байж голлон мөнгө, зэсээр зоос цутгаж байв. 1270 оноос Хорезмд, 1282 оноос нийслэл Сарайд зоос цутгах болов.

XIV зууны эхнээс нийслэл Сарайд мөнгөн зоос ихээр цутгаж 1330-аад он гэхэд Ижилийн Булгар, Молдав, Крым, Мордав, хойт Кавказад

<sup>1</sup> Л.Ф.Недашковский. Золотоордынский город Укек и его округа. М., 2000. стр. 159-168

тэдгээр зоос нь гүйлгээнд давамгайлан бусад зоосыг шахах болжээ.

1290-1312 онд төр барьж байсан Тогтох хаан 1310-1311 оны үед Алтан ордон улсад мөнгөний шинэчлэл хийж бүх улсын хэмжээнд нийслэл Сарайд цутгасан хатуу тогтоосон ижил жинтэй дирхемийг гүйлгээнд хэрэглэхээр зарлиг буулгаснаар монгол хаадын зоос хэсэг хугацаанд дагнах болов. Энэ нь гадаадын мөнгө зоосыг хориглон гадаад худалдааг шахах бус шинээр хийгдсэн хаадын зоос байр сууриа олтол түр арга хэмжээ байсан байж болох юм.

Алтан ордон улсын ноёрхлын сүүл үед худалдааны их зам торгон зам дайран гардаг нутгуудад эрх мэдэл, эд баялагийн төлөө дайн самуунтай, дээрэм тонуултай байсан нь худалдаачдыг хэрхэн Хятад улстай худалдааны харилцаа сэргээх арга замыг олоход хүргэсэн төдийгүй зарим эрдэмтдийн үзэж байгаачлан далайн гарц болон газарзүйн их нээлт хийхэд хүргэсэн<sup>1</sup> гэж үзсэнийг ч нягтлан үзүүштэй.

Хотын хүн амын бүрэлдэхүүн нь Монголын эрх баригч давхаргынхнаас гадна төрийн албан хаагчид, гар урчууд, шашны зүтгэлтнүүд малчин, тариачидаас бүрдэж байв. Хотын хүн амын нэлээд хувийг олзлогдон ирсэн буюу өр төлөөгүйгээс боол бологчид эзлэж байсан нь Алтан ордон улсын хотуудын нэг онцлог нь болно. Учир нь ашигтай наймааны орлогын гол эх үүсвэр нь цэргийн болон ажиллах хүчний гол цөмийг бүрдүүлдэг боолууд байв.

Байнга нэмэгдэж байсан урчууд-боолчуудын хөдөлмөр, эзлэгдсэн ард түмнүүдээс авах алба татвар зэрэг нь Алтан ордон улсын хотуудын хөгжилтөд нэмэр болж байв.

Хүн амын дийлэнхи нь нүүдэлчид байсан ч тэдний байгуулсан хотууд Алтан ордон улс төр, эдийн засгийн болон соёлын амьдралд чухал үүрэг гүйцэтгэх болжээ.

Монголчууд тэр үед олон орны соёлын дээж, үр шимийг хүртэж, тэдгээрийн эд барааг эдэлж хэрэглэж сурсан ч төрлөх ард түмнийхээ дадал заншил, хувцас хэрэглэлийг мартаагүйгээр барахгүй улам хөгжүүлэн баяжуулж, хойч үедээ өвлүүлжээ.

Алтан ордон улсын хаад тэр үеийн Монголын бүх хаад ноёдын нэгэн адилаар урлаг соёл, шинжлэх ухааныг шимтэн сонирхогч, хөхүүлэн дэмжигчид байсан учир нийслэл болон бусад хотууд нь лалын соёл хийгээд Азийн ямбалаг тансаг амьдралын гол төв болжээ<sup>2</sup>.

Дундад Азийн зэрэгцээгээр Сарай хотын соёлд византи-христосийн соёлын нөлөө ч бас буй. Сийлбэртэй улаан шавран сав суулга, шилэн бугуйвч, бөгж, шил сав суулганы зарим хэлбэрүүд, Крымээс гаралтай

<sup>1</sup> Х.Шагдар. Монголчуудын аян дайн, цэргийн урлагийн түүх. Дэд боть. УБ., 2000. т. 679

<sup>2</sup> Михаэл Правдин. Мөн зохиол. т. 271

зоос зэрэг нь Крым, Азактай худалдааны холбоо харилцаатай байсныг илтгэх хийгээд эдгээр нутаг орноос аваачсан гар урчууд Алтан ордон улсын гар урлалын үйлдвэрлэлд оролцож байсны гэрч мөн.

Гэвч тэдгээр цэцэглэн хөгжиж байсан хотуудын хөгжилд Алтан Ордны эрх баригчдын дотоодын тэмцэл, эзлэгдсэн орнуудын ард түмний эсэргүүцэл нөлөөлсөн юм. Крымийн хан Мэнгли-Гирей, Ахмад хааны хөвүүд хүчирхэгжиж 1502 оны зун Сарай хотыг гэнэт довтлов. Тэрбээр хотын хүн амыг зэрлэгээр хүйс тэмтэрч, Алтан ордны нийслэлийг газрын хөрстэй тэгшлэв. Гайхамшигтай орд харш, сүм хийд, соёлын үнэт зүйлсийг сүйтгээд авч болохыг нь дайны олз болгон Крым рүү авч одов.

XIII-XIV зуунд Алтан ордон улсын хаадын ур ухаан, төрийн бодлогоор босгосон хотууд эвдэгдэн сүйдсэн хэдий ч тэдний бүтээсэн хотын соёл зуун зуун дамжин дэлхийн соёл иргэншилд нөлөөлж уламжлан хөгжсөн юм.

## 12. ШАШИН ШҮТЛЭГ

Чингис хаан болон түүний залгамжлагчид шашны талаар алсын хараатай зөв мэргэн төрийн бодлого явуулсан нь асар том гүрний дотоодод шашны сөргөлдөөн гарахгүй байхад чиглэгдэж байлаа. Үзэл бодлоороо сөргөлдөн тэмцэлдэж байсан шашныхан Их хааны ивээл дэмжлэгийг олохын тулд нэгэн хотод хаяа дэрлэн сүм хийдээ босгож оршиж байсан нь Их хаадын шашны талаархи бодлого зөв байж амьдралд хэрэгжиж байсны тод илрэл юм.

Монголын Их хаад аливаа шашиныг ялгаварлахгүй адил тэгш хандаж дэмжлэг үзүүлж байсныг Оросын зарим эрдэмтэд хүлээн зөвшөөрч байна. Монгол хаад олон шашныг хүлээн зөвшөөрч байсныг шашны нэгдсэн бодлого явуулж чадахгүй, тэдний сул дорой байсантай холбоотой гэж үзэж буй. Гурав дахь нь Монгол хаад өөрсдөө аль нэг шашныг гүнзгий шүтдэггүй байсан учир тоодоггүй байсан гэж үздэг. Энэ бүхэн нь монгол хаадын төрийн бодлогын мөн чанарыг гүйцэд ойлгоогүйтэй холбоотой юм. Харин Оросын түүхч Чудовшивцов Монголчууд сүм хийдийг өөрийн засаглалаа бэхжүүлэх боломжийн зэвсэг гэж үзэж урьд өмнө эдлэж байгаагүй давуу эрх өгсөн гэж үзсэн нь бодит байдлыг зөвөөр ойлгосны гэрч юм. *Шашинд адил тэгш хандснаар шашны мөргөлдөөн гаргуулахгүй байх нөхцлийг бүрдүүлжээ.*

Аливаа шашин нь тухайн ард түмний оюун санааны хөтлөгч бөгөөд тэдний үйл ажиллагааг голлон чиглүүлэгч байдгийг монгол хаад анхнаасаа мэдэж, эрхшээлдээ оруулсан орны ард түмнийг зангидан барьж байх хөшгүүрэг гэж үзэж байснаас тэднийг алба татвараас чөлөөлөөд зогсохгүй, янз бүрийн хөнгөлөлт дэмжлэг үзүүлж байв.

Оросын шашны сүм хийдүүд нь монголын довтолгоонд өртөж зарим нь нэлээд сүйдсэн бөгөөд, түүний шалтгааныг бурхандаа тогтмол залбирал үйлдэж, шашиндаа үнэнч байгаагүйн хилэнц нүгэл буюу бурхнаас илгээсэн гэсгээл гэж үзэж байв. *Гэвч удалгүй монгол хаадын олон шашинд адил тэгш хандаж, төрийн бодлогоор дэмжиж буй үйл ажиллагааг нь мэдэрсэн Оросын үнэн алдартны шашны лам нар Алтан ордон улсын захиргаатай эв найртай байж, харилцаа тогтоож их хаадын ивээлд багтахыг эрмэлзэх болов.*

Тэр үед Оросын үнэн алдартны шашны тэргүүн нь Никейгээс томилсон Иосиф хэмээх грек хүн байв. Тухайн цагт Орос хүнийг метрополитоор өргөмжлөхийг Константинополь зөвшөөрдөггүй байжээ. Тэр үед байсан Грек митрополит нь байлдан дагуулалд өртсөн үү, эсвэл дайн дажны хөлөөс дайжин явсан уу гэдэг нь тодорхойгүй бөгөөд өдгөө ч судлаачид маргасаар л байгаа юм байна. Дараачийн тэргүүнийг томилох асуудал нэлээд удааширч, дахин Никейгээс тодруулахгүй нь тодорхой болсны дараа 1243 онд анх удаа Оросын үнэн алдартны шашны тэргүүн хамбаар Крилл гэдэг орос хүн томилогдов. Үүнийг судлаачид хоёр янзаар тайлбарлав. Нэг хэсэг нь ялагдсан Орос оронд хамбаар томилогдох нь ичгэвтэр байсан гэх буюу нөгөө хэсэг нь шинэ хамбын аюулгүй байдалтай холбон тайлбарлаж буй.

Шинээр өргөмжлөгдсөн хамбыг Византийн буюу Никейн улсад илгээж батламжлуулах асуудал гарчээ. Хамба Криллийн батламжлуулахаар явсан оныг 1246 он гэж үзсэн. Шинэ хамба нь Галицийн Даниилийн төлөөний хүн байсан бөгөөд Галицийн Даниил Ордны хаад, эрх баригч монголчуудтай харилцаагаа зохицуулахгүйгээр төлөөнийхөө хүнийг явуулах боломжгүй байв. Иймээс өргөмжлөгдсөнөөсөө хойш 3 жилийн дараа очжээ.

Никейн эрх баригчид Криллийг очиход нь Оросын митрополитоор батламжлахаас өөр аргагүй байсан. Алга болсон Иосифийн оронд болох Грек хүн олдоогүй, Орос руу явахыг хэн ч хүсээгүй учир анх удаа грекүүд өөрсдийн урьд баримталж байсан зарчмаасаа ухарч Криллийг хүлээн зөвшөөрч ёсоор болгов.

Юутай ч монголын байлдан дагууллын үр дүнд Орос хүн өөрийн улсын шашны тэргүүн болох боломжтой болсон байна. Зөвхөн энэ ч биш монголын байлдан дагуулаар дэлхийн улс төрийн газрын зураг өөрчлөгдөж гол гол шашнуудын хүч чадал, нөлөөллийн хүрээ өргөжин, олон бүс нутгийн хүн ам зүйд өөрчлөлт оров.

Монгол хаад зөвхөн Орос төдийгүй эрхшээлдээ оруулсан улсуудын шашин шүтлэгийг төрийн бодлогоор дэмжиж байлаа.

Алтан ордон улсын хараат байдалд орсноос хойш Оросын сүм хийд тогтворжин хөгжжээ. Учир юу гэвэл хааны засгаас Оросын шашинд олгосон хөнгөлөлт нь хүчирхэг материаллаг бааз бүрдүүлэх боломж олгож, ирээдүйд сүм хийдийн улс орны эдийн засаг, улс төрд эзлэх байр суурийг өргөтгөж өгчээ.

Тийнхүү харийн шашны сүм хийдүүдийг татвараас чөлөөлж үйл ажиллагааг нь дэмжиж байсан явдал монгол төрийн бодлогын үндсэн чиглэл болж байв. Энэ нь их улсын дотоод эв нэгдлийг хангахтай холбоотой байсныг тухайн шашны зүтгэлтнүүд монголчуудыг өөрийн

шашныг талархагч буюу шүтэгч хэмээн үзэхэд хүргэжээ.

Ираны түүхч Жузжаны “Табакат-и-Насир” хэмээх зохиолдоо бичихдээ: “Тэрбээр (Бат хаан) маш шударга, лалын шашинтны нөхөр байлаа. Түүний ивээл дор лалын шашинтнууд чөлөөтэй амьдарч байв.

Түүний овгийн хүрээнд үй олон мөргөлчдөөр дүүрэн сүм хийд байгуулсан. Түүнийг хаанчилж байсан бүх үед лалын шашинт орнуудын хүн ам дур зоргоор амьдарч байв. Түүнд захирагдагсад, цэргийн зүгээс нэг ч гамшиг зовлон дарамт үзүүлээгүй. Түрэгийн лалын шашинтнууд түүний хамгаалалтын дор ихээхэн тайван, айх аюулгүй амьдарч байлаа.

Бэрх хааны хатан чачраар зөөвөрлөдөг лалын сүмтэй байсан тухай мэдээ бий<sup>1</sup>.

Монголчууд славянчуудыг бүрэн захирагдаж алба гувчуур өгч байхыг хүсч, харин тэдний шашин шүтлэгийг чөлөөтэй байлгаж Үнэн алдартны сүмийг татвараас чөлөөлж хамгаалалтандаа авсан байна<sup>2</sup>.

Зөвхөн үнэн алдартны шашин ч бус эрхшээлдээ оруулсан бүх улс үндэстний шашинд нэгэн адил хандаж, тэдгээр шашны сүм хийдүүдийг татвараас чөлөөлж, үйл ажиллагааг нь дэмжиж байсан нь монгол төрийн бодлого, үйл ажиллагааны гол чиглэл болж байв.

Олон шашны тэргүүнүүд Сарайд Бат, Бэрх хаанд бараалхаж шашин, сүм хийдийнхээ байдлыг танилцуулж, дэмжлэг олохоор өрсөлдөж байв. Монгол хаад өөрийн төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө уян хатан байр суурь баримталж байжээ. Асар том улсыг цэргийн хүчээр байгуулан захирсан их хаад гэхэд тэдэнтэй уулзахаар өрнө дорноос зорин очсон хэнийг ч хүлээн авч санал хүсэлтийг нь сонсч, боломжтойг нь хэрэгжүүлж байсан нь нээлттэй бөгөөд зарим талаар ардчилсан хүмүүнлэг шинжтэй байв. Түүний цаана асар том бодлогын асуудал байсан бөгөөд түүний үрээр монголчууд хоёр зуу гаруй жил эл нутагт ноёрхлоо тогтоож чадсан юм.

Монголын хаадын тухай маш олон орны элч төлөөлөгч, түүхч сударч нар тэмдэглэл бичиж үлдээсний дотор Алтан ордон улсын хаан Батыг “Сайн хаан” гэж тэмдэглэсэн байдаг нь хий хоосон магтаал бус дээр дурьдсан ухаалаг бодлогын үр гарч буй хэрэг юм.

Бэрх, Батыг залгамжлан хаан ширээнд суухад лалын шашныг талархан үздэг өөрийнх нь хувийн үзэл бишрэл төрийн бодлогод саад болсонгүй нь хувийн эрх ашгаас төрийн хэргийг дээгүүр тавьж байсны илрэл билээ. Үүний тодорхой жишээ нь христ мөргөлт худалдаачдыг

<sup>1</sup> Салих Захиров. Алтан Ордны улсаас Египедтэй барьж байсан дипломат харилцаа. УБ., 2004. т. 55

<sup>2</sup> Чарльз Галперин (США). Россия в составе Монгольской империи - Монголоведные исследования. Вып. 4. Сборник научных статей. Улан-Удэ, 2003. стр. 78-92

хүлээн авч уулзан, үйл ажиллагааг нь хөхүүлэн дэмжиж, авчирсан барааг нь илүү үнээр худалдан авч улсынхаа нутгаар чөлөөтэй худалдаалах эрх олгож байсан явдал юм. Венецийн худалдаачин ах дүү Поло нар Константинополиос түүнийг зорин ирж байлаа.

Мөн Бэрх хаан Сарай хотноо Оросын үнэн алдартны шашны төлөөний газар байгуулахыг зөвшөөрсөн нь олон шашныг дэмжих төрийн бодлого нь хэрэгжиж байсны баталгаа болно.

1261 онд Сарайд үнэн алдартны шашны төлөөний газар байгуулагдаж, Митрофан ламтан тэргүүнээр нь томилогдов. Сарайд христийн шашны төв байгуулагдсан нь судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж, түүний учир шалтгааныг олохоор оюун бодлоо уралдуулахад хүрэв. А.Насонов зэрэг судлаачид Сарайд төлөөний газар байгуулагдах гол шалтгаан нь Оросын олзлогдогсодын төлөө байсан юм. Олзлогдогсод ч гэсэн өөрийн шашныг шүтэх эрхтэй байх ёстой. Тэдний тоо үлэмж байснаас тийнхүү уг төвийг байгуулсан гээд мөн Бэрх хаан Оросын метрополиттай шууд харилцах шаардлагатай байсан нь нөлөөлсөн гэж үзжээ.

Б.Д.Греков Сарай дахь суурин төлөөний газрын тухай бичихдээ: Сарайд олон оросууд ирсэн байсан. Энд Азов тэнгисийн эрэг дээр эрт дээр үеэс Славчууд аж төрж байжээ. 1261 онд суурин төлөөлөгчийн газар байгуулагдсан нь гайхалтай зүйл биш юм. Пашуто Сарайд төлөөлөгчийн газар байгуулагдснаар Орос Византийн харилцаа шууд Ордын хяналтад орсон гэжээ.

Г.В.Вернадский: Оросын сүм хийдийн хил хязгаарыг тэлэх санаачлагыг метрополит Крилл, Александр нар дэвшүүлж Бэрх хааны дэмжсэ-нээр байгуулагдсан гээд энэ нь Монголын эрх баригчид Оросын сүм хийдийн үйл ажиллагааг хянахад чухал байсан гэжээ.

С.М.Соловьев: энэ газар нь Бэрхийн дэмжлэгтэйгээр Александр Невскийн хөөцөлдөлгөөр байгуулагдсан. Монголчуудын хараат байдалд орсон нь Оросын шашныг Папын дарамтаас хамгаалах хаалт болсон юм. Монголчууд өөрсдийн зүгээс Византийтай харилцахад Оросын сүм хийд лам нарыг ашиглахад хамгийн тохиромжтой гэж үзэж байсан. Феннель суурин төлөөлөгчийн газар байгуулагдснаар Метрополит Крилл Ордын хааны Засгийн газартай байнгын харилцаа тогтоогоод зогсоогүй Византийтай харилцах тохиромжтой дипломат сувагтай болсон юм гэж үзснийг зарим судлаач аливаа этгээд харилцаа тогтооход зуучгүй бол сайн хэмээн дээрхи саналд эргэлзсэн байна.

М.Д.Полубоярина: Сарайд суурин төлөөлөгчийн газар байгуулагдсан нь хэд хэдэн шалтгаантай гэж үзжээ. Ордод, олзлогдсон олон боолууд худалдагдаж байсан. Тэдгээр олзлогдогсод шашны эрэлт

хэрэгцээ байсан, тиймээс Монголчууд үнэн алдартны шашныг дэлгэрүүлэхэд татгалзах зүйлгүй байв. Григорьев, Оросын он дарааллын бичигт Сарайд Митрофаныг хамбаар томилсон нь гэгээн цагаан өдөр тэнгэр ниргэх шиг үзэгдэл болсон гээд төв байгуулах санаачлагыг Ордын хаан дэвшүүлсэн ба эцсийн шийдвэрийг ч хаан л гаргаж байсан гэжээ.

В.Л.Егоров: Бэрх лалын шашинтан байсан учир Христиан шашны төв байгуулахад Александр Невский маш их чармайлт гаргасан. Төв байгуулагдснаар олзлогсод Оростой шууд харилцаа холбоотой болсон ба монголчууд ч төлөөний газраараа дамжуулан Оросын боолыг худалдан авах зорилгоор Сарайн төлөөний газрыг байгуулсан юм гэжээ.

М.А.Охотина: Сарай дахь суурин төлөөлөгчийн газар Оросууд болон Ордынхонд аль алинд нь ашигтай байсан. Суурин төлөөлөгчийн газар байгуулсан тухай ямар нэг баримт буюу эсвэл аман хэлэлцээр байх ёстой. Дээр дурдсныг нэгтгэн дүгнэвэл, Насоновын Оросын лам нарыг Византийтай харилцах харилцаандаа ашиглах хүсэлтэй байсан. Орос Византийн харилцааг дэмжих гэсэн энэ санаа зөв гэхдээ Оросын эрх баригчид сүм хийд нь Оросын олзлогдсон хүмүүсийн төлөө санаа тавьсныг дутуу үнэлж болохгүй хэмээн өөр өөрийн байр суурийг илэрхийлжээ.

Дээрх эрдэмтдийн дэвшүүлсэн саналууд бүгд сонирхолтой бөгөөд өөр өөрийн байр сууринаас хандсан байна. Эцсийн дүндээ аваад үзэхэд хоёр талын ашиг сонирхол хоёулаа байсан нь мэдээж.

Оросын тал ч Сарай дахь суурин төлөөлөгчийн газраас хааны ордны тухай дэлгэрэнгүй мэдээлэл авах, Монголын төрөөс Оросын аль ванд хэрхэн хандаж байгааг мэдэх боломжтой болов.

Монгол хаадын хувьд Сарайн шашны тэргүүнээр дамжуулан Оросын вангуудад нөлөөлөх, улмаар өрнөд рүү Византийтай холбоо тогтоож, өрнөдийн улс төрийн байдлыг тандан мэдэх гээд давхар давхар боломжийг бодолцсон байх.

Оросын Сарайн төлөөний газар нь нэг ёсны дипломат төлөөлөгчийн газар болж хувирсан бөгөөд аажмаар Алтан ордны бүх хот суурин газруудад үнэн алдартны шашны сүм байгуулагдахад нөлөөлсөн болой.

Үүнээс үзэхэд төлөөний газар байгуулсан нь ямар их чухал үйл явдлын эхлэл байсныг харуулж байна.

Оросын сүм хийдүүд хийгээд Ордын харилцааны чухал хэсэг нь Алтан ордын хаадын зарлигуудад тусгалаа олсон байдаг. Тэдгээрээс одоогоор олдоод байгаа хамгийн эртнийх нь Мөнхтөмөр хааны туулай жилд өгсөн зарлиг гэдэг. Туулай жил нь европын тооллоор хэдэн он болох талаар эрдэмтэд судлаад 1267, 1279 он гэж маргалдснаас 1267 он нь зөв бололтой гэдэг санал дээр олонхи нь нэгдэж байна. Учир

нь 1266 онд Мөнхтөмөр (1266-1282) хаанд өргөмжлөгдөөд, шинэ хаан Орост өөрийн харилцаагаа тодорхойлох шаардлага гарсан учраас уг зарлигийг өгсөн гэж үзжээ. Тус зарлигт сүм хийдийг Ордны алба татвараас чөлөөлсөн хийгээд хэнийг сүмийн хүн гэдэгт хамааруулахыг тодорхой болгож өгсөн юм. Сүм хийдэд үзүүлэх хөнгөлөлтүүдийг мөн тодорхой дурдсан байв. Тус зарлигт Чингис хаан болон монголын бусад хаадуудын гаргасан зарлигийг иш татсан нь монгол төрийн бодлого тасраагүй үргэлжилж байсны гэрч мөн.

Мөнхтөмөр хааны зарлиг анхных байгаагүй бололтой. Сурвалж бичгийн мэдээг харьцуулан үзэхэд хаан солигдох бүр зарлигийг бүх ван, метрополит, епископод дахин олгож, өөртөө үнэнч зүтгэх эсэхийг нь тодруулсны дараа тэднийг дахин батламжилдаг байлаа. Тиймээс Бат, Бэрх нарын үед ч мөн зарлиг хөнгөлөлтүүд олгож байсан хэдий ч тэдгээр нь хараахан олдоогүй байж болох юм. Учир нь 1261 онд Сарайд төлөөний газар байгуулсантай холбогдуулаад Оросын лам нарыг татвараас чөлөөлсөн гэх мэдээ байх боловч хууль эрхийн акт болох тодорхой баримт олдоогүй байна.

Монгол хаадаас Оросын сүм хийд, лам нарыг алба татвараас чөлөөлөн олгож байсан зарлигуудыг эрт үеийн бэлэг солилцооны тогтолцоонд хамруулж болох юм гээд энэ нь оросын вангуудын Монголын эрх баригчдад өгсөн бэлгийн хариу байсан гэж зарим судлаачид үзсэн төдийгүй тэр ч байтугай монгол хаад татвараас чөлөөлсөн орлогоо довтолгооноороо нөхөөд авчихдаг байсан гэж үзсэн нь уг асуудалд өрөөсгөл хандсан хэрэг юм.

Өөрийн эрхшээл нөлөөг өрнө зүгт тэлж байсан Монголын эрх баригчдын үйл ажиллагаа нь, Европ улмаар дорно зүг рүү нөлөөнийхөө хүрээг тэлж байсан Ромын Папын тэргүүдсэн католик шашны эрх ашигтай зөрчилдөх болов. Оросын евразийг судлагч нэрт түүхч Г.В.Вернадский: "Папын дэлхийг үзэл санааны хувьд нэгтгэх гэсэн үзэл нь Монгол хаадын дэлхийг нэгтгэхтэй сөргөлдсөн гэсэн нь бодит үнэн юм.

Тухайн үеийн дэлхийн хөгжлийг тодорхойлогч улс төр, шашны хоёр их хүчин өөрийн эрхшээл нөлөөг тогтоохын төлөө улс төрийн, дипломат харилцааны, шашны бүхий л хэлбэрээр өрсөлдөх болов. Тиймээс Ромын Пап алс холын тал нутаг руу нэг бус удаа элч илгээж, Монголын Их хаадад захидал бичиг илгээж байсан ба тэд ч зохих хариуг нь өгч байв. Монгол хаад Ромын Пап нь бүх християн шашны толгойлогч бус зөвхөн нөлөөнийхөө хүрээг тэлж буй католик шашны тэргүүн гэдэг утгаар хандаж байв. Тиймээс Ромын ч, Никейн ч шашны тэргүүнүүдтэй аль алинтай нь адил харьцаж байв.

Папын тавьж байсан гол зорилго нь болж өгвөл Монголын их

хаадыг өөрийн шашинд оруулах, чадахгүй бол Дорнод Европын католик шашинт орнууд руу монголчуудын довтлох аюулыг зайлуулах, монголчуудыг өөрийн гол өрсөлдөгч Никейн Эзэнт улстай ойртуулахгүй байх, Турк Сельжуктэй тэмцэхдээ монголчуудыг ашиглах, нүүдэлчдийн хүрээнд өөрийн шашныг түгээн дэлгэрүүлэх, түрэг, монголчуудыг католик шашинд оруулж чадвал тэдний эзэмшилд орсон газар нутгийг Папын захиргаанд авах зэрэг өргөн агуулгатай байв. Тиймээс зорилгодоо хүрэхийн тулд ихээхэн хүчин чармайлт гаргаж байв.

Монголчуудыг ирэхээс өмнө Оросын шашны зүтгэлтнүүд өөрийн үнэн алдартны шашныг, католик шашны нөлөөнөөс чадлын хэрээр хамгаалан тэмцэж байсан ч Ромын захиргаа Оросын баруун хэсэгт нөлөөлж чадсан байна. Монголчуудын довтолгооноос эмээсэн Галицийн ноён өрнөөс тусламж авахын тулд католик шашинд оржээ. Ингээд Ромын Папаас вангийн титэм гардсан ч тусламж дэмжлэг авч чадалгүй монголчуудад автаж, хараат улсын ёсоор Литов, Польшийн эсрэг дайнд хамжин орж байжээ.

Ромын захиргааг хүлээн зөвшөөрөх юм бол татааруудтай тэмцэхэд нь түүнд герман рыцаруудыг илгээж туслуулья гэсэн гэгээн хутагтын саналыг Александр няцааж улс орноо Европ, Азийн тулалдааны талбар болгох тавилангаас гэтэлгэж чадсан юм. Хэрэв ийм тэмцэл өрнөсөн бол Азийн ялалтаар дуусч Орос орон газрын хөрснөөс бүрэн арчигдах байлаа. Тэр эцгийн нэгэн адил Бат хаанд очиж бараалхан өршөөл соёрхолд нь багтаж хүчин зүтгэх хүсэл зориггоо илэрхийлэхээр Ижил мөрнийг зорьсон нь зөв шийдэл<sup>1</sup> байсныг хожмын үйл явдлууд харуулсан юм..

Л.Н.Гумилев Александр дүү Андрейг бодвол “улс төрийн нөхцөл байдлыг гаргуун сайн ойлгож байв”. Тэрээр Ордон руу очиж монголчуудаас тусламж хүсч дэмжлэг олон, Владимирийн их вангийн орыг эзэлсэн билээ. Тэр үед Александр Бат хааны хүү Сартагтай анд бололцсон аж. Ромын католик шашны нөлөөг хазаарлан барихын тулд монгол хаад ч, оросын вангууд ч бололцооны хэрээр хамтран ажилласан юм.

Ордоос их ван болж ирсэн Александр Ярославичийг Владимир хотын Алтан хаалгын өмнө “метрополит болон бүх лам нар ба ард иргэд нь угтан авсан юм”. Монголчуудын дэмжлэгтэйгээр Александр Орос улсын түүхэнд чухалд тооцогдох ялалтуудыг хийж чадсан юм.

Никей, Монгол, Орос гурван улс хэлэлцээр хийж, түүний үр дүнд А.Невский оросын лам нарт хөнгөлөлт үзүүлэх боломжийг олж авсан гэж түүхч Пашуто тэмдэглэжээ. 1238 оны энэхүү дипломат арга

<sup>1</sup> Михаэл Правдин. Дурдсан зохиол. т. 273

хэмжээний үед монголчуудад захирагдаагүй байсан Новгородыг Ордын захиргаанд оруулахыг оросуудад үүрэг болгожээ.

Ингэхдээ Ордын хааны засаг өөрийн зорилгодоо Оросын лам нарын нэр хүндийг ашиглахыг зорьж байсан. Энэ үйл явдлаас үүдэн түүхч М.А.Охотина монголчууд улс төрийн зорилгоор эдийн засгийн хөнгөлөлт үзүүлдэг байсан гэж дүгнэсэн нь бодитой юм. Аль ч улс, ямар ч удирдагч ашиггүй үйлдэл хийхийн төлөө бодлого явуулдаггүй нь ойлгомжтой.

Хаадуудын төрийн бодлогын мөн чанар нь аль ч шашны эрх ашгийг ноцтой хөндөхгүйгээр төвийг сахисан байдалтай байлгаж эрх баригчдын эсрэг турхирахгүй, шашны зөрчлийг сэдрээхгүй байсанд оршино.

Монголчууд сүм хийдэд эрх чөлөө олгож, вангуудаас хамааралгүй болгов. Тариачид зөвхөн сүм хийд болон өөртөө ажиллах болов. Тэд сүм хийд вангууддаа ч, монголчуудад ч татвар төлөхгүй болов. Монголын дарлалын үед Орос дахь сүм хийдийн амьдрал үгүйрээгүйгээр барахгүй, сүм хийд нь эдийн засгийн талаар хүчирхэгжиж, Монголын эрхшээлийн эхний зуунд 30 сүм хийд, дараагийн зуунд нь 150 гаруйг нэмэн байгуулжээ.

Сүм хийд хүчирхэгжснээр Оросыг нэгтгэх гол хүчин болж чадсан юм. Оросын нутагт үе үе бослого тэмцэл гарахад вангууд байлдан дагуулагчдын эсрэг тэмцэхийг хориглож байв. Ийм тэмцэл маш хатуу зайлшгүй цээрлэл дагуулдаг байв.

Тэр үед нөлөө бүхий байсан шашны нэг бол лалын шашин байв. Бэрх, Узбек хаад лалын шашинд орсон учир түүний үед Сарай хотын байдалд лалын өнгө төрх давамгайлах болжээ. Худалдаа наймаанд онцгой байр суурьтай байсан мусульман худалдаачид монголын төрд өндөр албан тушаал хаших болсноор хаадад ойр дотно байж, тийнхүү харийн шашныг талархагч буюу шашинд нь орох хүртэл нөлөөлжээ.

1327 оны Тверийн бослоготой холбоотойгоор Узбек хаан шашны талаар өөр бодлого баримтлах болсон юм. Л.Н.Гумилевын үзэж байгаагаар Оросын хийдийн нарийн чанд дипломат бодлого нь үнэн алдартны Оросыг мусульман Ордтой холбоо тогтооход хүргэжээ.

Узбек хааны шинэчлэл нь өвөг дээдсийнхээ уламжлалт шашныг солихыг хүсээгүй монгол ноёдыг Орос нутаг руу нүүн шилжихэд хүргэжээ.

Тийнхүү монголчууд Алтан ордны оршин тогтнох хугацаанд эрхшээлдээ орсон ард түмнийг зэвсгийн хүчээр ч, оюун санааны дэмжлэг, ивээлээр ч баримтлан захирч байв.

## ТӨГСГӨЛ

Куликовын тулалдаанаас хойшхи 100 жилд Алтан ордон улсын хаад эрх мэдлийн төлөө тэмцэлдэн богино хугацаанд олон хаад солигдож, төрийн нэгдсэн бодлого алдагдсан нь тус улсын хүчирхэг байдлыг задлаж, Ногайн, Казаны, Крымийн, Астраханы зэрэг хэд хэдэн улсуудад хуваагдахад хүргэсэн юм. Тэдгээрийг дахин нэгтгэхээр Тогтамыш, Ахмед хаан нар тэмцэж Ир ордыг байгуулсан ч 1480 онд Ахмед өрсөлдөгч этгээдүүддээ алагдсанаар Алтан ордон улс мөхөж Монголын ноёрхол унав.

Монголын ноёрхол унасан ч монголчуудын үлдээсэн өв уламжлал цаашид хадгалан дан хөгжсөн юм

Судлаачид Монголын Эзэнт гүрнийг суперимперия буюу хэт их гүрэн байсан гэдгийг хүлээн зөвшөөрч түүний бүрэлдэхүүний улс болох Алтан ордон улс, Юань улс, Цагаадайн улс, Эл хаант улс нь улсуудын холбооны шинжтэй байсан гэж бичиж байна.

Японы монголч эрдэмтэн, Монголын Эзэнт гүрний түүх судлаач Окада Хидэхиро: “Монголын Эзэнт гүрнийг үндэслэгч Чингис хаан Их Монгол улсыг байгуулснаас хойш хагас зуун жилийн дараа XIII зууны дундуур Монголын Эзэнт гүрэн нь түүний ач нарын 4 их хаант улс болон задарсан нь ... Эзэнт гүрэн бутарсан хэрэг бус ... тус тусдаа автономит эрхтэй улсын холбоо болсон хэрэг юм”<sup>1</sup> гэжээ.

XIII зуунд дэлхийн түүхийн тавцанд монголчууд хүчирхэгжин гарч Монголын Эзэнт гүрнийг байгуулснаар дэлхий ертөнцийн амьдрал ихээхэн өөрчлөгдсөн билээ. Түүний дотор Ази, Европ тивийг дамнасан Алтан ордон улс байгуулагдсан нь Евроазийн түүхийн эргэлтийн үе болжээ.

Орос болон Евразийн түүхэнд Алтан ордон улсын гүйцэтгэсэн үүргийг ихэнх түүхчид үй олон хүний амь насыг бүрэлгэсэн, нөхөж баршгүй хохирол учруулсан, соёлт бүхнийг устгасан, хоцрогдлын балчигт унагасан хэмээн дан сөргөөр үнэлж байсан нь түүхэн үнэнийг гуйвуулсан хэрэг байв. Гэвч үүний эсрэгээр тус улсын дэлхийн болон

<sup>1</sup> Окада Хидэхиро. Монголын Эзэнт улсын мандал, буурал. Чикума шёбоо, 2001 – Т.Мөнхцэцэг. XIII-XIV зууны үеийн Монгол Японы харилцаа. УБ., 2004. т. 41

Евразийн түүхэнд үзүүлсэн нөлөөг бодитой үнэлэх нь байсан бөгөөд ийм хандлага сүүлийн жилүүдэд хүч авч байна.

Алтан ордон улсын нэг онцлог нь нүүдэлч болон суурьшмал иргэншилтэй улс түмнийг нэгэн төрийн жолоонд чадварлаг зангидан 300 шахам жил оршин тогтнож чадсанд оршиж байна.

Монголын төр энэ хугацаанд төгөлдөржин боловсорсон төдийгүй эзлэгдсэн улс орнууддаа төрийн үүрэг ач тусыг мэдрүүлсэн юм.

Академич Ж.Болдбаатар Монголын Эзэнт гүрний төр олон үндэс, язгуур угсааны иргэд харьяатууддаа “Төр бол эрхэмсэг байдаг” хэмээн эгэл үнэнийг ойлгуулж чадсан нь олон жил хэвийн оршин тогтнох үндэс болж өгчээ<sup>1</sup> хэмээн үнэлжээ.

Алтан ордноос Оросуудын авч үлдсэн соёл нь Хятад, Иранд монголчуудын үлдээсэн өвөөс хэд дахин илүү аж.

Алтан ордон улсын задрал, уналтын үед тусгаар улсаа байгуулсан улс орнууд Алтан ордны төр, засаглалын системийн олон зүйлийг төдий л өөрчлөлгүй авч хэрэглэсэн байна.

Засаглалын оновчтой хэлбэр төдийгүй түүнтэй холбоотой нэр томъёог ч хэвээр уламжилсныг Японы эрдэмтэн Мияваки Жюнко гярхай ажиглаж XIV-XV зуунд Алтан ордон улс угтаа Цагаан ордны хант улс хэмээн нэрлэгдэж байсан бөгөөд Москвагийн энэ хант улсын ханыг залгамжлагч гэдэг угтаар “Белая царь” (Цагаан хаан) гэж нэрлэгдэх болсон. Халимаг, Буриадууд XVIII-XIX зуунд ч Оросын хааныг “Цагаан хаан” гэдэг байсан нь тэр үеэс улбаатай<sup>2</sup> гэж тэмдэглэжээ.

Алтан ордны монголчууд нүүдэлчдийн төр засаглалын оновчтой хэлбэр-аравтын тогтолцоо, хурилдай, гадаад харилцаа, дипломат дэг жаяг, алба татварын журам, хүн амын тооллого хийх туршлага, өртөө, хууль цаазны баялаг өвийг халаагаа өгсөн улсуудад үлдээсэн юм.

Монгол хаад аливаа шинэ зүйлийг өөрсдөө таньж мэдээд зогсохгүй хөхүүлэн дэмжиж дэлгэрүүлэн хөгжүүлэх онцгой бодлого хэрэгжүүлж байсан нь нийгмийн шинэчлэлийн үндэс, хөшүүрэг болж байжээ. Германы монголч эрдэмтэн Удо Баркман: “Ашигтай чухал зүйлийг түргэн таньж, оновчтой ашиглах оюуны их чадвар Чингис болон түүнийг залгамжлагчдад байв. Тэд хотын соёлыг хадгалан үлдэх, сэргээх, лалын нутагт эдийн засгийн амьдралыг сэргээн хөгжүүлэхийг сонирхох явдал илтэд өсч байлаа. Тэдний удирдлага доорхи газар нутгийн засаг захиргаа нь нэгд, монголын эрх мэдлийг хадгалах, хоёрт эдийн засаг

<sup>1</sup> Ж.Болдбаатар. Дэлхийн болон бүс нутгийн түүхэнд монголчуудын гүйцэтгэсэн үүрэг. УБ., 2003. т. 29

<sup>2</sup> Мияваки Жюнко. Оросын царь Алтан Ордныг залгамжилсан нь. //«Чингис хаан» -Түүхт хүмүүсийн цуврал. №26. Дэд дэвтэр. Гакушюү кэнкюүшя, 1991.

хөгжин цэцэглэх урьдач нөхцлийг хангаж, удаан хугацааны туршид ашиг тусаа өгнө гэдгийг хэдийн ойлгож байв<sup>1</sup> гэж монголчуудын алсын хараатай бодлогын мөн чанарыг оновчтой тодорхойлжээ.

Шинэ содон соргог, улсын хөгжилд тустай бүхнийг монгол хаад гар таталгүй урамшуулж, элдэв хөнгөлөлт, эрх дарх олгож байсан нь богино хугацаанд олон улсын худалдааг урьд байгаагүй өргөн цар хүрээтэйгээр хөгжүүлж дэлхийн чөлөөт худалдааны бүсийг буй болгожээ.

Монголчуудын авч очсон, байгуулсан, нэвтрүүлсэн олон зүйл Европт урьд огт байгаагүй шинэ зүйл байв.

Энд юуны түрүүн өртөөг нэрлэж болно. Өртөө нь Монголын Эзэнт гүрний засаглалыг хэрэгжүүлэх, мэдээлэл, гадаад харилцаа, худалдааг хөгжүүлэх гол хэрэгсэл болсон төдийгүй өрнө дорны ард түмэн бие биенээ танин мэдэх, соёл шинжлэх ухааны ололт амжилт харилцан нэвтрэх гүүр болсон юм. Алтан ордон улс өртөөгөөр урьд хэзээ ч байгаагүйгээр мэдлэг, мэдээллийг өргөн хэмжээгээр түгээн дэлгэрүүлсэн юм. Өртөөний тогтолцоо тэр чигээрээ өвлөгдөн үлдэж дэлхийн шуудан харилцаа, мэдээлэл, мэдлэг дамжуулах гол хэрэгсэл болов. Ийнхүү морин өртөө байгуулснаар монголчууд гурван зууны турш Евразид ноёрхлоо тогтоож чадсан төдийгүй дэлхий дахины улс төр, эдийн засгийн хөгжлийг урагш ахиулж чадсан юм.

Худалдаа гаалийн хөнгөлөлтүүд, санхүүгийн дэмжлэг, замын аюулгүй байдал зэрэг нь олон улсын худалдаа цэцэглэн хөгжих нөхцөл хөрс суурь болов.

Дундад зууны түүхийг судалсан Японы эрдэмтэд Ижил мөрөн, Хар далай, Хорезмыг холбосон олон улсын худалдаа Алтан ордон улсын нийслэл Сарай хотод төвлөрч, XIV зууны эхээр дорно зүгийн гар урлал, олон улсын худалдааны Метрополис болсон<sup>2</sup> байв. Сарай хотын хөгжил цэцэглэлт нь “монголчуудын тогтоосон энх”-ийн хүрээнд багтаж, XIV зууны Каспийн тэнгисийн эргэн тойрны улстай худалдаа хийж, эдийн засаг нь хөгжсөн бөгөөд Монголын эзэнт гүрний бүтээсэн соёл иргэншлийн нэгэн дүр төрх болсон<sup>3</sup> хэмээн тухайн үед Алтан ордон улсын гүйцэтгэсэн үүргийг бодитой дүгнэсэн нь буй.

Алтан ордон улсын арми нь Оросын цэргийн стратеги, тактик, зэр зэвсэг, бүтэц зохион байгуулалтад гүнзгий нөлөө үзүүлсэн юм. Монгол цэргийн дайтах, байлдах урлаг, зэр зэвсгийн гайхамшгийг Алтан Ордны хаад өөрсдийн биеэр мэдрүүлж мөн Орос орныг ч өрнөдийн

<sup>1</sup> Mongolian Great Empire (formation, growth, decline). UB., 2005. p. 81

<sup>2</sup> Монголын Эзэнт улс ба Өрнө дахин. Ред.Сагүчи Тоору. Хэйбонша, 1970. т. 134. Т.Мөнх-цэцэгийн орчуулгаар эш татав.

<sup>3</sup> Мөн тэнд. т. 379.

довтолгооноос аварч байв. Тиймээс Ж.Ж.Саундерс “Монголын удирдагчид дэлхий ертөнцөд урьд нь ховорхон тааралдсан, цаашдаа ч ховорхон тохиолдох дайны урлагийн мастерууд байжээ”<sup>1</sup> гэж дүгнэжээ. Үнэхээр загалмайн ертөнцийн рыцаруудтай харьцуулбал, Бат, Сүбээдэйн цөөн монгол цэргийн ялалт нь зэрлэг эр зориг, хүний олноор хийсэн зүйл огт биш, харин цэрэг, зэвсгийн хосгүй зохион байгуулалт, стратеги тактикийн гарамгай бэлтгэл, эсрэг этгээдийн талаар бодитой судалж, байлдааны стратеги, тактикийг сайтар боловсруулсны үр дүн байсан юм<sup>2</sup>. Үнэхээр монгол цэргийн урлаг, тактикийн гайхамшиг, өмнөх байлдааны туршлагын хүчээр монголын дайны гурван фронтоос хамгийн хялбар, хохирол багатай туулсан нь Орос, Европын фронт байсан. Орос, европчууд монголчуудын цэргийн урлагаас их зүйлд суралцаж, дайтах урлагийн ид шидийг хүртэж байв. Үүний дүнд цэрэг зэвсгийн шинэчлэл Европод эхлэв.

Алтан ордон улс унасны дараа ч монгол цэргийн стратеги тактик, зохион байгуулалт Орос оронд чухал үүрэг гүйцэтгэсний тодорхой жишээ нь уланы хороо (уланские полки), казакийн морьт цэргүүд Оросын армид чухал байр эзлэх болсон юм.

Еврази болон дэлхийн гадаад харилцааны түүхэнд монгол хаадын эртнээс уламжилж ирсэн болон шинээр нэвтрүүлж төгөлдөржүүлсэн дипломат ёсны дэг жаягууд өвлөгдөн үлджээ.

Тухайн үед гадаад харилцаа урьдах үеэс өргөн цар хүрээтэй хөгжиж гадаадын элч төлөөлөгчдийг хүлээн авах дэг ёс, захидлын хэлбэр маяг, найруулга зэрэг нь Монгол хаадын тогтоосноор хэлбэршин үлджээ. Монголын гадаад харилцаанд гэрэгэ бүхий элч нар чухал үүрэг гүйцэтгэж байв. Элчийн гүйцэтгэх алба, эдлэх эрхийн хэм хэмжээ, хэнийг төлөөлж буй зэргээс хамаарч алт, мөнгө, хүрэл гэрэгэ олгодог байсан бөгөөд алтан гэрэгэ бүхий элч нь их хааны нэрийн өмнөөс шийдвэр гаргах эрхтэй байв. Энэхүү Гэрэгэ нь олон улсын харилцаанд шинэ зүйл болов.

Монгол хаадын шашны талаар баримталсан бодлого нь шашны эрх чөлөөг тунхаглаж нэгэн төрийн удирдлага дор шашны зөрчил мөргөлдөөн гаргуулахгүйгээр олон шашны хүмүүс энх тайвнаар зэрэгцэн оршиж болохын гайхамшигт жишээг үзүүлэв. Монголчууд европд бөө мөргөл, буддын шашныг анх хүргэсэн бол өөрсдөө загалмайтны болон лалын шашныг таньж мэджээ. Монголчуудын дэмжлэгтэйгээр Оросууд үнэн алдартны шашнаа өрнөдийн католик шашны шахалтаас авран хамгаалсан билээ.

<sup>1</sup> Ж.Ж.Саундерс, өмнө дурдсан зохиол, т. 100

<sup>2</sup> Х.Шагдар, өмнө дурдсан зохиол, т. 461

Монгол хаадын энхжин тохинуулах бодлогын үрээр Эзэнт гүрний нийслэлд олон орны гар урчууд, худалдаачид, одон орон судлаач, эрдэмтэд, шашны элч төлөөлөгчид мөр зэрэгцэн амьдарч, бүтээлээ туурвих боломжтой болсон юм.

Монгол хаадын төрийн мэргэн бодлого, олгож буй нөхцөл боломж нь өрнө, дорны соёл, шинжлэх ухааны солилцооны алтан шижим болж дэлхийн соёл иргэншлийн сор болсон зүйлс нийт гүрний нутгаар түгэн дэлгэрэхэд үлэмж үүрэг гүйцэтгэсэнээрээ Монголын Эзэнт гүрэн дэлхийн соёл иргэншлийн түүхэнд баларшгүй ул мөрөө үлдээж, дэлхий нийтийн эдийн засгийн хөгжлийн хурдцыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулжээ.

Өртөө, худалдааны замыг дагаж соёл шинжлэх ухааны олон шинэ зүйл өрнө, дорнодод нэвтэрчээ. Хятад сампин, элдэв амтат халуун ногоо, чинжүү, цагаан гаа, шанцай, задь тэргүүтний эх нутаг болох далайн орныг ч өрнөдийнхэн таньж мэдэв. Энэтхэг, Мосул даавуу, эрээн бөс, сувд эрднийн чулуу Европт өргөн төрхжээ. Иранаас зэр зэвсэг, хивс, арьс ширэн эдлэл ирж байв. Ази тив урьд өмнө хэзээ ч байгаагүй зүйл бүрийн соёлын хослол болов. Византийн Клуассоны паалан Хятадад хүрч урлагийн шинэ төрөл бий болгоход түлхэц өгчээ<sup>1</sup>.

Энэтхэг тоо, лалын одон зурхайн арга барил Төв, зүүн Азид нэвтэрч, Ойрхи дорнотын бичил уран зураг, нэхмэл хатгамлын урлаг, шаазан ваарын урлалд Хятадын нөлөө гүнзгий тусчээ. Энэ үеийн ихэнх нээлтүүдийг эрдэмтэд бус эгэл жирийн гар урчууд, ажлын хүмүүс хийж байсан нь онцлогтой юм.

Италийн дархчуудын алтан эдлэл Ази даяар өндөр үнэлэгдэж Венецийн шилэн эдлэл үнэ хүрч, шүр сувд Хятадад ч өргөн наймаалагдаж байжээ. Энэхүү худалдаа арилжааны шугамд хамрагдсан орнууд бүгд л асар их орлого олж хөлжсөн бөгөөд Дорно Өрнийг холбохыг өөрсдийн түүхэн үүрэг гэж үзсэн ойрхи дорныхон л гол ашиг хонжоог олсон билээ.

Чухам тэр үед хятадын луужин, шаазан, дарь, чулуун нүүрс зэрэг гайхамшигт зүйлс өрнө дахинд нэвтэрч Арабын анагаах ухаан, яруу найраг, одон орны шинжлэл, түүх бичлэг түлхүү хөгжив.

Газарзүйн мэдлэг урьд байгаагүйгээр өргөжин дэлгэрч худалдаачид, элч төлөөлөгчид, цэргүүд шинэ шинэ газар орныг ч нээв<sup>2</sup>.

Алтан Ордны улсад хотууд маш хурднаар сэргэн хөгжиж худалдааны том төвүүд болохын хирээр алт, мөнгөн зоос цутгаж гүйлгээнд оруулжээ.

<sup>1</sup> Михаэл Правдин. Чингис хаан, түүний өв.

<sup>2</sup> Мөн тэнд.

Цөөн хүн амтай монголчууд Эзэнт гүрний асар уудам нутагт тархан суурьшсан үлэмж тооны хүн амыг хэрхэн захирч байв гэдэг нь өнөө ч бүрэн тайлагдаагүй байна. Үүнийг эрдэмтэд монголчуудын оюуны өндөр чадавхи, төмөр мэт сахилга бат, хуулийн тэгш байдал, хүний хүч, нөөцийг зөв зохион байгуулж, хүн бүрт тохирсон ажлыг нь оноож байсантай холбон тайлбарладаг. Хэрэв дан ганц харгислан дарангуйлж, зөвхөн хүч хэрэглэж байсан бол монголчууд тэр олон улсыг хэрхэн эрхшээлдээ нэгтгэн захирч чадах билээ. Монголчууд хүнийг үндэс угсаагаар ялгаварлахгүй, оюуны чадавхийг өндөр үнэлж төрийн албанд үнэнч зүтгэсэн хэнийг ч урамшуулан хэрэглэж чаддаг байснаараа Монголын төр хүчирхэг байж удаан хунацаанд ноёрхлоо барьж чадсан юм. Дэлхийн улс, улсын мэргэд, төрийн зүтгэлтнүүд монголын төрд үнэнчээр зүтгэж байсан нь үүний жишээ болно.

Алтан ордон улсын задрал, уналтад хаадын эрх мэдлийн төлөө тэмцэл, харийн шашны нөлөө, олон удаагийн байгалийн бэрхшээл, олон сая хүнийг авч одсон тахал гээд олон хүчин зүйл нөлөөлжээ.

М.Правдин: “Монголчуудын засаг захиргаа дэлхийн бүх л оронд нурж унасан ч тэдний ноёрхолд байснаар дэлхий ертөнцийн нүүр царай ихээхэн өөрчлөгдсөн билээ. Байлдан дагууллаар хүн төрлөхтнийг нөмөрсөн их үймээн түйвээн, гай гамшиг учруулсан ч залгамж хойч үеийнхэн нь дэлхийг өөрчилж хувиргасан тэрхүү их гүрний ач буяныг амсаж олон үндэстний соёлыг холбож өгсний үр шимийг хүртсэн агаад ийнхүү хожмын Европын их хувирал өөрчлөлт, дараа дараагийн зуунд хүрсэн тэрхүү санаанд оромгүй дэвшил хөгжил үүсч бий болох хамгаас чухал нөхцөл бүрдсэн бүлгээ. Харин Монголын улс гүрнүүд оршин тогтнохоо болих тэр цаг үед дарлагдсан улс түмнүүд өөрсдөө тэдний голомтыг залгамжлах хэмжээнд нэгэнт хүрсэн байлаа”<sup>1</sup> гэсэн нь түүхэн үнэн юм.

1 М.Правдин. Дурдсан зохиол. т. 351

## ХАВСРАЛТ

### АЛТАН ОРДОН УЛСЫН ХААД<sup>1</sup>

1. Зүчи	1223-1227
2. Бат	1227- 1255
3. Сартаг	1255-1257
4. Улаагчи	1257
5. Бэрх	1257-1266
6. Мөнхтөмөр	1266-1282
7. Туда-Мөнх	1282-1285
8. Тулабуга	1285-1290
9. Тогтао	1290-1312
10. Узбек	1312-1342
11. Тинибек	1342
12. Жанибек	1342-1357
13. Бердибек	1357-1361
14. Кули (Кульна)	1361-
15. Нуруз	1359-1361
16. Хидырь (Хизрь)	
17. Орд Шейх	1361-1362
18. Мердуд	
19. Төмөрходжа	
20. Келдибег	
21. Муриходжа	1363-1364
22. Болдходжа	
23. Күтлүүгходжа	
24. Азизшейх	1362-1364
25. Абдаллах	1364 (1362)-1371
26. Хасан	1366
27. Мухаммед булаг буюу Мамат салтаан	1371-1375
28. II Жанибек	
29. Тулунбег	

<sup>1</sup> С.Лочин. Алтан ордны хаад. УБ., 2000. т. 10-13.

30. Хажичеркес	
31. Айбек	
32. Ала-ходжа	
33. Харихан	
34. Арабшаг	1373-1378
35. Хаанбег	1375-1378
36. Уруус хаан	1375-1378
37. Тогтамыш	1378-1395 (1406)
38. Бег болд	
39. Хайриджак	1395-1399
40. Төмөрхүтлүг	
41. Шадибек	1400-1408
42. Болдсултаан	1408-1410
43. Төмөр хан	1410-1412
44. Желал-ад-дин	1411
45. Керимберди	1412-1414 (1414-1417)
46. Кебег хаан	1414
47. Жаббарберди	1416-1419
48. Чекры-Оглан	1414-1416
49. Иерем ферден	1416
50. Дербиш хан	1417-1419
51. Кадыр Берди	1414-1421
52. Улуг Берди	1421
53. Борак	1423-1428
54. Давлет Берди	1426-1427
55. Өлөг Мухаммед	1420-1424, 1428-1430
56. Кичик Мухаммед	1430
57. Саид Ахмед	1430-1465
58. Ахмад	1465-1480

### АЛТАН ОРДОНД ОЧИЖ БАЙСАН ОРОСЫН НОЁД<sup>1</sup>

1243/43 Ярослав II Всеволодович

1244 Углицийн Владимир Константинович, Ростовын Борис Василькович, Белозерийн Глеб Василькович, Василий Всеволодович

<sup>1</sup> Ю.В.Мизун, Ю.Г.Мизун. Ханы и князья: Золотая Орда и русские княжества. М., 2005. стр. 324-329

- 1245 Ростовын Борис Василькович, Дасилий Всеволодович, Константин Ярославич, Ярослав II Всеволодович, Углицийн Владимир Константинович, Ростовын Василькович өөрийн хөвгүүн Борис, Глеб, ач хүү Всеволод ба түүний хөвгүүд Святослав, Иваны хамт
- 1246 Черниговын Михаил (Ордод ирж явах замдаа алагдсан)
- 1247 Андрей Ярославич, хөвгүүн Ярослав II, Невийн Александр Ярославич, Святослав, хөвгүүн Дмитрийн хамт
- 1252 Рязанын Олег
- 1256 Ростовын Борис Василькович, Невийн Александр
- 1257 Невийн Александр, Ростовын Борис Василькович, Тверийн Ярослав Ярославич, Ростовын Глеб Василькович
- 1258 Суздалийн Андрей Ярославич
- 1263 Галицийн Даниил, ах Василько, түүний хөвүүн Лев Данилович, Невийн Александр, ах Тверийн Ярослав Ярославич, Рязанын Владимир, Стародубийн Иван
- 1268 Ростовын Глеб Василькович
- 1270 Рязанын Роман (Ордод саатуулагдсан)
- 1271 Тверийн Ярослав Ярославич, Ростовын Глеб Василькович, Белозерийн Глеб Василькович хөвүүнтэйгээ, Ярославын Федор Ростиславич, Михаил, Невийн Александрийн хөвүүн Андрей Александрович
- 1278 Ростовын Глеб Василькович, хөвүүн Михаил Глебович, ач хөвүүн Константин Борисович, Ростовын Борис Василькович, (1278 оны 9-р сарын 16-нд Ордод нас барсан)
- 1281 Андрей Александрович
- 1282 Их ноён Дмитрий Александрович, Андрей Александрович
- 1288 Ростовын Дмитрий Борисович, Углицийн Константин Борисович
- 1292 Александр Дмитриевич, хөвүүн Их ноён Владимир (Ордод нас барсан)
- 1293 Городецийн Андрей Александрович, Ростовын Дмитрий Борисович, Углицийн Константин Борисович, Белозерийн Михаил Глебович, Ярославын Федор Ростиславич, Ростовын Иван Дмитриевич, Тверийн Михаил Ярославич
- 1295 Андрей Александрович (хатантайгаа?), Переяславль-Залесскийн Иван Дмитриевич
- 1302 Андрей Александрович, Их ноён Тверийн Михаил Ярославич, Москвагийн Юрий Данилович бага дүүгийн хамт
- 1305 Нижегородын Михаил Александрович

- 1307 Рязанын Василий Константинович (Ордод алагдсан)  
1309 Брянскийн Василий  
1310 Углицийн Константин Борисович  
1314 Тверийн Михаил Ярославич, Москвагийн Юрий Данилович  
1317 Москвагийн Юрий Данилович, Тверийн Михаил Ярославич,  
түүний хөвүүн Константин Ярославич  
1318 Тверийн Михаил (Ордод алагдсан)  
1320 Москвагийн Иван Данилович, Юрий Александрович (Ордод  
алагдсан), Тверийн Дмитрий Михайлович  
1322 Тверийн Дмитрий Михайлович, Юрий Данилович  
1323 Их ноён Юрий Данилович (III Юрий), Тверийн Дмитрий  
Михайлович, Тверийн Александр Михайлович, Москвагийн  
Иван Данилович (Иван I Калита), Константин Михайлович  
1326 Тверийн Дмитрий Михайлович (Ордод алагдсан),  
Новосилийн ноён Александр (Ордод алагдсан)  
1327 Рязанын Иван Ярославич (Ордод алагдсан)  
1328 Иван I Калита, Тверийн Константин Михайлович  
1330 Стародубийн Федор Иванович (Ордод алагдсан)  
1331 Иван I Калита, Тверийн Константин Михайлович  
1333 Борис Дмитриевич (Ордод алагдсан)  
1334 Тверийн Федор Александрович  
1335 Иван I Калита, Тверийн Александр Михайлович  
1337 Тверийн Александр Михайлович хүү Федорыг хааны дэргэд  
барьцаанд үлдээсэн, Иван I Калита, Гордийн Симеон  
Иванович  
1338 Ярославийн Василий Давидович, Белозерийн Роман  
1339 Тверийн Александр Михайлович хөвүүн Федор Александрович  
Ордод цаазлагдсан (10-р сарын 28), Рязаны Иван Иванович,  
түүний ах Семен Иванович, Андрей Иванович  
1342 Пронсын Ярослав Александрович, Гордын Их ноён Симеон  
Иванович, Суздалийн Константин, Тверийн Константин,  
Ростовын Константин  
1344 Иван II Красный, Гордын Симеон Иванович, Андрей Ивано-  
вич  
1345 Тверийн Константин Михайлович, Холмын Всеволод Алек-  
сандрович, Кашины Василий Михайлович  
1347 Гордын Симеон Иванович, түүний ах Иван II Красный  
1348 Холмын Всеволод Александрович, Кашины Василий  
1350 Гордын Симеон, түүний ах Москвагийн Андрей Иванович,  
Суздалийн Константин ба Иван

- 1353 Иван II Красный, Суздалийн Константин Васильевич  
 1355 Суздалийн Андрей Константинович, Стародубийн Иван Федорович, Федор Глебович, Юрий Ярославич, Пронсын Василий
- 1357 Тверийн Василий Михайлович, Холмын Всеволод Александрович
- 1359 Тверийн Василий Михайлович ач хүүтэйгээ, Рязаны ван, Ростовын ван, Нижегородын Андрей Константинович
- 1360 Суздалийн Андрей Константинович, Суздалийн Дмитрий Константинович, Галицийн Дмитрий Борисович
- 1361 Донын Дмитрий (Дмитрий IV Иванович), Суздалийн Дмитрий Константинович, түүний ах Нижегородын Андрей Константинович, Ростовын Константин, Ярославын Михайл
- 1362 Белозерийн Иван
- 1364 Кирдяпын Василий, түүний хүү Суздалийн Дмитрий
- 1366 Тверийн Михаил Александрович
- 1371 Донын Дмитрий
- 1372 Кашины Михаил Васильевич
- 1382 Тверийн Михаил Александрович хүү Александрын хамт, Суздалийн Дмитрий Константинович хоёр хөвгүүн: Василий, Симеон нарын хамт
- 1383 Городецын Борис Константинович, Донын Дмитрий өөрийн ахмад хүү Василий (Василий II), Суздалийн Дмитрий Константинович хөвүүн Симеоны хамт, Суздалийн Борис Константинович хүү Иваны хамт
- 1385 Москвагийн Василий Дмитриевич, Кирдяпын Василий
- 1390 Суздалийн Василий Дмитриевич хөвүүн Симеоны хамт
- 1393 Суздалийн Василий Дмитриевич хөвүүн Симеоны хамт
- 1402 Суздалийн Симеон Дмитриевич, Рязаны Федор Ольгович
- 1406 Пронсын Иван, Тверийн Иван
- 1407 Тверийн Иван Михайлович, Юрий Всеволодович
- 1412 Москвагийн II Василий, Кашины Михайлович, Тверийн Иван Михайлович, Ярославийн Иван Васильевич
- 1430 Москвагийн III Василий, Юрий Дмитриевич (?)

## ТОМООХОН БАЙЛДААН, ТУЛАЛДААНЫ ТОВЧООН

### Ялагч тал:

1. Калка голын тулалдаан монголчууд	1223 оны V сарын 31
2. Сить голын тулалдаан монголчууд	1238 оны III сарын 4
3. Киев хотыг эзэлсэн нь монголчууд	1240 оны XII сарын 6
4. Вальштадтийн тулалдаан монголчууд	1241 оны IV сарын 9
5. Пьяне голын тулалдаан монголчууд	1377 оны VIII сарын 2
6. Воже голын тулалдаан оросууд	1378 оны VIII сарын 11
7. Куликовын тулалдаан	1380 оны IX сарын 8 оросууд
8. Тохтамыш Москваг эзэлсэн нь монголчууд	1382 оны VIII сарын 26
9. Едигей Москваг бүсэлсэн нь монголчууд	1408 оны XII сарын 1-20
10. Белёвийн тулалдаан монголчууд	1437 оны XII сарын 5
11. Нерли дэх Спасо-Ефимьевийн сүмийн дэргэдэх тулалдаан монголчууд	1445 оны VI сарын 7
12. Угре голын тулалдаан	1480 оны X сарын 8-12
13. Угре голын хэрэг	1480 оны X сарын 2-30

### ОРОС-ТАТАРЫН ДАЙН

1. Казаний татарын Москва руу хийсэн I аян – 1439 он
2. Казаний татарын Москва руу хийсэн II аян – 1444-1445
3. Казан руу Василий III хийсэн аян – 1461
4. Орос-Татарын дайн – 1467-1469
5. Иван III Казан руу хийсэн I аян дайн – 1478

**ТАТАРААС ОРОСТОЙ БАЙГУУЛСАН  
ЭНХИЙН ГЭРЭЭ**

1. Улу-Мухаммед Василий III-тай байгуулсан гэрээ – 1445.VIII.25
2. Казань-Оросын гэрээ – 1460.
3. Ибрагим хан Иван III-тай байгуулсан гэрээ – 1469.IX.3

## НОМ ЗҮЙ

### 1. Монгол хэлээр

1. Ала-ад-Дин Ата мелик Жувеини. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. I, II дэвтэр. ӨМ-ын Соёлын хэвлэлийн хороо. 1989
2. Ала-ад-Дин Ата мелик Жувеини. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. Тэргүүн боть. Орос хэлнээс орчуулсан М.Д.Бадамням. УБ., 2006
3. Алишер Акишев. Скифээс улбаалсан их торгон зам. УБ., 2001
4. Алтан ордны улсын мандаж доройтсон түүх. ӨМСХХ, 1991
5. Алтаншаа Н. Монголын гурван хаан: Өгэдэй, Гүюг, Мөнх. Хөх хот, 1985
6. Алтаншаа Н. Монголчуудын өчигдрийн мөр. Хөх хот, 1992
7. Амар А. Монголын товч түүх. А.Очир хуучин монголоос кириллээр хорвүүлэв. УБ., 1989
8. Баабар Б. ХХ зууны Монгол нүүдэл, суудал, гарз, олз. УБ., 1996
9. Базарсүрэн Ж. Чингис хааны цэргийн зэр зэвсэг. УБ., 2000
10. Баясах Ж. Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг. УБ. 2005
11. Баяр Д, Эрдэнэбат У. Монголын эзэнт гүрний үед холбогдох нэгэн ховор дурсгал. // Археологийн судлал. Том XX. Fasc.8. УБ., 2000. т. 100-129
12. Баяр Д. Монголчуудын чулуун хөрөг. УБ., 2002
13. Бира Ш. БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд. УБ., 1977
14. Бира Ш. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. Токио, 1994
15. Бира Ш. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. Боть III. Эмхэтгэн хянасан Ц.Ишдорж, Х.Пүрэвтогтох. УБ., 2001
16. Болдбаатар Ж. Түүх зулсан он жилүүдийн ойллого. Боть I. УБ., 2003
17. Болдбаатар Ж. Түүх зулсан он жилүүдийн ойллого. Боть II. УБ., 2003
18. Болдбаатар Ж, Обрушанский Борбала. Бат хаанаас Унгарын IV Белал илгээсэн захидлын тухай. -Монголын түүхийн сурвалж судлал: Өнөөгийн байдал, судалгааны асуудлууд. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын материал. УБ., 2004. т. 30-32
19. Бор Ж. Монголын дипломатын товчоон. УБ., 1998
20. Бор Ж. Монгол хийгээд Евразийн дипломат шаштир. Боть II. УБ., 2004
21. Бор Ж. Эгэл, эгэл бус өнө мөнхийн Чингис хаан. УБ., 2005

22. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ., 1966
23. БНМАУ-ын түүх. Дэд боть. УБ., 1968
24. БНМАУ-ын түүх. Нэгэн боть. УБ., 1984
25. Вернадский Г.В. Чингисийн үеийн монголчууд ба Орос улс. УБ., 2004
26. Ганбаатар Я. Их нүүдлийн түүх (эрдэм шинжилгээний өгүүллүүд). УБ., 2001
27. Гийом де Рубрук Дорно этгээдэд зорчсон тэмдэглэл. Франц хэлнээс орчуулсан Т.Төмөрхүлэг. УБ., 2000.
28. Далай Ч. Монголын түүх (1206-1260). УБ., 1992.
29. Далай Ч. Өгөөдэй хаан. УБ., 2001.
30. Дамба. Монголын үе улиралын бичиг. ӨМАХХ., 2000
31. Дамдинсүрэн А. Монголын зэвсгийн товч түүх. УБ., 1990
32. Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм. УБ., 1957
33. Дамдинсүрэн Ц. Мянган жилийн харьцуулсан хүснэгт. УБ., 1959
34. Дашдаваа Ч. Монголын эзэнт гүрний түүх Оросын сурах бичгүүдэд туссан нь. -Их Монгол улс, эзэнт гүрний түүх, соёлын асуудлууд. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. Улаанбаатар, 2006.06.23-24
35. Ерөөл-Эрдэнэ Ч, Г.Рэгзэн. Загас агнуурын холбогдолтой нэгэн олдворын тухай //Археологийн судлал. УБ., 2000. тал 28-33
36. Жамсран Л, Урангуа Ж, С.Дэмбэрэл. Монголын түүхийн бага нэвтэрхий толь I (А-3). УБ., 1998
37. Жек Ведерфорд. Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан. УБ. 2003
38. Ким Жон Ре. Мянган жилийн түүхэн хүн. Орчуулсан Б.Лхагва, Ж.Ломбо, Ч.Цэрэнхорлоо. Улаанбаатар-Соёл, 1999
39. Ким Жон Ре. Их шуурганаар сийлэгдсэн түүх (нүүдэлчдийн тухай өгүүлэх нь). УБ., 2000
40. Их монгол улсын зам харилцаа, өртөө. УБ., 2006
41. Ишжамц Н. Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ., 1974
42. Ишжамц Н. Чингис хаан, Их монгол улс, Монголын байлдан дагуулалын асуудлыг сургууль, соёлын ажилд хэрхэн тусгах тухай. // Монголын түүхийн зарим өгүүлэлийн эмхэтгэл. УБ., 1998
43. Леон Куне. Хөх монголын хөх туг. УБ., 1990
44. Лочин С. Алтан Ордны хаад УБ., 2000
45. Лочин С. Ил хаад. УБ., 2002
46. Михаэл Правдин. Чингис хаан түүний өв. Герман хэлнээс орчуулсан Д.Моононцагаан. УБ., 2005
47. Майдар Д. Чингис хаан ба Монголын Эзэнт гүрэн. УБ., 1990
48. Мандир Т. Хорин нэгэн хөрөг. УБ., 1990
49. Монгол-Татарууд Ази Европт. УБ., 1984
50. Монгол угсаатны бага нэвтэрхий толь. Боть I. Эрхлэн хэвлүүлсэн А.Батболд. УБ., 1993
51. Монгол улсын түүх (Түүх, онол арга зүйн асуудалд). УБ., 2001

52. Монгол улсын түүх. Дэд боть. УБ., 2003
53. Монгол цэргийн түүхийн товчоон. Тэргүүн дэвтэр (МЭӨ III-XX зууны эхэн). УБ., 1996
54. Монголын соёлын түүх. Боть I. Оршихуйн аймаг. УБ., 1999
55. Монголын түүхийн сурвалж судлал: өнөөгийн байдал, судалгааны асуудлууд (Олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал). УБ., 2004
56. Монголын феодализмын нийтлэг онцлогийн зарим асуудал. УБ., 1987
57. Мөнхцэцэг Т. Япон дахь Монголын түүхийн судалгаа (1900-1995). УБ., 2000
58. Мөнхцэцэг Т. XIII-XIV зууны Монгол Японы харилцаа. УБ., 2004
59. Нацагдорж Ш. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978
60. Нацагдорж Ш. Чингис хааны цадиг. УБ., 1991
61. Нямаа Б. Монголын эзэнт гүрний мөнгө, хаадын овгийн тамга (XIII-XIV зуун). УБ., 2005
62. Оссон 'Д. Монголчуудын түүх. УБ.
63. Плано Карпини. Монголчуудын түүх. В.Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988
64. Позднеев Н.Н. Чингис хааны үеийн монгол гүрэн. Улсын хэвлэл, 1931 он
65. Пэн Дая, Сюй Тин Хар татаарын хэргийн товч - Ж.Баясах. Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг. УБ., 2005
66. Пэрлээ Х. Монгол ард улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон. УБ., 1961
67. Рашид-ад-Дин. Судрын чуулган. II боть. Орос хэлнээс хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо. УБ., 2002
68. Рене Груссе. Чингис хааныхны монголчууд. Франц хэлнээс орчуулсан Л.Бат-Очир. УБ., 2004
69. Ринчен Б. Дундад эртний Монголын тухай хоёр сонин бичиг. - "Шинжлэх Ухаан, амьдрал" сэтгүүл. УБ., 1989. №2
70. Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд. Хөх хот, 1987
71. Сайшаал. Чингис хааны товчоон. Доод. Хөх хот, 1987
72. Сайшаал. Чингис хааны товчоон. Дээд. Крилл үсэгт хөрвүүлсэн Ш.Чоймаа, М.Баярсайхан, С.Батхишиг. УБ., 2004
73. Сайшаал. Чингис хааны товчоон. Доод. Крилл үсэгт хөрвүүлсэн Ш.Чоймаа, М.Баярсайхан, С.Батхишиг. УБ., 2004
74. Салих Закиров. Алтан Ордны улсаас Египедтэй барьж байсан дипломат харилцаа. Орос хэлнээс хөрвүүлсэн С.Оюунсүрэн. УБ., 2004
75. Санду. Чингисээс Хубилай хүртэлх зуун хүний намтар. Хайлар, 1995
76. Санждорж М. Монгол төрийн түүхээс. УБ., 1999
77. Саруулбуян Ж. Хан Хэнтий уулын тэнгэрийн тайлга. УБ., 2000
78. Саундерс Ж. Ж. Монголын байлдан дагуулал. Орчуулсан Ж.Гэндэн-дарам. УБ., 1992
79. Сумьяабаатар Б. Чингисийн алтан ургийн угийн бичиг ба гэрийн

- үеийн бичмэл. Тэргүүн дэвтэр. УБ., 2002
80. Сүхбаатар Г. Монголын түүхийн дээж бичиг. II дэвтэр. УБ., 1992
  81. Товуудорж С. Зүчи хаан. УБ., 1999
  82. Урангуа Ж, Энхцэцэг Д. Монгол хатад. УБ., 2000
  83. Хавх Н. Эзэн Чингис хаан, хүн төрөлхтөний түүхэнд түүний гүйцэтгэсэн үүрэг. УБ., 2004
  84. Хүүхэнбаатар Д. Монгол гүрний элчин харилцаа (XIII зуун). УБ., 1964
  85. Цахилгаан Д. Бат хаан. УБ., 2003
  86. Цолмон С. Монголчуудын хусны үйсийг бичгийн хэрэглэл болгон ашиглаж байсан уламжлалаас. //Письменное наследие Монгольских народов. Материалы I международного семинара (г. Улан-Удэ, 2-6 августа 2004 г). Улан-Удэ, 2005. т. 149-154
  87. Чингис хааны нэвтэрхий толь. УБ., 2004
  88. Чойсамба Ч. Бат хааны байлдан дагуулал. УБ., 2003
  89. Шагдар Х. Гүюг хаан. УБ., 2000
  90. Шагдар Х. Монголчуудын аян дайн, цэргийн урлагийн түүх (XIII зуун). Боть I, II. УБ., 2000
  91. Шагдарсүрэн Ц. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991
  92. Энхбат Ч., Нямаа Б., Батсайхан Ц. Монгол улсын зоос мөнгөн тэмдэгт. УБ., 2002
  93. Эрдэнэбат У. Монголчуудын “шувуулахуй” агнуурын уламжлалын асуудалд. //Түүхийн судлал. Том. XXXII. Fasc.13, УБ., 2000. т. 149-166
  94. Юань улсын судар (Дандаагийн эх). Хятад хэлнээс Монгол хэлнээ хөрвүүлсэн Ч.Дэмчигдорж. (Дандаа) Оршил бичиж, хэвлэлд бэлтгэсэн Ц. Цэрэндорж. УБ., 2003

## 2. Орос хэлээр

1. Армянские источники о Монголах. Извлечения из рукописей XIII-XIV вв. Перевод древнеармянского, предисловия и примечания А.Г.Галстяна. М., 1962
2. Бабенко В.Г, Кузнецов А.А. Птицы Красной книги СССР. М., 1986
3. Бартольд В.В. История культурной жизни Туркестана. Ташкент, 1922
4. Бартольд В.В. История изучения восток в Европе и России. Ленинград, 1925
5. Вернадский Г.В. Монголы и Русь. Тверь-Москва, 2001
6. Горский А.А. Москва и Орда. Москва, 2005
7. Греков Б.Д, Якубовский А. Золотая Орда (Очерк истории Улуса Джучи в период сложения и расцвета в XIII-XIV вв). Ленинград, 1937
8. Григорьев А.П, Фролов О.Б. Географическое описание Золотой орды в энциклопедии ал-Калкашанди. //Тюркологический сборник. 2001. Москва, 2002. с. 261-300
9. Григорьев А.П. Сборник ханских ярлыков русским митрополитом. СпБ., 2004
10. Григорьев В. Достоверности ярлыков, данных ханами Золотой Орды

русскому дуковейству. М., 1842

11. Грушевский М.С. Очерк истории Киевской земли от смерти Ярослава до конца XIV столетия. 1891
12. Гумилев Л.Н. Древняя Русь и Великая степь. М., 1989
13. Гумилев Л.Н., Панченко А. Чтобы свеча не погасла (диалог). Ленинград, 1990
14. Гумилев Л.Н. От руси до России. М., 2000
15. Дамир Исхаков. Сеиды в поздние Золотоордынских татарских государствах. //TATARICA. Казань, 1997/98. с. 42-95
16. Доде З.В. Средневековый костюм народов северного Кавказа. М., 2001
17. Дорж Банзаров. Собрание сочинений. Улан-Удэ, 1997
18. Древность и средневековье. СпБ., 2000
19. Золотая Орда в источниках. Том первый. Арабские и персидские сочинения. М., 2003
20. Золотая Орд и ее наследие. М. 2002
21. Золотая Орда в источниках. Том первый. Арабские персидские сочинения. Тизенгаузен. М.2003
22. Ключевский В.О. Курс русской истории. М., 1906
23. Кляшторный С.Г., Султанов Т.И. Государства и народы Евразийских степей древность и средневековье. СпБ., 2000
24. Коростовец И.Я. От Чингис хана до Советской Республики. УБ., 2004
25. Костомаров. Н.И. Русская история в жизнеописаниях ее главнейших деятелей. М., 2004
26. Крамаровский М.Г. Символы власти у ранних монголов. Золотоордынские пайцзы как феномен официальной культуры. // Тюркологический сборник. 2001. М., 2002. с. 212-224
27. Кривошеев Ю.В. Русь и Монголы. СпБ., 2003
28. Куликовская битва в истории и культуре нашей родины (материалы юбилейной научной конференции) в Москве. Издательство Московского университета. М., 1983
29. Кляшторный С.Г., Султанов. Государства и народы Евразийских степей. Древность и средневековье. СпБ., 2000
30. Иванин М.И. О военном искусстве и завоеваниях монголо-татар и средне-азиатских народов при Чингис хане и Тамерлане. СпБ., 1875
31. Источниковедение истории улуса Джучи (Золотой орды). От Калки до Астрахани 1223-1556. Казань, 2002
32. Исхаков Д. О концептуальных проблемах татарской исторической науки и задачах журнала "Tatarica". //TATARICA. №18. Казань, 1997/98
33. Лихачев Д.С. Русские летописи и их культурно-историческое значение. МЛ. 1947
34. Мен-да Бэйлу. Факсимиле ксилографий и приложения Н.Ц.Мункуева. М., 1975

35. Мизун Ю.В., Мизун Ю.Г. Ханы и князя Золотая Орда и русские княжества. М., 2005
36. Монгольская империя и кочевой мир. Улан-Удэ, 2004
37. Мэнэс Г, Баяр Д. Два погребения монгольского времени из Каракорума. // Археологийн судлал. Т. XXIII, Fasc. 14
38. Мясников В.Ю., Дугаров В.Д. Военное дело кочевников Байкальского Региона в период средневековья. Улан-Удэ, 2004
39. Насонов А.Н. История русского летописания XI-XVIII века. М., 1969
40. Недашковский Л.Ф. Золотоордынский город Укек и его округа. М., 2000
41. Ням-Осор Н. Монгольское государство и государственность в XIII-XIV вв. Улан-Удэ, 2003
42. Очерки культуры и искусства народов Евразийских степей и золотоордынских городов. М., 1976
43. Петрушевский И.П. Иран и Азербайджан под властью Хулагуидов (1256-1353гг). //Татаро-Монголы в Азии и Европе. М., 1977. с. 228-259
44. Покровский М.Н. Русская история. Том. I, М., 1920
45. Полубояринова М.Д. Русские люди в Золотой Орде. М., 1978
46. Полубоярина М.Д. Русские люди в Орде. //Мир Льва Гумилева "арабески" истории. Русский разлив. Т.1, Вып. 3-4. Минск, 1993
47. Равиль Амирхан. Золотая Орда и ее правители. Казань, 2003
48. Рашид-ад-Дин. Сборник летописей. Том. 2. М-Л, 1960
49. Романив В.Я. Бату хан и "центральное монгольское правительство" от
50. Противостояния к соправительству. //Тюркологический сборник. 2001. Москва, 2002. с. 84-100
51. Сокровища Золотой Орды. СПб., 2000
51. Султанов Т.И. Чингиз -хан и Чингизиды. Судьбы и власть. М.,
52. Усманов М.А. Золотая орда: истоки и наследия сокровища Золотой орды. СПб., 2000. с. 26-46
53. Храпачевский Р.П. Воснная держава Чингис хана. М., 2005
54. Христианский мир и Великая Монгольская Империя. Материалы францисканской миссии 1245 года. СПб., 2002
55. Худяков М. Очерки по истории Казакского ханства.
56. Федоров-Давыдов Г.А. Культура и общественный быт Золотоордынских городов. //Труды 7 международного конгресса антропологических и этнографических наук. Том V. М., 1970, с. 467-472
57. Феодоров-Давыдов Г.А. Общественный строй Золотой Орды. М., 1973
58. Чарльз Галперин. Россия в составе Монгольской империи //Монголоведные исследования. Вып. 4. Сборник научных статей. Улан-Удэ, 2003. стр. 78-92
59. Чингис хан и судьбы народов Евразии. Материалы международной научной конференции. 3-5 октября, 2002 г. Улан-Удэ, 2003
60. Шара туджи. Монгольская летопись XVII века. Сводный текст, перевод, введение и примечания Н.П.Шастиной. М., 1957

61. Широкоград А.Б. Русь и Орда. М., 2004
62. Эренжен Хара-Даван. Чингис-хан (как полководец и его наследие). Элиста, 1991
63. Юрченко А.Г. Францисканская миссия 1247 г. Во владениях Бату хана. //Тюркологический сборник. М., 2001
64. Юрченко А.Г. Золотая статуя Чингис хана (русские и латинские известия). //Тюркологический сборник. 2001. Москва, 2002. с. 245-260
65. Юрченко А.Г. Империя и космос. СПб., 2002
66. Якубовский А. Ф. Столица Золотой Орды-Сарай Берке. Л., 1932
67. Якубовский А.Ф. К вопросу о происхождении ремесленной промышленности в Сарай Бэрке. //“Исторический журнал”. 1944. №1

### 3. Англи хэлээр

1. Colmon S., Enchimag C. Podboj polcki przez wojska Batu khana Eroberung Polens durch Armee Batu khans. //Bitwa legnicka Historia Tradycja. Wroslaw-Wraszawa, pp. 84-89
2. David Morgan. The Mongols. Oxford, 1998
3. Jan Wrabec. Legnickfpole. Wroclaw, 1991
4. Jeremian Curtin. The Mongols a history. Cambridge, 2003
5. Namio Egami. The Mongol Empire and Christendom. San Paolo, 2000
6. Michal Biran. Qaidu and the rise of the indepenent Mongol state in central Asia. Curzon, 1997
7. Mongolian Great Empire (formation, growth, decline). Ulaanbaatar, 2005
8. Morgan D. O. Ibn Battuta and the Mongols //Journal of the Royal Asiatic Society, Volume 11, Issue 01. April 2001. pp. 1-11
9. Nyamaa B. The coins of Mongol Empire and clan tamgha of Khans. Ulaanbaatar. Mongolia, 2005
10. Rashiduddin Fazlullah. Jami'u't- Tawarikh. Compendiumof Chronicles. A History of the Mongols. Translated and Annotated by W.M.Thackston. Part Two. Harvard University, 1999. pp. 328-329
11. Reuven Amita-Preiss. Mongols and Mamluks. Cambridge, 1995
12. Charles J. Halperin. Russia in te Mongol empire in comparative perspective. //Harvard journal of “ASIATIC STUDIES”. Vol. 43, №1.

### 4. Япон хэлээр

1. Акасака цүнэаки. Зүчийн улсын газар өмчлөл. //“Шитэки”. №13. 1992.
2. Акасака цүнэаки. Зүчийн улсыг залгамжлагчдын түүхийн судалгаа. Казама шёбооь, 2005
3. Исоно Фүжико. Хүрээг дахин нягтлах нь. -“Монгорү кэнкюү”. № 19. Ард шётэн. Оосака,
4. Мияаваки Жюнко. Оросын царь Алтан Ордныг залгамжилсан нь. //“Чингис хаан” -Түүхт хүмүүсийн цуврал. №26. Дэд дэвтэр. Гакушюү

- кэнкюүшя, 1991.
5. Мияваки Жюнко. Монголын түүх. Тоосү шёбоо, 2002.
  6. Монголын Эзэнт улс ба Өрнө дахин. Ред. Сагүчи Тоорү. Хэйбоншя, 1970.
  7. Мүраока Хитожи. Нүүдэлчдийн улсад хил байгаагүй. //“Чингис хаан” -Түүхт хүмүүсийн цуврал. №26. Дэд дэвтэр. Гакүшоү кэнкюүшя, 1991
  8. Окада Хидэхиро. Төв евразийн түүхийн ертөнц. Үндэсний дэлхийн түүх 4. Ямакава шюппаня, 1990
  9. Окада Хидэхиро. Дэлхийн түүхийн үүсэл. Чикүма шёбоо, 1992
  10. Окада Хидэхиро. Монголын эзэнт улсын мандал буурал. Чикүма шёбоо, 2001
  11. Сагүчи Тоорү. Дөрвон хаант улс бий болсон нь. -Чингис хаан ба Монголын эзэнт улс. Шинжинбүцү оорайшя, 1991
  12. Сүгияма Масааки. Монголын эзэнт улсын мандал буурал. Тэргүүн, дэд дэвтэр. Кооданшя, 1996

